



**ЭНХ ТАЙВНААР ЗЭРЭГЦЭН ОРШИХУЙ:
ОРЧИН ҮЕ БА МОНГОЛ**

**Улаанбаатар
2025**


International Day Of Peace 2025

ISBN 978-9919-536-00-8



9 789919 536008

“ЭНХ ТАЙВНААР ЗЭРЭГЦЭН ОРШИХУЙ: ОРЧИН ҮЕ БА МОНГОЛ”
(Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл)



НАА 60
ДАА 300
Э-66

ОЛОН УЛСЫН ЭНХ ТАЙВНЫ ӨДӨР-2025

Энэхүү эмхэтгэлд ашигласан баримт, илэрхийлсэн үзэл бодол гагцхүү зохиогчийн байр суурь бөгөөд ЮНЕСКО-ийн үзэл бодлыг илэрхийлээгүй тул тус байгууллага аливаа хариуцлага хүлээхгүй болно.

“Энх тайвнаар зэрэгцэн оршихуй: Орчин үе ба Монгол”
(Улаанбаатар.,2025.09.21)

*Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэлийг ЮНЕСКО-ийн
Монголын Үндэсний Комиссийн дэмжлэгээр хэвлүүлэв.*

Эмхтгэсэн:	П.Мягмарсайхан
Редактор:	Ж.Энхбаяр
Хавтасны дизайнер:	З.Гантулга
Цаасны хэмжээ:	В5
Хэвлэлийн хуудас:	10 хх
Хэвлэсэн тоо:	100 ш
Хэвлэлийн “Тотопресс” ХХК-д хэвлэв.	

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	5
Б.Даш-Ёндон <i>«Үндэстний намтар цадиг» хэмээх асуудалд</i>	7
Б.Батхишиг <i>Олон улсын худалдааны дайн ба энх тайвны асуудал</i>	11
М.Гантуяа <i>Рерихийн тунхаглал ба түүний дэлхий дахин болон Монгол улс дахь өнөөгийн түүхэн нөхцөлд үзүүлэх ач холбогдол</i>	20
Б.Галиндэв <i>Энх тайвныг дээдэлсэн уран зохиолын дүрүүдийн тухай философи эргэцүүлэл</i>	24
Б.Галаарид <i>Монголчуудын тэнгэр шүтлэг дэх амар амгалангийн үзэл санаа Батлан хамгаалах бодлого, энхийг сахиулахуй</i>	32
Ч.Сосорбарам <i>Батлан хамгаалах бодлого ба энхийг сахиулах</i>	38
М. Мөнхзул, Г.Уянга <i>Глобальчлал ба үндэсний үнэт зүйлсийн уялдаа</i>	46
Ш.Ганхуяг, М.Амантай <i>Аристотелийн эв найрамдлын тухай ойлголт</i>	52
А.Энхбаяр <i>Монголчуудын Ерөөл ба Энхтайван</i>	58
Б.Баатарсүрэн <i>Эх оронч үзлээр дамжуулан Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх нь</i>	60
Ж.Энхбаяр <i>И.Кантын Үүрдийн энх тайван</i>	67
Ж.Жаргалсайхан <i>XIII зууны монголчуудын даян дэлхийд энх тайвныг тогтоох бодлого</i>	70
Т.Дорждагва <i>Дайн ба энхийн талаарх орчин үеийн зарим асуудал</i>	75
Г.Баатарнум <i>Түүхэн үнэн цэргийн сонин энхийг сахиулах үйлсийг эхлүүлжээ</i>	78
П.Мягмарсайхан <i>Эв нэгдэл: нийгмийн гоо сайхны зарим асуудал</i>	82

Ж.Бямбасүрэн	
<i>Энх тайвнаар оршихуй ба боловсролын үнэт зүйл</i>	<i>86</i>
О.Болор-Эрдэнэ	
<i>Сэтгэлийн амар амгалангаас мөнхийн энх тайван руу</i>	<i>89</i>
Д.Энхтайван	
<i>“Z” үеийн оюутан, залуусын ёс суртахууны төлөвшилийн зарим асуудал</i>	<i>94</i>
Н.Тогтох	
<i>Арга билгийн ухааны нэгдэл ба танин мэдэхүй</i>	<i>101</i>
О.Мөнгөнсор	
<i>Эв зүйгээр зэрэгцэн оршихтой холбогдож болох шашины эксклюзивизм, инклюзивизм, плюрализм, релятивизм үзэл санаануудын тухай</i>	<i>108</i>
Б.Цэрэнханд	
<i>Хүний оршихуйн гол мөн чанар нь энх тайван болох тухай асуудал</i>	<i>112</i>
Ц. Ганбат	
<i>Монголын уламжлалт нүүдэлчин соёлын ба НҮБ-ын энхийг сахиулах философийн уялдаа</i>	<i>118</i>

ӨМНӨХ ҮГ

НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага (ЮНЕСКО) жил бүрийн 09 дүгээр сарын 21-нд **Энх тайвны олон улсын** (“Peace Day”) өдрийг тэмдэглэн, дэлхий нийтийг энх тайван, эв нэгдэл, хүмүүнлэгийн үнэт зүйлсийн төлөө санаачилгатай оролцохыг уриалдаг. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей 1981 онд энэхүү өдрийг албан ёсоор тэмдэглэхээр зарлаж, дэлхий нийтэд хүний эрх, тэгш байдал, шударга ёс, энх тайвны соёлыг түгээн дэлгэрүүлэх өдөр болгосон. Энэ жил ШУА-ийн Философийн хүрээлэн, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисс хамтран Дэлхийн Энх тайвны өдрийг хамтран тэмдэглэж байна.

Философи нь дэлхий даяарх туршлага, соёлын олон ургальч үзлийг нэгтгэн авч үздэг, нийгмийн өөрчлөлт, аливаа асуудлыг гүнзгий шүүн тунгаах, бодитой шийдэл олоход хувь нэмэр оруулдаг төдийгүй хүн төрөлхтний мөнхийн сэдэв болох энх тайвныг ойлгох, түгээн дэлгэрүүлэх эрхэм үүргийг ч бас хүлээдэг. Философичдын хувьд энх тайван нь зүгээр нэг нөхцөл байдал бус, хүний ёс зүй, шударга ёс, эрх тэгш байдлын үндэс суурь болохыг онцолж ирсэн. Тухайлбал “И.Кантын ‘Үүрдийн энх тайван’ бүтээлд энх тайвныг тогтоон хадгалах суурь нөхцөл нь хууль дээдлэх зарчим, иргэдийн оролцоонд тулгуурласан ардчилсан байгуулал, мөн олон улсын эрх зүйд нийцсэн хамтын ажиллагаа гэж үзсэн бол Ж.Ж.Руссо шударга ёс, хууль дээдлэх зарчим, “ерөнхий хүсэл зориг” (*volonté générale*)-д суурилсан улс төрийн зохион байгуулалт л энх тайвны үндэс болно гэж өгүүлдэг. Л.Толстой, М.Ганди нар энх тайвныг хүчирхийлэлгүй замаар хэрэгжүүлэхийг уриалж байв.

Иймээс философи нь зөвхөн онолын судалгаа төдийгүй, энх тайвны үзэл санааг нийгмийн ухамсарт гүн суулгах замаар бодитой өөрчлөлтийг бий болгох, энх тайван хэмээх үүрдийн үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг салбар юм. Тэр ч утгаараа эл өдрийг НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага ЮНЕСКО болон ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс Философийн хүрээлэнтэй хамтран тэмдэглэж, “Энх тайвнаар зэрэгцэн оршихуй: Орчин үе ба Монгол” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, энэхүү үйл ажиллагаагаар нийгэмд энх тайвны ойлголт, тэгш байдлын үнэт санааг түгээх, ирээдүй хойч үеийн хүмүүжилд эерэг хувь нэмэр оруулахыг зорьж байна. Энэхүү үйл ажиллагааг зохион байгуулж байгаа нь хүн төрөлхтний язгуур үнэт зүйл болох харилцан хүндлэл, эв нэгдэл, зэрэгцэн оршихуй, тэгш боломжийг дэмжих, хүн хоорондын ойлголцол, нийгмийн шударга ёс зэрэг энх тайвны үндэс суурийг түгээн дэлгэрүүлэх, дэмжих цогц оролцоог бий болгох чухал алхам болж байна. Бид энэхүү хурлаараа энх тайвнаар оршихуйн түүхэн туршлага ба соёлын өв, орчин үеийн сорилт ба боломж, хамтын ажиллагаа ба олон улсын харилцаа, энхийг сахиулахуй, батлан хамгаалах бодлого дахь энх тайвны үзэл санаа, боловсрол, ирээдүйн чиг хандлага зэрэг асуудлуудыг судалж, хэлэлцэхэд чиглэж буй болно.

Мөн энэ жил ЮНЕСКО-оос Олон улсын энх тайвны өдрийг тохиолдуулан “Амар тайван дэлхийг үйлдлээрээ бүтээе” (Act Now for a Peaceful World) уриатай зохион байгуулж буй билээ. ЮНЕСКО-ийн Нийгэм, Хүмүүнлэгийн Шинжлэх ухааны салбар нь мэдлэгийн янз бүрийн салбарыг нэгтгэсэн олон талт арга хэмжээг хэрэгжүүлэхийг санал болгодог бөгөөд эдгээр өдрүүдэд иргэд, олон нийтийг энх тайван, хүчирхийллээс ангид, тэгш байдал, хүний эрхийн төлөө бодитой үйлдэл хийхийг уриалжээ. Дэлхийн зарим хэсэгт, үймээн самуун, тодорхойгүй байдалтай энэ үед хүн бүр санаа бодлоо бодитой үйлдэл болгож, энх тайвны төлөө идэвхтэй оролцох нь чухал гэдгийг онцолжээ. Одоо үйлдэл хийх олон арга бий хэмээн ЮНЕСКО-оос уриалж байгаа бөгөөд энэхүү эрдэм шинжилгээний хурал нь Философийн хүрээлэнгийн соён гэгээрүүлэх үйл ажиллагааны нэг хэсэг болж, нийгэмд энх тайвны ойлголт, хүмүүнлэгийн үнэт санаа, эв нэгдлийн зарчмыг түгээх бодит үйлдлийг илэрхийлж байна.

Олон улсын энх тайвны өдрийг тэмдэглэх, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисс болон илтгэл хэлэлцүүлсэн эрдэмтэн судлаач, хуралд оролцсон эрхэм та бүхэндээ гүн талархал илэрхийлье.

*ШУА-ийн Философийн хүрээлэнгийн
захирал, доктор (Ph.D), профессор
Б.Пүрэвсүрэн*

«ҮНДЭСТНИЙ НАМТАР ЦАДИГ» ХЭМЭЭХ АСУУДАЛД

Б.ДАШ-ЁНДОН

Доктор (Sc.D), профессор.

ШУА-ийн Философийн хүрээлэн

Түлхүүр үгс: Үндэстэн, Үндэстний намтар, Үндэстний сэтгэл, Үндэстний адилсахуй, Монгол үндэстэн,

Хураангуй утга: үндэстэн агаад түүний сэтгэлийн нь түүхийг тусгайлан гаргаж үндэстний адилсахуйн асуудлыг монгол үндэстэнтэй холбогдуулан шинжлэх нь

Тус эрдэм шинжилгээний хуралд оролцож, илтгэл номоо айлтгаж буй Та бүхнийхээ амар амгаланг айлтгаж, сайн сайхны ерөөл өргөн дэвшүүлье.

Үндэстэн оршин тогтнож, хөгжин цэцэглэхүйн асуудал ертөнц дахинд өрнөж буй геополитиктой салшгүй холбоотой.

«Үндэстэн» хэмээх бодит үзэгдлийн талаарх төсөөлөл хоорондоо нийтлэгдүү амьдралтай хүн ардын өвөрмөц мэдрэмжээс нийгэм шинжлэлийн нэр томьёо, улстөрийн бодлого дахь тодорхой ухагдахуун болтлоо судлагдаж иржээ.

Тухайн цагтаа “дэлхийг дахин хуваан колончлох” гэсэн Өрнийн империалист гүрнүүдийн бодлого, үйлдэл буурай улс орнуудын хүн амыг бүүр **үндэс угсаагаар нь** хүртэл хүчээр хөнөөн устгах аюул учруулах болсон тул «үндэстний асуудал» дэвшилтэт сэтгэгчдийн анхаарлыг татах болсон байна. Үндэстний асуудалд эхэндээ гол нь Марксчид (К.Маркс, В.И.Ленин) ихээхэн анхаарчээ. Тэдний зүгээс, энэ асуудлаар, багагүй судалгаа хийгджээ. Энэ тухайд нуршилгүйгээр, цаашилсан судалгааны байдлыг тоймлон ажиглаваас, миний бодлоор, «үндэстнүүд»-ийн асуудлаарх судалгаанд, болзмол байдлаар хэлбэл, “субъективжсэн”, “объективжсон” гэсэн хоёр янзын чиг хандлага гарчээ.

Субъективжсэн (ухамсар бүхий объектийг ухамсарлал талаас нь голлосон) судалгааны дүнгээс зарим санаа гарч байжээ:

- Үндэстэн бол “нийтлэг хувь заяанд үндэслэсэн нийтлэг зан төрхөөрөөр холбогдсон хүмүүсийн нийлбэр юм (Австрийн Отто Бауэр);
- Үндэстэн бол “нийтлэг бүлгүүдийн өнгөрсөн ба одоогийн хувь заяаны хамгийн чухал хэсгүүдийг ухамсарлах явдал мөн (Америкийн социологич У.Коннор);
- “Үндэстэн бол дан ганц хүсэл зоригийн асуудал мөн” (Баруун Германы онолч К.Шмидт);
- “Үндэстэн бол зохиомлоор бий болгосон нийтлэг мөн” (Америкийн социологич Р.Баркет);
- “Үндэстэн бол нийтлэгээ ухаарах субъектив мэдрэмж, нийтлэг хувь заяаны мэдрэмж юм” (Израилын профессор Этингер) гэх мэт.

Эдгээрээс О.Бауэр, У.Кроннер овор, К.Шмидт, Этингер нарын санаа үндэстэн **сэтгэл санаандаа** бодож явбал зохих зүйлийг, эсхүл үндэстэн өөрийгөө ухаарч, өөрийгөө авч явах, хамгаалах сэтгэлтэй байхад холбогдсон чухал санааг гарган авч болно.

Тэгэхдээ дараах зүйлийг тусгайлан хэлэх хэрэгтэй: хэрэв үндэстэн зөвхөн “хувь заяандаа” эсхүл “дан ганц хүсэл зоригтоо” эсхүл “субъектив мэдрэмждээ” найдаж өөрийгөө авч явна гэвэл оршин тогтнох нь хязгаарлагдмал болно. Бүүрч, “үндэстэн бол зохиомлоор бий болгосон нийтлэг” хэмээхийг дагавал “Үндэстэн”-д оршин амьдрах ямар ч найдвар, ирээдүй байхгүй болно.

Ингээд үзэхлээр, “үндэстэн”-ний асуудлыг судлахдаа зөвхөн иймэрхүү явцуу санаануудаар хязгаарлавал дутмаг болно. Юу гэвэл, “үндэстэн”-д бас хайрлаж, хамгаалж, өөрийнхөө **биет хэсэг** гэж бодож явах ёстой өөр зүйл ч бодитойгоор бий. Энэ нь, “үндэстэн”-ийг: тодорхой нутаг дэвсгэр, нийтлэг эдийн засгийн амьдрал, нэгдмэл хэл яриа, нэгдмэл соёл, өөрийн төр засаг гэсэн таван шинжээр хамт **тодорхойлох** ёстой гэсэн объективжсон дүгнэлт юм. Эндээс л үндэстний

олон талт бөгөөд хоорондоо авцалдсан дан ганц субъектив бус, **нэгдмэл мэдрэмж** үүсдэг. Энэ бол арвин баялаг мэдрэмж бөгөөд үндэстний **сэтгэлийн цадиг түүхийн асуудлыг** үүсгэдэг аж.

Үндэстний асуудлаарх дээрх олон тодорхойлолт-дүгнэлтийг баримжаа болгон **монгол үндэстэн** дээрээ буулгаж, үүнийгээ дагалдуулах маягаар үндэстний намтар цадгийн асуудал гэж юу вэ? гэдэг талаар цөөн санаа хэлье.

Богд Чингис хаан одоогийн Монгол нутаг дахь эсгий туургат угсаатнуудыг нэгтгэн нэгэн дээвэр доор оруулсан түүхэн аугаа үйлсийн дунд **монголчууд маань үндэстэн** болж төлөвшсөн билээ. Юу гэвэл, монголчууд тэр үедээ нэгдсэн газар нутагтай, нэгдмэл захиргааны төртэй, ерөнхийдөө нэгдмэл хэлтэй, нэгдмэл соёлтой, улс гүрнээ дамнасан шуудан холбооны нэгдсэн сүлжээтэй, нийтээр дагаж мөрддөг хууль цаазтай, нэгдмэл аж төрөх ёс бүхий **хүмүүсийн нийтлэг** болж нягтран төлөвшжээ.

Үндэстний ийм нийтлэг талууд нь түүний ерөнхий **нэгдлийг** буй болгодог. Үндэстэн бол гишүүд нь үеэс үед, өөртэйгөө адил хүмүүсийг төрүүлж өсгөж хамтач ёсоор аж төрдөг нийгэмшсэн “хамт олон” юм. Эл “гишүүд” нь хамтын хүч чармайлтаараа үндэстнийхээ оршин тогтнож амьдрахуйг хангадаг. Монголынхоо нөхцөл дээр авчирж хэлбэл, “монгол үндэстэн” бол **монгол хүн, Монгол Улсын иргэн** гэдэг ойлголтуудын нэгдмэл, шүтэлцээ юм.

Энэ хувьд, эхэнд тодруулж хэлбэл, Монгол Улсын Үндсэн хуульд “монгол үндэстэн” гэдэг илэрхийлэл шууд хэллэгээрээ байхгүй боловч “ард түмний эв нэгдэл”, “Монгол Улсын уугуул иргэн”, “үндэсний эв нэгдэл”, “үндэсний эдийн засгийн аюулгүй байдал”, “мал сүрэг бол үндэсний баялаг”, “үндэсний болон хүн амын аюулгүй байдал”, “үндэсний цөөнх” гэсэн хэллэгүүдээр оржээ. Эдгээр хэллэг нь, цаанаа **“монгол үндэстэн”**-ий амьдрал, ахуйн асуудлыг тэмдэглэж буй хэрэг гэдэг нь илэрхий амой.

Цаашилбал, “үндэстэн” **дотогшоо ч, гадагшаа ч** адилсдаг. Тодруулбал, үндэстний “гишүүн” бүр нь өөрийгөө өөрөө би “тэр” (жишээ нь монгол үндэстэн гэж) хэмээн ухамсарлаж явдаг, энэ бол, дотоод юмуу **дотогшоох** адилсал юм. Бас үндэстний “гишүүн” бүр нь бусдыгаа өөрийнх (манайх) гэж, бусадтайгаа нэгдмэл гэж ухаардаг, энэ бол гадаад юмуу гадагшаах адилсал юм.

Үндэстний **намтар цадиг** гэдэг нь тухайн үндэстэн энэ бүх нийтлэгээ хайрлан хамгаалж оршин тогтнох, өөрөө хөгжиж өөдлөхүйтэй холбоотой сэтгэлийн түүхийн асуудал юм. Энэ нь “үндэстэн” өөрийгөө ухамсарлах, өөртөө хандах бодит мэдрэмжийг үүсгэдэг. Энэ талаар Италийн Коммунист Намыг үндэслэгч (тус нам 1921 онд байгуулагдсан), их сэтгэгч Антонио Грамш (1891-1937)-ий бичсэнээс үндэс авъя. Тэрвээр, фашистуудын байгуулсан хэрцгий шоронд сууж байхдаа «Шоронгийн дэвтрүүд»^{*} хэмээсэн тэмдэглэлүүд бичсэн бөгөөд түүндээ **«Түүх бол үндэстний намтар»** гэж нэн даацтай бөгөөд гүн утга санаа бүхий бэсрэгхэн үгүүлэл оруулжээ.

Тэрбээр эндээ, **үндэстний намтар** хэмээх тусгайлсан сэдэв гарган судлах нь **түүх бичихүйн** нэгэн арга бөгөөд ийм арга үндэстний мэдрэмж бүрэлдсэнээр үүссэн; «энэ арга бол өргөн түмний дотор байдаг, цогцолбороороо үндэстний мэдрэмжийг бүрдүүлдэг чухам тийм эд эсүүдийг эвд оруулан зохицуулж бэхжүүлэхэд зориулагдсан **улстөрийн зэмсэг** юм» хэмээжээ. Ингэхлээр үндэстний мэдрэмжийг бүрдүүлдэг эд эсүүд байдаг, тэдгээрийг судлан эвд буюу нэгэн чигт оруулах нь **улс төрийн зэмсэг** болдог байна.

Цаашилбал, А.Грамшийн бичсэнээр, судалгааны « энэ арга нь: **нэгд**, ямагт оршин байж, түүндээ хүрэхийг зорьдог авч гадаад хүчний хөндлөнгийн оролцооноос, эсхүл дотоод хүчин хараахан “зүйрмэглэж” буйгаас хамааран ил тодоор илэрч, бэхжиж чаддаггүй байсан тэр зүйлийг уудлан гаргадаг; **хоёрт**, энэ арга ард олны сэтгэлийн түүхийг өнгө ялган зураглах замыг нээдэг»¹ ажээ.

Энд хэлэгдэж буй хоёр зүйлийн **нэгдэхийг** нь Чингис хааны эзэнт гүрнээс хойшхи түүхэндээ **монгол үндэстэн** маань нилээд хугацаанд туулж өнгөрөөсөн билээ; харин одоо монгол үндэстэн “ямагт оршин байж, түүндээ хүрэхийг зорьдог байсан” сэтгэлээ хэнээр ч хаалгахгүйгээр хөгжил цэцэглэлтээрээ ханган биелүүлэх бүрэн боломжтой болжээ.

^{*} Антонио Грамши. Тюремные тетради. М., 1959.

¹ Дурдан буй ном, с.341.

Дээрд дурдсан эшлэлийн **хоёрдахь** санааны үүднээс бодвол, үндэстэнд **сэтгэлийн түүх** гэж байдаг, үндэстний түүх цадигийг чухам эндээс эрж хайвал тус түүхийг өнгө ялган зураглах зам харагддаг байна. Үндэстний **сэтгэлийн түүхэн дэх өнгө ялгарсан зам** гэж юу вэ? Энэ тухай дахь санаагаа А.Грамши тухайн цагийнхаа Итали орон дээр буулгаж «Итали орон бол ээж, бүх италчууд түүний “хүүхдүүд”..., ээжийн намтар нь үнэний замаас хальтарч эвдэрч завхарсан хүүхдүүдэд нь сөрөг буй “сайн хүүхдүүд”-ийн хамтын намтар юм»¹ хэмээн илэрхийлжээ.

Ингэхлээр, үндэстний сэтгэлийн намтар хэмээх нь эх орондоо хандахуйн “эвдэрч завхарсан” болон үүнд сөрөг буй “сайн сэтгэл”-ийн хамтын намтар, эх орных нь түүх ажээ. Дайсанд бууж өгөх, эх орноосоо урваж шарвах, улс орноо цөлмөн тонох эсхүл эх оронч хатуу чанга байх, үндэстний жинхэнэ эв нэгдлийг сахин хамгаалах сэтгэл гэсэн сөргөлдсөн чиглэлүүдээр үндэстэн сэтгэлийн **“түүхээ бүтээдэг”** байна. Монгол хүний “сэтгэлийн өнгө” би **монгол үндэстэн** шүү гэсэн ухаан бодлоор гялалзаж байх ёстой.

Антонио Грамши “үндэстний намтар цадигийн тухай” дахь **хийсвэрлэсэн баясалгалаа** бататгах үүднээс, түүхийг (улс орны) бичих ийм арга суртал ухуулгын шинжтэй боловч бас цаанаа бодолцох зүйл олныг агуулдаг, гол нь улс орны доторх сөргөлдөгч хүчнүүдийг нэгтгэх асуудал энд холбогдоно гэж үзжээ. Түүний хэлж буйгаар, «ухаандаа, яагаад Напалеон өөрийгөө Францын эзэн хаан гэлгүй **францчуудын** гэв, үүн шигээр Луй Филины өөрийгөө **францчуудын** ван гэж нэрлэв. Энэ нэрлэлт нь үндэстэн-ард түмний гэсэн гүн гүнзгий шинжтэй бөгөөд шийдвэрлэх учир холбогдол нь нутаг дэвсгэртээ бус, хүмүүсдээ байна гэсэн үг юм»² гэжээ.

А.Грамши энд хүмүүсийг оршин амьдардаг газар нутгаас нь салган хэлж буй мэт боловч энэ нь **үндэстний агаад түүний сэтгэлийн нь түүхийг** тусгайлан гаргаж үзэх гэсэн **хийсвэрлэн бясалгахуйн арга** юм. Гадаадад оршин сууж, ажиллаж, амьдарч буй манай монголчууд улсынхаа нутаг дэвсгэрээс алс хол байвч **монгол үндэстэн** гэдгээ бүх сэтгэл санаагаараа мэдрэн сэтгэж биеэ авч явж байх учиртайг эндээс ч ухаарах ёстой.

Антонио Грамши дурдагдан буй номондоо «**Үндэстэн төлөвшин хөгжихүй дэх улстөрийн удирдлагын асуудал ба орчин үеийн Итали улсын байдал**» сэдэв гаргаж түүхчлэн бичжээ. Энэ сэдвээс ч ургуулан бодоход: «Үндэстэн» өөрийгөө хөгжүүлж, **үндэстэн** гэдэг **сэтгэлээ** бадраан авч явахад тухайн улс орны улстөрийн удирдлага нь чухал үүрэгтэй ажээ. Тэрбээр энэ үгүүлэлдээ, үндэстний өөрийн ухамсрыг төлөвшүүлэхэд, наад зах нь, **улстөрийн намуудын бодлого**, үйлдэл чухал үүрэгтэй хэмээн үзсэн нь **практикийн** хувьд ч их ач холбогдолтой юм. Энэ тухайд түүний хэлж буй нь: “Итали улс өөрөө учраа олно” гэсэн лоозон гаргасан боловч энэ хувьд гол нам нь «тодорхой байр суурьгүй, хулчгар, хоёрдмол утгатай, дээр нь хөнгөмсөг бодлого явуулсан учраас» энэ лоозонгийн утга санаа өөрөө унтарсан төдийгүй, Итали улсдаа ч ихээхэн хохирол учруулжээ.

Их сэтгэгч Антонио Грамшийн бичсэн энэ бүхнээс санаа авч «Монгол үндэстний намтар цадик» гэсэн сэдэв гарган судалж болох юм хэмээн санагдана. Үүний тулд, наад зах нь, дараах асуултууд тавьж хариу хайх хэрэгтэй болно:

- монгол үндэстэн хэдүйд бүрэлдэв?(энэ талаарх санаагаа түрүүн хэлчихсэн);
- монгол үндэстэн яг **үндэстэн** гэдгээрээ оюун санааны хувьд ямар ямар хувьсалд орж ирэв?;
- аж амьдрал, улстөр-эдийн засгийн хувьд туулсан замнал нь монгол **үндэстний өөрийнх нь сэтгэлд** ямар нөлөө үзүүлж байв?;
- монгол үндэстнээ **үндэстэн** гэдэг утгаар нь хөгжүүлэх талаар бид Монголдоо юу хийдэг вэ?;

Миний бие одоогоор өөрөө хариулж чадахгүй байгаа ийм асуултууд тавилаа. Сонирхсон судлаач гарч ирэн хариу хайвал сайнсан.

Гол нь эдгээр асуудалд хариу гаргахад дахиад л дараах асуултууд гарч ирэх буй заа:

- Монголчууд маань **үндэстэн** гэдгээ Чингис богд хааны Монголын болон Монголын эзэнт гүрний үед хэрхэн ухаарч байсан бол?;

¹ Дурдсан ном, с.342.

² Дурдсан ном, с.342

- Манжийн дарлалын үед Монголчууд **үндэстэн** гэдгээ хэрхэн ухаарч байсан бол?;
- Богдыг Монгол Улсын шашин төрийг хослон баригч хаан болгосон тэр үед монголчууд **үндэстэн** гэдгээ хэрхэн ухаарч байсан бол?;
- 1921 оны ардын хувьсгалын үед монголчууд **үндэстэн** гэдгээ хэрхэн ухаарч байсан бол?; (Ямар ч байсан, хүч чадал багатай, тоо толгой цөөн гэгдэж байсан Монгол үндэстэн бие даасан хүчин зүйл болж гадаадын булаан эзлэгчидтэй тэмцэж улс орноо авран чөлөөлсөн билээ. Энэ бол Монгол «үндэстэн» дотроо язгуур угсаа гэгчийг харгалзахгүй нэгдсэн их тэмцлийн дүн байв)
- Бүгд Найрамдах Монгол Ард Улсын үед энэ асуудал ямар байдалтай байсан бол?;
- 1990-ээд оноос эхэлсэн өөрчлөлт шинэчлэлийн үед Монголчууд **үндэстэн** гэдгээ хэрхэн ухаарч байв?;
- Эдүгээ ямар байдалтай байна вэ?

Энэ бүхэн нь судалгааны нэн сонирхолтой агаад судлан үзэхэд онол, практикийн ашиг тус өгөх чухал сэдэв амой.

Миний бие энд учир начиргүй, хий хоосон “үндсэрхэх үзэл” гаргаж яриагүй, харин монголчууд өөрийгөө үндэстэн мөн хэмээн тусгайлан ойлгож үйлдэх тухайд холбогдуулан ярьж байгаа билээ. Энэ бол улс орны **тусгаар тогтнолд** хамаарах сэтгэлийн суудал юм, бас эдийн засаг, улс төрийн асуудал юм.

Бид бол үндэстэн юм шүү гэдгийг ухааруулах үйл хэргийн **жанжин штаб** нь улстөрийн намууд байх ёстой гэж А.Грамши шууд хэлжээ. Үүний учраас бодолцоход, Монгол дахь **улстөрийн намууд** эцсийн бүлэгт **монгол үндэстнээ** хадгалан хөгжүүлэх бодлого баримталдаг байх учиртай болж байна. Чухам үүн дээрээ нэгдэж байх ёстой, үүний тулд монгол үндэстнийхээ цадиг түүхийг мэддэг байвал зохионо. Үүн дээрээ нэгдэж байх ёстой, тэгвэл хэт улстөржсөн элдвийн аар саар маргаан цэгцэрч, нэг зүг рүү орох үндэс суурь тавигдах болно.

Үндэстний эв нэгдэл хэмээх нь тухайн үндэстний улс төрийн зүтгэлтнүүдийн эв нэгдлээс ихээхэн хамаарна. Эв нэгдэл гэдэг бол нэгдэж чаддаг сэтгэлзүйн чадвар юм.

Их Аристотель «Улс төр» зохиолдоо ийм нэгэн зүйл бичжээ: «Төр улс өөрөө бүхэлдээ нэг л эцсийн зорилготой байдаг болохоор бүх хүнд нь нэгдмэл бөгөөд нэгэн адил хүмүүжил хэрэгтэй нь тодорхой, харин эл хүмүүжлийн тухайд санаа тавих нь хувийн биш, нийтийн хэрэг байх ёстой»¹. Энд «төр улс» гэдгийн оронд «үндэстэн» гэдэг үгийг тавьж бодон үйлдэх бололцоотой хэмээн санагдлаа.

Монгол улсынхаа Төрийн дуулал ёсоор:

«Үндэс язгуур, хэл, соёлоо

Үрийн үрд өвлөн бадраа».

¹ Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. Орчуулсан Б.Даш-Ёндон, ред. академич Г.Чулуунбаатар. I боть, УБ., 2021, 592-р тал.

ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ДАЙН БА ЭНХ ТАЙВНЫ АСУУДАЛ

Б.БАТХИШИГ


Доктор (Sc.D), академич

ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Философийн
салбарын эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан,

Худалдаа нь хүн төрөлхтөний үүсэл хөгжлийн эрт үед үүссэн салбар учраас олон мянган жилийн түүхтэй бөгөөд хожим нь худалдаа нэг улс, нэг ард түмний хүрээнээс хальж, улс болон ард түмэн хоорондын худалдаа болон өргөжин хөгжсөн билээ. Манай эрний өмнөх он жилүүдэд Зүүн Өмнөд Азиас Энэтхэг хүртэл үргэлжилж байсан Уттаратагийн худалдааны зам болон Торгоны замын түүх олон улсын худалдааны түүхийг бэлхнээ өгүүлнэ. Усан тээвэр үүссэнээр тив хоорондын худалдаа өргөжиж тэлсэн билээ. Эдүгээ олон улсын худалдаа хуурай зам, агаарын болон усан замаар төдийгүй интернетээр хүртэл хийгдэж байна.

Нэг. Худалдааны онол ба олон улсын худалдааны зохицуулалт

Сонгодог улс төрийн эдийн засгийн ухааныг үндэслэгч А.Смит, Д.Рикардо нар чөлөөт худалдаа, чөлөөт өрсөлдөөн эдийн засгийн өсөлтийг хангадаг болохыг нотолж байв. Тухайлбал, А.Смит бичихдээ “Хэрэв аль нэг гадаад орон ямар нэг барааг биднийхээс хямд үнээр хангаж чадах бол түүнийг өөрийн үйлдвэрийн бүтээгдэхүүний нэг хэсгээр сольж авах нь зөв. Тухайн улсын аж үйлдвэрийн хөдөлмөрийн нийлбэр дүн түүний хэрэглэж буй капиталын хэмжээтэй шууд хамааралтай тул үүнээс болоод багасахгүй. Өөрсдөө үйлдвэрлэснээс хямд худалдан авч болох зүйлийг үйлдвэрлэхэд хөдөлмөр зарцуулах нь ашиг багатай гэдэг нь илэрхий.”¹ гэжээ. Гэвч чөлөөт худалдааны эсрэг протекционизмын урсгал гарч ирсэн бөгөөд импортын татварыг өсгөх замаар дотоодын үйлдвэрлэгчдийг хамгаалах бодлогыг сурталчилж хэрэгжүүлэх болсон. Гэтэл импортын татварыг өсгөх протекционист бодлого нь өнгөн дээрээ үндэсний эдийн засгийг хамгаалж байгаа мэт боловч нийт дүнгээрээ тухайн улсын эдийн засаг, ард иргэдийн амьдралд сөрөг нөлөө үзүүлдэг болохыг эдийн засгийн онол баталсан. Зураг 6-г үзнэ үү.



Зураг 1. Гаалийн тарифын өртөг зардал

Зураг 1 дээр ногооноор будсан В хэсэг нь Засгийн газрын олсон тарифын орлогыг илэрхийлнэ. Энэ нь тарифын хэмжээг импортын нэгжээр үржүүлсэнтэй тэнцүү буюу $4\$ \times 200 = 800\$$. Гаалийн тариф нь үнийг 8-аас 12 доллар болгож өсгөсөн. Ингэснээр дотоодын үйлдвэрлэгчид үйлдвэрлэлээ 300 нэгж хүртэл нэмэгдүүлсэн. Үүний дүнд нийт ашиг 1000 доллараар өссөн, үүнд урьд нь олсон 800 доллар дээр сүүлд 100 нэгжээс олсон 200 доллар нэмэгдсэн. Үүнийг LEHM дүрсээр үзүүлжээ. Харин хэрэглэгчид гаалийн тарифын улмаас өндөр үнэ төлсөн. Үүний дунд хэрэглэгчдийн орлогын үлдэгдэл /consumer surplus/ 2200 доллараар багассан. Үүнийг LMJF дүрсээр харуулжээ. Ийнхүү Засгийн газрын орлого 800 доллар дээр дотоодын үйлдвэрлэгчдийн орлого 1000 долларыг нэмбэл 1800 доллар болох бөгөөд энэ нь хэрэглэгчдийн орлогын үлдэгдлийн бууралт 2200 доллараас 400 доллараар бага байна. Гаалийн тарифын улмаас бий

¹ Adam Smith, An inquiry into Nature and Causes of the Wealth of Nations, MetaLbri, 2007, Book IV, p.350

болсон нийгмийн цэвэр өртөг зардал /net social cost/ 400 доллар болсон бөгөөд үүнийг график дээр А ба С хэсэгт тэнцүү ногдуулж болно. А хэсэг дэх цэвэр алдагдал /200 доллар/ нь дотоодын үйлдвэрлэл гадаадын үйлдвэрлэлээс илүү зардалтай байсантай холбоотой. Гаалийн тариф нэмэгдсэний хүчинд үйлдвэрлэгчид хаасан үйлвэрээ дахин нээж, нэгж бүтээгдэхүүнийг 10 долларын дундаж ахиуц зардлаар үйлдвэрлэснээр 8 доллараар гаднаас авах боломжийг алдсан. График дахь С хэсэг нь хэрэглэгчдийн орлогын үлдэгдэл буурсныг харуулж байна. Энэ алдагдал нь бас 200 доллар болжээ. Гаалийн тариф нь ийнхүү нийт эдийн засгийн үр ашигт муугаар нөлөөлөхийн зэрэгцээ орлогын дахин хуваарилалтад илүү их нөлөө үзүүлдэг. Хэрэв тарифын эдийн засгийн үр ашигт үзүүлсэн сөрөг нөлөө нь 400 доллар бол дахин хуваарилалтад Засгийн газрын тарифын орлого 800 доллар ба үйлдвэрлэгчдийн олсон 1000 долларын ашиг хамаарагдана. Иймд гаалийн тарифыг тогтоох нь эдийн засгийн үр ашигт биш, орлогыг дахин хуваарилах зорилгод илүү чиглэгддэг ажээ.¹

Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийг уламжлан үргэлжлүүлж 1995 оны 1-р сарын 1-нд байгуулагдсан Дэлхийн худалдааны байгууллага /ДХБ/ нь дэлхий дахин дахь улс орнуудын хоорондын худалдааны дүрэм журмыг зохицуулах, худалдааны шинэ хэлэлцээр байгуулах, байгуулагдсан гэрээ, хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэх, гишүүн улсуудаас ДХБ-ын гэрээ, хэлэлцээрийг биелүүлэхийг шаардах, олон улсын чөлөөт худалдааг хөгжүүлэх зорилготой.

ДХБ дараах үүргийг гүйцэтгэнэ гэж ДХБ-ын гэрээнд дурлжээ. Үүнд:

- Энэхүү хэлэлцээр болон олон талт худалдааны хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэхэд туслах
- Гишүүн орнуудын олон талт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулах асуудлаарх чуулга уулзалтын үүрэг гүйцэтгэх
- Маргааныг зохицуулах дүрэм, журмын тухай гэрээ, хэлцлийн талаар захиргааны үүрэг гүйцэтгэх
- Худалдааны бодлогыг дүгнэх механизмын талаар захиргааны үүрэг гүйцэтгэх
- Дэлхийн эдийн засгийн бодлогыг зохицуулах үүднээс шаардлагатай үед Олон улсын валютын сан, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон түүнтэй холбоотой агентлагуудтай хамтран ажиллах.²

Олон улсын худалдаанд дараах зарчмыг баримтлах тухай GATT болон ДХБ-ын баримт бичгүүдэд тусгагдсан. Үүнд:

1. Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим. Энэ зарчим нь нэгд, илүү тааламжтай хандах улс гэсэн дүрэм, хоёрт, үндэсний худалдааны бодлого гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Энэ зарчим нь бараа, үйлчилгээний худалдаа ба оюуны өмчийн эрх зэрэг бүх хүрээг хамрах бөгөөд гэхдээ тус бүрд нь зарим онцлогтой үйлчилнэ. Илүү тааламжтай хандах улс гэсэн дүрэм нь ДХБ-ын гишүүн улс бусад гишүүн улстай хийх худалдааны бүх төрөлд адил нөхцөл тавих бөгөөд тодорхой зарим бүтээгдэхүүний хувьд илүү тааламжтай нөхцөл бүрдүүлэх ёстой болохыг заана. Өөрөөр хэлбэл, тухайн улс өөр нэг улсад худалдааны тааламжтай нөхцөл олгосон бол ДХБ-ын гишүүн бусад улсад уг нөхцөлийг бас адил олгох ёстой.

Үндэсний худалдааны бодлого нь импортын барааны талаар дотоодын үйлдвэрлэлийн бараа шиг адил бодлого явуулахад оршино. Тухайлбал, техникийн стандарт, аюулгүйн стандарт зэрэг тарифын бус хязгаарлалтыг ашиглан импортын барааг ялгаварлах бодлогыг хязгаарлах ёстой.

2. Харилцан үйлчлэх зарчим. Чөлөөт худалдааны хүрээг хязгаарлах гэсэн бодлого ба гадаад зах зээлд илүү сайн гарцтай болох гэсэн хүсэл хоёрын аль алиныг энэ зарчим илэрхийлнэ. Хэлэлцээ хийж буй орны хувьд дээрх хоёр шийдвэрийн аль нэгийг нь гаргахаас олох ашиг тус нь дангаараа гаргах шийдвэрээс илүү өгөөжтэй байх, өөрөөр хэлбэл, харилцан ашигтай байх нь чухал юм.

3. Заавал биелүүлэх үүрэг амлалт авах зарчим. Олон улсын худалдаанд ДХБ-ын гишүүн орнуудын тарифын талаарх үүрэг амлалтыг тусгай жагсаалтад бүртгэн авдаг. Энэ нь тарифын

¹ Б.Батхшиг, Эдийн засгийн ухааны тайлбар толь бичиг, УБ, 2008, т.53

² Agreement Establishing the World Trade Organization, Article III, www.wto.org

дээд хязгаарыг тогтооно. Хэрэв тухайн орон энэ үүрэг амлалтаа өөрчилнө гэвэл худалдааны холбогдох түнштэйгээ хэлэлцээ хийнэ. Тарифыг өөрчилснөөр хүлээсэн алдагдлыг нөгөө хэлэлцэгч тал тавьж болзошгүй. Хэрэв хэлэлцээ амжилтгүй болсон бол гомдол гаргагч тал ДХБ-д хандаж маргааныг шийдэж өгөхийг хүснэ.

4. Ил тод байх зарчим. ДХБ-ын гишүүн орнууд өөрсдийн худалдааны зохицуулалтыг ил тод хэвлэн нийтлэх үүрэгтэй. ДХБ-ын гишүүн бусад улсын хүссэн мэдээллийг гаргаж өгөх, мөн худалдааны зохицуулалтад хийсэн өөрчлөлтийг ДХБ-д мэдээлэх ёстой. Түүнчлэн гишүүн улс худалдааны тайланг тодорхой хугацаанд ДХБ-д гаргаж өгнө.

5. Аюулгүйн хавхагын зарчим. Онцгой зарим нөхцөлд гишүүн улсын засгийн газар худалдааг хязгаарлах арга хэмжээ авч болно. Байгаль орчин, хүн амын эрүүл мэнд, мал амьтны болон ургамлын эрүүл мэндэд аюул занал учирсан нөхцөлд худалдааны хязгаарлалт хийхийг ДХБ зөвшөөрдөг. Худалдааны хязгаарлалтыг эдийн засгийн бус зорилгоор хийх, байгаль хамгаалах арга хэмжээг протекционист бодлогоо халхавчлах зорилгоор авах, шаардлагатай үед эдийн засгийн зорилгоор худалдаанд хөндлөнгөөс оролцох эрх хэмжээг тусгайлан зааж өгсөн байна.

Хоёр. Олон улсын худалдааны дайн

Улс хоорондын худалдааны зөрчил явсаар дайн тулаанд хүргэж байсан түүх цөөнгүй. Тухайлбал, Англи улс 1692 онд Францын бараанд 25%-ийн импортын татвар тогтоосон, харин бусад орны бараанд ердөө 5%-ийн татвар ногдуулжээ. 1696 онд Францын бараанд дахиад 25%-ийн татвар нэмж ногдуулав. Ийнхүү татварыг нэмсээр байгаад дайны өмнө Францын хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн барааны үнийн 75%-тай тэнцэх хэмжээнд хүргэжээ. Ихэнх барааны хувьд энэ өндөр татвар нь тэдгээрийг оруулахыг хориглосонтой адил байв. Франц ч мөн адил Их Британий бараанд бас хатуурхан хандах болжээ.¹ Үүний улмаас 1689 онд хоёр улсын хооронд дайн эхэлсэн бөгөөд 1815 он хүртэл дайны байдалтай байжээ.

Гэтэл ХХI зуун гараад 25 жил болж, дижитал болон квантын технологи, хиймэл оюун хөгжиж буй өнөө үед дэлхийн улс орнуудын хооронд худалдааны дайн үе үе гарч, тэр нь даамжран зэвсэгт мөргөлдөөн, хорлон сүйтгэх ажиллагаа болон хувирч байгаа нь харамсалтай. Хүн төрөлхтөн худалдааны дайнаас сэргийлж, олон улсын худалдаа болон мөнгө, санхүүгийн системийг бүрдүүлэхийн тулд өнгөрсөн ХХ зуунд багагүй зүйлийг хийсэн юм. Тухайлбал, 1948 онд Тариф ба худалдааны ерөнхий хэлэлцээрийг /General Agreement on Tariffs and Trade-GATT/ байгуулж, тариф болон бусад саад тотгорыг үлэмж багасгах, олон улсын худалдаанд ялгаварлан гадуурхах явдлыг арилгах замаар амьдралын түвшинг дээшлүүлэх зорилт тавьсан билээ.

Дэлхийн худалдааны байгууллага улс хоорондын худалдааг зохицуулах гэрээ хэлэлцээр байгуулж, худалдааг хөнгөвчлөх бодлого явуулж байгаа ч сүүлийн үед гадаад худалдааг улс төрийн болон цэрэг дайны сөргөлдөөний арга хэрэгсэл болгон ашиглах нь нэмэгдэж, улс орнуудын хоорондын худалдааны зөрчил улам бүр гүнзгийрч, зарим үед бүр худалдааны дайн болон өргөжиж байна.

Сүүлийн 40 гаруй жил олон улсын зүгээс худалдааны хориг саадад өртөж буй орон бол Иран юм. Иран улс цөмийн зэвсэгтэй болох зорилгоор уран баяжуулж байна гэсэн үндэслэлээр АНУ тус улсын эсрэг худалдаа, эдийн засгийн хориг тавьж эхэлсэн бөгөөд гурав дахь хоригийг 2006 онд тавьсан. Уг хоригт газрын тос, байгалийн хийн болон нефтьхимийн салбарт хөрөнгө оруулахыг хориглох, газрын тосны бүтээгдэхүүний экспортыг зогсоох, мөн банкны болон даатгалын шилжүүлгийг хаах, гадаадын банкууд дахь Ираны мөнгөн хөрөнгийг царцаах зэрэг арга хэмжээнүүд багтсан юм.

Европын холбоо 2012 оноос Ираны газрын тосны экспортод хориг тавив. Үүний улмаас Ираны газрын тосны экспорт 2012 онд өмнөх оныхоос бараг 3 дахин багасч, орлого үлэмж буурч, үндэсний валютынх нь ханш хүчтэй унасан байна. Харин Хятад улс Ираны газрын тосыг тойруу замаар худалдан авч байсан нь түүний эдийн засагт зохих дэмжлэг болжээ.

2016 онд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн гишүүн орнууд болон Ираны хэлэлцээний дүнд тус улсын эсрэг авсан хориг арга хэмжээг сулруулсан боловч АНУ-ын засаг захиргаа 2018 онд


¹ Adam Smith, An inquiry into Nature and Causes of the Wealth of Nations, MetaLbri, 2007, Book IV, p.359

Ираны эсрэг хориг арга хэмжээг дахин сэргээж, юуны өмнө автомашины үйлдвэрлэл, алтны худалдаа, нүүрс, ус төрөгчийн түүхий эдийн экспортыг онилов.

Худалдааны энэ хориг, хязгаарлалт үргэлжилсээр 2025 оны 6 дугаар сард Израйль улс Иран луу пуужин харваж, дараа нь АНУ-ын хүнд бөмбөгдөгч онгоцууд Ираны цөмийн объектуудад цохилт өгөв. Энэ бүс нутагт зэвсэгт мөргөлдөөн, дайн хэзээ ч дэгдэж болзошгүй байдалтай байна.


Худалдаа, эдийн засгийн хүчтэй хоригтой тулгарч байгаа дараагийн орон бол манай хойд хөрш ОХУ юм. 2022 оны 2 дугаар сарын 24-нд ОХУ Украины эсрэг цэргийн тусгай ажиллагаа явуулж эхэлснээс хойш АНУ, Европын холбоо Оросын эсрэг авах хориг арга хэмжээгээ эрс чангатгасан юм. Оросын эсрэг барууны авч буй хориг арга хэмжээ цэрэг улс төрөөс гадна худалдаа, эдийн засаг, банк, санхүү, тээвэр, холбоо зэрэг олон салбарыг хамарч байна.

Ялангуяа газрын тос болон байгалийн хийн худалдаанд хориг тавьж эхэлсэн бөгөөд үүний улмаас Европ руу хийх Оросын экспорт үлэмж буурлаа. Тухайлбал, Европын байгалийн хийн импортын 45%-ийг ОХУ эзэлдэг байсан бол 2024 онд 17.6% болжээ. Дайны өмнө буюу 2019 онд тус улс Европын холбооны улсуудад нийтдээ 179.5 тэрбум шоо метр байгалийн хий экспортолж байжээ. Зураг 2-ыг үзнэ үү.



Зураг 2. Европт байгалийн хий нийлүүлэгч гол орнууд, 2019, тэрбум шоо метр¹

Гэтэл Европын холбооноос Оросын экспортод хориг тавьсны улмаас байгалийн хийн нийлүүлэлт 2024 онд 17.6 хувь болтлоо багасчээ. Зураг 3-ыг үзнэ үү.




Зураг 3. Европт байгалийн хий нийлүүлэгч гол орнууд, %²

¹Key World Energy Statistics, 2021, p.13, www.iea.blob.core.windows.net/assets

² Where does the EU's gas come from? www.consilium.europa.eu, January 7, 2025

Европт нийлүүлэлтээ нэмэгдүүлэхийн тулд Оросын “Газпром” компани барууны зарим компанитай хамтран “Умард урсгал-2” хэмээх байгалийн хийн шинэ магистраль шугам тавих ажлыг 2021 оны намар үндсэнд нь дуусгасан. Түүний урт нь 1234 км бөгөөд жилд 55 тэрбум шоо метр байгалийн хий дамжуулах хүчин чадалтай. Уг хоолойг зөвхөн Балтийн тэнгисийн доогуур тавих зардал 9.5 тэрбум доллар болсон бөгөөд түүний талыг нь барууны 5 компани санхүүжүүлсэн байна. Гэвч уг хоолойг ашиглаж эхлээгүй байхад 2022 оны 9 сарын 26-нд түүний нэг шугамыг дэлбэлэв. Худалдааны дайн том хэмжээний хорлон сүйтгэх ажиллагаа болж хувирав. Уг дэлбэрэлт болохоос хэдэн сарын өмнө 2022 оны 2 сарын 7-нд АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Байден “Хэрэв ОХУ Украинд халдвал “Умард урсгал-2-ыг устгах болно”¹ гэж мэдэгдэж байсан билээ. Зураг 4-ийг үзнэ үү.




Зураг 4. Байгалийн хий дамжуулах “Умард урсгал-2” хоолой²

ОХУ ийнхүү байгалийн хий нийлүүлэх Европын зах зээлийн үлэмж хэсгийг алдаад байна. Харин 2025 оны 9 сарын 2-нд Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нар Бээжин хотноо уулзаж, гурван талын хамтын ажиллагааны тухай ярилцсан бөгөөд түүний дараа ОХУ-аас Монголоор дамжуулан Хятад руу байгалийн хий дамжуулах хоолой тавих тухай меморандумд Оросын “Газпром”, Хятадын CNPC компаниуд гарын үсэг зурлаа. Уг хоолой нь жилд 50 тэрбум шоо метр хий дамжуулах бөгөөд энэ нь Европт алдсан зах зээлээ нөхөх боломж олгох ажээ.

2022 онд ОХУ газрын тосныхоо экспортын 51-54%-ийг Европ руу гаргадаг байсан бол 2023-2025 онд 11-13.5% болж буурлаа.

¹ Biden warns Russia, www.reuters.com, February 12, 2022

² North stream-2, www.wikipedia.com



Зураг 5. ОХУ-аас Европт нийлүүлсэн газрын тосны хэмжээ (2021-2024)¹

Европын холбоо 2022 оны эцэс гэхэд Оросын газрын тосны импортыг 90% хүртэл багасгах, тэгэхдээ тэнгисийн тээврээр газрын тос оруулахыг хориглох, “Дружба” хоолойн хойд салааг хаах, зөвхөн өмнөд салаагаар газрын тос оруулахыг зөвшөөрөхөөр болжээ. Эдүгээ Унгар, Словак, Серб зэрэг улс Оросоос газрын тос авсан хэвээр байна. Зураг 6-г үзнэ үү.



Зураг 6. Газрын тос дамжуулах “Дружба” хоолой²

1960-аад онд баригдсан уг хоолойн Украинаар дамждаг өмнөд салааг одоо ашиглаж байгаа бөгөөд уг хэсэг үе үе дэлбэрэлтэд өртөж байна. Тухайлбал, 2022 оны 11 дүгээр сард уг хоолойг буудасны улмаас ажиллагааг нь зогсоож байсан. 2025 оны 8 дугаар сард тус хоолойг хоёр ч удаа дэлбэллээ. Үүний улмаас Унгар, Словак улсууд газрын тос авч чадахаа больж, Европын комисст гомдол гаргасан бөгөөд хоолойг засварласны дараа нийлүүлэлтийг сэргээсэн байна. Үүнээс үзэхэд худалдааны дайн ба халуун зэвсгийн дайн хоёр үе үе сүлжилдэж, олон улсын энх тайван байдлыг алдагдуулах боллоо. Европын холбоо Украиныг бүх талаар дэмжиж байгаа боловч Украины тал түүний гишүүн хоёр улсын эсрэг ийм хорлон сүйтгэх ажиллагаа явуулж байна.

1978 оноос БНХАУ-д эдийн засгийн шинэчлэл эхэлсэн үеэс хойш тус улсын АНУ-тай хийх худалдаа жил тутам өссөөр ирсэн юм. Хятадын эдийн засгийн хүчин чадал нэмэгдэхийн хамт АНУ руу хийх түүний экспорт улам бүр өсөж, импорт хоцорсны улмаас АНУ-ын

¹ Падение доходов от экспорта нефти, www.lenta.ru, 16 августа 2024 г.

² Нефтепровод “Дружба”, www.ru.wikipedia.org

худалдааны алдагдал өсөж, 2017 оны байдлаар 375.6 тэрбум ам.долларт хүрчээ.¹ Энэ нь Америк, Хятадын худалдааны дайн эхлэх үндэс болжээ.

АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш, Б.Обама нарын үеэс Хятадын зарим бараанд, тухайлбал, нэхмэл эдлэлд ногдуулах гаалийн тарифын хэмжээг нэмэгдүүлсэн нь хоёр улсын хоорондын худалдааны зөрчлийг ил болгосон хэдий ч Д.Трампын үед уг зөрчил хурцдаж, илэрхий дайны шинжтэй болсон юм. Үүний өрнөлийг доор товчлон жагсаав.

- 2018 оны эх. АНУ Хятадын нарны эрчим хүч хураагч хавтанцар, угаагч машин, ган болон хөнгөн цагааны импортын тарифыг нэмэгдүүлэв.
- 2018 оны 3 дугаар сар. Хятадын нийтдээ 50-60 тэрбум ам.долларын өртөг бүхий 1300 гаруй нэр төрлийн бараанд тариф ногдуулах шийдвэр гаргасан. Үүнд нисэх онгоцны эд анги, хэрэгсэл, зай, телевизор, эмнэлгийн хэрэгсэл, хиймэл дагуул зэрэг бүтээгдэхүүн оржээ.
- Үүний хариуд БНХАУ Америкийн нисэх онгоц, автомашин, гахайн мах, шар буурцаг зэрэг бараанд 25%-ийн, жимс, самар, ган хоолой зэрэг бараанд 15%-ийн гаалийн тариф ногдуулахаар шийдэв. Энэ хариу арга хэмжээнд нийтдээ 128 нэр төрлийн барааг хамруулжээ.
- 2018 оны 6 дугаар сар. АНУ Хятадын нийтдээ 50 тэрбум ам.долларын экспортод дунджаар 25%-ийн тариф ногдуулах шийдвэрийг зарлав.
- БНХАУ үүний хариуд бас 50 тэрбум ам.долларын АНУ-ын бараанд тариф ногдуулах тухай мэдэгдсэн.
- 2018 оны 9 дүгээр сар. АНУ Хятадын 200 тэрбум ам.долларын бараанд эхний удаад 10%-ийн тариф ногдуулах, цаашид 25% болгож өсгөх шийдвэр гаргасан нь худалдааны дайн улам ширүүссэнийг нотлов.
- Хятадын эсрэг арга хэмжээ Америкийн нийтдээ 60 тэрбум ам.долларын барааг хамрав. Энэ нь Америкийн импорт Хятадын экспортыг бодвол харьцангуй бага байсантай холбоотой.
- 2019 он. АНУ, БНХАУ-ын худалдааны дайн үргэлжилж, харин 2020 оноос хоёр улсын худалдааны сөргөлдөөн бага зэрэг зөөлөрсөн байна.²

БНХАУ Америкийн худалдааны тарифын бодлогыг эсэргүүцэн Дэлхийн худалдааны байгууллагад гомдол гаргасан бөгөөд 2020 оны 9 дүгээр сард тус байгууллагын 3 хүний бүрэлдэхүүнтэй комисс Трампын засаг захиргаа дэлхийн худалдааны журмыг зөрчсөн гэсэн дүгнэлт гаргажээ. Учир нь АНУ уг шийдвэрийг зөвхөн Хятадад зориулж гаргасан, мөн тарифыг урьд нь тохиролцсон хувь хэмжээнээс хэтрүүлсэн гэж үзжээ. Гэвч АНУ Хятадын талаарх бодлогоо үргэлжлүүлж, 2020 оны 9 дүгээр сард Хятадын хагас дамжуулагчийн томоохон үйлдвэрлэгчид хязгаарлалт тогтоов. Үүнээс үзэхэд Дэлхийн худалдааны байгууллагын чадамж сул байна. Иймд тус байгууллагын үүрэг, эрх мэдлийг дээшлүүлж, улс орнуудын хоорондын худалдааны зөрчлийг газар авахуулалгүй зохицуулдаг болгох шаардлагатай байна. Үүний тулд худалдааны маргаан шийдвэрлэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх бодитой механизмыг олж тогтоох нь чухал юм.

Д.Трамп 2025 оны 1 дүгээр сарын 20-нд АНУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг 2 дахь удаагаа хэрэгжүүлж эхэлснээс хойш Америк ба Хятадын худалдааны дайн дахин ширүүсэв. Тухайлбал:

- 2025 оны 2 сарын 1. АНУ Хятадын бараанд 10%-ийн гаалийн татвар тогтоов.
- Хариуд нь Хятад АНУ-ны нүүрс, шингэрүүлсэн хий зэрэг бараанд 15%-ийн хувийн татвар тогтоов.
- 2025 оны 4 сарын 2. Хятадын барааны татварыг 34%-иар нэмэгдүүлсэн бөгөөд Хятад хариуд нь АНУ-ын бүх бараанд 34%-ийн татварыг нэмж тогтоов.
- 2025 оны 4 сарын 9. Хятадын бараанд 145%-ийн татвар тогтоосноо зарлав.
- Хятад хариуд нь Америкийн бараанд 125%-ийн татвар ногдуулав.
- АНУ хариуд нь Хятадын зарим бараанд 245%-ийн татвар ногдуулна гэж мэдэгдэв.

¹ China-United States trade war, The Free Encyclopedia Wikipedia

² Trade war between the US and China, www.google.com, January 20, 2020

Энэ мэтчилэн тарифын дайн улам ширүүсэж, эцэст нь 2025 оны 5 сарын 12-нд хоёр улсын сайд нар уулзаж хэлэлцээ хийсний дүнд АНУ Хятадын бараанд тогтоосон татвараа 30% болгож бууруулах, Хятадын тал Америкийн бараанд ногдуулсан татвараа 10% болгохоор тохиролцож, 90 хоногийн дараа асуудлыг дахин авч үзэх болов. 2025 оны 8 сарын 11-нээс уг хэлэлцээрийг дахин 90 хоног сунгахаар болжээ. АНУ-д суралцаж байгаа хятадын оюутнуудын визийг хүчингүй болгох сүрдүүлэг хийснээ зогсоосны хариуд Хятад газрын ховор элементийг АНУ-д үргэлжлүүлэн нийлүүлэх болов.

Америк, Хятадын худалдааны дайны гол шалтгаан нь АНУ-ын худалдааны алдагдал нэмэгдэж, улсын өр хурдан өсөж байгаа явдал юм. 2025 оны 9 сарын 11-ний байдлаар АНУ-ын үндэсний нийт өр 37.4 их наяд доллар байв.¹ 2024 онд Америкийн Хятадтай хийсэн худалдааны алдагдал 295 тэрбум доллар болжээ.² Түүнчлэн Хятадын эдийн засгийн өсөлт ба технологийн дэвшил хурдсаж, худалдан авах чадварын үзүүлэлтээр тооцсон хэмжээ нь АНУ-ынхаас давсан явдал үүнд нөлөөлж байна. Олон улсын валютын сангийн тооцоолсноор 2025 онд АНУ-н болон БНХАУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ нэрлэсэн үнээр 30.5 ба 19.2 их наяд доллар бол худалдан авах чадварын үзүүлэлтээр 30.5 ба 407 их наяд доллар болжээ.

АНУ худалдааны алдагдлыг багасгах замаар улсын өрийн өсөлтийг сааруулахын тулд худалдааны гол түншүүдийн бараанд импортын өндөр татвар тогтоох, улмаар тэдгээрийн эдийн засгийн өсөлтийг боогдуулах арга хэмжээ авч байна. Саяхан тус улс Энэтхэгийн бараанд 50%-ийн татвар ногдуулсан нь хоёр улсын харилцааг үлэмж муутгалаа. ОХУ-аас газрын тос худалдан авч боловсруулан бусад оронд худалдаж ашиг олохын зэрэгцээ Украины эсрэг явуулж буй Оросын дайныг санхүүжүүлэхэд тусалж байна хэмээн уг шийдвэрийг гаргасан байна.

Монгол Улсын хувьд гадаад худалдааны хэмжээ өсөж байгаа боловч экспортынхоо дийлэнх хэсгийг БНХАУ-тай хийж байна. Хүснэгт 1-ийг үзнэ үү.

Хүснэгт 1. Экспорт, улсаар, миллион \$³

Улс	2020	2021	2022	2023	2024
Нийт	7576.3	9241.1	12538.6	15186.9	15783.4
Хятад	5493.6	7638.6	11061.6	13940.2	14420.7
Швейцар	1681.6	869.7	1030.7	666.3	745.0
АНУ	10.8	31.0	9.9	36.6	166.4
ОХУ	57.3	112.8	93.4	112.7	100.7
Иран	1.9	1.7	8.0	34.9	66.3

Хүснэгт 2. Импорт, улсаар, миллион \$⁴

Улс	2020	2021	2022	2023	2024
Нийт	5298.9	6845.5	8704.4	9250.2	11614.7
Хятад	1910.3	2520.0	3077.2	3773.3	4672.5
ОХУ	1400.0	1955.2	2611.5	2386.3	2824.8
Япон	406.7	453.2	674.3	716.3	1175.0
АНУ	245.4	213.4	266.1	280.8	535.2
Өмнөд Солонгос	235.8	308.7	424.6	415.2	482.3

Хүснэгт 1 ба 2-т 2024 оны байдлаарх Монгол Улсын худалдааны тэргүүлэх 5 орныг үзүүлэв. Монголын экспортын 91.3% нь БНХАУ-д ногдож байна. Харин импортын 40.2%-ийг БНХАУ, 24.3%-ийг ОХУ, 10.1%-ийг Япон улс эзэлж байна. Монгол Улс БНХАУ, ОХУ гэсэн хоёр том хөрштэй боловч экспортын хувьд ОХУ ердөө 0.6%-ийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл ОХУ-ын том зах зээлийг тус улс ашиглаж чадахгүй байна. Үүнд ОХУ-ын импортын болон нэмэгдсэн өртгийн татвар өндөр байгаа явдал нөлөөлж байна. Тухайлбал, Монголоос мах оруулахад Оросын импортын гаалийн татвар 15%, нэмэгдсэн өртгийн татвар 20%, нийлээд

¹ What is the National debt today? www.pgpf.org/national-debt-clock

² US trade deficit with China, www.google.com

³ Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2024, т.500

⁴ Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2024, т.502

35% болж байна.¹ Ийм нөхцөлд Монголоос ОХУ руу хийх экспортыг нэмэгдүүлэх боломж бага юм.

Харин Монгол Улс ОХУ 2025 оны 6 дугаар сарын 25-нд Евроазийн эдийн засгийн холбоотой худалдааны түр хэлэлцээр байгуулав. Ингэснээр Монголын үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчид 200 сая гаруй хүн амтай, ЕАЭЗХ-ны гишүүн орон болох ОХУ, Беларусь, Казахстан, Киргиз, Армени улсуудад гаалийн татваргүй 367 төрлийн бараа бараа бүтээгдэхүүн экспортлох боломжтой болно. Гэхдээ дотоодод үйлдвэрлэдэг гол нэрийн барааны гаалийн татварыг бүрэн тэглээгүй, харин бага хувиар бууруулахаар тохиролцсон байна. Энэ нь тус улсын гадаад зах зээлийг өргөтгөж, илүүдэл бараа, бүтээгдэхүүнийг экспортлон ашиг орлогоо нэмэгдүүлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг. Монгол хэл дээр:

1. Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2024
2. Б.Батхишиг, Эдийн засгийн ухааны тайлбар толь бичиг, УБ, 2008

Хоёр. Англи хэл дээр:

1. Adam Smith, An inquiry into Nature and Causes of the Wealth of Nations, MetaLbri, 2007, Book IV
2. Agreement Establishing the World Trade Organization, Article III, www.wto.org
3. Biden warns Russia, www.reuters.com, February 12, 2022
4. China-United States trade war, The Free Encyclopedia Wikipedia
5. Key World Energy Statistics, 2021, www.iea.blob.core.windows.net/assets
6. North stream-2, www.wikipedia.com
7. Trade war between the US and China, www.google.com, January 20, 2020
8. US trade deficit with China, www.google.com
9. What is the National debt today? www.pgpf.org/national-debt-clock
10. Where does the EU's gas come from? www.consilium.europa.eu, January 7, 2025

Гурав. Орос хэл дээр:

1. Б.Батхишиг, В.В.Доржиева, Торгово-экономические отношения Монголии и России в условиях меняющейся мировой экономики. “Мировая экономика и международные отношения, 2025, том 69, №1
2. Нефтепровод “Дружба”, www.ru.wikipedia.org
3. Падение доходов от экспорта нефти, www.lenta.ru, 16 августа 2024 г.

¹ Б.Батхишиг, В.В.Доржиева, Торгово-экономические отношения Монголии и России в условиях меняющейся мировой экономики. “Мировая экономика и международные отношения, 2025, том 69, №1, с.80

РЕРИХИЙН ТУНХАГЛАЛ БА ТҮҮНИЙ ДЭЛХИЙ ДАХИН БОЛОН МОНГОЛ УЛС ДАХЬ ӨНӨӨГИЙН ТҮҮХЭН НӨХЦӨЛД ҮЗҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ

М.ГАНТУЯА

*Доктор (Sc.D.), профессор
ШУА-ийн Философийн хүрээлэнгийн
э.ш. тэргүүлэх ажилтан,*

Хураангуй: Энэхүү илтгэлд “Рерихийн тунхаглал” буюу “Пакт Рериха”-г дайны болон энхийн цагт соёлын үнэт зүйлсийг хамгаалахад зориулагдсан анхны олон улсын эрх зүйн баримт бичгийн нэг гэж авч үзэн, түүний олон улсын эрх зүйд эзлэх байр суурь, мөн энхийг эрхэмлэх гадаад бодлого, хүмүүнлэг санаачилга, соёлын хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсад үзүүлэх өнөөгийн нөлөөлөл, ач холбогдлыг онцлон авч үзэх юм. Тунхаглал байгуулагдсан түүхэн нөхцөл, хуулийн заалтууд, хүмүүнлэг эрх зүйн хөгжилд үзүүлэх нөлөөллийг судалснаар, Николай Рерихийн соёл, оюун санааны үзэл баримтлалыг Монголын өнөөгийн улс төрийн бодлогод тусгах, олон улсын түншлэлийг хөгжүүлэх үндэс болгоход тодорхой хэмжээгээр тус дөхөм болох учиртай.

Түлхүүр үгс: Рерихийн тунхаглал, олон улсын хүмүүнлэг эрх зүй, соёлын өвийг хамгаалах, Энхийн бэлгэдэлт туг, Монгол Улс, гадаад бодлого, буддын үнэт зүйлс, соёлын дипломати.

Удиртгал: ХХI зууны энэ үеийн олон улсын зөрчилтэй нөхцөл байдал, улс төрийн хямрал, соёлын дурсгалт зүйлсийг эвдэн сүйтгэж болзошгүй аюул занал - энэ бүхнээс үүдэн соёлын өвийг хамгаалах асуудал нэн чухал болж байна.

Соёл нь тухайн нийгмийн түүх, оюун санааны үнэт зүйлсийн уламжлалыг хойч үед нь дамжуулах үүрэгтэй байдаг тул олон улсын түвшинд хамгаалалт шаарддаг. Монгол Улс нь буддын соёл, нүүдлийн уламжлал, энх тайвны зарчмыг дээдэлдэг улс бөгөөд дэлхий дахинд энхийг бэхжүүлэх, оюуны болон материаллаг соёлын өвийг хамгаалах үйлсэд ямагт анхаарал хандуулж ирсэн билээ. Иймээс “Рерихийн тунхаглал”-д агуулагдсан үзэл санаа нь Монгол Улсын өнөөгийн улс төрийн бодлогод тодорхой хэмжээгээр ач холбогдолтой байгаа юм.

1935 онд байгуулагдсан энэхүү тунхаглал нь дайны болон энхийн цагт соёл, боловсрол, шинжлэх ухааны үйл ажиллагааг хамгаалах заалттай анхны олон улсын тунхаглал юм. Тунхаглалыг санаачлагч, Оросын нэрт уран зураач, философич, түүхч, археологич Николай Рерих нь ХХ зууны эхээр Монголын оюуны болон шашны сэхээтнүүдтэй нягт харилцаж, Азийн ард түмнүүдийг соёл, оюун санаагаар нэгтгэх үзэл санааг дэлгэрүүлж байв.

1. Рерихийн тунхаглал байгуулагдсан түүхэн цаг үеийн эрх зүйн орчин.

Дэлхийн I дайны дараа олон улс орнуудын соёлын дурсгал, уламжлалыг хамгаалахын шаардлага улам тодрох болсон. Николай Рерих нь соёлын үнэт зүйлсийг хамгаалах олон улсын гэрээ байгуулах санааг 1920–30-аад онд боловсруулж байв.

1935 онд АНУ-ын Ерөнхийлөгч Франклин Рузвельтийн оролцоотойгоор Вашингтон хотод 21 Хойд болон Өмнөд Америкийн улс орнууд “Рерихийн тунхаглал”-ыг баталсан. Монгол Улс тунхаглалд гарын үсэг зураагүй ч, тунхаглалын философи нь Монголын буддын соёл, энхийг дэмжих үзэл, соёлын дурсгалыг шүтэх ахуйн үнэт зүйлстэй нийцнэ.

2. Рерихийн тунхаглалын үндсэн заалтууд:

Музей, архив, сүм хийд, шинжлэх ухааны болон шашны байгууллагууд зэрэг соёлын объектуудын халдашгүй байдлыг дайны болон энхийн үед хамгаалах, Эмнэлгийн тусламжийг илэрхийлдэг улаан загалмай тэмдэг лүгээ боловч соёлын хүрээнд хэрэглэгддэг Гурван цагирагт “Энхийн бэлгэдэлт туг”-ийг (Знамя Мира) хамгаалбал зохих соёлын байгууламжуудад байрлуулах,

Нийт хүн төрөлхтөнийг нэгтгэх үндэс суурь болдог соёлыг эрхэмлэн дээдлэх үйл хэрэг нь улс төр, цэрэг дайны ашиг сонирхлоос илүү тэргүүнд хамгаалагдах ёстой гэж үзнэ.

Энэ гэрээ нь 1954 оны Гаагийн конвенци болон соёлын хамгааллын талаарх олон улсын бусад баримт бичгүүдэд суурь болж өгдөг. Монгол Улс Гаагийн конвенцийг соёрхон баталсан орны хувьд Рерихийн тунхаглалний зарчмыг дэмжиж буй гэж үзэж болно.

3. Олон улсын болон Монгол Улсын орчин үеийн нөхцөл дэх Рерихийн тунхаглалний ач холбогдол

3.1. Улс үндэстнүүдийн хооронд зөрчил маргаант үүссэн нөхцөлд соёлын өвийг хамгаалах тухай.

Орчин үед Сири, Ирак, Афганистан, Украин зэрэг газруудад үүссэн зэвсэгт мөргөлдөөнөөс соёлын дурсгалын хамгаалалт хангалттай биш байгаа нь харагдаж байна. Энэ утгаар Рерихийн тунхаглалний ёс зүй болон, эрх зүйн нөлөөлөл улам чухал болж байна. Монгол Улс бүс нутгийн геополитикийн эмзэг нөхцөлд байдаг ч, төвийг сахисан бодлого баримталж, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд идэвхтэй оролцож ирлээ. Соёлын үнэт зүйлсийг хамгаалах нь энх тайвныг тогтворжуулахад зайлшгүй чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж гадаад бодлогодоо энэ зарчмыг баримталдаг.

3.2. Соёлын үнэт зүйлсийг снаатайгаар устгах, хууль бусаар наймаалахын эсрэг үйл ажиллагаа

Археологийн дурсгалт зүйлс, олдворуудыг хулгайлах, хууль бусаар илрүүлэх, түүхэн дурсгалт байгууламжуудыг устгах нь дэлхий нийтийн асар том асуудал болоод байна. Монгол Улс нь сүм хийд, хөшөө чулуу, суварга байгууламж, хот суурины үлдэгдэл зэрэг археологийн болон оюун санааны баялаг өв уламжлалтай орон бөгөөд ЮНЕСКО, Интерпол зэрэг байгууллагуудтай хамтран соёлын дурсгалт зүйлсийг хамгаалахад чиглэсэн идэвхтэй үйл ажиллагааг явуулж ирлээ.

Рерихийн тунхаглалний зарчмууд нь Монголын соёл хамгааллын бодлогод ёсзүйн үндэс болж байна.

3.3. Соёлын дипломат харилцаа ба Монголын “Зөөлөн хүч”-ний бодлого

Соёлын салбар нь Монголын гадаад бодлогын нэгэн гол хэсэг билээ. Олон улсын Буддын соёлын харилцаа, наадам фестиваль, ЮНЕСКО-гийн хөтөлбөрт оролцох зэрэг хэлбэрээр Монгол Улс гадаад харилцааны эерэг хандлагаа үзүүлсээр байна.

Рерихийн тунхаглалний бэлгэдэл болох “Энхийн бэлгэдэл туг”-ны философийн үзэл санаа нь соёлыг “хүмүүний эрхэмсэг чанарын үндэс” гэж үздэг Рерихийн үзэл бодолтой нэгдмэл утгатай бөгөөд Монгол улс энэхүү үзлээр “гурав дахь хөрш”-тэй явуулах гадаад бодлогынхаа хүрээнд улс орнуудтай энэрэнгүй, харилцан хүндэтгэх үндсэн дээр өргөн хүрээний хамтын ажиллагаа өрнүүлэхийг хичээж ирлээ.

3.4. Рерихийн өв Монгол Улсад: соёлын болон оюун санааны харилцаа

Рерихийн тунхаглал нь зөвхөн олон улсын эрх зүйд төдийгүй, Монгол Улс дахь Рерихийн оюуны өв залгамжлалыг илэрхийлэх ач холбогдолтой билээ. Николай Рерих, эхнэр Елена Рерих болон хоёр хүү Юрий Рерих, Станислав Рерих нартайгаа хамт гэр бүлээрээ Орос, Энэтхэг, Төвөд, Монголын хоорондох оюун санаа, соёлын харилцааг бэхжүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон юм.

1920-оод онд Монголд ирээд тэдний амьдарч байсан жижигхэн модон байшинг Рерихийн музей болгох саналыг академич Ш.Бира гарган, нэлээд хүчин чармайлт гаргасны эцэст Улаанбаатар хот дахь Рерихийн музей байгуулагдаж, өнөөдөр ОХУ-ын Санкт-Петербургийн Рерих нарын гэр-музейтэй нягт холбоотой ажиллаж, жилээс жилд үйл ажиллагаа нь өргөжин тэлсээр байна.

Николай Рерих Монгол орныг “амьд оюун санааны орон” гэж үзэж, орчин үеийн хүмүүсийн хэрэглээний прагматик хандлагаар устаж үгүй болоод байгаа соёл, шашин, уламжлал Монгол газраа амьд хэвээр үлдэж хадгалагдсаныг онцолсон байдаг. Түүний хийсэн алдарт “Төв Азийн экспедиц” (1925–1928) нь Монголын газар нутгаар дамжсанаар бүс нутгийн соёлын нэгдмэл байдлыг ойлгоход шинжлэх ухааны чухал түлхэц болсон юм. Тэрээр уран зургийн бүтээлүүддээ Монголын дүр төрхийг тод томруун гаргаж, нийт хүн төрөлхтөний оюун санаанд чухал байр суурь эзэлж байгааг онцлон илэрхийлсэн байдаг.

3.5. Орчин үеийн Монголын Буддын соёл, гүн ухаан судлалд Рерих нарын оруулсан хувь нэмэр.

1960–аад оноос эхлэн Юрий Рерих нь монгол хэл, соёл, гүн ухаан, Буддын судлалаар эрчимтэй ажиллаж, дорно дахин судлал, хэл шинжлэл, орчуулга, толь бичиг, Төвөд-монголын харилцаа, түүх, археологийн чиглэлийн өргөн хүрээний гүнзгий судалгаа явуулж, шинжлэх ухааны үнэ цэнэтэй бүтээл туурвилыг үлдээсэн нь өнөө хүртэл Монголын их, дээд сургууль, судалгааны байгууллагуудад нэн чухал гарын авлага болон ашиглагдсаар байна.

Юрий Николаевич Рерих Монголд орчин үеийн Буддын гүн ухаан судлалын эхлэлийг тавихад ихээхэн нөлөө үзүүлсэн. Энэ нь хоёр зүйлтэй холбоотой: нэг нь түүний шавь, академич Ш.Бирагийн төвөд хэлт эх сурвалжуудыг Монголын түүх судлал нэвтрүүлсэний явдал, нөгөө нь Рерих Барууны эрдэмтэдтэй хамтран Олон улсын Монгол судлалын конгрессийг санаачилж зохион байгуулсан явдал юм.

1969 онд Ю.Н.Рерихийн шавь академич Ш.Бира МУ-ын ШУА-ийн Түүхийн хүрээлэнд судалгаа хийж байх үедээ Буддын судлалын тэнхимийг байгуулж, Монгол дахь орчин үеийн Буддын судлалын шинжлэх ухааны үндсийг тавьсан. Харин 1972 онд энэ тэнхим Философийн хүрээлэнд “Буддын судлалын сектор” нэртэйгээр шилжиж, Буддын философийг судлахад гол анхаарлаа хандуулж эхэлсэн. Ингэж Монголд орчин үеийн Буддын философийн шигнжлэх ухааны судалгаа эхэлсэн юм.

Монголын сэхээтнүүд Рерихийг “соёлын элч” хэмээн хүндэтгэж ирсэн ба түүний “Энхийн бэлгэдэл туг”-ны болон соёлын түгээмэл үнэт чанарыг эрхэмлэх үзэл санаа нь монголчуудын эртний уламжлалт шүтээн - Буддын гүн ухаан дахь үл хүчирхийлэх, зохицон нэгдэх, өвөг дээдсийн билиг ухааныг хүндэтгэх үзэл санаанд шингэсэн юм.

4. Дүгнэлт:

Өнөөгийн Монголд Рерихийн өвийг судлах олон нийтийн сонирхол илэрсээр байна. Тэдний бүтээл туурвил, үзэл бодлыг судлах зорилго их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт туссан байгаагаас гадна соёл-шинжлэх ухааны форум арга хэмжээ, эрдэм шинжилгээний хурал зөвлөгөөнүүдэд хэлэлцэн ярилцаж, нийгэм-хүмүүнлэгийн судалгааны хөтөлбөрүүдэд тусгах уламжлал бий болсон байна. Ийм өргөн утгаар авч үзвэл, “Рерихийн тунхаглал” нь зөвхөн хууль эрх зүйн баримт бичиг төдийгүй, Рерих нарын амьдрал тэмцлийг тусгасан Өрнө-Дорнын соёлын нэгдлийг илэрхийлэх гүн ухааны нэгэн агуу бүтээл болж байна.

Ийнхүү Монголд Рерихийн өв соёл хоёр утгаар уламжилжээ. Үүнд, нэг талаас, соёлыг хамгаалах эрхзүйн баримт бичиг, нөгөө талаас, өмнөх болон хойч хойч үеүүдийн хоорондын, янз бүрийн ард түмнүүд болон олон талт соёлуудын хоорондын амьд гинжин холбоог хадгалан хамгаалахын чухалыг сануулсан оюун санааны дуудлага болж байна.

“Рерихийн тунхаглал”-ыг үүсгэн байгуулснаас хойш бараг нэгэн зуун жил өнгөрсөн ч орчин үеийн дэлхий дахины зөрчилт тогтворгүй нөхцөлд түүний үнэ цэн алдагдаагүй хэвээр байна. Энхийг эрхэмлэх, үндэсний өв соёлоо хамгаалах, соёлын дипломат харилцааг хөгжүүлэхийг зорьж байгаа Монгол Улсад Рерихийн үзэл санааг хууль-эрх зүйн болон түүхийн үнэт зүйл гэж хүндэтгэн дээдлэхээс гадна, нийгэм-хүмүүнлэгийн үйл ажиллагаа, гадаад бодлогын стратегидаа философи үндэс болох чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Рерихийн тунхаглалний зарчим, үзэл баримтлалуудыг Монголын үндэсний болон олон улсын бодлого, хамтын ажиллагаанд нэвтрүүлснээр тэр нь тогтвортой хөгжил, оюун санааны зүг чигийг заах, даяаршлын харилцааны шударга загвар болох ач холбогдолтой болох юм.

НОМ ЗҮЙ

1. Рерих Н.К. Знамя Мира. – М.: Международный Центр Рерихов, 1991.
2. ЮНЕСКО. Охрана культурного наследия в условиях вооружённых конфликтов. – Париж: UNESCO, 2020.
3. Гантуяа М. Рериховское понимание ценности и его современное применение //Доклад на Международной конференции "Мир через Культуру" к 90-летию Пакта Рериха. Санк-Петербург. Апрель 16, 2025 гг
4. Батболд Ж. Монгол Улсын гадаад бодлогод соёлын дипломатийн үүрэг. – Улаанбаатар: МУИС, 2021.
5. Бердяев Н.А. Философия культуры. – М.: Эксмо, 2007.

6. Лувсанвандан С. Культурное наследие Монголии и международное право. – Улан-Батор: ШУА, 2012.
7. Пименов А.Ю. Международно-правовые аспекты охраны культурных ценностей. – М.: Юрист, 2015.
8. Пүрэвсүрэн. Б. Наследие исследования буддийской философии Рерихов в Монголии // Доклад на Международной конференции "Мир через Культуру" к 90-летию Пакта Рериха. Санк-Петербург. Апрель 16, 2025 гг
9. Convention for the Protection of Cultural Property in the Event of Armed Conflict. – The Hague, 1954.
10. UNESCO. Culture in Crisis: Policy Guide for the Protection of Cultural Heritage in Emergencies. – Paris: UNESCO, 2018.

ЭНХ ТАЙВНЫГ ДЭЭДЭЛСЭН УРАН ЗОХИОЛЫН ДҮРҮҮДИЙН ТУХАЙ ФИЛОСОФИ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Б.ГАЛИНДЭВ

*Философийн ухааны доктор,
ОТИС-ийн профессор*

Түлхүүр үг.Дайн, энх тайван, уран зохиол

Улс төрийн харилцааны бодлогоо зэвсэг хэрэглэн үргэлжлүүлж буй улс хоорондын болон нэг нийгмийн доторхи үйл явцыг “дайн” хэмээн товч тодорхойлж болох юм. Хүн төрөлхтний түүхэн эдүгээ хүртэл 4500 орчим дайн болж үүнд 4 тэрбум хүн амь үрэгдсэн түүхтэй. Зөвхөн Дэлхийн II дайнд ЗХУ-аас 25 сая хүний амь нас сүйдэж, мөн ийм хэмжээний айл, өрхөд хагацал өнчрөл тохиолдожээ.

Уран зохиол судлаач доктор (Sh.D),МУИС-ийн профессор Дашлхүмбийн Галбаатар “Уран зохиол нь үг, хэлний “ид шидийг нээн ашиглаж, уран дүрийг зан төрхөөр амилуулж, түүгээрээ хүний амьдралын үзэгдэл, үйлийн нийтлэг түгээмэл, зүй тогтлыг баатрын үйлдэл, хэл яриа, сэтгэл зүй, сэтгэцийн орчилт харилцаа, шилжилтүүдээр үүтгэгдэн үүсэх сэрэл, мэдрэхүй, сэтгэл хөдлөлтэй нийлэгшүүлэн тэрхүү цогцолборын нөлөөгөөр дамжуулан хүний сэтгэлийн дотоод нууц ертөнц рүү нэвтэрдэг үгийн урлаг юм” гэж тэмдэглээд “ Урлаг, уран зохиолд амьдралыг тусган гаргах аргыг дүр гэнэ. Дүр нь зохиолын үйл явдлын өрнөлийн бүхий л явцыг өөртөө тээж, хадгалагч, хөтлөгч хэрэгсэл. Зохиолд ерөнхийг тодорхой хэлбэрээр, зүй тогтлыг үзэгдлийн хэлбэрээр дүрслэх явцад бүтэж бүрэлдсэн хүн, юмс, үзэгдэл, бусад хүчин зүйлсийг бүхэлд нь дүр гэнэ” гэж (Дашлхүмбийн Галбаатар. Уран зохиол. Нэвтэрхий толь. 2012. Т.376,137)тодорхойлжээ

Дайны үйл явцыг урлаг, уран зохиолоор хийсвэрлэн дүрслэж уран сайхны дүр бүтээж , янз бүрийн түүхэн цаг хугацаанд амьдарч буй олон түмэн уншигчдын оюун санаанд урт богино хугацаагаар бичиглэн зурж үлдээдэг уламжлал бүр эртнийх юм. Эртний Грекийн яруу найрагч Гомерийн “Илиаде”, Одессе” гэс эхлээд “Монголны нууц товчоо”гоор дамжиж, орчин үеийн дэлхийн дайны түүхийн уран сайхны дүр дүрслэл, философи сэтгэлгээг тэлж баяжуулсаар ирсэн байна.

1812 онд Наполеон тэргүүтэй Францын эрх мэдэлтнүүдийн өдөөсөн Орос, францын хооронд өрнөсөн дайны хэрэг явдлыг Лев Толстой “Дайн ба энх” романдаа урлан бүтээжээ. “Дайн ба энх”-д хорооны захирагч Андрей Болконский, түүний хайртай бүсгүй Наташа Ростова, гүн Пьер Безухов, Михайл Илларионович Кутузов, Наполеон, байлдааны талбарт амь нас нь үрэгдэж байгаа офицер, эр нөхөртөө хайр сэтгэлээ өгсөн үзэсгэлэнт бүсгүй, их хэмжээний хөрөнгө өвлөж авсан гүн зэрэг баян эр болон уг дайны байлдах урлагийн жолоодогчид болсон цэргийн жанжнуудын дүрийг урлан бүтээсэн байна. Зохиолч уг романаа бичихийн тулд олон сараар архивт сууж I Александр хааны үеийн түүхийн баримтуудыг нэг бүрчлэн нягтлан судлаж, 1812 онд Орос, франц цэргүүд амь өрсөн тулалдсан гол газар нутаг болох “Бородино”гийн орчмоор олонтоо аялан явж судалгаа хийжээ. I Петр хааны тухай түүхэн роман бичихээр олон баримт цуглуулж байсан ажлаа гэнэт зогсоож “ Би өөрийн ойр дотны хамаг таньж мэддэг хүмүүсийнхээ дүрийг “Дайн ба энх” зохиолдоо ашиглачихсан, одоо энэ зохиолоо бичихдээ үлгэр загвар болгомоор зан үйлдлийг нь сайн мэдэх хүмүүс алга байна.Тэгэхээр I Петр хааны тухай роман бичих ажлаа орхиё гэж шийдээд байна”гэж дурсан бичжээ. “Анчны тэмдэглэл”, “Эцэг хөвгүүд”, “Ася” зэрэг алдартай зохиолууд бичсэн Оросын зохиолч И.С.Тургенев (1818-1883) “Дайн ба энх”романы тухай “Энд хэзээ ч өөрчлөгдөхөөргүй бүхэл бүтэн бүлгүүд байна, энд түүхэн бие хүн Кутузов, Расточин гээд олон хүн байна. эдний шинжлүүд туршлагаар тогтоогдсон байна.Энэ бол их зохиолчийн агуу бүтээл болжээ. Энэ бүтээл Оросын жинхэнэ дүр төрх болжээ.Оросын ахуйн ба цэргийн амьдрал гайхамшигтай бичигдсэн байна.Ийм уран чадвартай зохиолч одоохондоо манайд төрөөгүй...Толстойгоос өөр хэн ч Европт ийм хорхой хүрэм, бахархал төрөм бүтээл бичсэн зохиолч алга. Түүний авъяас билгийг

философидолт зүдрээж, ундрааж байжээ” гэж хэлсэн байх юм. Лев Толстойн бүтээлүүдийг олонтоо шүүмжлэж байсан Павел Васильевич Анненков (1812-1887) “Дайн ба энх” романы түүхэн ба гоо зүйн асуудлууд “ гэсэн шүүмжидээ “ түүхэн үйл явдал, баатруудынхаа хувийн амьдралыг гайхамшигтай холбож хослуулж чадсанаараа бусдаас ялгарч байна” гэж тэмдэглэжээ. Европт Вольтер Скотт өөрийнхөө романуудад түүхэн үйл явдлуудыг ямагт нэгдүгээрт тавьдаг байсан бол “Дайн ба энх”-дээ Толстой энэ уламжлалыг эвдэж, баатруудынхаа хувь заяаны түүхэн эргэлтүүдийг тодорхойлж дүрслэхэд л түүхэн үйл явдлуудыг тусган ашиглаж, шингээжээ. М.И Драгомиров (1830-1905 онд амьдарч байсан Оросын цэргийн онолч, уран зохиол судлаач) “Дайн ба энх “ роман цэргийн хүн бүрийн ширээний ном болох ёстой. Цэргийн албанд өөрийгөө зориулсан хүмүүс энэ романаас үнэлж баршгүй практик зөвлөмжүүд олж авах болно. “Дайн ба энх”-д дүрсэлсэн Багритионы дүрийг дарга нарын чин эрмэлзлэл болохоор тодруулан дүрслэж зурсан байдаг гэж тэмдэглэсэн байна.

“Дайн ба энх” роман Орос орны түүхийн нэгэн ээдрээтэй , хүнд хэцүү сорилтын он жилүүд болох 1805-1815 оны үеийнг хамарсан байдаг. Энэ үеийн Орос орны улс төр, нийгмийн түүхийг хамарсан үйл явдлуудын өргөн талбар дээр Андрей Болконский, Безухов гүнгийнхэн, Николай Ростовынхон гээд гурав, дөрвөн язгууртнуудын гэр бүл удам угсаатны түүхэн дүрийг бүтээжээ.

“Хүнд муу муухай хоёр үүсвэр байдаг, энэ бол танхи хүмүүжил, мухар сүсэг хоёр” гэж үздэг өвгөн ноён Николай Болконский “хүнд бас хоёр үүсвэр байдаг, энэ бол үйл ажиллагаа, оюун ухаан хоёр” гэж хүүхдүүдээ сургамжлан өсгөж хүмүүжүүлсэн энэ өвгөнийн хүү Андрей Болконский Москвагаас жирэмсэн эхнэрээ дагуулсаар ирж байна. Өрөөндөө санаашран холжиж нааш цааш алхаж байгаа нь Андрейд дайнд явах нь аюулшмгтай санагдсан уу? , жирэмсэн эхнэрээ орхиод дайнд явж байгаа нь гунигтай бодогдсон уу? аль аль нь л биз (Лев Толстой. Дайн ба энх. УБ.2009. т.126) Хүүгээ дайнд үдэн мордуулж буй аав-ноён Николай Болконский “Хожигддогтүйд чинь , эмийн банзалаас зууралддагтүйд чинь , Юуны өмнө алба. Баярлалаа, баярлалаа. Энэ захиаг Михайл Илларионовчид өгөөрэй. Чамайг олигтой газраа хэрэглэг. Бараа бологч завхарсан ажил байгаа юм. Битгий удаан барь гэж би Би бичсэн... Ямар шүү хүлээж авах нь вэ, надад мэдэгд. Санаа таарвал албыг нь хаа. Николай Андреевич Болконскийн хүү гуйж алба хаахгүй шүү, мэдээ биз... Бодвол би чамаас түрүүлж үхнэ байх... Андрей ноён минь хэрэв чамайг алчих юм бол хөгшин би муугаа үзнэ шүү... гээд гэнэт дуугүй болсноо, Аа хэрэв чамайг Николай Болконскийн хүү шиг явж чадсангүй гэж дуулах юм бол... ичиж үхнэ шүү гэж хашгичлаа” Андрей ноён аавдаа хандан “Танаас гуйх бас нэг юм байна. Хэрэв би алагддаг юм гэхэд, тэгээд эхнэрээс минь хүү гардаг юм гэхэд , миний өчигдрийн ярьдагаар , биенээсээ битгий холдуулаарай, таны дэргэд өсөг тэгэх үү” гэж гуйх хүүгээ “Эхнэрт өгөхгүй гэж үү? гэсэн асуултаар аав нь хариулав” (мөн тэнд.т 91)

Андрей ноён өөрийнхөө хүсэлтээр Кутузовын бараа бологчийн ажлаа өгч байлдааны хороо командлах болов. Аустерлицийн тулалдааны үеэр амь үрэгдсэн эсвэл олзлогдсон эсэх нь тодорхойгүй болоод дайчин нөхдөдөө ихэд үгүйлэгдэж байсан Андрей Болконский ховорхон тохиолдлоор тулалдааны талбар эргэж явсан Наполеонтой ухаангүй хэвтэж байгаад дайралдаж, их жанжны тушаалаар тэдний эмнэлэгт хүргэгдэж амь аврагдаад амьд мэнд буцаж ирлээ. Наполеон Андрейг цэрэг эрийн хийморь золбоог үзүүлж, эрэлхгээр тулалдаж байсан дайчин чанарыг нь өндрөөр үнэлж өөрийнхөө жанжнуудыг сувилдаг эмнэлэгт хүргүүлжээ.

Андрейг гэртээ ирсэн үед төрөх гээд өвдөж байсан эхнэр нь аль хэдийн ухаан тавьсан байсан учраас “нөхрөө олж харлаа ч одоо түүний дэргэд хүрч ирсний учир холбогдлыг ойлгохгүй байв” (мөн тэнд.т 92) Москвагаас залагдсан эмчтэй цуг гэртээ ирсэн Андрейд хүү төрөх, эхнэр нь таалал болох баяртай, эмгэнэлтэй хоёр янзын учрал тохиолдож утгсан юм. Андрей аян дайнаас ирснийхээ дараа гурав хоноод л эхнэрээ ёслол төгөлдөр хүндэтгэлтэй оршуулж, тав хоноод нялх хүүдээ загалмай зүүлгэжээ. Шил даран урагшлах дайсанд хөөгдсөн Андрей ноёны хороо наймдугаар сарны 10-нд Халзан уул руу орох цэцэрлэгт гудамжны шар замаар өнгөрөв. Дайсныг хорсон зүхэх сэтгэлээр бялхсан хорооны захирагч Андрей ноёны дотор бачимдах ч багадаа. “Хорооныхоо ажил үйлсэд хамаг зүрх сэтгэл нь явж, өөрийн цэрэг, дарга нарт санаа тавин тэдэнтэйгээ эелдэг дотно байна. Хорооныхон нь түүнийг манай ноён гэж нэрлэн , түүгээр бахархаж, хайрлаж хүндэтгэнэ.

Ерөнхий командлагч Кутузовтой уулзахаар генерал хувцсаа өмсөж, хамаг одон медалиа зүүгээд зэхэж байсан өвгөн генерал Андрей гэнэт хэвтэрт орж удалгүй таалал болжээ. Андрей ноён аавынхаа нас барсан гунигт мэдээг Кутузовт дуулгахад “Кутузов хирдхийн дүрлийсэн нүдээр Андрей ноён өөд харснаа малгайгаа аван загалмайлан залбирч “ Диваажинд очих болтугай гэж уншив. Тэгснээ цээж дүүрэн гүнээр шүүрс алдаад дуугүй болов. “Би аавд чинь хайртай их хүндэтгэдэг байсан юм даа.Чамайг би үнэнхүү сэтгэлээс өрөвдөж байна” гэж хэлээд Андрей ноёныг тэврэн авч, цээжиндээ нааж удтал тавилгүй зогсов”(мөн тэнд.т 95)

Их бууны ширүүн гал дор цаг хугацаатай өрсөн тулалдаж байгаа Андрей ноёны хороо тэсэн байлдсаар хүмүүсийхээ гуравны нэгийг алдлаа. Андрей ноён гэдсэндээ шархдаж, тэсэхийн аргагүй гол тасрам өвдлөө. Тэгснээ ухаан алдлаа. Андреиг нүдээ нээмэгц дээрээс нь бөхийж байсан эмч уруул дэр нь дуугүйхэн үнсээд шалавхан холдон явлаа. Ван Андреид хайртай Наташа ноёныг нүд салгалгүй сахиж, халамжилна. “Ван Андрей өөрийнхөө үхэх гэж буйг мэдэхээр барахгүй үхэж байгаа, биеийнхээ тэн хагасыг үхчихээд буй гэдгийг ойлгож байлаа. Ертөнцийн бүх юмнаас хөндийрөн салж, хачин амар хялбар, баяртай , байх бодол төрнө.Тулгаран ирж буй зүйлийг яарч түгшилгүй хүлээнэ. Байгааг нь амьдралынхаа бүх хугацаанд мэдрэхээ болихгүй байсан тэр догшин, мөнхийн үл мэдэгдэх, алсын зүйл ойрхны зүйл болж, одоо өөрт нь төрж байсан хачин амар хялбархан бодлоор уг ойртсон зүйл бараг ойлгомжтой санагдах болжээ. Шархадсны дараа анх ухаан ороход өөрийг нь дарж байсан амьдралын дарамтаас суларсан мэт сэтгэл зүрхэнд гэнэт энэ амьдралаас үл шалтгаалах чөлөөтэй мөнхийн дурлалын цэцэг дэлгэрэх мэт болж,үхлээс айхаа нэгэнт больж түүн тухай бодохоо ч больжээ. (Мөн тэнд.т.103)

“Бүгдэд дурлан, бүхнийг хайрлан, хайр дурлалын тулд өөрийгөө хэзээ ямагт золионд гаргана гэдэг бол хэнд ч эс дурлан , энэ ертөнцийн амьдралаар амьдрахгүй гэсэн үг болж байлаа” Андрей үхэлд ойртож очноо ойлгож байлаа.”Дурлал?Дурлал гэж юу вэ? Үхэхэд хайр дурлал саад болно. Хайр дурлал гэдэг бол амьдрал . Би дурлаж байгаа учраас л ойлгож байна. Миний ойлгож байгаа бүхэн хайр дурлал мөн. Бүх юм ганцхан хайр дурлалтай холбоотой .Хайр дурлал бол бурхан мөн. Үхнэ гэдэг бол тэгэхээр хайр дурлалын нэг хэсэг болсон нэр, ерөнхий мөнхийн эх сурвалждаа эргэж очно гэсэн үг мөн гэж бодно”(мөн тэнд.т. 105) Андрей ноён ийнхүү хүний амьдралын мөнхийн зангилаа, амьд ахуй цагийн сэтгэлийн уяа болж, өөрөөсөө гэрэл гэгээ цацруулсан үзэл, ойлголт сэтгэл хөдлөл, хөөрлийн манангаасаа салж чадалгүй орж гарсан бодол, эргэцүүлэлдээ автсаар хүний хорвоог орхиж байна. Дайн ийнхүү үй олон залуусын хайр сэтгэлийн галыг унтрааж, гал голомтыг нь самардагийг Толстой “Дайн ба энх” зохиолдоо дүрслэн үзүүлжээ.

Михайл Илларионович Кутузов бол Сувоовын дараа тодорсон Оросын цэргийн гарамгай жанжнуудын нэг.Тэрбээр 1812 онд Орос орны амар тайван амьдралыг сандааж түрэмхийлэн довтолсон Наполеоны армитай байлдсан Оросын цэргийн ерөнхий командлагч байв. Кутузов жанжин Орос, Австрийн холбоотон бож Францтай хийж байгаа энэ дайнд Орос орон өөрийнхөө оролцоог өөрөөр үнэлээд байгаа юм шиг яриа Австрийн генералд хэлдэг.”Би ганцхан л юмыг давтан хэлээд байгаа юм генерал аа, юу гээд байгаа юм бэ гэвэл хэрэв бүх үйл явдал ганцхан миний хүслээр шийдвэрлэгддэгсэн бол эрхэмсэг эзэн хаан францын хүсэл аль хэдийн биелчихсэн байх байж. Би аль хэдийн эрцгерцогтой нийлчихсэн байх байж.Надад өөрт минь ч гэсэн энэ армийг , надаас илүү мэдлэгтэй, чадвартай генералд дамжуулж өгөөд , өөрөөсөө хамаг хариуцлагыг мултална гэдэг миний хувьд тун баяртай явдал болохсон, чин үнэнээ хэлэхэд тийм генерал Австрид бишгүй элбэг байна.Гэтэл юмны нөхцөл байдал манаас хүчтэй юм.Генерал аа”(мөн тэнд.т.108) Эх орныхоо хувь заяаг шийдэх торгон мөчид үй олон цэрэг эрсийн амь насыг хариуцаж тулалдааны талбарт шийдвэр гаргаж буй командлагч хүн байлдааны ажиллагаа өрнөж буй нөхцөл байдлыг гарын таван хуруу шигээ тод томруун харж, өөрийн болон дайсныхаа талын хүч чадал, байлдах чадвар, туршлагыг цогцоор нь үнэлж дүгнэдэг мэргэн гэмээр стратеги, тактикийн ухаантай байх ёстойг зохиолч ингэж дүрсэлжээ.

Жанжин Кутузов шадар бараа бологчдоосоо эхлээд байлдаанд эрэлхэг зориг гаргасан цэрэг эрчүүдийг дээд, доод , дарга цэрэг гэж ялгалгүй сургаар нь ч гэсэн таньж мэддэг, марталгүй анхаарал тавьдаг зантай хүн байжээ. “Кутузовын царай санаандгүй зөөлөрч нүдэнд нь нулимс мэлтэгнэн солгой гараараа Багратионыг тэврэн баруун гараараа , харанхуйд сурамгай

хөдөлгөөнөөр түүнийг загалмайлан бэцлгэр хацраа ойртуулбал Багратион тэрнийх нь оронд , хүзүүг үнсэв” (мөн тэнд.т. 109) Багратионтой уулзах үед нь санаандгүй орж ирж таарсан Болконскийг таньж ядаад байсан Кутузов “Суу” хэмээн хажуудаа урьж “сайн офицерууд надад өөрт минь хэрэгтэй байна, өөрт минь хэрэгтэй байна гэж дахин дахин хэлсээр Венад юу болж байгааг асууж гарав.

Дайн үеэр янз бүрийн санаа хэлдэг хүн Кутузов жанжинд нэг бус тохиолдож байлаа. Денисов гэгч Кутузовыг байрандаа ирэхэд тосч уулзаад Наполеон Смоленскоос Москва руу явах замыг сэт татаж байлдаад , түүнийг хамаг зам харилцаанаас нь таслах төлөвлөгөөтэй байгаа гэж мэдээлжээ. Фельдмаршал тэр офицерийн танилцуулгыг сонсоод “Энэ бүх хэргээ галд хий гэж чамд үүрд хэлье” гээд зууханд хийхийг тушаажээ. Кутузов энэ байтугай эзэн хааны омтог шийдвэр тушаалыг ч Орос орны хувь заяанд эргэж муугаар нөлөөлөхөөр байвал эрс эсэргүүцдэг жанжин байжээ. Кутузов байлдааны явцын “мэдээлэл сонсож байх үедээ өөрт нь ярьж буй үгний агуулгыг эс сонирхон , мэдээлэгчийн үг ярианы өнгө, нүүр царайны байдлыг сонирхож байгаа юм шиг санагдана. Үхэлтэй тэмцэлдэж буй олон зуун хүнийг ганцхан хүн удирдаж барахгүй, гэдгийг цэрэг дайны олон жилийнхээ туршлагаар мэдэж , настай хүнийхээ ухаанаар ойлгон, тулалдааны хувь заяаг ерөнхий командлагчийн захирамж ч, цэргүүдийн байрлаж байгаа газар ч, их бууны суманд алагдсан хүний тоо ч шийдвэрлэхгүй, харин “цэргийн санаа сэтгэл” гэгч тэр гарт үл баригдагч хүчин л шийддэг гэдгийг мэдэн, энэ хүчийг ажин, өөрийнх нь эрх мэдэлд орж болохын хэрээр нь түүнийг удирдан залж байлаа. Кутузовын царайны ерөнхий төрх бодлогошронгүй, анхаарал нь уужуу тайвуу хөгшин сульдмал биеийнхээ ядаргааг барин биеэ хөвчлөлгүй байх ажээ”(мөн тэнд.т.111) “Тэвчээр, цаг хугацаа л хэрэгтэй дайчин баатар цэргүүд минь” гэж тэр бодно.

Оросын арми зөвхөн эх орноо төдийгүй Европыг аварчээ гэсэн эзэн хааны үгийг цаашдаа Оросын цэрэг Европ руу нэвтэрч байлдах юм байна гэж ухаарсан Кутузов ганцаараа эзэн хааны санааг эсэргүүцэж, шинэ дайн Оросын байдлыг дээрдүүлэхгүй, нэр алдрыг нь өргөхгүй, харин ч байр байдлыг нь дортгож, өөрийнх нь бодлоор Орос орны одоогийн олж авсан дээд зэргийн алдар цууг бууруулна гэж үзсэн байдаг.

Нобелийн шагналт зохиолч Эрнест Хемингуэй “Зэр зэвсэг минь баяртай” романы гол дүрүүдийн тухай эргэцүүлэл

“Зэр зэвсэг минь баяртай” роман 1928-1929 онд бичигдсэн. Америкийн дайны эсрэг сэдэвтэй шилдэг бүтээлүүдийн нэг болж он цагийн шалгарлыг давж, бодит байдлыг дүрслэн зурсан уран сэтгэмж, зохиомж, дэвшүүлж хөндсөн үзэл санаагаараа өнөөдрийг хүртэл уншигч олон түмэнд дэлхийн I дайны түүхэн сургамжийг буухиалан авчирч, оюун санааных нь сэргээш болж уншигдсаар байна. Италийн армид элсэн байлдаж буй Америкийн офицер Генри фредерик Генри , Английн сувилагч Кетрин Баркли болон бусад эмч сувилагчдын дайны үеийн амьдрал тэмцлийн тухай яруу тод өгүүлнэ. Дэслэгч Генри өвдгөндөө хүнд шархдаж , хөл нь хөдөлөхөө больж, өвчтнийг зөөдөг дамнуурга дээр өргүүлсээр эмнэлэгт ирж байна. Генрийг үзсэн мэс засалын эмч Валентин “Чи ч эрүүл ёстой бух шиг , лут амьтан юмаа. Энэ аятайхан хүүхэн юусан билээ. Амраг чинь үү? би тэгэж бодсон юм. Энэ муу хар дайныг дээ. Энд өвдөж байна уу ? гэж Генритэй энгүүн ярилцсаар түүний өвдөгний зургийг үзэж, ийм байж гэсээр мэс ажилбараа эхэлдэг. Валентин эмч энэ олон сайхан залуу эрчүүдийн амь насыг хөнөөж,бие эрхтнийг нь эрэмдэг зэрэмдэг болгоод хаячихдаг дайныг үнэн сэтгэлээсээ үзэн ядаж, заримдаа ч эдгэрч чадалгүй хоёр хөл дээрээ босох хувь заяагаа дуусгаж буй олон өвчитнийг үзэж эмчлээд бүтэлгүй болохын цагт цөхөрч гутаж гуниж байгаа сэтгэлийг зохиолч ийнхүү цөөн үгээр дүрслэн илэрхийлжээ. “Мэс засалын дараа сэрэхдээ юу болсныг би мэдэхтэй байлаа. Арай ч ухаан балартчихаагүй, гагцхүү амьсгаа давхацсан болой. Энэ нь үхэхтэй адилгүй. Юм үнэртүүлж,унтуулахад зөвхөн мэдрэхээ байж, их согтсон хүн шиг болоод ганцхан гашуун юмаар оргиулж дээрдэж өгөхгүй байлаа” гэж Генри өөрийнхөө мэс ажилбарын дараах биеийнхээ байдлыг тандан шинжиж ярьж байна. Сувилагч Гейж “Өвдгий чинь мөн ч бузгай сайн болгосон шүү... Хоёр цаг хагас болсон ” гэж хэлэхүй үг Генрийн чихэнд тун ч ховор,ивээл ээлтэй дуу авиа болж сонсогдлоо. (Эрнест Хемингуэй .Зэр зэвсэг минь баяртай. УБ.1970.т.124,132) Генри, цэрэг Пассини хоёрын хооронд ийм яриа өрнөв. “Бид дайн дуусгах ёстой гэж би бодож байна..Нэг тал нь байдлахаа зогслоо гээд дайн дуусахгүй. Бид байлдахаа

зогсвол бүр ч муу болно” гэж Генри хэллээ. “Муу болохгүй. Дайнаас дор юм байхгүй” гэж Пассини онцлон хэлэв. “-Ялагдана гэдэг бүр ч дор. –Үгүй ч биз. “Ялагдана гэдэг юу юм бэ? Гэртээ харина л биз” гэж Пассини онцлон хэлэв. -Хойноос чинь дайсан очиж, гэр орны чинь эгч, дүүгий чинь авна. –Тэгэх ч үү дээ. Тэгвэл айл болгонд очно. Айл болгон гэр орноо хамгаалдаг. Эгч дүүсээ гаргахгүй байг гэж Пассини хэлэв. “-Чамайг дүүжилнэ. Чамайг барьж дахиж байлдуулна. Гэхдээ эмнэлэгийн тээвэрт биш, явган цэрэгт оруулна шүү дээ” (Мөн тэнд.т.67) Генри ,Пассиних хоёр дайн тухай эргэцүүлэн ярьж, дайн шиг гамшигт, харгис хэрцгий үзэгдэл хүмүүний амьдралд ерөөс байхгүй,, Байлдаж байгаа цэргүүд төдийгүй гэр орныг нь сүйтгэж сүйрүүлдэг ийм аймшигт үзэгдэл хүний амьдралд хэзээ ч үл тохиолдоно гэдгийг нотлон өгүүлж байна. Пассини Генрид хандаж өгүүлэрүүн : Дэглэгч ээ Та сонс л доо. Дайнаас аймшигтай юм ер байхгүй. Бид эмнэлэгийн салбарт байгаа болоод дайны гамшигийг бүрэн мэдэх ч үгүй байна. Дайны аюулыг ойлгосон хүн ийм юманд хутгалдах ч үгүй, хутгалдвал галзуурна.Насандаа ойлгохгүй хүн ч бий. ..Тийм хүмүүс л дайн хийдэг юм” гэж Пассини хэлэв. Дэслэгч –Дайны гамшигийг би мэднэ. Гэхдээ энэ дайныг бид дуусгах ёстой гэхэд Пассини –Дуусахгүй. Дайнд эцэс гэж байхгүй” гэдэг. Өнөөгийн дэлхий дайнтай л байна. Ингээд бодвол Эрнест Хемингуэй улс орнуудын хоорондын эрх ашгийн зөрчил зогсохгүй, ийм зөрчил байгаа цагт хүн төрөлхтөн, улс орнууд эрх ашгийнхаа зөрчлийг дайнгүйгээр шийдвэрлэж чадах энэрэнгүй ёсны ухаан, оюуны чадвартай болох хугацаа лавтайяа XX,XXI зуунд л бүрэлдэн бий болохгүй гэдгийг урьдчилан харж хэлсэн юм шиг дүгнэлт гарна. Яриа цааш өрнөнө.” –Бид сэтгэдэг. Бид уншдаг...тариачид ч гэсэн дайнд итгэх тэнэгүүд биш.хүн болгон энэ дайныг жигшиж байна. – Хэзээ ч юу ч ойлгодоггүй тэнэг анги улс орныг захирч байна. Үүнээс болж бид дайтаж байна” (мөн тэнд.т.68) гэж хэлэв. Генри байлдааны талбараас энгийн хувцас өмсөн оргож, баригдах аюулын дохио дуулагуутаа харанхуй шөнөөр 35 км зайд гараа цэврүүтгэл далайн булангийн усаар сэлж явсаар Швейцарт ирж байна. Кетрин амьгүй хүүхэд төрүүлж, төрөлтийн хүндрэлээс болж амьсгал хураалаа. Сайн дураараа Италийн армид орж байлдсан дэслэгч Генригийн хувь зохиол ийм байдлаар гашуун үйл явдал, гунигт бодол, дурсамжаар төгслөө. Зохиолч өнөө болон ирээдүйд болзошгүй дайны эцсийг үзэхийн хүсэлдээ автаж “Зэр зэвсэг минь байртай” хэмээнх романаа төгсгөсөн юм.

Дэлхийн II дайны түүхийн гамшигт үйл явдлыг Зөвлөлтийн уран зохиол урлан бүтээсэн уран дүрүүдээр үе үеийн олон сая уншигчдын оюун санаанд зураглан үзүүлж мөнхөлсөн юм. Агуу эх орны дайнд Зөвлөлтийн улаан арми, дайчин цэрэг эрсийн алдар цуут зураглан дүрслэж, бие сэтгэлийн хагацал зовлон, шаналал, уйтгар гуниг, эмгэнэлт хувь заяаг нь хуваалцаж ялалтыг нь зарлан мэдээлэхээр 1000 орчим зохиолчид цэргийн сонинуудын сэтгүүлч, сурвалжлагчаар ажилласан мэдээ байдаг.

Нобелийн шагналт, зохиолч М.Шолоховын “Хүний хувь заяа”, “Тэд эх орныхоо төлөө тулалдсан юм”, К.Симоновын “Үрэгдэгсэд ба үлдэгсэд”, “Цэрэг цэргээрээ төрдөггүй”, “Сүүлчийн зун”, гурвал роман, Виктор Некрасовын “Сталинградын нуувчинд”, Ю.Бондеревийн “Халуун цас”, Василь Быковын “Сотников”, С.Смирновын “Брестийн цааз” зэрэг роман, М.Шолоховын “Үзэн ядахын ухаан”, А.Толстойн “Орос зан” зэрэг олон өгүүллэгүүд, Борис Васильевын “Үүрээр”, М.Шолоховын “Хүний хувь заяа”, “Чөлөөлөлт” зэрэг олон кино, жүжиг болон бусад зохиол бүтээлүүдээс өнөөгийн уншигчид 1941 оны 6 дугаар сарын 22-ноос 1945 оны 5 дугаар сарын 9 хүртэл 1418 хоног үргэлжилсэн агуу эх орны дайны дүр зургийг дурсан санаж, заримыг нь дээр нэрлэн дурссан болон бусад зохиол бүтээлүүдийн гол дүрүүдийн амьдралаар амьдарч, өөрийгөө энэ дүрүүдийн оронд тавьж, дайны талбар, ар талд тэдний амсаж эдэлсэн гашуун зовлон, уйтгар гуниг, бие сэтгэлийн шаналал, зовуур, бас ялалтын баяр хөөр, бахархалыг мэдэрч, бодож эргэцүүлж байна. Аугаа эх орны дайны түүхэн үйл явдлыг тодорхой хувь хүний үзэж туулсан байлдааны зам, мөрөөр мөшгин дүрслэн үзүүлж уран сайхны дүр бүтээсэн олон бүтээлүүдийн дотроос К.Симоновын гурвал романыг онцлож байна. Цэргийн сэтгүүлч байгаад намын билетаа алдсны учир жирийн цэргийн томилолт авч байлдааны талбарт ирж буй И.П.Синцов, арми командлагч генерал Ф.Ф Серпилин, цэргийн эмч Таня Овсянникова нарын бие сэтгэлээрээ амсаж туулсан үхэлтэй өрсөн амь тэмцэн тулалдсан байлдааны замын туужис хожмын үй олон уншигчдын сэтгэлийн мухарт эр зоригийн үлгэр жишээ болон хадгалагдан үлджээ. Энэ гурвал роман 1941 оны Москвагийн дэргэдэх

тулалдаанаас эхлээд Сталиградын хориглолтоор дайрч дайны эцэс хүртэл үргэлжилсэн үйл ядвлаар өрнөдөг. Генерал Серпилиний эх дүр танкийн цэргийн хорооны захирагч Кутепов болон бусад хорооны эрэлхэг захирагчид болжээ. Серпилин иргэний дайны үеийн генерал цолтон байв. Хилс хэргээр шийтгэгдэж ял эдлэж байгаад суллагдаж фронт руу илгээгдэж байна. Уран зохиол судлаач Л.А.Финг эх орны дайны үйл явцыг харуулсан зохиолууд дотроос Симоновын гурвал романы Серпилиныг онцлож хамгийн төгс төгөлдөр дүр болсон гэж үнэлжээ. Серпилин дүрээр байлдаж буй цэрэг эрс, түүний дотроос генералуудын сэтгэл санааны хувирал, өөрчлөлтийг бодитой зураглан үзүүлсэн, ийм учраас Симонов зохиолч төдийгүй сэтгэл судлаач байлаа гэж уран зохиолын судлаачид тэмдэглэсэн байх юм. Серпилины байлдааны замд хувийн болоод нийгмийн амьдралын чансаа сорьсон торгон мөчүүд тохиолдож байна. Эрчтэй давшилт хийж, Бугорын өндөрлөгийг эзлэх байлдааны даалгавраа биелүүлэх цаг хугацаатай давхцан эхнэрийнх нь бие муудж, эмнэлэгт үхлийн эрмэгт тулж байгаа хямралын үе зэрэгцэж байна. Генерал байлдааныхаа даалгаврыг биелүүлэхээр зориг хүч, байлдах ура чадвараа шавхан дайсантай нүүр тулан үзэлцэж байхад эхнэр нь амьсгалаа татаж байна. Үрчлэж авсан өнчин хүү Вадим нь цэргийн сургуульд сурч, мэргэжилтэн болоод фронт руу явсан байдаг. Дайн дуусч ялалтын баяр тохиох үеэр Берлинд хүүтэйгээ уулзаж учирах аз тохиодгийн даваан дээр 1945 оны 5-р сарын 08-нд хүү нь амь үрэгджээ. Ийм л урьдаас төсөөлөхийн аргагүй эмгэнэлт учрал тохиолдлоор Генерал Серпилиний байлдааны хагацал, өнчрөл, бэрхшээл зүдгүүрээр дүүрэн амьдрал зурагдаж байна.

М.Шолоховын “Үзэн ядахын ухаан” өгүүллэг онцгойрч уншигддаг бүтээлүүдийн нэг. Өгүүллэг их бууны галд сүйдсэн ой мод, үхсэн герман цэргүүдийн цогцосыг харж зохиолч энэ дайнд эвдэрч сүйтээгүй байгаль дэлхий, амь үрэгдэхгүй хүн гэж ерөөс алга, ухаант хүний хийж үйлдэж буй хамгийн аймшигт бузар хэрэг бол дайн л юм байна гэсэн бодол эргэцүүлэлээр эхэлдэг. Дайны үед олзлогдсон герман цэргүүдийг хооллож ундлаж байх ёстой, хүн болсон хойно ялгаа юу байх вэ? гэсэн итгэл үнэмшилтэй байсан дэслэгч Виктор Герасимов дайсанд олзлогдож хөлдүү газар хоноглож олон хоногийг өнгөрөөж, өлсөн цангаж үхэлтэй нүүр тулж зовж зүдэрсний дараа дайсны цэрэг –харгис хэрцгий герман хүнийг энэрч хайрлах хүнлэг сэтгэл нь аль хэдийн нисэн одож, өөрийнхөө дотор сэтгэлийн үнэнийг уншигчдад хэлж байна. “Би Байлдаж сурсан, фашистуудыг үзэн ядахын хэрээр эх орон, ард түмнээ хайрлах үзэл, итгэлтэй болсон. Энэ үзэл маань хий хоосон хийсвэр юм биш, Миний зан авир, үйлдэл болж хувирсан. Фашистуудыг үзэн ядахын ухаан өсөхийн хэрээр ард түмнээ хайрлах хайр, хүндэтгэл өсч томорсон, юугаар ч сольж болшгүй гүнзгий үзэл, итгэл үнэмшилтэй болсон” хэмээн сэтгэлийнхээ хувьслын өчигийг илэрхийлж байна.

Алексей Толстойн “Орос зан” өгүүллэг ихэд алдартай үе үеийн үй олон уншигчдын сэтгэл санааг байлдан дагуулсан бүтээл юм. Танкчин цэрэг Егор Дремовыг танкин дотроо шатаж үхэх аюулаас механик жолооч Чувилов аварчээ. Егор Дремовын нүд азаар сохорсонгүй, нүүрний бусад эрхнүүд бүгд хүнд гэмтэлд өртжээ. Чих, хамар, уруул, хацар нүүрэнд нь хүнд мэс засал хийж, 8 сар хэвтүүлж, эмчилгээ хийгээд, ядарч сульдсан биеэ тэхнрүүл гэж 20 хоногийн чөлөө өгч ар гэрт нь хариулжээ. Төрсөн аав, ээж нь ч, сэтгэлтэй бүсгүй Катя нь ч огт танисангүй, харин аав, ээж нь дайнд явсан хүүгийнхээ тухай л асууж сураглаад бүр цөхрөөж орхижээ. Егор Дремов “Би төрсөн аав, ээждээ танигдахааргүй болж хүний эрэмдэг болсон амьтан энд байгаад яах билээ. Хурдан л фронт руугаа буцъя гэж шийдээд өөрийнхөө байлдаж буй байсан ангидаа буцан иржээ. Гэтэл хэсэг хугацааны дараа ээжээс нь захиа ирж, “Хүү минь чи манай хүү байсан юм байна шүү дээ. Хүүгээ таниагүй буцаасан нүд муутай аав, ээжийгээ өршөөгөөрэй” гэсэн захиа ирүүлсэн юм.

Нобелийн шагналт зохиолч Имре Кертисийн “Хүн заяа ноогдоогүй нь” бэсрэг романын гол дүр 15 настай Кёвеш Дюри хүү романы эхний хуудснаас эхлээд л уншигчдийн өрөвдөж, энэрэх сэтгэлийг өдөөн дуудаж, өөрийнхөө амьдралын тэсч үлдэхэд хэцүү, сэтгэл санаанд багтамгүй гай гамшигт үйл хэргүүдээр тэднийг цочоон балмагдуулж эхэлдэг. Кёвеш Дюри бол жүүд еврей удам угсаатайнхаа хувьд өсөх наснаасаа гадуурхагдаж Будапешт хотод өсч өндийж яваа нэгэн. Аав нь Герман руу хөдөлмөрийн лагерьт дайчлагдан явж, Кёвеш хүү хойт ээжтэйгээ амьдрах болдог. Миний хүү 7 хоногт нэг удаа өөрийнхөө ээжтэйгээ очиж уулзаж байгаарай. Бусад цагт нь шинэ ээжтэйгээ цуг амьдарч байгаарай гэж захиад аав нь хөдөлмөрийн лагерьт

очиж ажилах албадлагын дайчилгаанд явдаг. Хойт ээжийнх нь ах дүүс “Эр хүний намба зааж дайны хүнд хэцүү цагт хойт ээждээ хань болж амьдрахыг ч бас сургамжлан захидаг байв. Хүү хотын захад байрлах барилгынх ажилд орж мөнгө олж гэр бүлийнхээ амьдралд нэмэр болж эхлэв. Гэнэт нэг өглөө ажилчдын автобусыг шалгаж, хүүг бусад хэдэн хүний хамт ялган авч үлдлээ. Жаал хүү юуны учир ийм үйлдэл болж байгааг ч ухаарах сөхөө байсангүй. Учир битүүлэг байдлаар өдөржин хорьж байгаад шийдвэр гарч галт тэргээр Герман руу илгээдэг юм байна. Вагоны нэг тэвшинд 60-80 хүн чихэн оруулж, хэвтэх байтугай өвдөг нугалж суух ч зайгүй чихэлдэж бүгчимдэж явсаар 3 дахь хоногийнхоо орой Аушвицид авчирчээ. Кёвеш Дюри хүүгийн үеийн хэд хэдэн хүүхэд ачигдаж иржээ. Усанд оруулж, үсийг нь хусч, эмчийн үзлэгт оруулаад ажилд тэнцэх эсэхийг тогтоож хоёр ялгаж, хорих байр болох асар, майханд байрлууллаа. Үсээ усуулсан хүүхдүүд бие биенээ харж инээд алдаад л... Зугаатай ч юм шиг үд өнгөрлөө. Бухенвалд хүргэж ирсэн галт тэрэгний буудлаас явганаар удаан явсаар хорих ангид ирлээ. Бас л усанд оруулж, үзлэг хийж, хэд хэдэн байранд хувааж орууллаа. Газар шорооны хүнд ажилд олон хоног зүтгэсээр сүүлдээ бараг л хүрээ даахгүй болтлоо турж эцлээ. Өглөө болгон махгүй усан шөл, ганц зүсэм талх өгнө. Модон хайрцаг аятай банзан орон дотор орж хоёул унтана. Өглөө, орой тооллого хийнэ. Өдөр ямар нэг хэрэг төвөг гарсан бол шөнө хүртэл унтуулахгүй байх тохиолдол олон. Өглөө аяга кофе уулгаж, 9 цагт тал хэрчим талх өгнө. Өглөөний хоол ингээд гүйцнэ. Модон ултай улавч, хоригдлын эрээн хувцас хөлд хатуу, биед хүйтэн. Бухенвалдын хорих ангиас арай зайтай өмхий хар утаа савсуулсан өндөр яндангууд харагдана. Энэ яндангийн учрыг мэдэх хуучуудын үг ярианаас болж дотор сэтгэлээс нь ямар нэг айдас салахаа больсон Кёвеш хүү ямар ирээдүй өөрийг нь тосч байгааг ч бүрэн ухаарах чадвараа аль хэдийн алджээ. Энэ яндантай зуухнуудад шийтгүүлсэн, өвчнөөр үхсэн, гэмт үйлдэл гаргаж буудуулсан хүмүүсийг шатаадаг юм гэж хүү сонслоо. Лагерьт чех, Литви, Финлянд гээд олон үндэстнүүдийн хоригдлуудтай учирч болно, Хэл мэдэхгүй, ойлголцоход бэрхшээлтэй учир дохио зангаагаар ойлголцох тохиолдол ч олон. Германаар өгсөн команд ойлгох хэд гурван үг мэдэхгүй бол үл ойлголцол амь насанд хүрч болзошгүй. Хүү лагерьт 3 сар болоход ёстой л яс арьс болтлоо туржээ. Гэртээ байхдаа ингэж турна гэвэл лав 50 жил хэрэгтэй болох байх аа гэж хүү төсөөлж бодно. Лагерт байхдаа залбирал үйлдэж бурханд амь насаа даатгадаг Рабби өвгөнтэй ч учирч байлаа. Энэ өвгөн залбиралаа нууж үйлдэнэ. Зарим хоригдол өвгөнд сүсэглэж ном уншуулна. Гэтэл тийм хүмүүсийн отроос байсхийгээд л хэн нэг нь ор сурагтгүй алга болчихно. Нимбэг хэмээх унгар залуу хоригдолтой хамт газар шорооны ажил хийдэг болсон. Нимбэг ах нь эхлээд Унгар хүн яаж ажилладагийг үзүүлнэ гэж яриад л хичээл зүтгэлтэй ажиллаж байснаа гэнэт ухарч ажилласан дүр эсгэж биеэ хямгадахгүй бол амьд гарахгүй юм байна гэж ярих болов. Нэг удаа гал тогоонд ажилладаг найз хүүхэд нь давсалсан төмсний хальс авчирч өгсөн. Түүн шиг амттай хоол идэж үзээгүй юм шиг санагдаж байлаа. Хүүгийн өвдөгөнд хатиг гарч, бугшин сүүлдээ өтсөн байхыг олж үзээд эмчилгээ хийлгэх боллоо. Эмч хатигных нь идээг бүрэн шахаж цэвэрлэхийн өмнө хүүгээс зөвшөөрөл эрэхэд хүү ихэд гайхсан, надаас зөвшөөрөл авдаг хүн бас байдгаа гэж. Франц эмч хүү минь гэж хэлээд ётон өгсөнд бүр алмайрч орхисон. “Хүү минь” гэх урин сайхан үгийг эс сонсоор мөн ч их уджээ. Энэ үгийг бараг мартах дөхснөө хүү гэнэт санажээ. Хүү лагериас чөлөөлөгдөх гурван арга л байна гэж хийсвэрлэн бодох болов. 1-д юуг бодож мөрөөдөж байсан хорьж чадахгүй, иймд лагериас гарч хүний амьдралаар амьдрах, 2-д Оргох энэ ч бүтэхгүй байх, 3 литви хүн оргож яваад баригдаж буудуулсан, 3-д Дахин сэхэхээргүй амиа хорлох гэсэн гурван хувилбар төсөөлж нууцхан бодох болов. Гэнэт лагерьт буудалцаан болсноо чив чимээгүй болсон учрыг хүү нэг л ойлгохгүй байв. Гэтэл Бухенвалд, Аушвицийн хоригдлуудыг Зөвлөлтийн цэрэг ирж чөлөөлсөн юм санжээ. Нутаг явах өдөр ингээд ирдэг байжээ. Нутагтаа ирэхэд ээж нь амьд мэнд хүүгээ хүлээж мэдээ сураг сонсох гэж явсан гэнэ. Хойт эх өөр хүнтэй гэрлэсэн гэнэ гэх сураг сонсдог. Будапешт хотдоо ирээд трамвайн суутал тийз нэхлээ. Би холоос ирсэн мөнгөгүй, миний хөл өвдөөд явган явж чадахгүй болоод трамвайн сууснаа хэлж царайчилж байтал нэг сэхээтэн байрын хүн бидний яриаг хальт сонсоод” Алив би аваад өгье” гээд надад тийз авч өглөө. “Миний хүү Германаас ирсэн үү? Нөгөө бөөгнөрүүлэн хорих лагериас уу?, Мэдээж Хаанаас вэ? “Бухенвальд” жинхэнэ тамын тогоо нь гэж би сонссон.” Чи тэнд тэгээд хир удав?, “Жил болсон” Ийш хүү минь их зовлон үзэж, их юм туулсан байна даа чи... Миний хүү тэнд үзэж

туулсан юмнаасаа жаал ярьж өгөхгүй юм уу? гэхэд би жаал гайхаж , нөгөөтэйгүүр залхаж эхлэн,”Би ч танд нэг их сүрхий сонирхолтой юм юу ярьж чадах билээ дээ . “Үгүй ээ надад биш бүх дэлхийд ярьж өг”гээд өөрийгөө сурвалжлагч гэж танилцуулаад “Миний ярьсан зүйлс цаанаа эрин солигдож буй чухал цагийг толилууллаа гэнэ.Миний жишээ мөн түмэн ийм хувь хүний үер шиг жишээ нь өнгөрсөн цагийн гунигт тамга нь болж хоцорно гэлээ. Намайг энэ талаар юу гэж бодож байна гэж асуухад нь ,би өөрийгөө болгохыг л хичээмээр байна гэж хариулбал “Үгүй ,хүү минь тийм биш, энэ бол зөвхөн чиний хувь хүний хэрэг биш, энэ бол бид бүхний , түүгээр ч зогсохгүй дэлхийн нийтийн хэрэг юм” гэж хэлдэг юм байна. (Имре Кертис.Хүн заяа ноогдоогүй нь. УБ.2005. т.154-155)гэдэг байгаа. Хүү төрөлх хотдоо ирсэн анхны өдрийн дурсамжаа ийнхүү хуваалцаж байна.

“Чи аан гэж бай миний хүү, юуны өмнө бүх аймшигт явдлыг март, цаашдаа амьдрахын тулд шүү, сая үзээд ирсэн муу муухай юмаа бүгдийг март. Сэтгэл зүрхэндээ ийм их ачаатай чи шинэ амьдрал эхэлж барахгүй хүү минь, нээрэн шүү” гэж хэлж буй байрных нь хоёр өвгөний яриаг эргэцүүлж суусан хүү “Шинэ амьдрал эхэлнэ гэж хэзээ ч байхгүй, бид хуучныгаа л цааш үүрч явах болно. Би өөрөө тавилангийнхаа мөрийг гаргасан.Миний оронд өөр хүн тэр замыг туулж өгөөгүй.Би тэр өгөгдсөн хувь заяандаа үнэнч явсан... Нэгэнт зурсан зураг байвал эрх чөлөө гэж байдаггүйг яагаад ойлгохгүй байна вэ?,Хэрэв эрх чөлөө нэгэнт оршдог номтой бол хувь заяа гэж юу байх билээ дээ?” гэж ярьснаа хүү амьсгаа авч “Өөрөөр хэлбэл бид өөрдөө, өөрсдийнхөө хувь заяа байна шүү дээ” (мөн тэнд. 161,164) гэж хэлээд авав.

Дүгнэлт

1. Дайны түүхийг он дараалан бичиглэж үлдээсэн түүхийн ном зохиолтой харьцуулахад урлаг уран зохиол дайны үйл явцыг дүрслэн зураглаж, бичиглэж үлдээдэг учраас тухайн үеийн болон хойч үеийнхний үй олон уншигчдын сэтгэл санааг хөдөлгөн догдлуулж, хөөргөн сэрээж, уншигчид өөрийнхөө дотоод сэтгэлд уран сайхны дүр хийсвэрлэн бүтээж, оюун санаандаа урт удаан хугацаанд хадгалан дурсан санаж, бодож бясалгах өргөн бололцоо олгодоогоороо онцлог, давуу талтай байдаг.
2. Дайны үйл явцыг тодорхой дүр-баатруудаар дамжуулан тусган илэрхийлж уран сайхны дүр бүтээдэг уран зохиол тодорхой хувь хүний бие сэтгэлээрээ эдлэж амсаж буй зовлон, шаналал, хагацал, өнчрөл, уй гашуу, бэрхшээл зүдгүүрийг уншигчид өөрсдийнхөө сэтгэл зүрхээр хуваалцаж, урлан бүтээгдсэн дүрүүдийн оронд өөрийгөө тавьж, тэдэнтэй адилхан хувь заяаны эргүүлгэнд өөрийгөө оруулж, бие сэтгэлийн хатуужил, тэсвэр тэвчээрийн сургуулиар дамжиж өөрийгөө хүнд хэцүү сорилтонд бэлтгэх оюун санааны боломж нээдэг.
3. Урлаг, уран зохиол хүний бие сэтгэлийн хэр хэмжээнээс хэтийдсэн дайны хүнд хэцүү сорилтыг туулж даван ялалтанд хүрсэн бодит хүний тэсвэр хатуужил, бэрхшээл зүдгүүр, зовлон , үхэл хагацал, өнчрөл, уй гашууны тусгал болсон уран сайхны дүрээр дамжуулж, тэдний амсаж эдэлсэн үхэл хагацал, уй гашуу, ялалтын хөөр баясалыг хойч үеийнхэн зүрх сэтгэлээрээ хуваалцаж, тэдний хувь заяаны эргүүлгэнд өөрийгөө оруулж, эх орноо батлан хамгаалах ариун үйлсэд хүчин зүтгэх үзэл, итгэл, үйл үйлдлийн уриа дуудлага болдог.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. Дашлхүмбийн Галбаатар Уран зохиол. Нэвтэрхий толь УБ.2012.
2. Лев Толстой “Дайн ба энх” УБ. Мон суддар. 2009 Ч.Чимидийн орчуулга.
3. Эрнест Хэмингуэй “Зэр зэвсэг минь барятай УБ. 1970
4. Ю.Я.Лидский .Творчество Э.Хемингуэя Киев 1973
5. Б.Галиндэв.Лев Толстойн ертөнц ба хүний асуудал. УБ.2019

МОНГОЛЧУУДЫН ТЭНГЭР ШҮТЛЭГ ДЭХ АМАР АМГАЛАНГИЙН ҮЗЭЛ САНАА THE CONCEPT OF PEACE IN MONGOLIAN TENGRISM

БАДАМ-ОЧИРЫН ГАЛААРИД

Доктор (Ph.D) Монголын тэнгэр Үзэлтнүүдийн
“Мөнх Тэнгэр” хорооны тэргүүн

Рак Mongolica-г монгол хаадаас эзэнт гүрний нутаг дэвсгэр даяар “Их засаг” хуулийг хатуу мөрдүүлэх бодлого тууштай хэрэгжүүлсний үр дүн гэж үздэг. Тийм эмх журам, тогтвортой байдлын үндэс нь монголчуудын Тэнгэр шүтлэг дэх энх тайван, амар амгалангийн тухай шашин-ертөнцийг үзэх үзэлд суурилсныг энэхүү илтгэлд онцолж байна. Мөнх Тэнгэрийн ивээл дор Орчлонгийн жамыг сахиж, хэмыг үл алдуулан зүй зохистой амьдрах тухай үзэл нь хожим Рак Mongolica гэж нэрлэгдсэн тэрхүү улстөрийн практикийн оюун санаа-ёс зүйн суурийг бүрдүүлсэн билээ. Түүнээс гадна “тэнгэризм” хэмээх нэр томъёоны гарал үүслийн асуудлыг хөндөж, орчин үеийн эрдэмтэн судлаачид янз бүрээр тайлбарлаж буйд шинжилгээ хийхийг оролдсон болно.

Түлхүүр үгс: Монголын тэнгэр шүтлэг, Мөнх Тэнгэр, Рак Mongolica, “Их засаг” хууль
Рак Mongolica is generally understood as the result of a deliberate policy enacted by the Mongol khans, enforced through the strict application of the Yassa (“Great Law”) across the vast territories of the Mongol Empire. However, this paper emphasizes that the foundation of such order and stability lay deeper—in the vision of peace and harmony inherent in the Mongols’ belief system of Tengrism. It was this spiritual orientation toward balance and concord under the Eternal Heaven (Mönkh Tenger) that provided the ideological and ethical ground for the policies which later came to be known as Pax Mongolica. The study also briefly addresses the origin of the term “Tengrism” and explores how modern scholars have interpreted and explained this concept.

Keywords: Mongolian Tengrism, Eternal Heaven, Pax Mongolica, Yassa (Great Law).

Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг Монгол Улсын Үндсэн хуулиар иргэддээ нээлттэй болгосон 1992 оноос хойш монгол бөө эрчимтэйгээр дахин сэргэсэнтэй холбоотойгоор Монгол бөө судлалд мэдэгдэхүйц ахиц гарч байна. Тэр дундаа монгол бөөгийн сургаал номлол, ертөнцийг үзэх үзлийн асуудал судлаачдын анхаарлыг татсан сэдвийн нэг болоод байна. Энэ нь монгол бөөгийн сургаал номлолд Амар амгалангийн асуудал хэрхэн туссан бэ гэх асуултад хүссэн ч, эс хүссэн ч хүргэдэг. Энэ асуултад өөрийн хэмжээнд хариулт эрэх нь энэхүү илтгэлийн зорилго болно.

Үндсэн сэдэв маань “Амар амгалангийн үзэл санаа” боловч илтгэлийн нэлээд хэсгийг Тэнгэризм гэдгийг гадаад, дотоодын судлаачид хэрхэн ойлгож томъёолж байгаа асуудлыг нягтлахад зориулах шаардлагатай байна. Учир нь Евразийн өргөн уудам орон зайд нэн эртнээс амьдарч ирсэн нүүдэлчин соёлтой ард түмнүүдийн тэнгэр шүтэх ёсны өвөрмөц шинж, онцлогийг судлах явцад Тэнгэризм гэх нэр томъёо гарч ирсэн бөгөөд энэ чиглэлийн судалгаа нэг голдиролд хараахан орж амжаагүй, орон орны судлаачид өөр өөрийнхөөрөө тайлбарлаж байгаа сэдэв юм.

Тэнгэр шүтлэг нь өвөг монголчуудын үеэс өнөөг хүртэл уламжлагдан ирсэн язгуурын шашин соёлын үзэгдэл бөгөөд шинжлэх ухааны судалгааны эргэлтэд “Бөө мөргөл”, “Бөөгийн шашин”, “Бөө шүтлэг” зэрэг нэршлээр ихэвчлэн илэрхийлэгдэж байгаад сүүлийн үед “Тэнгэр шүтлэг”, “Тэнгэрийн шашин” гэх нэр томъёо давамгайлах боллоо. “Мөнх Тэнгэрийн шашин”¹ гэж томъёолсон нь ч бий. Евразийн нүүдэлчин ард түмнүүдийн тэнгэр шүтэх ёстой холбоотой шашин-соёлын үзэгдлүүдийг олон улсад бүхэлд нь Tengrism (Tengriism, Tengerism, Tengrianism) гэж нэрлэж байна. Уг нэр томъёог 1938 онд финляндын шашин судлаач Уно (Хольмберг) Харва² анх хэрэглэж, францын судлаач Жан Поль Ру³ судалгааны эргэлтэд идэвхтэй оруулсан гэж үздэг.

¹ Гэрэлбаатар, Г. 2001. *Монголын уламжлалт шашин шүтлэг*. Ред Н.Ням-Осор. Улаанбаатар, 176х.

² Harva, U. 1938. *Die Religiöse Vorstellungen der Altaischen Völker*. (Folklore Fellows Communications 125.) Werner Söderström Osakeyhtiö.

³ Roux, J. P. 1956. *Tängri. Essai sur le ciel=dieu des peuples altaïques*. Revue de l'Histoire des religions. CXLIX. No. 1-2: 49-82. CL. No. 1-2: 197-230; Roux, J. P. 1957. *Tängri. Essai sur le ciel=dieu des peuples altaïques*. Revue de

Оросын судлаач Р.Безертинов тэнгэр шүтлэгийг түрэг, монголчуудын шашин гэж тодорхойлоод “Түргүүд буддизм, христосын шашин, исламаас өмнө өөрийн гэсэн илүү эртний, бие даасан шашинтай байсан. Тэр нь сансрын бурхан Тэнгри-г шүтэхүүд үндэслэсэн. Уг үндсээрээ нийтийн тооллоос өмнөх V-IV мянгантай холбогдох Тэнгри-г гол бурхан гэж үзэх евразийн тал нутгийн түрэг, монголчуудын шашны онцлох шинж нь францын шашин судлаач Жан-Поль Ру-д түүнийг “тэнгэрзм” гэх нэр томъёогоор баяжуулах шалтгаан болж өгсөн”¹ гэж тэмдэглэсэн байдаг.

“Евразийн өргөн уудам орон зайд 1500 гаруй жил оришиж, хамгийн том гүрнүүдийн үзэл суртлын үндэс болж байсан шашныг агуу гэж нэрлэхэд хэцүү биш”² гэж Тэнгэрзмийн асуудлаар хэд хэдэн өгүүлэл бичсэн оросын судлаач Григорий Томский дүгнэсэн нь бас бий. Монголын эрдэмтэн судлаачдаас Гүнжийн Сүхбаатар 1980 онд хэвлүүлсэн бүтээлдээ анх “Тэнгэрзм бол хүннүгийн хөгжингүй бөөгийн шашны ертөнцийг үзэх үзэл юм”³ хэмээн тэмдэглэж, академич Шагдарын Бира⁴ 1986 онд Ташкентад болсон Алтай судлалын олон улсын хуралд “К изучению истории культа Тенгри у монголов” нэртэй илтгэл тавихдаа Тэнгэрзмийн асуудлыг тухайлан хөндөж, насан эцэслэлтээ тэнгэр шүтлэг, тэнгэр үзлийн судалгаа хийн Монголын тэнгэрзм судлалын үндсийг тавьсан байна.

Тэнгэрийн шашин 2300-гаас багагүй жилийн тэртээд талын гүрний үзэл суртлын үндэс болон үүссэн гэж францын түүхч Рене Грүсс⁵ 1939 онд хэвлүүлсэн “Талын эзэнт гүрэн: Төв Азийн түүх” номондоо үзсэн нь дээр дурдсан Уно Харва-тай он цагийн хувьд давхцаж байна. Энэ нь Монголын түүхч Г.Сүхбаатарын тэнгэрзм бол хөгжингүй бөөгийн шашны ертөнцийг үзэх үзэл гэсэнтэй Хүннүд хамаарах цаг хугацааны хувьд бас дүйж байгаа ч Рене Грүсс Тэнгэрзм бол шашин гэж, Г.Сүхбаатар Тэнгэрзм бол бөөгийн шашны үзэл номлол гэж үзсэнээрээ ялгаатай байна. Академич Ш.Бира “Чухамхүү эртний монголчуудын тухай өгүүлэхэд жинхэнэ өөрсдийнхөө төр улсыг анхлан байгуулах үеэсээ тэдний бүхий л санаа бодол, үзэл онол нь нүүдэлчдийн уламжлалт шүтлэг болох бөө мөргөлийн суртлаар тодорхойлогдож байжээ”⁶ гээд монголчуудын энэхүү эцэг Тэнгэрийн шүтэх үзэл нь Чингис хааны үед Монгол улсын улс төрийн тулгуур үзэл болон хувирч, “Тэнгэр хэмээх ойлголт улам бүр гүнзгийрэн хөгжиж, ертөнц дахины хувь заяаг шийдвэрлэх ер бусын шидэт Дээдийн их хүчний тухай бүхэл бүтэн улстөрийн үзэл суртал болж, Чингис тэргүүтэй монгол хаадын суу залийн сурвалжийг үүсгэн ертөнц дахины хэмжээний хүчирхийллийн үйл ажиллагааг нь нэг ёсондоо хуульчлан зөвтгөх сэтгэл санааны хүчтэй хэрэгсэл болсон байна. Энэ учраас Монголын Тэнгэрийн үзэл нь хэдүгээр бөөгийн мөргөлийн гол шүтлэгт тулгуурласан боловч үнэн хэрэг дээрээ шашны номлол байсан бус, илүүтэй гэнэн шулуун улс төрийн үзэл суртал мөн байсныг хэлэх хэрэгтэй”⁷ гэсэн байна. Тэрээр монголчууд XII-XIV зуунд гэнэт түүхийн тавцнаа товойн гарсан нь тэдний Тэнгэр шүтлэгтэй шууд холбоотой, тэрхүү шүтлэг нь хөгжин хөгжсөөр Тэнгэрзм хэмээх бүхэл бүтэн улс төрийн үзэл суртлыг бий болгосон гэх байр суурийг баримталжээ.

Ийнхүү тэнгэрзм гэдэг нэршлийг янз бүрээр тайлбарлаж, ойлгож байна. Зарим судлаач энэ бол шаманизмаас өөр, бие даасан шашин Евразийн орон зайд байж байгаад бусад шашинд түрэгдэн мартагдсан гэж үздэг ч монголчуудын хувьд Тэнгэр үзэл, Тэнгэр шүтлэг түүхийн бүх цаг үед

l'Histoire des religions. CL. No. 1-2: 197-230; Roux, J. P. 1962. *La religion des Turcs de l'Orkhon des VII e et VIII e siècles*. Revue de l'Histoire des religions. CLIX. No. 1-2: 1-24; Roux, J. P. 1984. *La religion des Turcs et des Mongols*. Paris.

¹ Безертинов, Р.Н. 2004. *Тэнгерианство – религия тюрков и монголов*. Казань, Слово, с.5.

² Томский, Г.В. 2014. *Религия Аттилы и Чингис-хана* // Académie internationale CONCORDE, -100 p.; Томский, Г.В. 2014. *Тангризм и естественная религия* (Tomski G. Tangrisme et religion naturelle) // Académie internationale CONCORDE; Томский, Г.В. 2014. *Классический тангризм* (Tomski G. Tangrisme classique) // Académie internationale CONCORDE.

³ Сүхбаатар, Г. 1980. *Монголчуудын эртний өвөг*. Улаанбаатар, ШУА-ийн хэвлэлийн газар; Г.Сүхбаатар. 2000. *Хүннү нарын аж ахуй, нийгмийн байгуулал, соёл, угсаа гарвал. (МЭӨIV - МЭИ)*. Улаанбаатар, Бемби сан. тал.79.

⁴ Бира, Ш. 2015. *Монголын тэнгэр үзэл ба Хубилай хаан*. Улаанбаатар, Адмон; Бира, Ш. 2017. *Монголын тэнгэр үзэл*. Улаанбаатар, Соёмбо принтинг.

⁵ Grousset, R. 1965. *L'Empire des steppes*. - Payot, -656 p.

⁶ Бира, Ш. 2011. *Монголын тэнгэр үзэл ба тэнгэрчлэл* // Tenggerizm and Mongols (Тэнгэрзм ба Монголчууд). Улаанбаатар, Цалиг, -55-р тал.

⁷ Мөн тэнд. -73-р тал.

оршоор ирсэн гэж судлаач миний бие ойлгодог. Тэгэхдээ Тэнгэр үзлийг шашнаас ангид, улстөрийн үзэл суртал гэсэн Ш.Бира гуайн байр суурийг тодорхой тохиолдолд дэмжиж, Тэнгэр үзэл, Тэнгэр шүтлэг нь ихэнхдээ харилцан нөхцөлдсөн, нэгийг нөгөөгөөс нь ангид авч үзэх аргагүй нийгэм-шашин-соёлын үзэгдэл байсан гэж үзэж байгаа болно. Үүнийгээ “Тэнгэр үзэл монголчуудын хувьд нэгдүгээрт мэдлэг, хоёрдугаарт шүтлэг, гуравдугаарт үзэл суртал гэсэн давхар давхар үүрэг функцтайгаар үйлчилж байснаа буддын шашин гүнзгий нэвтэрсний дараа тэргүүлэгч байр сууриа алдаж, XX зууны тэргүүн хагаст социалист тогтолцоонд нийт монголчууд хамрагдаж, шашингүйн үзлийн тулгалтад орсон үеийг хамтатган тооцвол 1990-ээд он хүртэл нийтдээ 400 орчим жил өнгөрчээ. Ингэснээр Тэнгэр шүтлэг нь уугуул шүтлэгийн хувьд ямар нэг байдлаар хадгалагдаж, харин Тэнгэр үзэл төрийн бодлогын тулгуур үзлийн хувьд оршин тогтнохоо больсон байна. Гэхдээ Тэнгэр үзэл нь монголчуудын ертөнцийг үзэх үзлийн хувьд ард түмний ой санамж, зан үйл, сургаал айлдварт “буддист” өмсгөл нөмрөн оршоор ирсэн гэж хэлж болно”¹ хэмээн илэрхийлсэн билээ. Энэ байр суурь маань монголчуудын тэнгэр шүтлэг дэх амар амгалангийн үзэл санааг тодлон гаргах зөвтгөл болно.

Чингис хааны илэрхийлсэнчлэн дөрвөн зүг, найман зовхисын олон улс орныг нэгтгэн хурааж нэгэн төрийн жолоонд оруулсан нь “...манай Шаньюйн улсад мянган он, зуун үед эс гарсан хэрэг”² бөгөөд Хүннүгийн дараахи хоёр дахь гүрэн болох Их Монгол улс мянган оны дараа хэрэгжүүлсэн энэхүү даяарыг тэгшитгэх бодлогын үр дүнд Рах Mongolica хэмээн Их амар амгалан буй болсон билээ. Энэ их үйл хэргийг бүтээхэд монголчуудын оюун санаа, сэтгэл зоригийг нэгтгэгч гол хүчин зүйл нь бөөгийн шашин буюу Тэнгэр шүтлэг байсан бөгөөд “Нүүдэлчин түмний тэнгэрийг шүтэх ёсыг Чингис хаан монгол туургатныг нэгтгэн Их Монгол улсыг байгуулах төрийн бодлогынхоо нэг чухал үзэл болгон чадамгай хэрэглэсэн юм. Юуны өмнө Чингис хаан бөө мөргөлийг хэрэг дээрээ Монгол төрийн албан ёсны мөргөл болгов”³ хэмээн манай судлаачид үздэг. Энд бид монгол бөө буюу монголчуудын тэнгэр шүтлэг нь евразийн бусад нүүдэлчин ард түмнүүдийн тэнгэр шүтлэгээс ялгарах өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой, дэлхий нийтээр хэвшиж тогтсон шаманизмын тухай ойлголтод монгол бөө хамаарах ч бусад үндэстний бөөд байхгүй онцлог шинжүүдтэй⁴ болохыг тооцохгүйгээр зөв дүгнэлтэд хүрэх боломжгүй юм.

Түүхэнд Рах mongolica гэдэг үзэгдэл бодитой байсан, түүний бий болох үндсэн нөхцөл нь Их Монгол улсын төрийн бодлого байсан, Их Монгол улс ийм бодлого хэрэгжүүлэхийн үндэс нь монголчуудын тэнгэр үзэл, тэнгэр шүтлэгтэй холбоотой гэсэн гинжин хэлхээ эцэст нь тэрхүү Тэнгэр шүтлэгийн сургаал номлол, түүнийг илэрхийлэгч символ томъёолол, шашны зан үйлийн онцлог юу байсан, даяарын амар амгалан бий болгоход тэдгээрийн нөлөө юу байв гэсэн асуулт руу зүй ёсоор хөтөлнө.

Өвөг монголчууд болох хүннү нар тэнгэр шүтдэг байсан, шаньюйгаа тэнгэрийн хүү гэж үздэг, тэнгэр тайх ёс үйлддэг байсан зэрэг нь түүхэн сурвалжуудаас тодорхой ч дээрх асуултад хангалттай хариулах мэдээлэл алга. Хүннү, Хань улсын хооронд Энх ургийн гэрээ⁵ НТӨ 198 онд байгуулж, дундаа тасалдалтайгаар 200-гаад жил мөрдөхөд Тэнгэр шүтлэгийн нөлөө байсан эсэхийг нотлох, эсвэл үгүйсгэх баримт байхгүй учраас ямар нэгэн дүгнэлт хийх боломжгүй юм. Харин Чингис хааны үед монголчуудын тэнгэр шүтлэг дэх амар амгалангийн үзэл санаа их тод илэрдэг төдийгүй түүнийг дүрс(символ)-ээр ч, үгээр ч илэрхийлж чадсан нь түүхэн сурвалжууд, судлаачдын бүтээлийг харьцуулан судлах явцад тодорхой болж байна. Ялангуяа 1228 онд Хэрлэнгийн хөдөө аралд бичиж дүүргэсэн “Монголын нууц товчоон” түүхэн сурвалжид дурдагдсан үйл явдал, баримтууд нь тухайн цагийн монголчуудын бөөгийн шашны

¹ Галаарид, Б. 2021. *Монголчуудын тэнгэр үзэл, тэнгэр шүтлэг*. Ред. Т.Дагвадорж. Улаанбаатар, Цалиг. -.. тал.

² Жичан, Ли. 2010. *Чанчунь бомбын Өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл*. Орч. Я.Ганбаатар, Ц.Ганбаатар.

Улаанбаатар, Адмон. -19-р тал.

³ Батсүрэн Б, Дэлгэржаргал П, Эрдэнэбат У. 2019. *Их Монгол улс*. Монголын эзэнт гүрний түүх. Тэргүүн боть. Улаанбаатар, Степпе паблшинг. -697-р тал.

⁴ Галаарид, Б. 2024. *Монгол бөөгийн шашны дахин сэргэлтийн уламжлал, шинэчлэлийн асуудалд // Олон улсын монголч эрдэмтний XII их хурлын илтгэлүүдийн эмхэтгэл*. III, IV, V боть. Улаанбаатар, -31-р тал.

⁵ Сыма Цянь. 2014. *Хүннүгийн шастир (Сыма цяний “Ши цзи” зохиолын 110-р бүлэг)*. Орч.Д.Молор. Улаанбаатар, Мөнхийн үсэг. -50-р тал.

онцлог, төрт ёсонд үзүүлсэн нөлөө, тэнгэр шүтэх ёсонд хийсэн шинэчлэлийг нэлээд тодорхой харуулж чадаж байна. Монголын нууц товчоонд дурдагдаж буй есөн хөлт цагаан туг (МНТ, 202), хар, алаг туг (МНТ, 170), сүлдэр (63, 201, 249) зэрэг төртэй холбоотой бэлгэдлийн зүйлс нь тэнгэр шүтлэг, бөөгийн ёстой салшгүй холбоотой.

Мөн 1206 онд Их Монгол улсыг байгуулахад Чингис хаан зарлиг болсноор бүтэж, эзэнт гүрний хэмжээнд үйлчилж байсан “Их засаг” хуулийн агуулгад монголчуудын тэнгэр шүтлэгийн үзэл санаа тусгалаа олсныг хэлэх ёстой. Рах mongolica бүрэлдэн тогтох үндэс болсон “Их засаг” хуулийг дэлхий дахинаа судалж эхлээд 300 гаруй жил болоход¹ арвин их бүтээл олон хэлээр гарсан бөгөөд тэдгээр нь тус хуулийн агуулга, хамрах хүрээ зөвхөн эрх зүйн акт гэдгээс илүү өргөн байгааг нотолж байна. Судлаач Ц.Минжин “*Ингээж өргөн хүрээнд харвал “Их засаг”-ийг зарлиг, зарга, ёс бүрдүүлж байжээ гэсэн санаа улам тодорхой болох аж. Өөрөөр хэлбэл Зарлиг нь төрөөс буюу хаанаас тогтоосон хууль буюу хуульчилсан акт, Зарга нь гэмт хэрэг буюу хэрэг шийдэх үндсэн зарчим, шүүхийн жишиг, Ёс нь зан заншлын хэм хэмжээг өөртөө шингээсэн хэв хуулийн шинжтэй хэм хэмжээ буюу ёс суртахуунд нөлөөлөхүйц уламжилж ирсэн дадал зуршил, журам болно*”² гэж дүгнэсэн байна. Их Монгол улс анх байгуулагдах үед түүнийг бүрдүүлэгч овог, аймгуудын дийлэнх нь, тэр дундаа Чингис хаан өөрөө тэнгэр шүтлэгтэн байсан. Ийнхүү тэнгэр шүтлэгийн сургаал номлол нь тухайн үеийн монголчуудын амьдралын хэв маяг, зан заншил, ёс суртахууныг тодорхойлогч гол хүчин зүйл байж, “Их засаг” хуулинд хэв хуулийн шинжтэйгээр тусгалаа олсон учраас Рах mongolica-гийн гол хүчин зүйлийн нэг нь монголчуудын тэнгэр шүтлэг дэх амар амгалангийн үзэл санаа гэж үзэж байна.

Дараагийн нэг чухал асуудал бол монголчуудын тэнгэр шүтлэг дэх ертөнцийг үзэх үзлийг илүү тодорхой томъёолж, бэлгэдлийн симбол болон үгээр илэрхийлж, биежүүлэн шүтээн болгосон, өөрөөр хэлбэл монголчуудын тэнгэр шүтлэгт шинэтгэл хийсэн хүн бол Чингис хаан гэж үзэх үндэс байна.

Үгээр илэрхийлсэн хэлбэр нь түүний томъёолж хэвшүүлсэн “Мөнх Тэнгэр” гэх ойлголт юм. Монголчуудын тэнгэр шүтлэг дэх Тэнгэр гэх ерөнхий ойлголтыг нарийвчлан тодолов Мөнх Тэнгэрийн тухай үзэл баримтлал нь Монголын их амар амгаланг тогтооход тэргүүлэгч хүчин зүйл болсон билээ. МНТ судлаач Б.Сумъяабаатар “*Мөнх Тэнгэр*” гэдэг хэллэгийг анх хэрэглэсэн хүн бол Тэмүүжин байна. Тэрбээр, Чингис хаанд өргөмжлөгдөхөөсөө урьд буюу 1206 оны барс жилээс өмнө хэлжээ. Үүнийг, 1202 оны нохой жилээс хойш, 1204 оны хулгана жилээс урагш гэж тогтоож байна”³ гэж МНТ-ны 172-т дурдсан үйл явдлыг түшиглэн авч үзсэн. Доктор А.Цанжид монголчуудын төр барих ухааныг судлах явцдаа монголчууд Төр бол Улс оршин тогтнохын үндэс гэж эртнээс үзэж, төрөө хамгаалахын төлөө хаад, харцасгүй бүгд нэгдмэл санаа сэтгэлтэйгээр амь үл хайрлан тэмцдэг байсан уламжлалыг “Тэнгэр-төр” гэсэн өвөрмөц шүтлэг гэж болох юм гэсэн санааг дэвшүүлж, “*Энэ нь чинад оюуны ертөнц дэх болон түүний наана буй бодит ертөнц дэх шүтээнтэй байж иржээ гэсэн үг юм*”⁴ гэсэн байдаг. Энд өгүүлж буй чинад ертөнц дэх шүтээн буюу Дээдийн дээд хүчийг үгээр илэрхийлсэн хэлбэр нь “Мөнх Тэнгэр” мөн байна.

“Мөнх тэнгэрийн хүчин дор, Их хааны суу залийн ивээлд” гэсэн тогтмол хэллэг хожим нь эзэнт гүрэн даяар түгэн тархаж, хэдэн зуун өртөөлөн хэрэглэгдэж байсныг түүхэн баримтууд гэрчилдэг. Энэ хэллэгийн тухай “*Тэнгэрийг шүтэх ёс үнэхээр Монголын их эзэнт гүрний улс төрийн үндсэн үзэл суртал болж хувирсныг монгол хаадын бараг бүх албан бичигт хэвшил болон бичигдэж байсан оршил үг гэрчилнэ*”⁵ хэмээн манай эрдэмтэн судлаачид тэмдэглэсэн нь буй. Түүхэн сурвалжууд сөхөх юм бол 1233 онд Өгөдэй хааны үед Өмнөд Сүн улсын элчээр ирж байсан Пэн Дая, Сюй Тин нар “*Тэд энгийн яриандаа ч Мөнх тэнгэрийн хүчин дор, хааны*

¹ Францын дорно дахиныг судлаач Petis de la Croix-ийн 1710 онд Парист хэвлүүлсэн “Их Чингис хааны түүх” номонд “Их засаг” хуулийн талаар анх дурдсан гэж үздэг.

² Минжин, Ц. 2021. *Их Монгол улсын их заргач* Шихихутаг. Улаанбаатар, Мөнхийн үсэг. -105-р тал

³ Сумъяабаатар, Б. 2020. *Монголын нууц товчоон: Иж судалгаа*. Ред. О.Содномпил. –Улаанбаатар, Жиком пресс. -194-р тал.

⁴ Цанжид, А. 2019. *Монголын төрт ёс*. Ред. С.Отголжий. Улаанбаатар, Соёмбо принт. -73-р тал.

⁵ Батсүрэн Б, Дэлгэржаргал П, Эрдэнэбат У. 2019. *Их Монгол улс. Монголын эзэнт гүрний түүх*. Тэргүүн боть. Ред. С.Өлзийбаяр. Улаанбаатар, Степп пабблишинг. -697-р тал.

сууд ивээгдэж гэж ярьдаг”¹, Хубилай хааны дэргэд 1272-1289 онд 17 жил алба хаасан Марко Поло “Тэд энэ ертөнцийн үзэгдэх ба үл үзэгдэх бүх юмсыг бүтээгч, орчлонгийн жаргал зовлонг үүтгэгч цорын ганц Тэнгэрт сүсэглэн биширнэ”² гэж тэмдэглэн үлдээсэн байна. Гийом де Рубрук 1254 онд Мөнх хаантай уулзахад хаан “Бурхан та нарт судар ном хайрлаж. Та нар тэрийгээ сахидаггүй юм байж. Бурхан бидэнд мэргэч төлгөчдийг (зайран) заяасан юм аа. Бид тэдний айлдсаныг дагаж мөрддөг, тэгээд ч амар тайван аж төрдөг”³ гэж өгүүлж буйгаас монголчуудын амар амгалангийн үндэс нь тэнгэр шүтлэгтэй байдаг гэсэн санаа тод уншигдаж байна.

Мөнх тэнгэрийн бэлгэдлийн дүрс буюу символ хэлбэрт илэрхийлэл нь Чингис хааны ургийн тамга⁴ болох Ширээт онгин тамга мөн. Онги буюу Цагариг дүрс нь нарыг илэрхийлдэг гэж олон судлаач үздэг. Харин Чингис хааны ширээт онгин тамганы тухайтад дээд хэсэг дэх цагариг нь Тэнгэр, суурийн хөндлөн зураас нь Газар, тэр хоёрыг холбосон босоо зураас нь Хүнийг, тамганы бүх дүрс нийлээд Орчлонгийн хамаг бүхний жам ёсны оршихуйг тодорхойлогч Дээдийн дээд хүч Мөнх тэнгэр гэсэн санааг илэрхийлж байна гэсэн тайллыг миний бие бичиж, тэмдэглэсээр ирлээ.

“Тэнгэр шүтлэг бол тэнгэрийг шүтэж үйл бүтээхийн тулд түүнд залбирдаг, үйл бүтвэл түүнд баярладаг байхын зэрэгцээ тэнгэр газрын заяагаар буй болсон жам ёсыг, одоогийн хэлээр яривал зүй тогтлыг илэрхийлдэг ажээ. Харин “Тэнгэрийн хөвүүн” хэмээх ойлголт нь нийгмийн ялгарлыг тусгаж байгаа байж болох юм. Бүгд тэнгэрээс заяат. Харин тэдний дотроос ялгарсан нь тэнгэрийн хөвүүн” гэж доктор А.Цанжид үзсэн нь Их хааны тамга Ширээт онги байгаагийн бас нэг тайлал мөн. Чингис хааны ширээт онгин тамгатай зоосыг судалсан доктор Б.Нямаа бас “Чингис хааны алтан ургийн олон хаадуудын зоосон дээр наран тамганаас үүсэлтэй тамгад байдаг нь алтан ураг угаас тэнгэрээс заяатай гэдэг үзэл баримтлалын илэрхийлэл”⁵ гэж үзсэн.

Монголын тэнгэр үзлийн бодит ертөнц дэх биет шүтээн хэлбэр нь Төрийн их цагаан сүлд мөн. Аливаа бурхад, сахиус шүтээнийг икон, танка гэхчлэн янз бүрээр хөрөглөж, зурж, сийлж, цутгах зэргээр урлан биежүүлэх уламжлал бүх шашинд бий. Монгол бөөд эсгий, малын үс ноос, мод зэргээр гэр онго үйлдэн тахидаг уламжлалтай байсан нь түүхэн эх сурвалжууд, археологийн олдворуудаар нотлогддог. Тэгвэл дундад эртний үеийн монголчууд Мөнх Тэнгэрийг үүн лүгээ адилаар шүтээнчлэн биежүүлсэн нь төрийн Их цагаан шүтээн буюу Их цагаан сүлд юм. Төрийн их цагаан сүлднээс дээш гарах эрэмбэтэй шүтээн сүлд байхгүй байгаа нь ингэж үзэх үндэслэл болж байна. Монголчуудын туг, сүлдийн тахилгыг судалсан Г.Бадамсамбуу “Ертөнцийн тухай эрэмбэ дараатай төсөөлөл, уг дэсээр онго шүтээнээ төлөөлүүлэх загварчлал бол монголчуудын шүтлэг, зан үйлийн дагах хэм хэмжээ байжээ... Тэнгэрийн хөвүүн, түүний Туг шүтээн хоёр бол Мөнх тэнгэрийн сүнснийг төлөөлөх бодгаль мөн. Энгийнээр хэлбэл Мөнх тэнгэр монголчуудын дээд Бурхан аж”⁶ гэж үзээд, туг сүлдийн тахилга нь шүтээн биетээр дамжуулан Эзэн хаан хийгээд Тэнгэрийг тахих зан үйлийн хэлбэр хэмээн тодорхойлсон. Түүний Туг шүтээн бол “Мөнх Тэнгэрийн сүнснийг төлөөлөх бодгаль” гэсэн санаа нь Мөнх Тэнгэрийг шүтээнчлэн биежүүлж, Амилуулсан гэх үзлийн нэг хэлбэр мөн байна. Төрийн их цагаан сүлд шүтэх, тахих үйлдэл нь төр улс, ард түмэн, сав шим ертөнц даяараа амар амгалан байхыг бэлгэддэг.

Өмнө өгүүлсэн бүхнийг нэгтгэн дүгнэвэл Монголын тэнгэр шүтлэг дэх ертөнцийг үзэх үзэл нь Орчлон(Universe) бүхэлдээ нэг амьтай, орчлонгийн бүх юмс, үзэгдэл, амьд бодгаль үлэмж их, эсвэл нэн бичлээсээ үл хамааран хоорондоо амин холбоотой, харилцан үйлчлэлтэй, нэгдмэл

¹ Пэн Дая, Сюй Тин. 2006. *Хар татарын хэргийн товч*. Их монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг. Орч. Ж.Баясах. Улаанбаатар, -255-р тал.

² Жиованни дел Плано Карпини. 1988. *Монголчуудын түүх*. Улаанбаатар, -16-17-р тал.

³ Гийом де Рубрук. 2020. *Монголын эзэнт гүрэнд зорчсон нь. 1253-1255*. Орч. Т.Төмөрхүлэг. Улаанбаатар, -155-р тал.

⁴ Бира.Ш ба бусад. 2012. *Чингис хааны өв*. Улаанбаатар. -80-р тал.

⁵ Нямаа, Б. 2005. *Монголын эзэнт гүрний зоосон мөнгө ба хаадын тамга*. Улаанбаатар. тал-33.

⁶ Бадамсамбуу, Г. 2014. *Туулын Гурван улхуны дэвсэх саглагар мод хаана вэ*. Ред.С.Чулуун. Улаанбаатар, Соёмбо принтинг. тал-25-26.

нэгэн зүй тогтол(жам)-д захирагддаг, түүнээс гажвал буруутдаг гэсэн тулгуур үзэл, “Хэрхэхийг Тэнгэр мэднэ” хэмээх зарчимд суурилж байжээ. Жамыг эн тэргүүнд авч үзэж, түүнээс зөрөхгүйг хичээдэг тул бусдын шашин шүтлэг, зан заншил, соёлын ялгаатай байдалд хүлээцтэй ханддаг, өөрийнхтэйгээ харьцуулан үгүйсгэдэггүй, өөрийн итгэл үнэмшлийг бусдынхаас дээгүүрт тавьдаггүй байсан нь хүн төрөлхтөн шүтэх бишрэх заяамал эрхээ тэгш эдлэн, мөр зэрэгцэн эвтэй найртай амьдрах боломжийг бий болгож чадахуйц амар амгалангийн үзэл санаа байжээ. Мөн байгалийг хүчээр эзэгнэх биш, харин зүй зохис(гармони)-ыг нь алдагдуулахгүйгээр зохицож амьдрах, тэнгэр шүтлэгийн зан үйлээр дамжуулан Тэнгэрийн ивээлийг өөртөө төдийгүй, байгальдаа хүртээхийг хичээдэг байсан нь амьдрах орчин, байгаль дэлхийгээ амар амгалан байлгах үзэл санааны илэрхийлэл байжээ гэж үзэж байна.

Монголчуудын тэнгэр шүтлэг дэх аливаа юмс үзэгдлийн амин шүтэлцээг эрхэмлэдэг, бусдын итгэл үнэмшил, шашин соёлыг хүндэтгэдэг, экологич, ертөнцийн зүй зохисыг эвдэхгүйг хичээгч үзэл санааг нь орчин үеийн мэдлэг, бусдын сайн туршлагаар баяжуулан бүтээлчээр ашиглавал Энх тайвныг бүтээхүйд ихээхэн тустай гэж үзэж байна.

АШИГЛАСАН БҮТЭЭЛҮҮДИЙН ЖАГСААЛТ

1. Бадамсамбуу, Г. 2014. *Туулын Гурван улхуны дэвсэх саглагар мод хаана вэ*. Ред.С.Чулуун. –УБ.: Соёмбо принтинг.
2. Батсүрэн Б, Дэлгэржаргал П, Эрдэнэбат У. 2019. *Их Монгол улс. Монголын эзэнт гүрний түүх*. Тэргүүн боть. Улаанбаатар, Степпе пабблишинг.
3. Безертинов, Р.Н. 2004. *Тэнгрианство – религия тюрков и монголов*. Казань, Слово.
4. Бира, Ш. 2011. *Монголын тэнгэр үзэл ба тэнгэрчлэл // Tenggerizm and Mongols* (Тэнгэризм ба Монголчууд). Улаанбаатар, Цалиг.
5. Бира, Ш. 2015. *Монголын тэнгэр үзэл ба Хубилай хаан*. Улаанбаатар, Адмон; Бира, Ш. 2017. *Монголын тэнгэр үзэл*. Улаанбаатар, Соёмбо принтинг.
6. Бира.Ш ба бусад. 2012. *Чингис хааны өв*. Улаанбаатар.
7. Галаарид, Б. 2024. *Монгол бөөгийн шашны дахин сэргэлтийн уламжлал, шинэчлэлийн асуудалд // Олон улсын монголч эрдэмтний XII их хурлын илтгэлүүдийн эмхэтгэл*. III, IV, V боть. Улаанбаатар.
8. Галаарид, Б. 2021. *Монголчуудын тэнгэр үзэл, тэнгэр шүтлэг*. Ред. Т.Дагвадорж. Улаанбаатар, Цалиг.
9. Гэрэлбаатар, Г. 2001. *Монголын уламжлалт шашин шүтлэг*. Ред Н.Ням-Осор. Улаанбаатар, 176х.
10. Жичан, Ли. 2010. *Чанчунь бомбын Өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл*. Орч. Я.Ганбаатар, Ц.Ганбаатар. Улаанбаатар, Адмон.
11. Карпини, Жиованни дел Плано. 1988. *Монголчуудын түүх*. Улаанбаатар.
12. Минжин, Ц. 2021. *Их Монгол улсын их заргач Шихихутаг*. Улаанбаатар, Мөнхийн үсэг.
13. Нямаа, Б. 2005. *Монголын эзэнт гүрний зоосон мөнгө ба хаадын тамга*. Улаанбаатар.
14. Пэн Дая, Сюй Тин. 2006. *Хар татарын хэргийн товч*. Их монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг. Орч. Ж.Баясах. Улаанбаатар.
15. Рубрук, Гийом де. 2020. *Монголын эзэнт гүрэнд зорчсон нь. 1253-1255*. Орч. Т.Төмөрхүлэг. Улаанбаатар.
16. Сумъяабаатар, Б. 2020. *Монголын нууц товчоон: Иж судалгаа*. Ред. О.Содномпил. – Улаанбаатар, Жиком пресс.
17. Сүхбаатар, Г. 1980. *Монголчуудын эртний өвөг*. Улаанбаатар, ШУА-ийн хэвлэлийн газар.
18. Г.Сүхбаатар. 2000. *Хүннү нарын аж ахуй, нийгмийн байгуулал, соёл, угсаа гарвал. (МЭӨIV - МЭII)*. Улаанбаатар, Бемби сан
19. Сыма Цянь. 2014. *Хүннүгийн шастир* (Сыма цяний “Ши цзи” зохиолын 110-р бүлэг). Орч.Д.Молор. Улаанбаатар, Мөнхийн үсэг.
20. Томский, Г.В. 2014. *Религия Амтлы и Чингис-хана // Académie internationale CONCORDE*.
21. Цанжид, А. 2019. *Монголын төрт ёс*. Ред. С.Отголжий. Улаанбаатар, Соёмбо принт.
22. Grousset, R. 1965. *L'Empire des steppes*. - Payot,
23. Harva, U. 1938. *Die Religiöse Vorstellungen der Altaischen Völker*. (Folklore Fellows Communications 125.) Werner Söderström Osakeyhtiö.
24. Roux, J. P. 1956. *Tängri. Essai sur le ciel=dieu des peuples altaïques*. Revue de l'Histoire des religions. CXLIX. No. 1-2.

*Чөлөөнд байгаа Бригадын генерал,
түүхийн ухааны доктор*

1990 оноос өмнө манай улсын батлан хамгаалах бодлого холбоотны стратегитай байсан. 1989 онд Жанжин штабын дарга Ж.Жадамбаа генерал энэ талаар “ах дүү Зөвлөлтийн армитай хамтран эх орноо хамгаалах номлол бий” гэж билээ. Цэргийн номлол байхгүй байсан юм билээ. 1990 оноос МАХН-ын Онц Их хурлаас өөрийн орны аюулгүй байдлыг улс төрийн аргаар хангаж, олон улсын баталгаатай болгох чиг шугамыг зарлажээ. Миний бие 1990 онд бичсэн өгүүлэлдээ : “... Энэ зорилт онол, практикийн үндэслэлийг хэр зэрэг бодитой боловсруулснаар хангагдах ёстой. Үүнд:

Нэгдүгээрт - өнөөгийн хүн төрөлхтний хөгжил дэвшил нь улс хоорондын маргаантай асуудлуудыг дайн байлдаангүй, хүч хэрэглэхгүйгээр шийдэж чадах төвшиндөө бүрэн хүрсэн үү, олон улсын харилцааны дулаарал тогтвортой юу, олон улсын баталгаажилт нь улс орны тусгаар тогтнолыг ямар хэмжээнд найдвартай хамгаалах вэ? манай орны хувьд нөлөөлөх онцлог хүчин зүйлүүд юу байна гэх зэрэг өргөн хүрээтэй асуудлуудад дүүрэн хариулт өгч байж зэвсэгт хүчний байх, байвал ямар хэмжээтэй, ямар үүрэгтэй байхыг тодорхойлох гол үндэслэл болох юм.

Хоёрдугаарт: манай орны газар зүйн байршил, түүхэн уламжлал хил залгаж байгаа улсуудын хүрээнд, тэдгээрийн нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хөгжил, цэрэг, улс төрийн бодлогын өөрчлөлттэй нь уялдан гарч болох үр дагавар... Түүнчлэн хоёр хөрш их гүрнээс манай оронтой харилцаж байсан цэрэг, цэрэг стратегийн бодлогыг өөрийн оюунаар, нэг талыг баримтлалгүй дүнсэн түүхийн бодитой судалгааг хэрэгтэй юм.

Аюулгүй байдлын олон улсын баталгаажуулалт нь манайх шиг хоёр том гүрний дунд байдаг, жижиг оронд яаж нөлөөлөхийг тооцох нь зөв юм.

Гуравдугаарт: ...Ирэх зуны манай гаригийн гол зангилаа асуудлууд хүн амын хэт өсөлт, амьдрах орчны эрс багасалт, экологийн хүчин зүйлүүд нь манай орон шиг хүн ам, нутаг дэвсгэр, хөндөгдөөгүй баялгаараа онцлог улсад маш их хамааралтай нь ойлгомжтой байна. Манай эдийн засгийн ядраг хөгжил, гадаад худалдааны өрөөсгөл туршлага нь улс төр эдийн засгийн нээлттэй хаалганы биеэ даасан бодлогын үр дүнд үүсэх хүчин зүйлүүд, улс орны тусгаар тогтнол, засаг төрийн тогтвортой байдалд хэрхэн нөлөөлөхийг нарийн тооцохыг шаардаж байна. Түүнчлэн цэрэг-стратегийн болон гадаад бодлогоо шинжлэх ухаантай уялдуулан судлах зорилготой стратегийн судалгааны үндэсний төвийг байгуулах нь цаг үеийн чухал шаардлага болж байна.” гэж 1990 онд бичиж байлаа.

1993 оны шинэ Үндсэн хуульд: “Монгол улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна” гэж заасан нь цэрэг армийн асуудлыг нэг мөр болгосон. Удалгүй батлагдсан “Цэргийн номлол” -оор улам баталгаажсан. 1990 ээд оны эхээр монголчууд олон улсын баталгаажуулалтыг энхийг сахиулахтай холбон судлах болж “Улаан од” сонины сэтгүүлч Баяраа “Цэнхэр дуулгатны” талаар нийтлэл бичиж, Стратеги судалгааны хүрээлэнг төлөөлөн генерал Ч.Пүрэвдорж БХЯ-ны удирдлагад энхийг сахиулах талаарх санал, мэдээлэл хүргэж, НҮБ-ын дэргэд Монгол Улсын төлөөлөн сууж байхдаа Л.Эрдэнэчулуун сайд ГХЯ, БХЯ-нд энэ талаар судалгаа явуулж байсан гэдэг.

“Монголчууд цэрэг зэвсгийн хүчээр өөрийгөө хамгаалж чадаж байсан, жижиг үндэстний аюулгүй байдлаа найдвартай сахиулахын тулд алс холын Төв Европ хүртэл мөрдөн хөөж устгах байлдаан хийн олон армийг ялан дийлж, анх удаа “дэлхийн дэг журам”-ыг тогтоож өгч байсан тэр цаг үе алс тэртээд үлджээ. Өнөөдрийн монголчууд дэлхийн шинэ “дэг журам”-тай аюулгүй байдлаа хэрхэн зохицуулах вэ гэж үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах төрийн бодлогоо нягтлан, арга замаа шинэчлэн тодорхойлж, хэрэгжүүлэх гэж мэрийж байгаа үед “энхийг сахиулах” гэсэн шинэ ч юм шиг, хуучин ч юм шиг нэр томъёо зэвсэгт хүчний үндсэн үүрэг, зориулалт болон гарч ирснийг ...” 1999 онд бичиж байлаа.

Энхийг сахиулах ажиллагаа Зэвсэгт хүчний үүрэг болон 1996 оны “Цэргийн шинэчлэлийн бодлого” болон 1998 оны “Төрийн баглан хамгаалах бодлого” баримт бичгүүдэд анх удаа албан ёсоор орж тусгагдсан бол анхны бодит үйл ажиллагаа 1999 оны эхээр Монгол Улсын Ерөнхийлөгч, ЗХЕК аас ЗХЖШ-т энхийг сахиулах алба байгуулах үүрэг чиглэл өгснөөр эхэлсэн. УИХ-аар 1998 онд батлагдсан “Төрийн цэргийн бодлогын үндэс”-т энхийг сахиулах ажиллагаанд оролцох тухай зэвсэгт хүчний тайван цагийн чиг үүрэг болгон заасан юм. Ингэснээр манай цэргийн олон улсын хамтын ажиллагаа идэвхжих, цэргийн албан хаагчидын нэр хүндийг дээшлүүлэх, улмаар аюулгүй байдлын баталгааны нэг үндсийг бүрдүүлэх ач холбогдолтой болно гэж үзжээ. Тухайн үедээ хэвлэлд: ...Товчхондоо өнөө үед энхийг сахиулах хүчний сургалт гэдэг нэрийн дор урьд нь сөргөлдөн дайсагнагч байсан зэвсэгт хүчнүүдэд хамтран ажиллах өргөн боломж бий болгож өгч байгаа юм. Улс төр, дипломатын аргыг эрхэмлэдэг манай улс ч тайван цагт цэргийн аливаа эвсэл, холбоонд нэгдэхгүй байх чиг шугамаа хадгалан олон улсын цэргийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох, ингэснээрээ байдал хүндэрсэн нөхцөлд болзошгүй холбоотнуудтайгаа хамтран ажиллахад бэлтгэх боломж олж авч байна гэсэн үг. Энхийг сахиулах нь цэргийнхний нэр хүнд үлэмж өснө гэж та үздэг үү? Гэсэн сурвалжигчийн асуултад: “Реасекеерег-энхийг сахиулагч нь цэрэг, цагдаа, дипломатч, зуучлагч, олон улсын хуульч, орчуулагч, аврагч, жолооч, сувилагчийн мэргэжлийг эзэмшсэн өндөр ёс суртахуунтай хүн байх юм. Энэ шалгуурт тэнцсэн ...бие бялдар, оюун санаа, хүмүүжил, харьцааны өндөр чадавх эзэмшсэн залуучуудыг ... их дээд сургуулиуд булаалдах нь ч мэдээж. Ийм цэргийн албан хаагчидтай армийн нэр хүнд ямар байх нь ойлгомжтой.” гэж хариулж байлаа.

Энэ үед Монгол Улсын цэргийн төлөөлөгчдийн Ази, Номхон далайн бүс нутагт зохиогдож байгаа цэргийн олон улсын хурал, семинарт урилгаар оролцуулах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх хэлбэрээр АНУ- тай хоёр талын харилцаа хөгжиж байв. АНУ-ын Олон улсын энхийг сахиулах чадавхийг нэмэгдүүлэх EIPC хөтөлбөрийн хүрээнд 1998 оноос эхлэн энхийг сахиулах ажиллагааны эрх зүйн семинарыг жил бүр Улаанбаатар хотод хийж, сургагч багшийн дамжаа, бусад сургалт-семинарт Монголын цэргийн албан хаагчид тогтмол оролцох таатай нөхцөл бүрдсэн. Манай хүсэлтийг харгалзан НАТО-ийн “Энхийн төлөө түншлэл”-ийн хүрээнд болсон Төв Азийн орнуудын 1999 оны 5 дугаар сард болсон “ЦентрАзБат-99” команд штабын сургуульд Монголын цэргийн ажиглагчдын 3 офицер зардлыг АНУ төлөн оролцуулсан бол 9-р сард НАТО-гийн “Энхийн төлөө түншлэл” хөтөлбөрийн хүрээнд Казакстан Улсад болсон Төв Азийн орнуудын энхийг сахиулах “ЦентрАзиБат-2000” хээрийн сургуульд Монгол Улсаас Зэвсэгт хүчний салаа (35 цэргийн албан хаагчид)-г АНУ дэмжиж өөрийн зардлаар оролцууж байв.

Монгол Улсын цэргийн боловсон хүчнийг АНУ-д цэргийн мэргэжлээр болон англи хэлний чиглэлээр сургаж (АНУ-ын-Олон улсын цэргийн боловсрол сургалтын хүрээнд манай-улсад эхний ээлжийн 650.000 ам.доллар дээрээ нэмж 100.000 ам.доллар Конгрессоос хуваарилан нийт 200 гаруй цэргийн албан хаагч суралцуулав)

2000 оны 6 дугаар сард Таван толгой дахь ЗХ-ний Сургалтын нэгдсэн төвд энхийг сахиулах ажиллагааны сургалтын цэгүүдийг байгуулан, ЗХ-ний 150 дугаар ангийг хичээлүүлж эхэлсэн УИХ гишүүн агсан Р.Гаваа, БХ-ын сайд агсан Ж.Гүррагчаа нар голлон “Цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай” хуулийг УИХ-аар 2002 онд батлуулснаар Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн албан хаагч, багийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах боломжтой болсон. УИХ-ын зарим гишүүд “манай тураалтай цэрэгтэй Зэвсэгт хүчин” ийм үүрэг гүйцэтгэх эсэхэд ихээхэн эргэлзэж байсан түүх бий. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннан 2000 оны 10 сард Монголд айлчлахдаа НҮБ-ийн Энхийг сахиулахад оролцохыг уриалав.

Монгол улсаас анх удаа Зэвсэгт хүчний хоёр албан хаагч хошууч Д.Даваадорж, хошууч Ч.Ерөөлцэнгэл нар Конго улсад энхийг сахиулагчаар үүрэг гүйцэтгэсэн .

2002 онд АНУ нь Монгол Улсад Энхийг сахиулах чиглэлээр англи хэлний лабораторийг оролцуулан/ 313 мянган ам.доллар, "IMET" олон улсын рргийн боловсролын сургалтын хөтөлбөрийн хүрээнд 756 мянган ам.долларын тусламжийг үзүүлсэн байна.2003 оны эхнээс

АНУ-ын шаргуу хүсэлтээр (Элчин сайд хатагтай Шульц, цэргийн атташе дэд хурандаа Вилхелм нар) Монгол Улсаас Иракийн эрх чөлөө олон үндэстэний ажиллагаанд цэргийн баг оруулах талаар Засгийн газар судалж эхэлсэн. Юуны түрүүн хууль эрх зүйн орчноо тодорхой болгох ажлын хэсэг УИХ-ын гишүүд, ГХЯ, БХЯ- бүрэлдхүүнтэй УИХ-ын даргын дэргэд байгуулагдан ажиллаж байв. Энэ ажил багагүй сунжирч мухардалд ч орж байсан. Түүхэн шитгээ 2: ЗГХЭГ-ын дэд дарга Хангай өрөөндөө Ерөнхийлөгчийн улс төрийн зөвлөх Я.Долгоржав, хуулийн зөвлөх Баясгалан нарын бүх зөвлөхүүдтэй БХЯ, ЗХЖШ-ын удирдлагаас байлцуулан зөвлөлдсөн. Олон талаас мухардлаас хэрхэн гарах талаар хэлэлцсэний эцэст БХЯ-ыг төлөөлж оролцсон СУТГ-ын дарга байсан хурандаа Ч.Сосорбарам “дайны дараах, сэргээн босгох хүмүүнлэгийн ажиллагаанд барилга инженерийн баг оруулах” гэсэн тодорхойлолт хэрэглэвэл ямар вэ? гэхэд Ерөнхийлөгчийн цэргийн зөвлөх Ц.Дашзэвэг “харин ингэвэл Ерөнхийлөгч зөвшөөрөх магадлалтай” гээд бүх зөвлөхүүдээ дагуулан гарч явсан. Удалгүй төр, засгийн шийдвэр гарсан.

Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн албан хаагчаас бүрдсэн 10 ээлжийн цэргийн баг "Иракийн эрх чөлөө" ажиллагаанд олон улсын эвслийн цэргийн хамт үүргээ амжилттай гүйцэтгээд ирсэн бөгөөд Афганистан улсын Үндэсний армийн артиллерийн цэргийн бүрэлдэхүүнтэй ажиллах сургагч нараас бүрдсэн баг үргэлжлүүлэн үүрэг гүйцэтгэсэн.

Шигтгээ 3. Миний бие БХ-ын сайд Ц.Шаравдоржийн үүрэг, шийдвэрийн дагуу 2005 оны 9 дүгээр сарын 6-наас 2006 оны 3 сарын 26-нд Ирак Улсын Багдад хотод Олон Үндэстний хүчний штабын Холбоотны операцын төвд /MNF-I Coalition Operations/ Үндэсний ахлах төлөөлөгч-Senior National Representative-өөр ажиллав. Намайг очихоос өмнөө Польшийн дивизийн удирдлага манай цэргийг Чарли баазаас Эл Кут хот руу шилжүүлэх шийдвэр гаргасан байв. Эл Кут хот замаас хол, Ирантай хиллэдэг, орон нутгийн удирдлага хээл хахуульд автсан Украинчууд цэргээ татаж байгаа бааз байсан.

ЗХЖШ-аас авсан үүргийн дагуу энэ шийдвэрийг өөрчилхийн тулд ...тайлбар шургуу хийж байсны үүр дүнд энэ асуудал эцэстээ манай талд ашигтайгаар шийдэгдэж манай цэрэг Эль Диваниях хот дахь "Эко" бааз руу хохиролгүй шилжин байрлав. Манай цэргийн багийн оронд Эль кутэд очсон Салвадорын багийн цэргээс очсон даруйдаа зэвсэгт халдлагад өөртөж олон цэргүүд алагдаж шархадсан байв.

Үр дүн: АНУ-тай батлан хамгаалах харилцаа шинэ шатанд гарч өндөр хэмжээний айлчлал идэвхжиж тусламж дэмжлэг нэмэгдсэн. Үүнд: Энэ ондоо АНУ-ын АНДЦКомандлалд Монгол Улсын ЗХЖШ-ын дарга хошууч генерал Ц.Тогоо айлчлал хийж, айлчлалын үеэр Иракийн сэргээн босголтод Монголын цэргийн багийг оролцуулах талаар нарийвчлан хэлэлцэн тохирсон. 2003 оны 9-р сард БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга хошууч генерал С.Баасанхүү тэргүүтэй төлөөлөгчид Вашингтон хотноо Батлан хамгаалах яамдын зөвлөлдөх уулзалтад оролцсон. Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Б.Эрдэнэбат Персийн буланд болсон “Иракийн эрх чөлөө” ажиллагаанд оролцож буй эвслийн орнуудын Батлан хамгаалахын сайд нарын уулзалтад оролцов. 2003-аас 2004 онуудад АНУ-ын Төрийн Департаментын орлогч сайд Ж.Армитаж, АНУ-ын Штабын дарга нарын нэгдсэн хорооны дарга генерал Р.Майэрс, Номхон далай дахь АНУ-ын Цэргийн ерөнхий командлагч адмирал Т.Фарго, Номхон далай дахь АНУ-ын Хуурай замын цэргийн командлагчийн орлогч хошууч генерал С.Том, АНУ-ын Батлан хамгаалахын сайдын ажлын албаны Ази, Номхон далайн асуудал хариуцсан тэргүүн дэд дарга бригадын генерал Р.Аллен, Аляска муж улсын Үндэсний гвардын дарга, хошууч генерал К.Кемпбелл, Небраска муж улсын Үндэсний гвардын дарга хошууч генерал П.Лемпке нар манай улсад тус тус албан ёсны айлчлал хийлээ. Номхон далай дахь АНУ-ын цэргийн Тэнгистйн явган цэргийн хүчний командлагч дэслэгч генерал Валас Грегсон Монгол улсад айлчилж, хоёр улсын цэргийн дадлага, сургуулийн төлөвлөлтийн үйл явцтай танилцав.

2004 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди АНУ-д албан ёсны айлчлал хийв. Ерөнхийлөгч ноён Ж.Буштай Цагаан ордонд хийсэн уулзалтаар хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа болон бүс нутаг, олон улсын асуудлаар санал солилцож, худалдаа, хөрөнгө оруулалтыг идэвхитэй хөгжүүлэхээр тохиролцож Худалдаа хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээрт гарын үсэг зурав. (Мянганы сорилын сангийн 300 сая долларын тусламжийн асуудал шийдэгдсэн). Ноён Ж.Буш, Н.Багабанди нар хамтран гаргасан Мэдэгдэлдээ, хоёр орны хооронд

хамтын үнэт зүйлс, стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурласан хамтын ажиллагаа, иж бүрэн түншлэлийн шинэ эрин үеийг тунхаглав. /2004.07.13-23/ 2005 онд АНУ-ын Батлан хамгаалахын сайд Д.Рамсфелд Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн нь хоёр орны батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа бүх хүрээг хамарч гүнзгийрч буйн нотолгоо болсон.

АНУ-ын Ерөнхийлөгч Жорж Буш 11 дүгээр сарын 21-ний өдөр Монгол Улсад айлчлав. АНУ-ын Ерөнхийлөгч Жорж Буш Монгол Улсад анх удаа айлчлах үеэр “Иракийн эрх чөлөө” ажиллагаанд оролцсон монгол цэргийн төлөөлөгчидтэй биечлэн уулзжээ. АНУ-ын Батлан хамгаалахын сайдын ажлын албаны Ази, Номхон далайн ерөнхий газрын тэргүүн дэд дарга бригадын генерал Ж.Аллен тэргүүтэй төлөөлөгчид 2 удаа манай улсад айлчилж, 2005 онд “Эвслийн эв нэгдлийн сан”-гаас 11 сая, “Дэлхийн энхийн төлөө ажиллагааны санаачилга сан”-гаас 4,5 сая, “Энхийг сахиулах чадавхийг нэмэгдүүлэх сан”-гаас 3 орчим сая, нийтдээ 15,5 сая ам.долларын тусламж үзүүлэх, Иракийн ажиллагаанд оролцсон 1, 2 дугаар ээлжийн цэргийн багийн сургалтын нөхөн төлбөрт 672,000 ам.доллар америкийн тал олгохоор шийдвэрлэснийг мэдэгдэж зохицуулалтын зарим асуудлыг тохиролцов. IMET хөтөлбөрийн хүрээнд АНУ-ын цэргийн сургууль, дамжаанд суралцаж буй болон тус улсын санхүүжилтээр олон улсын арга хэмжээнд оролцсон цэргийн алба хаагчдын тоо өсч, “Иракийн эрх чөлөө” ажиллагаанд оролцож буй бие бүрэлдэхүүний хангалт, Ирак дахь цэргийн багтай холбох HF радио станцын зардлын асуудлыг тусламжийн журмаар олгосон.

Монгол Улсын Зэвсэгт хүчин, АНУ-ын Тэнгисийн явган цэргийн хүчинтэй хамтарсан "Khan Quest" хээрийн сургуулийг 2003 оноос эхлэсэн бол “Хааны эрэлд - 2004”, “Энхийг дэмжих ажиллагааны хамтарсан дадлага”-д АНУ цэргийн багаа илгээн хамтран Таван толгой дахь сургалтын төвд зохион байгуулж, манай цэргийн албан хаагчдад олон улсын энхийг сахиулах болон бусад ажиллагаанд оролцох дадлагад суралцав.

Бусад улс орнуудаас манайхыг ихээхэн анхаарах боллоо.Бельгийн Вант Улсын ЗХЖШ-ын дарга генерал Ван Даэл Монгол Улсад албан ёсны айлчлал хийж, Косовод үүрэг гүйцэтгэж байгаа тус улсын цэргийн багийн бүрэлдэхүүнд монголын нэг салааг оролцуулахаар тохиролцов. Үүний дагуу энхийг сахиулах үүрэг бүхий 39 хүний бүрэлдэхүүнтэй цэргийн багийг Косовод илгээв.

БНПУ-ын ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга хурандаа генерал М.Чисениух айлчилж, Иракийн сэргээн босголтын ажиллагаанд оролцож байгаа эвслийн орнуудын цэргийн багийн ажиллагаа, хэтийн төлвийн асуудлаар ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Ц.Тогоотой санал солилцов.Энэхүү үйл ажиллагаатай зэрэгцэн манай улстай цэрэг-техникийн харилцаатай гол улс нь ОХУ-тай харилцаа эрчимжиж, зогсонги байдлаас гарах анхны алхамуудыг хийгдэж эхлэв. ОХУ-ын Цэрэг-техникийн хамтын ажиллагааны хорооны бүс нутгийн цэрэг-төхнийн хамтын ажиллагааны бодлогын нэгдүгээр газрын дарга, хошууч генерал В.К.Дзиркалн тэргүүтэй төлөөлөгчид 2003 оны 10 дугаар сард Монгол Улсад ажлын айлчлал хийж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Н.Багабанди, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Готов, Батлан хамгаалахын сайд Ж. Гүррагчаа нартай уулзан хоёр орны цэрэг-техникийн рамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх талаар харилцан санал солилцож, хоёр орны цэрэг-техник, боловсон хүчин бэлтгэх хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх талаар хоёр тал харилцан тохиролцоонд хүрлээ.

Хамгийн гол үр дүн: НҮБ-ын мандаттай энхийн сахиулах ажиллагаанд Монголын Зэвсэгт хүчин оролцсон явдал. Олон улсын Тусгай шүүхийн хамгаалалтын үүргийг гүйцэтгүүлэхээр НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газраас тавьсан саналыг Монгол улсын Засгийн газар хүлээн авч 2005 оны 225 дугаар тогтоолоор Африкийн Сьера Леон улс дахь тус ажиллагаанд мотобуудлагын рот илгээх шийдвэр гаргасан. Шигтгээ 4: Засгийн газрын хурлаар уг асуудлыг оруулах үед тухайн үед нийгмийн хамгааллийн сайд байсан УИХ-ын гишүүн Одончимэд гуай Африк тивд залуучуудаа илгээж маляр өвчнөөс болж эрүүл мэндийн томоохон эрсдэлд оруулах болж байгааг хатуухан анхааруулж байсан. Мөн түүнээс өмнө намайг Иракт Олон Үндэстний Цэргийн штабт Үндэсний ахлах төлөөлөгч байхад өмнө нь тэнд үүрэг гүйцэтгэж байсан Украйны цэргийн 70 хувь нь маляр тусдаг түүнээс болж цэргээ татах болсон ноцтой асуудал Зэвсэгт хүчин бий болсныг украйны төлөөлөгч надад хувиараа анхааруулж би тэр доор нь утсаар ЗХЖШ-ын дарга Ц.Тогоо руу мэдээлж байлаа. Бурханы авралаар манай

эхний ээлжийн цэргүүдээс 5-6 хүн халуурсан мэдээг аваад би хувьдаа ихэд гайхаж байсан ч удалгүй энэ нь манай цэргүүд дарга нарын сахилга хариуцлагатай шууд холбоотойг газар орон дээр очоод ойлгосон билээ. Дэд хурандаа Бадамбазар даргатай 2 дахь ээлж эмээ цагт нь ууж хамгаалатын арга хэмжээ сайн авч байсан учир нэгч хүн халуураагүй гэдэг. Украйны цэрэг, дарга нар архи их уудаг учраас хувийн хамгаалалтын арга хэмжээн дээр алддаг байсан бололтой.

2009 онд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр Зэвсэгт хүчнээс ХБНГУ-ын цэргийн багтай хамтран Афганистан Улсад үүрэг гүйцэтгэх тухай асуудлуудыг шийдвэрлүүлж, монголын цэргийн багийн бэлтгэлийг ханган илгээлээ.

2009 онд НҮБ-ын мандаттай ажиллагаанд анх удаа мото-буудлагын батальон оруулах зорилтын хүрээнд Чад Улсад үүрэг гүйцэтгэх монголын цэргийн багийн эхний ээлжийг илгээж, мөн “MINURCAT” ажиллагааны хүчний штабт ажиллах анхны штабын офицерыг илгээсэн юм. Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах “UNMISS” ажиллагаанд 2012 оны 1 дүгээр сараас эхлэн үндсэн бүрэлдэхүүнийг 8 дугаар сард ажиллагааны газар оронд илгээсэн нь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсаас нойтон түрээсээр бүрэн дэлгэгдэн үүрэг гүйцэтгэсэн анхны мотобуудлагын батальон байсан. Олон улсын жишгээр манай арми цэрэг-техникийн дунд хугацааны хөгжлийн стратеги бодлоготой болох талаар багагүй ажилласны эцэст гадаад харилцаа, дотоод нөөц, боломждоо тулгуурлан энхийг сахиулах чадавхиа нэмэгдүүлэх, зэвсэг техникийг хэсэгчлэн шинэчлэх, сэргээн сайжруулахад чиглэсэн “ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БАЙГУУЛАЛТЫГ 2015 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР” баримт бичигтэй болсон.

НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох чадвартай бригадтай болох зорилт тавиад үндсэндээ хэрэгжээд байна. 2009 онд Зэвсэгт хүчнээс ХБНГУ-ын цэргийн багтай хамтран Афганистан Улсад үүрэг гүйцэтгэх тухай асуудлуудыг ҮАБЗ, ЗГ-аар шийдвэрлүүлж, монголын цэргийн багийн бэлтгэлийг ханган талаар СУТГ-ын дарга бригадын генерал Ч.Сосорбарам хурандаа Д.Ганзориг тэргүүтэй төлөөлөгчид Герман Улсын ЖШ тай хэлэлцээр хийж, хамтын ажиллагааны талаар зөвлөлдөн Афганистан Улсад Бадахшан мужид газар орон дээр очиж ажиллаж байв. 2009 онд НҮБ-ын мандаттай ажиллагаанд анх удаа мото-буудлагын батальон оруулах зорилтын хүрээнд Чад Улсад үүрэг гүйцэтгэх монголын цэргийн багийн эхний ээлжийг илгээж, мөн “MINURCAT” ажиллагааны хүчний штабт ажиллах анхны штабын офицерыг илгээсэн юм.

Түүхэн шигтгээ 5: 2009 оны 11 сард НҮБ-ын мандаттай ажиллагаанд анх удаа мото-буудлагын батальон оруулах зорилтын хүрээнд Чад Улсад үүрэг гүйцэтгэх монголын цэргийн багийн эхний ээлжийг илгээх талаархи Засгийн газрын хуралдаан дээр Хууль зүйн сайд Нямдоржийн “энхийг сахиулахад оролцох нь манай улсад эдийн засгийн ямар ашиг тустай...” гэсэн асуултад миний бие дараах хариулт тайлбар өгсөн юм. 1-рт энхийг сахиулагчид буцаж ирэхээр манай зах зээл дээр долларын болон машины ханш үнэ өсдөг энэ бол эдийн засагт дэмжлэг гэж би ойлгож байна, 2-т –зэвсэгт хүчин анх удаа зэвсэг техникээ хэсэгчилэн шинэчлэх боломж гарч ирсэн, 3-т Ер нь дайн бүхий газар цэргээ явуулчихаад улс орон ашиг олох вэ...гэх нь зөв үү? гэх хариулт өгч байв.

2012 оны 1 дүгээр сараас эхлэн Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах “UNMISS” ажиллагаанд үндсэн бүрэлдэхүүнийг 8 дугаар сард ажиллагааны газар оронд илгээсэн нь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсаас нойтон түрээсээр бүрэн дэлгэгдэн үүрэг гүйцэтгэсэн анхны мотобуудлагын батальон байсан. Монгол улсын зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагаанд дахь оролцоо өнөө үед

Монгол Улсын Зэвсэгтхүчин анх 2002 онд Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс дахь НҮБ-ын “MONUC” ажиллагаанд 2 офицерыг цэргийн ажиглагчаар оролцуулж эхэлснээс хойш энхийг дэмжих 15 ажиллагаанд оролцсон туршлагатай бөгөөд үүнээс 9 ажиллагаа нь дуусгавар болж, 6 ажиллагаанд өнөөдрийг хүртэл цэргийн баг, алба хаагчдыг илгээн үүрэг гүйцэтгүүлж байна. Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдын оролцсон энхийг дэмжих ажиллагаанууд. Үүнд:

1. Олон улсын эвслийн цэргийн ажиллагаа

1.1 Ирак улс дахь “Иракын эрх чөлөө” олон улсын цэргийн ажиллагаа

Дээрх хугацаанд нийт 10 ээлжийн цэргийн багт 1194 цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэсэн байна.

1.2 Афганистан улсад явагдаж буй АНУ-ын тэргүүлсэн “Тогтвортой эрх чөлөө” ажиллагаа

1.2.1 Артиллерын сургалтын хөдөлгөөнт баг

2003 оны 10 дугаар сараас эхлэн 13 ээлжинд 265 цэргийн алба хаагч томилогдон үүргээ амжилттай биелүүлсэн.

1.2.2 Цэргийн хамгаалалтын рот

2009 оны 11 дүгээр сараас Афганистан Улсын Кабул хотод байрлах эвслийн хүчний “Эггэрс” цэргийн баазын харуул, хамгаалалтын үүргийг гүйцэтгэж эхэлснээс хойш цэргийн багийн нийт 10 ээлжинд 1252 цэргийн алба хаагчид үүргээ амжилттай гүйцэтгэсэн.

2.НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа

Монгол Улсын Зэвсэгт хүчин НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэргийн багуудаас гадна цэргийн ажиглагч, холбогч, зөвлөх офицер, штабын офицер, ахлагч гэсэн статустайгаар тус тус оролцуулдаг.

2.1 Цэргийн багуудын ажиллагаа

2.1.1 Сьерра Леон Улс дахь НҮБ-ын энхийг сахиулах “UNMIL” ажиллагаа

Тус ажиллагаанд Монгол Улсын цэргийн баг 2006 оны 1 дүгээр сараас 2011 оны 3 дугаар сар хүртэл оролцсон бөгөөд цэргийн багийн нийт 10 ээлжинд 2300 цэргийн алба хаагчид үүрэг гүйцэтгэсэн.

2.1.2 Чад, ТАБНУ дахь НҮБ-ын энхийг сахиулах “MINURCAT” ажиллагаа

2009 оны цэргийн багийн 2 ээлжийн 528 цэргийн алба хаагчид баазын харуул хамгаалалт, эргүүл, цувааны хамгаалалт, иргэн-цэргийн харилцаа, түргэн байрлах хүчний болон чухал хүний хамгаалалтын үүргүүдийг гүйцэтгэсэн.

2.1.3 Судан Улсын Дарфур муж дахь НҮБ болон Африкийн холбооны хамтарсан энхийг сахиулах “UNAMID” ажиллагаа

Одоогийн байдлаар эмнэлгийн цэргийн багийн нийт 6 ээлж үүрэг гүйцэтгэсэн бөгөөд 2015 оны 9 дүгээр сараас 7 дугаар ээлжийн цэргийн баг ажиллагааны газар оронд үүргээ амжилттай гүйцэтгэж байна.

2.1.4 Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах “UNMISS” ажиллагаа Тус ажиллагаанд мотобуудлагын батальоны нийт 4 ээлж үүрэг гүйцэтгэсэн бөгөөд 2015 оны 8 дугаар сараас тавдугаар ээлжийн мотобуудлагын батальон ажиллагааны газар оронд үүргээ хэвийн гүйцэтгэж байна.

2.2 НҮБ-ын цэргийн ажиглагч, холбогч болон штабын офицерууд

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс анх 2002 онд цэргийн 2 ажиглагч офицерыг илгээн оролцуулж эхэлснээс хойш нэг удаад үүрэг гүйцэтгэх цэргийн ажиглагч, холбогч, штабын офицер, ахлагч нарын тоо өссөөр одоогийн байдлаар НҮБ-ын UNAMA, MONUSCO, MINURSO UNAMID UNISFA UNMISS ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байна. Үүнд:

- Афганистан Улсад явагдаж буй ажиллагаанд цэргийн зөвлөхөөр 1 офицер цэргийн ажиглагчаар;
- БНАКУ-д явагдаж буй НҮБ-ын ажиллагаанд 2 офицер цэргийнажиглагчаар;
- Баруун Сахарт явагдаж буй НҮБ-ын ажиллагаанд 4 офицер цэргийнажиглагчаар;
- Судан Улсын Дарфур мужид явагдаж буй НҮБ/АХ-ны хамтарсан ажиллагаанд 2 офицер цэргийнажиглагчаар;
- Абией мужид явагдаж буй НҮБ-ын ажиллагаанд 2 офицер цэргийнажиглагчаар;
- БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын ажиллагаанд 2 офицер;
- БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын UNMISS ажиллагаанд 14 офицер Хүчний болон Секторын штабын офицeroор;
- БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын UNMISS ажиллагаанд 2 ахлагч Хүчний болон Секторын штабын ахлагчаар тус тус үүрэг гүйцэтгэж байна.

Өнгөрсөн хугацаанд нийт 181 цэргийн алба хаагч НҮБ-ын энхийг сахиулах 10 ажиллагаанд цэргийн ажиглагч, холбогч, штабын офицeroор үүргээ амжилттай гүйцэтгэсэн байна.

3. НАТО-гийн цэргийн ажиллагаа

3.1 Косово Улс дахь НАТО-гийн “KFOR” олон улсын цэргийн ажиллагаа
НАТО-гийн цэргийн Косовод явуулсан “KFOR” ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний салааны бүрэлдэхүүнтэй цэргийн баг 2005-2006 онуудад оролцож үүрэг гүйцэтгэсэн байна.

3.2 Афганистан Улсад явагдаж буй НАТО-гийн цэргийн “Аюулгүй байдлыг хангах олон улсын хүчин”-ий ажиллагаа

3.2.1 Эргүүл хамгаалалтын рот

Мотобуудлагын салаа хүртэлх цэргийн багийг ХБНГУ-ын “Фейзабад” цэргийн бааз болон нисэх онгоцны буудлын хамгаалалтыг хангах үүрэгтэйгээр ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран оролцож эхэлсэн. Эргүүл хамгаалалтын рот болгон өргөжүүлсэн бөгөөд 2009-2014 оны хооронд нийт 10 ээлжийн цэргийн баг үүргээ амжилттай гүйцэтгэсэн.

3.2.2 Нисдэг тэрэгний техникийн засвар үйлчилгээ, сургалтын бүлэг
2010-2014 онд нийт 8 ээлж үүргээ амжилттай гүйцэтгэсэн. нийт 170 гаруй нисэхийн механик, техникийн ажилтныг сургаж бэлтгэсэн.

3.2.3 Нисэх зурвасын хамгаалалтын салаа

Нийт цэргийн багийн 7 ээлж үүргээ амжилттай гүйцэтгэсэн.

3.2.4 Үндэсний ахлах төлөөлөгч, штабын офицерууд

2011 оноос “Аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх олон улсын хүчин”-ий ажиллагааны хойд бүсийн командлалд штабын офицерууд оролцуулж эхэлсэн.

Энхийг дэмжих ажиллагааны туршлага, сургамж

Монгол Улсын Зэвсэгт хүчний НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаан дахь оролцоо нь анхны 2 цэргийн ажиглагч офицерыг 2002 онд Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад явагдаж буй энхийг сахиулах ажиллагаанд илгээнсээс эхэлсэн түүхтэй. Үүнээс хойш 23 жилийн хугацаанд дэлхий нийтэд явагдсан НҮБ-ын энхийг сахиулах 10 ажиллагаа, Олон улсын эвслийн цэргийн болон НАТО-ийн цэргийн 5 ажиллагаанд нийт давхардсан тоогоор 22 000 цэргийн алба хаагч оролцож, дэлхий дахинд Монгол цэргийн ажиллагааны бэлэн байдал, үүрэг гүйцэтгэлт, үнэлэмжийг өндрөөр үнэлүүлж чадсан юм. Үүнээс эмэгтэй цэргийн алба хаагчдын оролцоо 1254 болжээ.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцсоноор цэргийн алба хаагчдын мэргэжлийн ур чадвар дээшлэн орчин үеийн цэргийн ажиллагаанд ашиглагдаж байгаа техник, технологид суралцах, түүнийг ашиглах чадварыг бүрэн эзэмшсэн төдийгүй бие бялдар, сэтгэл зүйн хувьд байгаль, цаг агаарын эрс тэс уур амьсгал, газар орны аюултай орчин нөхцөлд үүрэг гүйцэтгэх чадавхи нэмэгдэж, ажиллагааны арга техникт суралцан дадлагажсан.

НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны болон олон улсын цэргийн штабын шийдвэр гаргах, төлөвлөх, гүйцэтгэх төвшинд офицер, ахлагч нарыг үүрэг гүйцэтгүүлсэнээр бие бүрэлдэхүүний штабын мэдлэг болон удирдан зохион байгуулах ур чадвар дээшилж, Монгол Улсад олон улсын энхийг дэмжих ажиллагааны болон хамтарсан сургалт, дадлагуудыг мэргэжлийн өндөр түвшинд амжилттай зохион байгуулах бие бүрэлдэхүүний нөөц, боломжууд бүрдсэн. Миний бие 2007 онуудад Монгол улсад зохион байгуулагдсан “Хааны Эрэлд” Команд Штабын сургуульд НҮБ-ын Олон улсын Цэргийн Хүчний штабын дарга, 2008 онд НҮБ-ын Олон улсын Цэргийн Хүчний Командлагчаар оролцсон. Лу.Болд сайдын өгсөн үүргийн дагуу “Иракийн эрх чөлөө” анхны баримтат киног удирдаж хийлгэсэн, олон улсын жишгээр манай арми цэрэг-техникийн дунд хугацааны хөгжлийн стратеги бодлоготой болж “ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БАЙГУУЛАЛТЫГ 2015 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР” баримт бичиг батлагдаж түүн дотор НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох чадвартай бригадтай болох зорилго, зорилт оруулах ажилд хувь нэмэр оруулсандаа би баяртай явдаг юм.

Эцэст нь манай цэргийн шинэчлэлийн бодлого зөв зам дээр гарсан нь энхийг сахиулах үүрэг гүйцэтгэх явцад олон талаар батлагдаж байдаг. Монгол цэргүүд чмар ч нөхцөлд үүрэг гүйцэтгэх чадвар, сахилга, тэсвэр хатуужил, зохион байгуулалт өндөр байгаа нь харгдлаа. Дээр нь их зүйл сурч байна. Монгол цэргийн түүхэн шилдэг сайн чадвар, чанар хэвээр байна.

АШИГЛАСАН НИЙТЛЭЛҮҮД

1. Ч.Сосорбарам Энхийг сахиулах нь болзошгүй холбоотнуудтай хамтран ажиллах бэлтгэл: Зууны мэдээ 1999–12-21 №259 Ярилцсан сэтгүүлч: Билгээ
2. Ч.Сосорбарам Армийн тухай асуудлыг авч үзэхдээ Улаан Од сонины 1990 06-02, №“44”
3. Ч.Сосорбарам “Ардчилал ба цэргийн шинэчлэл” 2009 12 20 сайтад гарсан <http://www.dailynews.mn/modules.php?name=News&file=>
4. 2002 оос 2009 онд СУТГ-ын дарга байсан
5. 2016 аас 2019 онд ГХАГД-ын дарга байсан

ГЛОБАЛЬЧЛАЛ БА ҮНДЭСНИЙ ҮНЭТ ЗҮЙЛСИЙН УЯЛДАА

М.МӨНХЗУЛ

ХААИС-ийн НҮТ-ийн багш, доктор

Г.УЯНГА

ХААИС-ийн НҮТ-ийн багш, доктор

Хураангуй: Глобальчлал нь үндэстнүүдэд ямар нөлөө үзүүлж байгаа вэ? гэсэн асуулт нь нэлээн маргаантай сэдэв мөн. Глобальчлалыг дэмжигчид энэ асуултад “ардчилал бэхжих, энх тайвнаар зэрэгцэн орших, хүний эрх хангагдах нэг суурь нөхцөл болох, эдийн засаг тэлэх” гэх мэт үндэслэлүүдийг хэлнэ. Шүүмжлэгчид нь “глобальчлалын нөлөөгөөр үндэстэн өөрийн үнэт зүйлээ алдах, амьдралын уламжлалт хэв маягт өөрчлөлт орох, гадаад, дотоодын эдийн засгийн магнатууд төрийн байгууллагуудад ашиг сонирхлоо тулгах зэрэг олон сөрөг үр дагавар байна” гэж мэтгэнэ. Гэвч бид хоёр туйл болсон дээрх хоёр хариултын аль нэгийг баримжаалж “нэг бол глобальчлалыг туйлчилан хүлээн авах” нөгөө бол түүнээс татгалзах замаар дангааршин амьдрах бололцоогүй. Харин ямар хүрээнд хэр хэмжээнд глобальчлалыг зөвшөөрөх юм бэ? гэдэгт тодорхой хариулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, эдийн засаг, улс төр-нийгэм, боловсрол-соёлын үнэт зүйлийн хүрээнд үндэсний үнэт зүйлээ хэр хэмжээнд хадгалах ёстой юм бэ?, хадгална гэдэг нь юу гэсэн үг юм бэ? гэсэн асуултад хариулт эрэлхийлэв.

Түлхүүр үг: Глобальчлал, үндэстэн, үндэсний үнэт зүйл, дангааршил

Оршил: Энэ эрин үеийн глобальчлал хэмээх үйл явцад улс үндэстнүүд хэрхэн өөрсдийн үндэсний онцлогоо илэрхийлж буй нь нэлээн төвөгтэй бөгөөд зөрчил бүхий асуудлуудын нэг юм. Глобальчлалын мөн чанар, ач холбогдлыг тайлбарлах нь энх тайвнаар зэрэгцэн оршиход шаардлагатай олон асуудалд хандах арга зүйн чиг баримжаа болж байна. Глобальчлал нь эдийн засгийн хүрээнд хөдөлмөрийн зах зээл, худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа зэргээр голлон хэрэгжиж байгаа бол улс төрийн хүрээнд ардчилал, хүний эрхийн үнэт зүйлсээр дамжиж тэлж байна. Түүнчлэн мэдээлэл харилцаа холбооны ололт нь глобальчлалын хүрээг тэлж буй төдийгүй үүнээс гадна үндэстэн дамнасан соёлын солилцоо, амьдралын хэв маягын хувьд адилхан болох үйл явц гүн гүнзгий явагдаж байна. Японы бизнесмэн К.Охеми “уламжлалт үндэсний төр улс ер бусын, бизнесийн үзлийн үүднээс авч үзэх боломжгүй гэж бодогдохоор өөрчлөгдөж глобальчлагдсан эдийн засгийн нэгж болно, харин дэлхийн хуучин газрын зураг худал зүйл болж хувирч байна”¹ хэмээсэн байдаг. Энэ хирээр үндэстний гэх соёл, үнэт зүйл бүдгэрч байна. Энэ талаар Я.Пенроуз “угсаатны бүлгүүд болон үндэстнүүдийн уламжлалт үнэт зүйл нь глобальчлалын улмаас дэлхийн дэглэмд харш бөгөөд тохиромжгүй болно”² гэжээ. Түүнчлэн Ж.Нейсбит “бид 1000 орны ертөнц рүү явж байна....үндэсний төр улсууд сөнөнө. Үндэсний төр улсууд супер улсуудад залгигдах бус харин авсаархан, том компани шиг болж бутарна”³ гэж тэмдэглэсэн байдаг.

1960-аад оны эхээр Канадын философич М.Маклюэны зохиолд “глобальчлагдсан тосгон” гэсэн ойлголт гарсан байдаг. Энэ эрдэмтний бичсэнээр харилцаа холбоо, мэдээлэл хэрэгслийн хөгжлийн үр дүнд цаг хугацаа, орон зай хоёрын ялгаа алга болж дэлхийн хамгийн багахан тосгон хүртэл цахилгаанаар ороогджээ. Гэхдээ бид телевизийн нөлөөлөх нөлөөг олж хараагүй, бид глобальчлалын тосгонд уриалан дуудаагүй, бид зүгээр л анхнаасаа тэнд сууж байсан шүү дээ”⁴ гэсэн байдаг. Мөн түүнчлэн түүний үзлээр “глобальчлал нь соёлын ижилсэлд зайлшгүй хүргэнэ, үндэсний үнэт зүйлсийг өөрчлөх хүчтэй зэвсэг болно” гэдгийг урьдчилан харж “одоо манай дэлхийн зах зээлийн гэнцвэрийг дэмжиж байгаагийн нэгэн адил бүхэл бүтэн соёлын сэтгэл хөдлөл болон түүний тогтвортой байдлыг програмчлах цаг ирнэ”⁵ гэжээ.

¹ Omahe.K. (1995) The end nation state. New-York. P 256

² J.Gray (1998) Falce dawn. The delusions of global capitalism. London. P 68

³ Мөн тэнд

⁴ [Lerche.Ch](#) (1998) The conflicts of globalization. Formosa. P 59

⁵ Мөн тэнд

Ижилсэх үйл явц нь зөвхөн материаллаг зүйлд биш үнэт зүйл, дадал заншил, эрхэм хүсэлд хүртэл хутгалдан холилдсон байна. Нийтийн мэдээллийн хэрэгсэл, эдийн засгийн бүсчлэл, газар сайгүй нэг маягийн бараа, ахуйн хэрэглээ түгж байгаагийн нөлөөгөөр мөрөөдөл, уламжлал, сонирхол нь нэг орлуулагчаар солигдсоор байна.

Гэвч “Европ болон хойд Америк тивийн орнуудын глобальчлагдсан өрнөдийн соёлын эсрэг глобальчлалын нөхцөл байдалд үлдэж хоцорсон бага буурай үндэстнүүдийн үнэт зүйл эсэргүүцсэн байр суурьтай байна. Энэ бүхэн үндэсний ялгааг арилгаагүйгээр үл барам өөрийн үндэсний онцлогоо илэрхийлэх, нэг ард түмнийг нөгөөгөөс ялгах соёлын ялгааг илрүүлэхэд хүргэж үндэсний ухамсар нь улам сэргэж байгаа нь”¹ нэлээд сонирхол татаж байна.

Дэлхийн зарим улсад глобальчлалын эсрэг хандлага улам бүр ажиглагдаж байна. Өнөө үед үндэсний хоол, уламжлалт идээ будаагаа эрхэмлэх нь мода болж байна. Жишээлбэл, Францчууд Орос хүмүүс шиг бяслаг биш, харин Франц шинэхэн загасан талхаа эрхэмлэж байна. Мөнхүү үндэсний хувцасаа эрхэмлэх нь нэлээд түгээмэл болсон. Глобальчлалын хэл хүртэл эсэргүүцэлтэй тулгарч олон оронд Англи хэлийг тоохгүй болсноор үл барам гадаадын хүн англиар олон юм хэлэхийн оронд нутгийн хэлээр хазгай эвгүй ч хамаагүй хэлсэн нэг хоёр үг илүү нөлөөлөх болжээ. Европын орнуудад худалдаж байгаа барааны шошгыг дан ганц англи хэлээр бичиж болох байхад олон хэлээр бичсэн байгаа нь инээдтэй мөртлөө үндэсний хэлний бодлого гэдэг үүднээс зөвтгөж болох юм.

Глобальчлалын нэг чухал зүйл бол олон улсын, эдийн засгийн, улс төрийн бүсчлэлийн үйл явц, харилцаа холбоо, нийтийн мэдээллийн хэрэгслийн хөгжил, дэлхий дахины хэмжээнд чөлөөтэй байдаг болсон нь соёлын талаар янз бүрийн түвшинд байнгын харилцаа холбоо тогтоох, янз бүрийн соёл өөр хоорондоо нөлөөлцөхөд хүргэж байгаа явдал юм. Улс үндэстнүүдийн эдийн засгийн салбар харилцан ойртож байгаа хэдий ч өөр хоорондын ялгаа байсаар байна. Соёлын “үл ойлголцол” заримдаа ноцтой уршигт хүргэх талтай. Үндэстнүүд ойртож байгаа мэт боловч үнэт зүйл, амьдралд харилцах харилцаа, орчноо ойлгох ойлголтын ялгаа, үндэсний онцлогийн ялгаа байсаар байна.

Хүний чухал хэрэгцээний нэгэнд нийгмийн бүлэглэл, шашин шүтлэг, улс төрийн нам бүлэг, газарзүйн бүс нутаг зэрэг ямар нэгэн зүйлд өөрийгөө заавал хамаатай байлгах хүсэл эрмэлзэл зүй ёсоор багтдаг. Өөрийгөө таниулах ижилсэлийн эдгээр хэлбэрүүдийн дунд соёлын ижилсэл нь хамгийн дээгүүрт ордог. Мөн тухайн хүний ухамсар, оюун санааны сэтгэлгээ, амьдралын хэв маяг, байр суурийг бүхэлд нь ихээхэн хэмжээгээр тодорхойлж өгдөг. Судлаачид “АНУ нь санаатайгаар хэл соёлын олон төрөл зүйлийг устган, дэлхийн соёл иргэншлийн хувьд нэгэн ижил хэлбэртэй болгох зорилго бүхий үнэт зүйлийг боловсруулан гаргасан”². Учир нь дэлхийн хэмжээний болон бүс нутаг, улс орны томоохон өөрчлөлт шинэчлэлийн цаана үндэсний үнэт зүйл нь оршдог. Нөгөө талаас харвал глобальчлалын нөлөө нь шууд бус замаар тухайн улсын үндэсний үнэт зүйлсийг өөрчлөгдөхөд хүргэдэг. Гэхдээ энэ өөрчлөлт нь юуны өмнө үндэсний хэлийг дайран гарч байгаа бөгөөд үүнээс улбаалаад үндэсний үнэт зүйлс, үндэсний хэлний утга учир алдагдахад хүрч байна.

Эдийн засгийн аливаа үйл ажиллагааг үр өгөөжтэй явуулахын тулд цаг үеэ олсон мэдээллийн солилцоог тогтсон аль нэг хэл дээр хэрэгжүүлэх шаардлагатай болсон хэдий ч тодорхой нэгэн хувь хүн нийгэм, угсаатны аль аль нь хамгийн түрүүнд өөрийгөө хэл ярианы тусламжтайгаар таниулдаг. Тиймээс хэлийг үл ойшоох, тэр дундаа тухайн хэл ярианы тархац цар хүрээ багасах үйл явцыг хүмүүс эмзэгээр хүлээн авдаг. Үнэ цэнийн хувьд хэл нь дан ганц мэдээлэл дамжуулах хэрэгсэл болоод зогсохгүй тухайн хэлийг тээгч улс ард түмний ертөнцийг үзэх үзэл нь болдог. Хэл нь тухайн үндэстний түүх намтрыг агуулдаг бөгөөд хүрээлэн байгаа орчны тусгал болдог. Хэл нь үндэстний гэх шинж тэмдгийн салшгүй хэсэг байдаг. Өөрөөр хэлбэл, хэлгүйгээр үндэстэн гэж байхгүй. Үндэсний ухамсарт хэлийг халамж хайхрамж шаарддаг амьд организмын нэгэн адил гэж тооцдог. Ямарваа хэлийг алдсанаар тухайн үндэстний түүхэн өв уламжлал, цаг хугацааны уялдаа холбоо, дурсамжууд устан үгүй болдог. Хэл гэдэг бол төрөлхийн бөгөөд тухайн хүний амьдралын турш дахь хувийн өмч мөн. Тиймээс

¹ Fitoussi.J (1997) Mondialisation et inegalites. Futuribles. P 12

² Held.D. (1997) Democracy and globalization /Global governance/ Boulder. P 3

үндэсний хэл нь соёл, ухамсрын хамгийн чухал үзэгдэл билээ. Хэлгүйгээр ухамсар гэж үгүй. Ухамсрын бүхий л үзэгдлүүд хэлээр илэрдэг. Өөрөөр хэлбэл, бүхнийг эзэлхүүнтэй болгож өгдөг. Мөн тухайн цаг үе орчин нөхцөлд оршин тогтнож буй орчинг тодорхойлдог байна. Ерөнхийдөө хэл дотор үндэсний ухамсар, соёл оршин байдаг.

Бид эх хэлээ глобальчлалын нөхцөлд хадгалж хамгаалж чадаж байна уу?

№	Шалгуур	Зөрчиж буй кейс
1	Эх хэлийг залуу үе нь ашиглаж байна уу?	залуучууд гадаад үгийг эх хэлтэйгээ хольж ярих байдал нэмэгдэж байна.
2	Эх хэлээрээ албан ёсны сургалтын үйл ажиллагаа явагддаг уу?	Явагддаг, гэхдээ гадаад хэл дээр сургалт явуулах байдал улам бүр нэмэгдэж байна.
3	Төрийн хэл нь эх хэл нь байна уу?	Төрийн байгууллагуудын гаргасан тушаал, шийдвэр нь найруулгын болон зөв бичих дүрмийн алдаатай байх тохиолдол байна.
4	Эх хэлээ өдөр тутамдаа иргэд ашиглаж байна уу?	Ашиглаж байгаа мэт боловч хотын гудмаар хаяг, реклам, нэршил нь гадаад хэл дээр байна.
5	Үндэсний бичиг үсгийн хэрэглээ байна уу?	Үндэсний бичиг үсгээр унших, бичиж чаддаг хүмүүс цөөн.
6	Эх хэлний боловсрол олгох үйл ажиллагаа тогтмол явагддаг уу?	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол, дээд боловсролын бүх түвшинд эх хэлний боловсрол олгох заавал судлах судлагдахуунтай.
7	Эх хэлний бодлоготой юу?	Эх хэлний бодлоготой, эх хэлний үндэсний зөвлөл ажилладаг хэдий ч үйл ажиллагаа нь хүртээмжтэй биш.

Цаашлаад глобальчлалын үйл явцууд нь ой санамж, дурсамжууд алдагдах үндэс суурь нь болох талтай. Ой санамжид тухайн бүлгийн ахуй амьдралын хэв маяг, нийгэм ба оюун санааны туршлагыг тогтоох, хадгалах, санах үйл явцууд явагддаг. Хэрэв хүн ой санамжаа алдвал бие махбодийн хувьд оршин тогтнож чадах хэдий ч түүний хувьд өөрийн гэсэн өнгөрсөн, одоо, ирээдүй байхгүй болно. Тэр хүн улмаар өөрийгөө хэн болох, ямар учраас оршин тогтнож байгаа болон юу хүсч байгаагаа мэдэхгүй нь ойлгомжтой. Хувь хүний амьдралд ой санамж нь ухамсарт нь мөн тухайн нийгэм, үндэстний түүхэн аж амьдралд агуулагддаг. Үндэсний үнэт зүйлийг үеийн үед өвлүүлэн дамжуулагч нь ой санамж, ухамсар нь юм. Биологийн амьд организмуудын хувьд энэхүү үүргийг генийн бүтэц гүйцэтгэдэг. Нарийвчлавал байгалийн амьд организмын төрөл бүрийн популяцийг генетикийн удамшлаар тодорхойлдог бөгөөд удамшил нь цусаар дамжигддаг. Харин хүмүүсийн нийгмийн туршлагыг цусаар бус соёл, ухамсрын арга хэрэгслээр үеэс үед өвлүүлэн дамжуулдаг. Энэ утгаараа ухамсрыг генетикийн бус ой санамж гэж хэлж болно. Үндэстэн нь өөрийн нэгдмэл байдлыг ухааран ойлгож, түүхэн ой санамжаа хадгалан авч явснаараа одоо ба ирээдүйнхээ суурийг тавьж, өнгөрснийг таних боломжтой болдог. Ухамсар нь цаг хугацааны холбоог тасралтгүй нэгэн бүхэл зүйл мэтээр төсөөлдөг бөгөөд ийм учраас хүн төрөлхтний түүхэн хөгжилд эрт дээр үеийн өвөг дээдсээсээ холбоогоо таслалгүй ирсэн. Хэний ч өвөг дээдэс болон тэдний үйл хэрэг хойч үеийнхнийх нь амьдралд өөрийн нөлөөг үзүүлж байдаг.

Хүмүүс гадны соёлтой харьцах явцдаа ихэнх тохиолдолд өөрийн үндэстнээрээ бахархах бахархалаа улам бэхжүүлдэг. Тухайн хувь хүн зан чанараараа өөрийн үндэстэнтэйгээ ижил байдаг, үндэстний хувь заяа ба ухамсар нь түүний амьдралд байнга нөлөөлсөөр ирсэн, үндэстэн өөрөө түүнд оршиж биелэлээ олж байдгийг мэдсэн үед тэр хүн ямар нэгэн улс үндэстэнд

харьяалагдаж байгаагаа ухамсарладаг. Тэрээр улс үндэсээ өөрийн “би”-ийн нэгэн хэсэг мэт хүлээн авдаг тул тэрхүү улс үндэстэнд чиглэсэн тохуурхал доромжлолыг хувийн доромжлол мэтээр хүлээн авдаг¹. Мөн өөрийн улс үндэстний ололт амжилт болон эх орон нь бусад улсуудад хүлээн зөвшөөрөгдөх байдлыг үндэсний ба хувийн бахархал болгон хүлээн авч үздэг. Хүн өөрийн соёлоор танигдан тодорхойлогддог болохыг наад захын энгийн жишээнээс харж болно. Тухайлбал, тийм ч чухал биш асуудал мэт санагдах бэлэн хоол хүнсний салбарт гарсан өөрчлөлтийг үндэстэн бүр маш эмзэгээр хүлээж авдаг. Гүрж улсад л гэхэд түргэн хоолны “макдоналдс” болон “кока-кола” корпорациуд орж ирэх үед юу болсныг товч дурьдая. “Макдональдизаци” хэмээх үгийг “глобальчлал” хэмээх синоним буюу ижил төстэй утгатай мэтээр ойлгоход хүрээд байгаа энэхүү үзэгдэл глобальчлалын нэгэн адил ард түмний уламжлал, шашин шүтлэг, ёс зүй, урлаг, өдөр тутмын амьдралд хэр ихээр нөлөөлж байгааг илэрхийлэх байх. Эдгээрээс харахад уламжлалт байр суурьтай байгаа бөгөөд өөрчлөлт шинэчлэлтийг төдийлөн хийдэггүй ард түмэн глобальчлалын үйл явцуудыг илүү хүчтэйгээр эсэргүүцэж байгаа нь илэрхий байна. Тэдний хувьд үндэсний үнэт зүйл, үндэсний соёл, түүхэн дурсамж ой санамжийн ач холбогдолтой байдаг учраас соёлыг аж амьдралаа авч явах төрөлхийн загвар мэтээр хүлээн авдаг². Үндэсний үнэт зүйлээс татгалзах нь ой санамжаа алдах, улмаар өөрийн дахин давтагдашгүй байдлаа арилгахтай зүйрлэж болно. Үндэсний үнэт зүйл нь соёлын тасралтгүй шинж чанарыг хувь хүний үхлийг үгүйсгэх, мөнхийн амьдрал байдаг хэмээн үздэгтэй холбож болно. Соёл нь өөрийгөө тээгч хүн бүрт биеэ зохистой авч явах байдал, үнэ цэн хэм хэмжээний талаарх шаардлагыг тавьдаг. Эдгээр шаардлага нь хувь хүний хувьд сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангахад тусалдаг. Хэрэв тухайн хүний өдөр тутмын амьдралд олон өөр соёлын системүүд оролцон, нийгмийн орчин нь түүнийг өөрийн соёлын хэм хэмжээтэй нийцэхгүй эсвэл үгүйсгэсэн ямар нэгэн үйл хэрэг хийхийг шаардсан тийм нөхцөл байдалд орсон тохиолдолд тухайн хүн өөрийн соёлын хэв шинжийг ихэнхдээ хадгалан үлдээхийг оролддог. Энэ байдлыг адаптаци буюу дасан зохицох хэмээн ойлгож болно. Тухайлбал, нэг хүн аль эсвэл бүлэг хүн бие биедээ эсрэгцсэн эсвэл бие биеэ үгүйсгэсэн олон өөр үндэсний ухамсрын системийн шаардлагыг биелүүлэх хэрэгтэй болдог. Эдгээр зөрчил нь тухайн хүний ухамсрын бүхэллэг байдлыг нураахад хүргэхээс гадна хувь хүний болон тухайн бүлэг хүмүүсийн дотоод тэнцвэрт байдал алдагдахад нөлөөлдөг. Үүний үр дүнд тухайн хүн эсвэл бүлэг хүмүүсийн биеэ авч явах байдалд өөрчлөлт гарч, хувь хүн дотоод зөрчилдөөнтэй байгаа нь хэрцгий түрэмгий зан авиртай болох, үндсэрхэг үзэл санааг гаргах, гэмт хэргийн үйл ажиллагаанд оролцох аль эсвэл сэтгэлийн дарамтанд орох, меланхолик зан ааштай болж хувирах гэх мэт байдлаар илэрч болно.

Глобальчлалын эсрэг хандлагыг ямар хүчин зүйлс өдөөн гаргаж ирдэг буюу өөр өөр соёл, ухамсрууд дэлхий нийтийг хамарсан нэгдсэн нийгмийг байгуулах үйл явцад хэрхэн хандаж байгаа талаар зайлшгүй хөндөх хэрэгтэй. Хамгийн түрүүнд глобальчлалын үйл явцыг хамгийн ширүүнээр эсэргүүцэгч үндэстнүүд болох лалын шашинтнуудын улс орнуудын үндэсний ухамсрын талаар авч үзье. Өмнөх хэсгүүдэд дурьдсан аливаа үндэстэнд үнэ цэнтэй байдаг уламжлал, хэл, үнэт зүйлс, сэтгэлгээ, амьдралын хэв маяг бүхэн нь лалын орнуудад мөн адил үнэ цэнтэй. Гэхдээ тухайн үндэстнүүдэд бусдаас ялгарах гол онцлог нь тэд глобальчлалын үйл явц гэдгийг уламжлалт дайснууд болох христос шашинтнуудын ололт амжилт мэтээр ойлгосоор ирсэн. Тэдний зүгт хандсан улс төр, эдийн засаг, соёл, тэр тусмаа цэрэг дайны үйл ажиллагаа бүрийг тэд загалмайтнуудын байлдан дагуулал мэтээр хүлээн авдаг. Лалын шашинт улс орнуудын олон зуун жилийн түүхэн дурсамж, ой санамж нь христос шашинтнуудын эсрэг тэмцэл дээр бий болсон бөгөөд тэдний шашны гол судар Коран сударт үүнтэй холбоотой маш радикал номлол сургаалиуд бичигдсэн байдаг. Лалын шашинтнуудын христийн эсрэг энэхүү тэмцэл эсэргүүцлийг Кораны номлолуудад шашны дайнаар илэрхийлдэг. Тэр бүү хэл өөрийн итгэл үнэмшлийнхээ төлөө амь биеэ өгсөн лалын шашинтан бүр диваажинд өөрийн байрыг олж авах болно хэмээн бичсэн байдаг. Лалын шашинтны соёл өөрийн шашныг төдийлөн шинэчлэн

¹ Тишков.В.А.О нация и национализме. Свободная мысль.1996.№3.х.50

² Тишков.В.А.О нация и национализме. Свободная мысль.1996.№3.х.3,35

өөрчилсөнгүй. Өнөөг хүртэл шашин нь үндэсний ухамсрын гол бүрэлдэхүүн, гол тэнхлэг байсаар ирсэн учир ямарваа үйл явдлыг үнэлж дүгнэхдээ шашны ухамсраар ханддаг байна.

Өөрийн гэсэн характер бүхий эсэргүүцлийг үнэн алдартны шашин болон славян соёлын төлөөлөл болсон улс үндэснүүд тухайлбал, ОХУ гаргасаар ирсэн. ОХУ-ын глобальчлалд хандах хандлага, эсэргүүцэл нь тус улсын нэгэн үед их гүрэн байсныхаа хувьд өөрийн гэсэн онцлог хэв маягтай илэрдэг бөгөөд эсэргүүцэл нь тэдний сэтгэл зүрхнээс гардаг гэж хэлж болно. Олон зууны турш Орос улс панславяк үзэл санааг дэвшүүлэн дэмжсээр ирсэн нь гурав дахь Ром болох мөрөөдөлтэй холбоотой байсан. Гурав дахь Ромын тухайд гэвэл өдийд харамсалтай нь Москва бус Вашингтон болоод байна. Оросын улс төрийн чиг баримжаа, бодлогуудыг харвал яахын аргагүй антиглобалист хандлагатай. Тэрээр АНУ-тай өрсөлдсөөр ирсэн ч АНУ-ын эсрэг зогсох хангалттай хүчийг бий болгоогүй байна¹.

Зүүн Европын улс орнуудын хувьд энэ бүс нутагт глобалист үзэл санаа үүссэн хэдий ч тэдний өнөөгийн байр суурь бодит биш уран сайхны байдлаар дүрслэгдсэн шинжтэй байгаа юм. Нэг талаас харахад баруун Европын орнууд глобальчлалын үйл явц дунд АНУ-ын түнш мэт харагдах боловч уг үйл явц нь эдгээр улсуудын үндэсний сүрийг бууруулсан нь тодорхой харагдаж байна. Харин эдгээр улсууд өөрийн үндэсний сүр сүлд, бахархалыг эргээд өөрийн хэл болон урлагаа хамгаалах зорилгоор сэргээхийг оролдож, тийнхүү үндэсний ухамсраа илэрхийлж байна. Үүнийг Франц, Герман, Италийн соёлыг ойртон ажиглах замаар тодорхой олж харж болно. Шинэ нэгдсэн мөнгөн тэмдэгт гаргасныг ч мөн дээрхийн нэгэн адилаар тайлбарлаж болох юм. Английн хувьд өөрийн амбицийг хэрхэн хангаж байна вэ гэвэл глобальчлалын үр дүнд англи хэл дэлхийн хэл болж байгаагаар тус улс сүр хүчээ нөхөх боломжтой болсон.

Глобальчлалын эсрэг харьцангуй хүлээцтэйгээр эсэргүүцлээ үзүүлж байгаа төлөөллийн нэг Хятадын соёл, ухамсар юм. Европын орнуудтай харьцуулахад “Дорно дахины орнууд тэр дундаа Хятад, Энэтхэг, Япон, Солонгос зэрэгт үндэсний үзэл нь нэлээд хөгжсөн гэхэд болно”². Орчин үед тэд Хятадын их цагаан хэрмийг орчин энэ цаг үеийн дүр төрхтэйгээр бүтээн босгохыг хичээж байна. Хятадын соёлд гарч байгаа өөрчлөлтүүдийг тус соёл бүхий ард түмэн эмгэнэлтэйгээр хүлээн авч байгаа бөгөөд глобальчлал нь тэдний соёлын үнэт зүйл болсон “алтан үе”-ээс улам ихээр холдуулж байна хэмээн үзэж байгаа юм. Тиймээс Хятад үндэстнүүд тэдний үндэсний ухамсрыг арын эгнээнд шахан оруулах гадны хэлээр ярих тэрхүү урхинд төдлийн автдаггүй. Хятадууд хүний эрх, эрх чөлөөний талаарх аливаа ярианаас зайлсхийж ирсэн учраас өөрийн үндэсний дахин давтагдашгүй байдлыг хадгалан үлдээж чадсан.

Түүхээс үзэхэд цэрэг зэвсгийн хүчээр нэгтгэн хурааж, төрийн нэгэн далбааны дор тууж оруулсан олон угсаатан, олон хэл, соёл бүхий үндэстний хувьд байдал тогтворгүй байна. Харин язгуурын ойр төрөл угсаатнуудаас анх бүрэлдэж бий болсон, үндэсний үнэт зүйлийн хувьд нэгдмэл, хэл ба соёл нэгтэй нэгэн дан угсаатнаас бүрдсэн улс үндэстэн бол үндэсний дархлаа сайтай, урт настай, эв нэгдэл нь бат бэх эрмэлзэх тэмүүлэх зүйлс нь ч адилхан байх магадлалтай. Энэ нь үндэстний бүрэн бүтэн байдалд үнэт зүйлийн нэгдмэл байдал чухал байна гэсэн үг.

Дүгнэлт: Аливаа улс орнууд нэг холбоонд нэгдэж хамтран амьдрахад өөр хоорондын тэмцэл эцэслэж, энх тайван амар амгалан орших, гадны довтолгоог хамтын хүчээр няцаах, эдийн засаг, нийгмийн харилцаандаа бие биенээсээ дэмжлэг авах, харилцан соёл, зан заншлын нийтлэг харилцааг бий болгох гэх мэт глобальчлалын сайн талууд маш их бий. Харин нөгөөтэйгүүр өөр өөрсдийн үндэс язгуураа бусдын нөлөөнд алдахгүй байх, хэл, соёл, үнэт зүйлээ хадгалах, тусгаар улсын хэмжээнд өөрийн үндэсний төр улсын гадаад бодлого явуулах зэрэг сөрөг нөлөөнүүдтэй учирч болох болгоомж үүсч үүний улмаас дангааршилын талаарх санаа яригддаг. Гэвч дангаарших гэсэн оролдлого тодорхой үндэстэнд үр ашиг багатай. Өнөөгийн нөхцөлд үнэт зүйлээ хадгална гэдэг нь шинэчлэлээс зайлсхийх бус үндэсний эрх ашигт нийцүүлэн шинэчлэл хийхийг хэлнэ. Аливаа соёл шинэчлэгдэж байж уламжлагддаг. Тиймээс аль нэг үнэт зүйлээрээ дангаарших гэхээс илүүтэй тэрхүү соёлд шаардлагатай

¹ Болд-Эрдэнэ.Д (2014) Үндэсний үзлийн мөн чанар: төөрөгдөл, уг чанар, хүч боломж. Философи эрхийн судлал. №29. УБ. 179 дэх тал

² Мөн тэнд

шинэчлэлийг хийх замаар глобальчлалд үнэт зүйлээ уялдуулах шаардлага байна. Энэхүү шаардлагыг хэрэгжүүлэхэд соёлын салбар хамгийн эзмэг хэдий ч бид үүнээс буцах аргагүй. Глобальчлалын нөхцөлтэй өөрийн үнэт зүйлээ амжилттай уялдуулж чадсан нэг жишээ нь Япон үндэстэн мөн. Тухайлбал, Тэд сумо бөхийн спортыг бусад үндэстнүүдэд нээлттэй болгож шинэчилснээр тухайн спортоо дэлхийн хэмжээний болгожээ. Дэлхий нийтээрээ сумо бөхийг спортынх нь хувьд шударга, дэг жаягийн хувьд Япон үнэт зүйлээ хадгалсан хэвээр байна гэж дүгнэж байна. Өөрөөр хэлбэл, соёлоо шинэчлэх замаар улам бүр таниулж чаджээ. Үүний нэгэн адил бид ч амьдралыг төвөгтэй болгож буй шашин, ёс заншил, хэвшмэл үзлүүддээ шинэчлэл хийх замаар глобальчлалд үнэт зүйлээ уялдуулах хэрэгтэй байна.

НОМ ЗҮЙ

1. Болд-Эрдэнэ.Д “Үндэсний үзлийн мөн чанар: төөрөгдөл, уг чанар, хүч боломж. Философи эрхийн судлал”. №29. УБ 2014
2. Omaha.K. “The end nation state”. New-York. 1998
3. J.Gray “Falce dawn. The delusions of global capitalism”. London. 1998
4. [Lerche.Ch](#) “The conflicts of globalization”. Formosa. 1998
5. Fitoussi.J “Mondialisation et inegalites”. Futuribles. 1997
6. Held.D. “Democracy and globalization” /Global governance/ Boulder. 1997
7. Тишков.В.А.”О нация и национализме”. Свободная мысль.1996

АРИСТОТЕЛИЙН ЭВ НАЙРАМДЛЫН ОЙЛГОЛТ

Ш.ГАНХУЯГ

Доктор (Ph.D), ШУА, Философийн хүрээлэн

Х.АМАНТАЙ

Докторант, ШУА, Философийн хүрээлэн

Оршил ба судалгааны арга зүйн үндэслэл

Энхтайвныг философийн уламжлалд ихэвчлэн ёс суртахууны практик зорилт, улс төрийн тактик, эсвэл эрх зүйн шийдвэрлэх асуудал гэж ойлгож ирсэн боловч, энэхүү ойлголтыг онтологийн гүн гүнзгий түвшинд дахин сэргээн авч үзэх шаардлага урган гарч байна. Аристотелийн *De Anima*¹, *Никомахийн ёс зүй*², *Политик*³, *Риторик*⁴ зэрэг бүтээлүүдэд илэрдэг сэтгэлийн зохирол, зангийн дундаж, шударга ёсны харьцаа, иргэний нөхөрлөл, эв санааны нэгдэл (*homonoia*), хот-улсын телеологи зэрэг ойлголтуудыг системчилэн холбож үзэхэд энхтайван нь хүний амьдралын дээд зорилго, нийгмийн эмх журам, оюуны болон ёс суртахууны нөхцөл байдлын органик нэгдмэл үр дүн болохыг харуулж байна.

Энэхүү судалгааны арга зүй нь Аристотелийн өөрийн диалектик аргыг дагаж, эхлээд өмнөх философичдын (*endoxa*) байр суурийг шалгаж үзэж, дараа нь текстийн шүүмжлэлийн замаар анхдагч эх сурвалжуудыг нарийвчлан задлаж, эцэст нь ойлголтын шинжилгээ болон дүгнэлтийг гаргах системчилсэн хандлага баримтлав. Манай судалгааны гол тезис нь энхтайвны онтологийг "микро-мезо-макро" гурван түвшний хэлбэрээр дүрслэх боломжтойг харуулах явдал юм: хувь хүний дотоод сэтгэлийн зохицлоос (микро) эхлээд нийгмийн институцийн харилцаа (мезо), улмаар хот-улсын телеологийн зорилго (макро) хүртэлх үе шатуудыг нэгэн цогц системээр холбох онтологийн эмхтгэлийг тодруулах гэж оролдов.

Судалгааны арга зүйн бүтэц

Текст шүүмжлэлийн арга: *De Anima* II.1-ийн сэтгэлийн тодорхойлолт, *NE* II-ын дундажийн онол, *NE* V-ын шударга ёсны харьцаа, *NE* VIII–IX-ийн нөхөрлөлийн онол, *Politics* I.2-ын хот-улсын үүсэл, IV.11-ийн дунд ангийн үүрэг, V-ын зөрчлийн шалтгаан, VII.14-ийн боловсролын зорилго зэрэг зангилаа хэсгүүдийг дараалсан логикийн холбож, тэдгээрийн онтологийн уялдааг тодруулах замаар Аристотелийн энхтайвны системчилсэн ойлголтыг сэргээн босгоно.

Ойлголтын шинжилгээний арга: *Philia* (нөхөрлөл), *homonoia* (эв санааны нэгдэл), *dike* (шударга ёс), *mesotēs* (дундаж), *koinōnia* (харилцан оролцоо), *telos* (зорилго) зэрэг үндсэн философийн нэр томъёонуудыг зөвхөн хэл шинжлэлийн утгаараа бус, харин онтологийн функц, метафизикийн үүрэг, практик ач холбогдлын гурван түвшинд задлан шинжилж, тэдгээрийн хоорондын системчилсэн холбоог тодруулна.

Дүгнэлтэн дээр: Эв найрамдлыг хуульчлах, шахах замаар бий болгож болдоггүй, харин шударга ёсны пропорциональ зарчим, ёс суртахууны дундаж, иргэний боловсрол, дунд ангийн институцийн тогтвортой байдал зэрэг нөхцөлүүдийг бүрдүүлэх замаар органик байдлаар урган гарах онтологийн зохицлын үр дүн болохыг харуулна.

I. Микро түвшин: Сэтгэлийн хэлбэр ба дотоод эмхтгэлийн онтологи

1.1. Сэтгэл ба хэлбэрийн үндсэн уялдаа

Аристотелийн онтологийн системд сэтгэл (*psyche*) нь амьд биеийн хэлбэр (*morphe*) бөгөөд *De Anima* II.1-д "амьдрах боломжит биеийн анхдагч актуалчилал"⁵ гэж тодорхойлогдсон нь энхтайвны онтологийн хамгийн үндсэн түвшинийг бүрдүүлдэг. Энэ тодорхойлолтын гүн утга нь сэтгэлийг биеийн зохион байгуулдаг идеал зарчим болгон харуулж, тэдгээрийн харилцан зохицол нь "дотоод энхтайван"-ы суурийг тавьдаг онтологийн нөхцөлийг илэрхийлнэ.

Аристотель "Хэрэв нүд нь амьтан байсан бол харах нь түүний сэтгэл байх байсан. Энэ нь түүний хэлбэрээр илэрч буй мөн чанар юм"⁶ гэсэн жишээгээр сэтгэл ба биеийн уялдааг тодруулж байгаа нь зөвхөн метафор биш, харин онтологийн бодит харилцааг илэрхийлдэг. Энэхүү хилеморф материализмын (*hylomorphism*) үзэлээр сэтгэл нь хэлбэр (*morphe*), бие нь бодис (*hyle*) бөгөөд эдгээр нь салшгүй "нэг бүхэл"-ийг бүрдүүлдэг тул сэтгэлийн үйл ажиллагаа зөв зохицсон, утга

учиртай байх үед хувь хүний дотоод амгалан тогтож, микро түвшинд энхтайвны онтологийн суурь бүрэлддэг.

1.2. Ёс суртахууны дундаж ба дотоод зохицлын механизм

Никомахийн ёс зүй II.6-д зангийн сайн чанарыг "бидэнд хамаарах дундаж арга"⁷ гэж тодорхойлсон нь зөвхөн ёс суртахууны заавар төдийгүй, хувь хүний сэтгэлийн хүчнүүдийн (хүсэл, уур хилэн, айдас зэрэг) онтологийн зохицлын зарчмыг илэрхийлдэг. Аристотель дундажийг тооцоолох аргыг "зөв хугацаанд, зөв зүйлд, зөв хүмүүсийн харьцаанд, зөв зорилгоор, зөв аргаар мэдрэгдэх явдал"⁸ гэж тодорхойлж, хувь хүний амьдралын практик нөхцөлд энхтайвны микро түвшинг хэрхэн бүтээж болохыг харуулсан.

Риторик II.2-3-д уур хилэнгийн онтологийн шинжилгээ нь энэхүү дундажийн зарчмын тодорхой жишээг өгдөг. Уур хилэн бол "өшөө хариугаа авах хүсэл, өвдөлттэй хамт"⁹ нэгдсэнийг хэлэх боловч зөв хэмжээнд илэрвэл шударга ёсны үйл хэрэгт тус дэм болж, хэтрүүлсэн тохиолдолд дотоод болон гадна зөрчилд хүргэдэг. "Уур хилэн нь эсрэг талын хүний хэрэггүй байдал, өөрсдийн буруу үйл хэрэг, цаг хугацаа өнгөрснөөр намдана"¹⁰ гэсэн тайлбар нь зөвхөн сэтгэл зүйн техник бус, дотоод зохицлын философийн зарчмыг илэрхийлдэг.

Энэхүү зохицлыг Аристотель *phronesis* буюу мэргэн ухаан, оюуны шалтгаан (*logos*)-аар удирдуулан хэмждэг бөгөөд *NE* VI.5-д *phronesis*-ийг "хүний сайн байдалд хүргэх үйл ажиллагааны тухай зөв дүгнэлт хийх чадвар"¹¹ гэж тодорхойлсон нь микро түвшинд энхтайвны хэрхэн бүрэлдэхийг харуулж байна.

II. Мезо түвшин: Нийгмийн харилцаа ба шударга ёсны архитектур

2.1. Шударга ёсны онтологийн хоёр төрөл ба нийгмийн зохицол

Никомахийн ёс зүй V номд Аристотель шударга ёсыг хувиарлалтын (*distributive*) болон залруулгын (*corrective*) хоёр төрөлд хувааж тайлбарласан нь мезо түвшинд энхтайвны онтологийн бүтцийг тодруулдаг чухал ач холбогдолтой. "Хувиарлалтын шударга ёс нь геометр пропорцоор, залруулгын шударга ёс нь арифметик пропорцоор хэмжигдэнэ"¹² гэсэн зарчим нь нийгмийн баялаг, эрх мэдэл, хариуцлагын зөв хуваарилалт, зөрчлийн залруулгын механизмыг онтологийн түвшинд систематизалж, мезо түвшинд энхтайвны институцийн суурийг бүрдүүлдэг.

Хувиарлалтын шударга ёсны хувьд Аристотель "Тэгш зүйл нь тэгш хүмүүст, тэгш бус зүйл нь тэгш бус хүмүүст хуваарилагдах ёстой, гэхдээ энэ тэгш бус байдал нь зөв шалгуурын дагуу байх ёстой"¹³ гэж тодорхойлсон нь орчин үеийн Жон Роулсын шударга ёсны онолтой¹⁴ гүн гүнзгий философийн холбоотой. Гэвч Аристотелийн хандлага нь Роулсын процедурын шударга ёсноос ялгаатай байдлаар телеологийн зорилго, хүний *eudaimonia*-д үндэслэсэн материаллаг шударга ёсыг онцолдог.

2.2. Зөрчлийн шалтгаан ба дунд ангийн институцийн үүрэг

Politics V номд *stasis* буюу хувийн буюу бүлгийн тэмцлийн шалтгаан, үр дагаврыг шинжилж, мезо түвшинд энхтайванг устгадаг үндсэн хүчнүүдийг тодорхойлсон нь судалгааны чухал хэсэг болдог. "Зөрчил нь тэгш бус байдлаас үүсдэг. Тэгш байдлыг хайж байгаа хүмүүс бослого өдөөдөг"¹⁵ гэсэн ерөнхий зарчмыг дараах байдлаар нарийвчлан ангилсан:

Эдийн засгийн тэгш бус байдал: "Олигархи нь баячуудын засаглал, ардчилал нь ядуучуудын засаглал"¹⁶ гэсэн тодорхойлолтоор эдийн засгийн ангийн зөрүү зөрчлийн үндсэн шалтгаан болохыг харуулсан байдаг

Хүндэтгэлийн тэгш бус хуваарилалт: Сайн хүмүүс хангалттай хүндэтгэл, эрх мэдэл авч чадахгүй байх нөхцөлд "сайн хүмүүс өөрсдийн гавьяагаа хүлээн зөвшөөрүүлэхийн тулд зөрчилд ордог"¹⁷.

Эрх мэдлийн хэт төвлөрөл: Цөөхөн хүн бүх эрх мэдлийг барьж авах нөхцөлд "засаглал нь олон нийтийн сонирхлыг илэрхийлэхээ больж, хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болдог"¹⁸. Эдгээр асуудлыг шийдэх арга зам нь дунд анги давамгайлах бүтэц байхыг *Politics* IV.11-д (1295b–1296a) дурддаг. "Дунд анги давхарга нь хамгийн тогтвортой, учир нь тэд баялгийг хэт эрмэлздэггүй, бусад нь тэдний байр суурийг атаархдаггүй, мөн тэд шударга ёсыг дагаж мөрддөг"¹⁹ гэсэн онтологийн үндэслэл нь мезо түвшинд энхтайвны институцийн нөхцөлийг бүрдүүлдэг механизмыг тодруулна.

III. Макро түвшин: Иргэний нөхөрлөл, эв санааны нэгдэл ба хот-улсын телеологи

3.1. Нөхөрлөлийн онтологи ба *philia*-ийн улс төрийн функц

Никомахийн *ἔс зүй* VIII.1-д Аристотель "нөхөрлөл нь хот улсуудыг нэгдмэл цул мэт болгодог, хууль тогтоогчид үүнийг шударга ёсоос ч илүү эрхэмлэнэ"²⁰ гэж тодорхойлсон өгүүлбэр нь манай судалгааны төв тулгуур санаа болдог. Энэхүү өгүүлбэрийн онтологийн ач холбогдол нь нөхөрлөлийг зөвхөн хувийн харилцааны хүрээнд авч үзэхээс гадна, макро түвшинд хот-улсын тогтвортой байдлын суурь зарчим болгон тайлбарлах боломжийг олгодог.

Аристотель нөхөрлөлийг гурван төрөлд ангилж, тэдгээрийн макро түвшинд энхтайванд үзүүлэх нөлөөг ялгаатай байдлаар тодорхойлсон: "Ашиг сонирхлын нөхөрлөл нь хамгийн амархан эвдэрдэг, таашаал авах нөхөрлөл нь залуучуудад илүү тохиолддог, харин зангийн нөхөрлөл нь хамгийн тогтвортой учир нь хүмүүс бие биенийхээ зангийн чанарын хувьд найз нөхөр болдог"²¹. Гуравдугаар төрлийн нөхөрлөл нь "бие биенийхээ сайн сайханыг хүсэх" харилцаа бөгөөд энэ нь хот-улсын тогтвортой байдлын онтологийн суурийг бүрдүүлдэг.

3.2. *Homonoia*: Эв санааны нэгдлийн онтологийн шинжилгээ

NE IX.6 ба *EE VII.7*-ын *homonoia*-г манай судалгааны гол онолын зангилаа болгон авч үзэхэд, энэ ойлголт нь орчин үеийн хэлэнд ихэвчлэн буруу ойлгогддог. *Homonoia* нь зөвхөн "адил санаатай байх" биш, харин "зөв зүйлийг хамтран таних чадвар"-ыг илэрхийлдэг онтологийн ойлголт юм. *NE IX.6*-д "Эв санааны нэгдэл бол улс төрийн утгаараа нөхөрлөл мэт"²² гэж тодорхойлж, *EE VII.7*-д "Эв санааны нэгдэл бол иргэншлийн хүрээний нөхөрлөл"²³ гэсэн нь энэхүү ойлголтын макро түвшинд энхтайванд үзүүлэх нөлөөг тодруулдаг.

Homonoia-ийн онтологийн гүн утга нь "Эв санааны нэгдэлтэй хүмүүс нь хамтын үйл ажиллагаанд оролцож, бие биенийхээ сонирхолыг хамгаалж, нийтлэг шийдвэр гаргадаг, харин тэдгээр шийдвэр нь зөв байдаг"²⁴ гэсэн тайлбарт илэрдэг. Энэ нь зөвхөн процедурын нийцэл биш, харин зөв зүйлийг хамтран сонгох онтологийн чадварыг илэрхийлж, макро түвшинд энхтайвны институцийн үндсийг бүрдүүлдэг практик нийцлийг харуулна.

3.3. Хот-улсын телеологи ба энхтайвны дээд зорилго

Politics I.2 ба *VII.14*-ийг телеологийн хүрээ болгон авч үзэхэд, Аристотелийн хот-улсын онтологи нь энхтайвны макро түвшинг тодорхойлдог үндсэн зарчмуудыг агуулдаг. "Хот-улс нь амьдралын хэрэгцээнээс үүсэж, сайн амьдралын төлөө оршино"²⁵ гэсэн тодорхойлолт нь зөвхөн хүн амын цуглуулга биш, харин хүний амьдралын утга учир, *eudaimonia*-д үйлчлэх онтологийн институци болохыг харуулдаг.

Politics VII.14-д боловсролын зорилго болон энхтайвны харилцааг тодорхойлохдоо "Боловсрол нь зарим зүйлийг ашиг хэрэглээний төлөө, зарим зүйлийг сайн сайханы төлөө заадаг ба хоёрынх нь дундаас сайн сайханыг гол болгон заах нь илүү чухал, учир нь энэ нь иргэдийг энх тайван, чөлөө завтай амьдрах чадвартай болгодог"²⁶ гэж тодорхойлсон нь макро түвшинд энхтайвны онтологийн зорилгыг илэрхийлдэг.

Дайн, зэвсэглэлийн талаарх Аристотелийн үзэл "Дайн нь энх тайвны төлөө хийгддэг, ажил нь чөлөө завын төлөө хийгддэг ба хэрэгцээт зүйлс нь сайхан зүйлсийн төлөө хийгддэг"²⁷ гэсэн зарчмаар илэрдэг нь энхтайванг зорилго болгон, бусад үйл ажиллагааг хэрэгсэл болгон авч үзэх телеологийн хандлагыг тодруулна.

IV. Микро-мезо-макро түвшний уялдаа

4.1. Ойлголтын шинжилгээ: Үндсэн *terminus technicus*-уудын онтологийн функц

***Mesotēs* (дундаж):** Микро түвшинд хувь хүний сэтгэлийн хүчнүүдийн зохицлын зарчим, мезо түвшинд нийгмийн ангиудын хоорондын тэнцвэр, макро түвшинд хот-улсын бодлогын дундаж зарчмыг илэрхийлдэг онтологийн ойлголт.

***Dikē* (шударга ёс):** Микро түвшинд хувь хүний дотоод зөв зохирол, мезо түвшинд нийгмийн баялаг, эрх мэдлийн пропорциональ хуваарилалт, макро түвшинд хот-улсын институцийн зөв үйл ажиллагааг хангадаг онтологийн зарчим.

Philia (нөхөрлөл): Микро түвшинд хувь хүний зангийн сайн чанарын илрэл, мезо түвшинд нийгмийн бүлгүүдийн хоорондын итгэлцэл, макро түвшинд хот-улсыг тогтоож байлгадаг онтологийн хүч.

Homonoia (эв санааны нэгдэл): Микро түвшинд хувь хүний дотоод оюун санааны зохирол, мезо түвшинд олон нийтийн асуудалд зөв дүгнэлт хийх чадвар, макро түвшинд иргэдийн хамтын шийдвэр гаргах онтологийн нөхцөл.

Koinōnia (харилцан оролцоо): Микро түвшинд хувь хүний нийгмийн үүрэг, мезо түвшинд иргэдийн нийтийн асуудалд оролцох идэр зорилго, макро түвшинд хот-улсын демократик үйл ажиллагааны онтологийн суурь.

Telos (зорилго): Микро түвшинд хувь хүний *eudaimonia*, мезо түвшинд нийгмийн институцүүдийн үйл ажиллагааны зорилго, макро түвшинд хот-улсын эцсийн зорилго болох сайн сайхан амьдралыг илэрхийлдэг онтологийн ойлголт.

4.2. Системчилсэн холболт: Гурван түвшний органик уялдаа

Тэгэхээр энхтайвны онтолог нь дараах системчилсэн холболтоор бүрэлддэг:

Микро → Мезо холболт: Хувь хүний дотоод дундаж (*mesotēs*) нь нийгмийн харилцаанд шударга ёс (*dikē*), нөхөрлөл (*philia*) үүсгэх онтологийн үндэс болдог. Аристотель "Хувь хүний зан чанар нь нийгмийн зан чанарыг бүрдүүлдэг"²⁸ гэж тодорхойлсон нь энэхүү холболтыг харуулна.

Мезо → Макро холболт: Нийгмийн дунд ангийн тогтвортой байдал, шударга ёсны институци нь хот-улсын телеологи, эв санааны нэгдэл (*homonoia*), нийтийн оролцоо (*koinōnia*) үүсгэх онтологийн нөхцөл болдог. *Politics* IV.11-д "Дунд анги давамгайлсан хот-улс нь хамгийн тогтвортой, учир нь бүх иргэд хуулийг дагаж мөрддөг"²⁹ гэсэн нь энэхүү холболтыг илэрхийлнэ.

Макро → Микро эргэх холболт: Хот-улсын сайн сайхан зорилго (*telos*), боловсролын бодлого нь хувь хүний зангийн хөгжил, дотоод амгаланд эргэн нөлөөлж, энхтайвны онтологийн эргэлтийг бүрдүүлдэг. *Politics* VII.14-д "Хот-улсын боловсролын зорилго нь иргэдийг сайн сайхан амьдрахад бэлтгэх"³⁰ гэсэн нь энэхүү эргэх холболтыг тодруулна.

V. Дүгнэлт: Энхтайвны хуульчлагдашгүй онтологи

5.1. Энхтайвныг хуульчилж болдоггүй шалтгаан

Аристотелийн системчилсэн шинжилгээгээр энхтайвныг хууль, дүрэм, албадлагын замаар шууд бүтээж болдоггүй. Энэ нь дараах шалтгаан үндэслэлүүдтэй: Нэгд, **Онтологийн үүднээс:** Энхтайван нь оршихуйн гүн гүнзгий түвшинд хүний сэтгэл ба биеийн зохирол, нийгмийн харилцааны зөв пропорц, хот-улсын телеологийн зорилгын органик нэгдмэл үр дүн учраас гаднаас тогтоосон дүрмээр бүтээгдэж чадахгүй. Хоёрт, **Динамик талаасаа,** Энхтайвны бүх түвшин (микро-мезо-макро) нь тогтмол хөдөлгөөнтэй, хувьслын процесс учраас статик хууль дүрмээр зохицуулагдаж чадахгүй. Гуравт, **Телеологийн үүднээс** Энхтайван нь хүний амьдралын дээд зорилго (*summum bonum*) учраас түүнийг хэрэгсэл болгон ашиглах хуульчлал нь түүний онтологийн мөн чанарыг устгадаг.

5.2. Энхтайвны нөхцөлийг бүрдүүлэх институцийн зарчмууд

Шударга ёсны пропорциональ зарчим: Хувиарлалтын болон залруулгын шударга ёсны системчилсэн хэрэглээгээр нийгмийн баялаг, эрх мэдэл, хариуцлагын зөв хуваарилалтыг хангах институцийн механизм.

Ёс суртахууны дундажийн боловсрол: Иргэдэд *phronesis* (мэргэн ухаан) хөгжүүлэх, уур хилэн зэрэг сэтгэлийн хөдөлгөөнийг зохицуулах практик чадварыг заах боловсролын систем.

Дунд ангийн институцийн бэхжүүлэг: Эдийн засаг, улс төрийн хэт ялгааг арилгаж, нийгмийн тогтвортой байдлыг хангадаг дунд ангийн үүрэг, эрх мэдлийг институцийн түвшинд баталгаажуулах механизм.

Иргэний нөхөрлөлийн хөгжүүлэлт: Зангийн нөхөрлөлийг үндэс болгон *homonoia* (эв санааны нэгдэл) бүрдүүлэх нийтийн оролцооны, хэлэлцүүлгийн, шийдвэр гаргалтын демократик процесс.

Телеологийн боловсрол: Хот-улсын зорилгыг "амьдрахаас" "сайн сайхан амьдрал" руу чиглүүлэх, иргэдийн *eudaimonia*-д үйлчлэх боловсрол, соёлын бодлого.

Дүгнэлт: ристотелийн энхтайвны онтолог нь хувь хүний дотоод сэтгэлийн тэнцвэр, нийгмийн шударга ёс, улс төрийн тогтвортой байдал, хамтын сайн сайхан зорилгод чиглэсэн таван багана бүхий нэгэн цогц бүтэц болохыг харуулж байна. Микро түвшинд сэтгэлийн хэлбэр-үйл ажиллагааны зохирол, ёс суртахууны дундаж, мезо түвшинд шударга ёсны харьцааны архитектур, дунд ангийн институцийн үүрэг, макро түвшинд иргэний нөхөрлөлөөс төрөх *homonoia*, хот-улсын телеологийн зорилго гэсэн системчилсэн холболт нь энхтайвныг "идеал, хийсвэр үнэт зүйл" биш, харин онтологийн эмхтгэлийн органик үр дүн болохыг харуулж байна. Энэхүү судалгааны гол дүгнэлт нь энхтайванг зөвхөн зөрчил үгүй байдал бус, зөв харьцаа, зөв дундаж, зөв зорилгоор бүтээгдсэн эмх журам гэж онтолог үүндээс илэрхийлж болохоор байна. Орчин үеийн энхтайвны боловсрол, хүний хөгжлийн бодлогод Аристотелийн энэхүү системчилсэн хандлагыг шингээх нь зөвхөн техникийн шийдэл биш, хүний оршихуйн гүн гүнзгий ойлголтод суурилсан, микро-мезо-макро түвшинг холбосон цогц стратегийн онтологийн үндэслэлийг олгох ач холбогдолтой.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Анхдагч эх сурвалжууд:

- Aristotle. *De Anima*. Trans. D.W. Hamlyn. Oxford: Clarendon Press, 1968.
- Aristotle. *Nicomachean Ethics*. Trans. Terence Irwin. Indianapolis: Hackett, 1999.
- Aristotle. *Politics*. Trans. C.D.C. Reeve. Indianapolis: Hackett, 1998.
- Aristotle. *Eudemian Ethics*. Trans. Anthony Kenny. Oxford: Clarendon Press, 2011.
- Aristotle. *Rhetoric*. Trans. W. Rhys Roberts. In *The Complete Works of Aristotle*, ed. J. Barnes. Princeton: Princeton University Press, 1984.

Орчин үеийн судалгаа:

- Shields, Christopher. *Aristotle*. Routledge, 2014.
- Kraut, Richard. "Aristotle's Ethics." In *The Stanford Encyclopedia of Philosophy* (Fall 2022 Edition).
- Keyt, David. "Aristotle's Political Philosophy." In *The Stanford Encyclopedia of Philosophy* (Fall 2021 Edition).
- Rawls, John. *A Theory of Justice*. Harvard University Press, 1971.
- Galtung, Johan. "Positive and Negative Peace." *Journal of Peace Research* 6(3): 167–191, 1969.
- Habermas, Jürgen. *The Theory of Communicative Action*. Vol. 1–2. Boston: Beacon Press, 1984.
- Freire, Paulo. *Pedagogy of the Oppressed*. New York: Continuum, 1970.

Эшлэл зүүлтүүд:

- ¹ Aristotle, *De Anima*, trans. D.W. Hamlyn (Oxford: Clarendon Press, 1968).
- ² Aristotle, *Nicomachean Ethics*, trans. Terence Irwin (Indianapolis: Hackett, 1999).
- ³ Aristotle, *Politics*, trans. C.D.C. Reeve (Indianapolis: Hackett, 1998).
- ⁴ Aristotle, *Rhetoric*, trans. W. Rhys Roberts, in *The Complete Works of Aristotle*, ed. J. Barnes (Princeton: Princeton University Press, 1984).
- ⁵ Aristotle, *De Anima* II.1, 412a20-27.
- ⁶ Aristotle, *De Anima* II.1, 412b18-20.
- ⁷ Aristotle, *Nicomachean Ethics* II.6, 1106b36-1107a2.
- ⁸ Aristotle, *Nicomachean Ethics* II.6, 1106b21-23.
- ⁹ Aristotle, *Rhetoric* II.2, 1378a31-33.
- ¹⁰ Aristotle, *Rhetoric* II.3, 1380a8-15.
- ¹¹ Aristotle, *Nicomachean Ethics* VI.5, 1140b20-21.
- ¹² Aristotle, *Nicomachean Ethics* V.3, 1131a31-b15.
- ¹³ Aristotle, *Nicomachean Ethics* V.3, 1131a25-29.
- ¹⁴ John Rawls, *A Theory of Justice* (Harvard University Press, 1971).
- ¹⁵ Aristotle, *Politics* V.2, 1302a25-28.
- ¹⁶ Aristotle, *Politics* V.8, 1309b18-20.

- ¹⁷ Aristotle, *Politics* V.3, 1303a7-10.
¹⁸ Aristotle, *Politics* V.4, 1304a17-20.
¹⁹ Aristotle, *Politics* IV.11, 1295b13-19.
²⁰ Aristotle, *Nicomachean Ethics* VIII.1, 1155a22-27.
²¹ Aristotle, *Nicomachean Ethics* VIII.3-4, 1156a6-1156b32.
²² Aristotle, *Nicomachean Ethics* IX.6, 1167b2.
²³ Aristotle, *Eudemian Ethics* VII.7, 1241a33.
²⁴ Aristotle, *Nicomachean Ethics* IX.6, 1167a28-b16.
²⁵ Aristotle, *Politics* I.2, 1252b27-30.
²⁶ Aristotle, *Politics* VII.14, 1333b3-10.
²⁷ Aristotle, *Politics* VII.14, 1334a14-16.
²⁸ Aristotle, *Politics* VIII.1, 1337a11-18.
²⁹ Aristotle, *Politics* IV.11, 1295b34-39.
³⁰ Aristotle, *Politics* VII.14, 1333b37-1334a2.

ЕРӨӨЛ БА ЭНХТАЙВАН

А.ЭНХБАЯР

Доктор (Ph.D)

Хайрлах Урлагийн Академийн ерөнхийлөгч

Өнө эртний түүх, нүүдэлчдийн энгүй хараа хурсан гайхамшигт учрал дор өнөөдөр бид чуулж байна. Энэ чуулганаас эгшиглэсэн үг бүхэн зүрхэнд тань хүрч дэлхийг гэрэлтүүлэх ерөөл тогтог.

1. Дэлхий дахины эмзэг нөхцөл

Хүн төрөлхтөн шинжлэх ухаан, технологийн оргилд хүрч, сансар огторгуйн хаалгыг нээж, хиймэл оюун ухааныг бүтээж чадлаа. Гэвч энэ гайхамшигт ололт дунд бид өөрсдийгөө асар том зөрчил, эмзэглэлтэй нүүр тулгуулж байна.

Өнөөдөр дэлхий дахин:

- Хэн хамгийн хурдан пуужин бүтээх вэ,
- Хэн хамгийн ухаалаг дрон үйлдвэрлэх вэ,
- Хэн хамгийн аймшигт зэвсэг бүтээж чадах вэ хэмээх өрсөлдөөнд автаж байна.

Дайны галд үй олон хүний амь үрэгдэж, олон арван улс үндэстний зуун зууны туршид цогцлоон бий болгосон төрт ёс, нийгмийн тогтолцоо нь задран унаж, эдийн засаг нь сүйрснээр ард иргэд нь эх орон, газар нутгаа орхин дайжиж байна. Хамгийн эмгэнэлтэй нь бид энэ бүхнийг “байдаг л зүйл” мэтээр хүлээн авч, цочирдохоо больсон явдал. Энэ бол хүн төрөлхтөн өөрийн бүтээсэн харгис тогтолцооны машинд хүлэгдэн, устгалын зүг алхаж буй дүр зураг юм.

2. Ёс суртахууны доройтол ба хэт хэрэглээ

Хүн төрөлхтний хоёр дахь том аюул нь ёс суртахууны доройтол ба хэрэгцээнээс давсан тансаг хэрэглээ юм. Энэ байдал биднийг дотоодоос нь задалж байна. Дэлхий хоёр туйлд хуваагдаж байна:

- Нэг хэсэг нь хэрэглээгээ хязгаарлаж, байгаль дэлхийтэйгээ зүй зохистой харьцахыг эрхэмлэн, аливаа бүх зүйл хэм хэмжээтэй байх ёстойг сурталчилж байна.
- Нөгөө хэсэг нь хувь хүний эрх чөлөө, аминч үзлийг дэвэргэж, либерал үзэл, чөлөөт өрсөлдөөний тухай сурталдан, хамтдаа бие биеэ дэмжин нийтээрээ урагшлан хөгжинө гэсэн ой санамжийг арилгаж, хүний араатанлаг зөн совинг сэдэрэж байна.

Улс орнууд өвөрмөц зан заншлаа хадгалж, төрт ёсны уламжлалаа даган, хөгжил дэвшилд хүрэх боломж нэн хомс боллоо. Улаан шугамын аль нэг талд хүчээр зогсож, өөрсдийн үнэт зүйлийг орхин, өрөөл бусдыг аялдан дагаж, их гүрнүүдийн нөлөөнд автаж, тал засаж, эдийн засаг, улс төрийн хараат байдлаар оршин тогтнохоос өөр сонголтгүй болсон байна. Хоёр туйлт ертөнц бие биенийгээ эдийн засаг, зэр зэвсгийн өрсөлдөөнд уриалан дууддаг нь жам ёсны хэрэг билээ.

Эдгээр хүчин зүйлс нь хүн төрөлхтний хамгийн том аюул бөгөөд эд баялаг, эрх мэдэлд хүрэх, дэлхийн дэг журам тогтоохын тулд дайн хийх, эзлэн түрэмгийлэх, байгалийн унаган төрхийг өөрчлөх, эко системийг сүйтгэх гэх мэт олон хор хөнөөлтэй үйлдлүүдэд хүргэж байна. Өнөөдөр бид “Орших уу, эс орших уу” гэх Шекспирийн эртний асуултыг биш, харин “Хүн төрөлхтөн үргэлжлэх үү, эсвэл өөрсдийгөө устгах уу?” гэсэн амин чухал асуултыг дахин тавихад хүргээд байна.

3. Монголын өв ба Ерөөл: Монголчуудын уламжлалд аливаа үйлийг зөвхөн

тохиолдлын эрхээр бус, орон зай, цаг хугацаа, байршлын шүтэн хамаарлыг авч үзэн, түүндээ ерөөл, билиг шингээж үйлддэг уламжлал гүн шингэсэн. Өнөөдөр бид дэлхий дахинд энхтайван тогтоох энэ зарчмыг дахин сэргээх цаг иржээ.

Өнөөдөр та бид зөв цагт, зөв газраа, тодруулж хэлбэл XIII–XIV зуунд хоёр гурван зууны турш дэлхий дахинд энх амгаланг цогцлоож байсан Их Монгол Улсын газар нутаг дээр тэдний үр хойч болсон монгол эрдэмтэд, судлаачидтай хамтдаа хуран чуулж байна. Энэ нь тохиолдол бус, харин хувь заяаны бэлгэ тэмдэг, хүн төрөлхтөнд зориулсан нэгэн ерөөл болой.

Монголчуудын өвөг дээдэс бол зөвхөн газар нутгийг тэлэгчид бус, оршихуйн гүн философийг бүтээгчид байв. Суут богд Их эзэн Чингис хааны алдар зөвхөн цэргийн ялалтдаа бус, хүн төрөлхтний оршихуйн хууль ёсыг таньж, түгээсэнд оршино.

Тэрбээр **“Орчлонгийн хүн ардыг энхжүүлэн амаржуулна”¹** хэмээн мөнх тэнгэрт андгайлж тэр зорилгодоо ч хүрч чадсан. Мөн **“Иргэнийг хураах хэцүү. Иргэнийг хураахын тулд сэтгэлийг нь хураа”²** хэмээх зарлиг, сургаал нь удирдагчийн энэрэл, шударга байдал, ард түмнийхээ сэтгэл санааг ойлгох нь улс орны хийгээд оршихуй амгалан оршин тогтнох үндэс болохыг илтгэнэ. **Энэ нь улс төрийн захиас бус, харин хүн төрөлхтний оршихуйн үндсэн хууль юм. Энэ бол өнөөдөр ч үнэ цэнээ алдаагүй, хүн төрөлхтний ирээдүйг тэтгэх сургаал мөн.**

Тиймээс бидний өвөг дээдэс гурван зууны турш дэлхийд энх амгалан тогтоож чадсан нь цэргийн хүч бус, харин дээд ёс суртахууныг сахисанд оршино.

4. Энхтайваны нууц

Хайрлах Урлагийн Академийн судалгаагаар энхтайваныг хэзээ ч зэвсгийн хүчээр тогтоож болдоггүй. Энхтайван зөвхөн ухамсрын гүнд үндэслэж, зүрхний гэрлээс ургадаг болохыг олж тогтоолоо.

Тэгвэл дэлхий дахинд энх амгаланг цогцлоох нууц юунд оршиж байна вэ?

Тэр нь ердөө л:

- Хайр
- Ёс суртахуун
- Хэм хэмжээ
- Ерөөл буюу Өөдрөг төсөөлөл

Энэ дөрвөн зүйлийг төрийн бодлогоор ард түмэндээ сахиулж чадсан улс үндэстэн амар амгалан оршдог юм байна. Тэгвэл бүх улс үндэстэн ингэж чадвал даян дэлхийд яг юу болох вэ? Мэдээж бидний хүсээд байгаа “Дэлхийн Энхтайван” жинхэнэ утгаараа бий болж чадна. Энэ бол хүн бүрийн зүрх сэтгэлийн ариун үнэн мөн бөгөөд Монголын “ерөөл”-ийн гүн ухаан юм. Хүн төрөлхтний энхтайваны суурь үндэс нь ухамсар ба ёс суртахуунаас хамааралтай гэдгийг монголчуудаас гадна дэлхийн олон арван эрдэмтэд, гүн ухаантнууд хэлж байсныг тодруулах нь зүйтэй болов уу. Тухайлбал Дээрхийн гэгээнтэн Далай лам **“Жинхэнэ энхтайван бол зүрх сэтгэлээс эхэлнэ”³** гэж хэлсэн бол АНУ-ын ерөнхийлөгч асан Жон Кеннеди **“Хүн төрөлхтөн дайныг зогсоох ёстой. Эс тэгвээс дайн хүн төрөлхтнийг зогсооно”⁴** хэмээн тунхаглан хэлсэн нь ухамсар ёс суртахуун энхтайваны суурь болохыг бататгасан явдал билээ.

5. Хамтын уриалга

Хайрлах Урлагийн Академиас хэрэгжүүлж байгаа “Ерөөлч үндэстэн” үндэсний төсөл нь өнөөдрийн энэхүү чуулгантай ямар нэгэн сэмжээр холбоотой гэдгийг онцолж хэлмээр байна. Учир нь “Ерөөлч үндэстэн” үндэсний төслийн гол уриа нь **дэлхийн бүх улс үндэстэн хоорондын харилцаа нь “Сум дрон дээр бус итгэл, ерөөл дээр тулгуурлана” гэсэн уриалга юм.** Бидний энэхүү уриалгыг чуулганд оролцож буй зочид та бүхэн таатайгаар хүлээн авч чуулганаас гарах баримт бичигт тусгаж өгөхийг хүсэмжилж байна. Энэ бол зөвхөн Монголынх бус, бүх дэлхийн ирээдүйд зориулагдсан уриалга билээ.

Тиймээс:

- Дэлхий дахины бүх улс үндэстэн бие биедээ сум, дрон бус, итгэл, ерөөл илгээдэг байхыг энэхүү чуулганаас хамтдаа тунхаглая.
- Хүн төрөлхтний хувь заяа сорилт, эмзэглэлийн ирмэгт тулж буй энэ цагт Монголын ерөөл бол хүн төрөлхтөнд өгөгдөж буй нэгэн гэрэл, нэгэн гарц, нэгэн итгэл юм гэдгийг дахин хэлье.

Энэ бол энх амгалан, хамтын оршихуйн амин чухал арга зам мөн төдийгүй, хүн төрөлхтний зүрх сэтгэлийн чанад дахь хамтын дуудлага юм.

Эцэст нь хэлэхэд, бид хамтдаа хүн төрөлхтний ирээдүйг энх тайвнаар гэрэлтүүлэх боломжтой.

¹ “Их хаадын зарлигийн дээжис” ном, 63-р тал, 2022 он

² “Их хаадын зарлигийн дээжис” ном, 63-р тал, 2022 он

³ Nobel Lecture, Dalai Lama, December 11, 1989

⁴ Address before the United Nations, John F. Kennedy, September 25 1961

ЭХ ОРОНЧ ҮЗЛЭЭР ДАМЖУУЛАН ҮНДЭСНИЙ СӨРӨН ТЭСВЭРЛЭХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Б.БААТАРСҮРЭН
БХЯ-ны БХЭШХ-ийн
ЭШТА, доктор, дэд профессор

Хураангуй: Энэхүү судалгааны хүрээнд ЕБС-ийн бага, дунд, ахлах ангийн нийгмийн ухааны хичээлүүдийн хөтөлбөрүүдэд эх оронч үзэл, хүмүүжил, бахархлын талаарх агуулга хэрхэн тусгагдсан байгаад агуулгын шинжилгээ хийхийн зэрэгцээ их, дээд сургуулиудын заавал судлах ерөнхий суурь хичээлүүдэд энэ агуулга, арга зүйн залгамж холбоо байгаа эсэх талаар судалж тогтоох зорилго дэвшүүлэн ажиллав. Түүнчлэн эх оронч үзэл хүмүүжил нь үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг хэрхэн эерэгээр дэмжиж болох боломжийн талаар зарим орнуудын сайн туршлагыг судлан дүгнэв. Судалгаанд бага болон бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр, төрийн болон төрийн бус өмчийн 4 их дээд сургуулийн заавал судлах ерөнхий суурь хичээлийн хөтөлбүүдийг шинжлэн ашигласан. Мөн хичээл, сургалтаар олж авсан эх оронч үзэл, хүмүүжил, бахархлын талаарх мэдлэг, чадвар, хандлагыг эцэг, эхийн зүгээс хэрхэн үнэлж байгааг тодруулсан чанарын судалгааг авч, үнэлгээний байдлыг нэгтгэн дүгнэж, статистик шинжилгээний үр дүнгээр баталгаажуулав.

Түлхүүр үг: Эх оронч үзэл, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх, үнэт зүйлс, хөтөлбөрийн агуулга.

Судалгааны зорилго: Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх нь улс орны сөрөн тэсвэрлэх чадавхад чухал нөлөө үзүүлнэ гэсэн ойлголтын хүрээнд ЕБС-ийн бага, дунд, ахлах ангийн нийгмийн ухааны хичээлүүдийн болон их, дээд сургуулийн заавал судлах ерөнхий суурь хичээлүүдийн хөтөлбөрт эх оронч үзэл, хүмүүжил, бахархлын талаарх агуулга тусгагдсан байдалд агуулгын шинжилгээ хийж, тэдний мэдлэг, чадвар, дадлыг үнэлсэн эцэг, эхийн үнэлгээний үр дүнтэй холбон судлах.

Судалгааны арга зүй: Сурагчдын эх оронч үзэл, хүмүүжлийг улс орны сөрөн тэсвэрлэх чадавхтай холбон судлахын тулд “Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Боловсрол үндэсний хөтөлбөр” (МУЗГ-ын 2018 оны 209 дүгээр тогтоолын хавсралт), “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл

төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр” (МУЗГ-ын 2019 оны 200 дугаар тогтоолын хавсралт), ЕБС-ийн бага, дунд, ахлах ангийн нийгмийн ухааны хичээлийн хөтөлбөрүүдийн агуулга, их дээд сургуулийн заавал судлах ерөнхий суурь хичээлийн хөтөлбөрүүдийн агуулгыг үндэс болгон, “хувь хүн бие бялдар, сэтгэл зүй, эрүүл мэнд ба эдийн засгийн хувьд аливаа гэнэтийн цочирдлыг тэсвэрлэх чадавхтай байх ёстойтой адил гэр бүлүүд, нийгэм тэр чигээрээ ийм чадавхтай байснаар улс орны үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх бүрдэнэ” (Bodin Wiman, 2004; Gordon, 1978)¹ гэсэн үзэл баримтлал, АНУ-ын судлаачдын гаргасан эх оронч үзлийг хэмжих концепци” (William I, Gordon A. Bennett Whaley, Marie A. Whaley, 1983) зэргийг ашиглан судалгаа авсан. Чанарын судалгааны мэдээллийг боловсруулахдаа QDA Miner программ ашиглан шинжилгээ хийсэн. Сурагчдын эх оронч үзлийн талаарх мэдлэг, чадварыг үнэлэхдээ сургалтын хөтөлбөрийн агуулгын хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадвар, дадлыг эцэг, эхийн үнэлгээтэй харьцуулан шинжлэв. Монгол улсын хэмжээнд 2024 оны байдлаар ЕБС-д өдрөөр суралцагч 771722 хүүхэд, 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш насны хүүхэдтэй өрх 54873 байна.²

Үдиртгал: Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг олон янзаар тодорхойлдог хэдий ч энэ нь улс орны аливаа гэнэтийн аюул, заналыг тэсч давах, дасан зохицох, түүнчлэн эргэн сэргэх чадавхыг хэлдэг гэсэн нэгдсэн түгээмэл ойлголт дээр ерөнхийдөө санал нэгддэг.³ Магадгүй

¹ Fran H. Norris, Susan P. Stevens, Betty Pfefferbaum and others “Community Resilience as a Metaphor, Theory, Set of Capacities and Strategy for Disaster Readiness”, April 2008, [American Journal of Community Psychology](#)

² 1212.mn

³ The White House, National Resilience Strategy, Washington DC, 2025, p 4.

маш энгийн сонсогдож байгаа ч энэ нь улс орнуудыг өөрчлөгдөн буй аюулгүй байдлын орчин, эрчимжиж буй геополитикийн өрсөлдөөн, мөн өсөн нэмэгдэж буй олон төрлийн аюул, заналуудын дунд үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхаа маш өндөр түвшинд байлгах шаардлагатай гэсэн үнэ цэнтэй үзэл баримтлалыг бий болгосон ач холбогдолтой ойлголт юм. Улс орнуудын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал ба стратеги, батлан хамгаалах бодлого, стратеги нь улс орны аюулгүй байдлыг хангах үндсэн чиглэл, үйл ажиллагаа, арга хэмжээг тодорхойлдог хэдий ч энэ нь хангалттай биш байна гэдэг дээр мэргэжилтэнүүд санал нийлж эхэлж байгаа. Учир нь аюулгүй байдлаа хангах үйл ажиллагаа нь дан ганц Засгийн газрын үүрэг биш бөгөөд нийгмийн болон иргэдийн мөн хүлээх үүрэг хариуцлага юм гэдгийг үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын ойлголт илүү тодорхой харуулж байна.

Дэлхийд эдийн засаг, цэрэг, улс төрийн нөлөөгөөрөө тэргүүлэгч зарим орнууд үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг өөрсдийн аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, стратегийн нэгэн бүрдэл хэсэг байсаар ирсэн гэж үздэг байсан хэдий ч орчин цагийн шинэ эрсдэл, аюул нь үүнийг өөрөөр харуулаад байна. Жишээлбэл, Англи улс Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын стратегидаа саяхан тохиолдсон КОВИД-19 цар тахал нь тус улсын аливаа эрсдэлийн эсрэг бүрдүүлсэн бэлэн байдал хангалттай бус байсныг илрүүлэн харуулж, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаандаа онцгойлон анхаарах шаардлагатай байгааг мэдрүүлсэн хэмээн дурдсан байна.¹ Энд хөндөх гол асуудал нь улс орнууд хэдий эдийн засгийн хувьд хүчирхэг, дэлхийн тавцанд нөлөөтэй, аюулгүй байдал болон батлан хамгаалахын бодлого, стратегидаа бүх системийн оролцоог тусган хэрэгжүүлдэг байсан хэдий ч үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх нь илүү өргөн хүрээг хамарсан энгийн иргэнээс эхлээд нийгэм, цаашлаад улс орны бүх институт болон системүүдийн аливааг тэсвэрлэн гарах, эргэн сэргэж хэвийн байдалдаа түргэн орох, магадгүй улам хүчирхэг болох чадавхыг онцолдог байна.

Үүнийг бүр илүү дэлгэрүүлэн үзвэл, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх асуудлыг хөндөхдөө улс оронд тулгарч болох эрсдэлүүдийг эхэлж судлан үзэх ёстой ба ингэснээр аль аюулыг хэрхэн сөрөн туулж, даван гарах, болж өгвөл урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах бодлого, стратегийг боловсруулан хэрэгжүүлдэг. Иймээс эрсдэлийн үнэлгээг хийхдээ орчин үед гарч буй түгээмэл эрсдэлүүд болон тэдгээрийн урьдач нөхцөлүүд мөн магадлалуудыг судлан үзэх ёстой боловч хамгийн чухал, магадгүй хамгийн хэцүү асуудал бол ирээдүйн аюулгүй байдлын болон бусад чиг хандлагуудыг судлан үзэх нь зүйтэй гэдэгт бүгд санал нийлэх нь гарцаагүй байна. Үүний тодхон жишээг дэлхийн хамгийн хүчирхэг орнуудын дэлхийн чиг хандлагыг урьдчилан таамаглан гаргасан судалгааны бүтээлүүдээс харж болно. Тухайлбал, АНУ-ын Үндэсний тагнуулын зөвлөлөөс гаргасан “Дэлхийн чиг хандлага-2040”, Англи улсын Батлан хамгаалах яамнаас гаргадаг “Дэлхийн стратегийн чиг хандлага-2055”, Дэлхийн эдийн засгийн форумаас эрхлэн гаргадаг “Дэлхий дахины эрсдэлүүд-2035” зэрэг нь онцолбол зохих нэр хүндтэй бүтээлүүд юм. Эдгээр бүтээлүүдээс харахад учирч болох чиг хандлагуудыг дараах үндсэн хэсгүүдэд хувааж болох юм. Үүнд: Геополитикийн, Эдийн засгийн, Нийгмийн, Хүрээлэн буй орчны ба Технологийн эрсдэлүүд орно.²

Судалгааны сэдвийн хүрээнд хамааруулан нийгмийн эрсдэлийг авч үзвэл “Дэлхийн чиг хандлага-2040” илтгэлд дурдсанаар нийгмийн эрсдэлтэй байдлын гол асуудлууд нь олон нийт нийтдээ сэтгэл ханамжгүй ба талцан хуваагдалттай байдалд хүрэх чиг хандлагатай байгаа юм. Энэ нь төр засагтаа итгэх итгэл алдрах, шашны болон онцлог байдал (identity)–аараа нэгдэх, мэдээллийн орчны зориудын төөрөгдүүлэлтэд автах гэх мэт олон учир шалтгаанаас үүдэн гарч болох боловч хамгийн хортой нь аливаа аюул, гамшгийн үед бүх нийтээрээ тэсвэрлэн давж гарах үндэсний эв нэгдэлтэй байдалд сөргөөр нөлөөлөх асуудал юм.³ Сүүлийн үед тохиолдож буй үндэсний аюулгүй байдлын хэмжээний эрсдэл, аюулыг даван гарч буй жишээнүүдээс харахад холбоотнууд, найрсаг холбоотой орнуудын тусламж, олон улсын байгууллагуудын дэмжлэг гол нөлөө үзүүлж байгаатай маргах аргагүй ч тухайн улс орнуудын үндэсний эв нэгдэл,

¹ Cabinet Office, The National Resilience Strategy: Call for Evidence, London, 2021 p 9.

² <https://www.weforum.org/publications/global-risks-report-2025/in-full/paste-test/>

³ Галбадрах.Т нарын орчуулга, “Дэлхийн чиг хандлага-2040”, АНУ-ын ҮТЗ-ийн хэвлэл, 2021 оны 3-р сар.

эх оронч үзэл, хүмүүжил, үндэсний бахархал хамгийн чухал элементүүд байсаар ирсэн гэдгийг улам бүр баталж байна.

“Эх оронч үзэл” (Patriotism) гэдэг үг нь Латин хэлнээс гаралтай бөгөөд удирдуулж байгаа газартаа үнэнч байх гэж тодорхойлж болно. Эх оронч үзлийг агуулга, онцлог шинж чанараар нь тодорхойлох янз бүрийн хандлага байдаг. Эх оронч үзлийн хамгийн энгийн тодорхойлолт нь бүлгийн гишүүд бие биедээ, хамтран амьдарч буй газар нутагтаа үнэнч байх.¹ (Bar-Tal and Staub, 1997). Эх оронч үзлийн талаарх судалгаануудад мөн өөр өөр тодорхойлолтыг дэвшүүлжээ. Тухайлбал, Аливаа улс үндэстэн үндэсний нийтлэг бэлгэдэл, улс орноо гэсэн сэтгэлээр дамжуулан улс орныхоо давуу талыг ард иргэддээ мэдрүүлснээр тэд илүү бахархалтай болж улсдаа хайртай байх нь тодорхой итгэл үнэмшил бүхий үндэстнийг бий болгож, үнэнч байдлыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэн улс орныг илүү хүчтэй болгодог.² гэсэн байна.

Монгол Улсын хувьд Боловсролын Ерөнхий хуульд “Монгол Улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд оршино” гэж тодорхойлсон. Түүнчлэн бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт дараах агуулгыг заавал тусгаж, боловсролын сургалтын байгууллага өмчийн хэлбэр харгалзахгүй хэрэгжүүлнэ:

- Монголын түүх, монгол хэл, уран зохиол, үндэсний бичиг, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, төлөвшил;
- Хувь хүн, гэр бүлийн төлөвшил, амьдрах ухаан, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйл;
- Хүний эрхийн боловсрол, жендэрийн эрх тэгш байдал;
- Иргэний ёс зүйн болон зан төлөвийн боловсрол;
- Эрүүл мэндийн боловсрол;
- Хүмүүнлэг иргэн, тогтвортой хөгжлийн боловсрол;
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах, аюулгүй амьдрах арга ухаан;
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох;
- Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, түүний хор уршиг, дэлгэцийн донгоос сэргийлэх талаар³ хэмээн тусгаж өгсөн байна. Энэхүү бодлогыг баримтлан Монгол Улсын Ерөнхий Боловсролын Сургуулийн Нийгмийн ухааны суурь хичээлүүдийн дараах хөтөлбөрүүдэд агуулгын шинжилгээ хийв. Үүнд:
- Бага ангид 1-3 дугаар анги: “Хүн ба орчин”, 4-5 дугаар ангид “Хүн ба нийгэм”, 1-5 дугаар ангид “Монгол ёс хүмүүжил”
- Дунд ангид 6-9 дүгээр анги: “Түүх”, “Нийгэм судлал”, “Иргэний ёс зүйн боловсрол”
- Ахлах ангид 10-12 дугаар анги: “Түүх”, “Нийгэм судлал”, “Иргэний ёс зүйн боловсрол”

Харин их дээд сургуульд Ерөнхий суурь буюу заавал судлах Нийгмийн ухааны хичээлүүдийн хөтөлбөрийг сургуулиуд өөрсдийн мэргэжлийн чиглэл, онцлогт тохируулан боловсруулж байна. Тухайлбал, “Монголын түүх”, “Монголын түүх, соёл ёс заншил”, “Сэтгэлгээний түүх соёл”, “Хүний хөгжил, харилцааны ёс зүй, эрх зүй” гэх зэрэг хичээлүүд ордог байна.

Оюутны Ерөнхий суурь хичээлээр эзэмших суралцахуйн үр дүн нь:

Нийгмийн ухааны хичээлүүдийн хувьд: Нийгэм, эдийн засаг, засаглал, соёлын олон талт байдал, хувь хүн, гэр бүлийн төлөвшил, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйл, хүн хоорондын харилцаа, зан үйлийг танин мэдэх, бүтээлчээр сэтгэх, асуудалд шинжлэх ухаанчаар хандах; - Хүмүүнлэгийн ухааны хичээлүүдийн хувьд: Хүний хөгжлийг танин мэдэх, түүх, соёл, гүн ухаан, урлаг, гоо зүйн сэтгэлгээг хөгжүүлэх, хүний эрх, жендэрийн эрх тэгш байдал, иргэний ёс зүй болон зан төлөв, хүмүүнлэг иргэн, тогтвортой хөгжлийн мэдлэг ойлголтыг хэрэглэх гэсэн агуулгатай байна.⁴ Их, дээд сургуулиудын хөтөлбөрөөс жишээлбэл, ҮБХИС-ийн “Монголын түүх” хичээлийн хөтөлбөрийн агуулга нь дараах онцлогтой боловсруулагджээ. Үүнд: Цэргийн

¹ Bar-Tal, Daniel, Patriotism Its scope and meaning, 1997, <https://www.researchgate.net/publication/>

² Hurwitz & Peffley 1999; Spinner-Halevand Theiss-Morse 2003; Sullivan, Fried & Dietz, 1992.

³ Боловсролын Ерөнхий Хууль, 2023.

⁴ БШУ-ны сайдын А/147 дугаар тушаал, 2024 он.

төрөл болон тусгай мэргэжлээр суралцаж буй сонсогчдын хувьд монголын түүхийн тухай үндсэн ойлголт, төр, цэргийн болон соёл, ёс заншлын тухай судлан мэдэж, амьдрал ахуйдаа хэрэглэх, түүхийн мэдлэгтээ тулгуурлан судалгаа хийх, асуудал шийдвэрлэж сурах, удирдан зохион байгуулахад шаардагдах мэдлэг, ур чадвар, эзэмшсэн байх. “Хүний хөгжил” хичээлийн хувьд Хүний хөгжлийн үзэл баримтлал, хүний хөгжлийн индекс, хүний тогтвортой хөгжил, цогц хөгжил, хүмүүжил төлөвшил, түүнд нөлөөлөх хүчин зүйл, харилцааны тухай ойлголт, харилцааны ёс зүй, ухамсарт чанар, албан харилцааны ёс зүйн хэм хэмжээ, харилцах чадвар, хүний эрх, эрх чөлөө, хүйсийн тэгш байдал, хүний аюулгүй байдал, түүнийг хангах тухай мэдлэг чадвартай болох. МУИС-ийн “Хүний хөгжил, харилцааны ёс зүй” хичээлийн хувьд хүний хөгжлийн тухай ойлголт, хэмжигдэхүүн, үзэл баримтлал, хөгжил дэх тэгш бус байдал, хүний аюулгүй байдал, хүний хөгжлийн төлөөх эдийн засгийн өсөлт болон макро микро түвшний бодлогуудын өвөрмөц байдлуудын талаар онолын мэдлэг эзэмшин, эдгээртэй холбоотой аливаа асуудалд дүн шинжилгээ хийх, учир шалтгаан, үр дагавар, харилцан хамаарлыг тодорхойлох, асуудалд шинжлэх ухааны үндэслэлтэй хандах чадвар, дадал олгох гэж боловсруулагдсан байна.

Судалгааны хэсэг: Улс орнууд үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх тал дээр 4 түвшинд авч үзвэл ач холбогдол өндөртэй гэж үзэж байгаа ба үүнд хувь хүний, гэр бүлийн, нийгмийн болон улс орны сөрөн тэсвэрлэх чадавх орно. Хувь хүн бие бялдар, сэтгэл зүй, эрүүл мэнд ба эдийн засгийн хувьд аливаа гэнэтийн цочирдлыг тэсвэрлэх чадавхтай байх ёстойтой адил гэр бүлүүд, нийгэм тэр чигээрээ ийм чадавхтай байснаар улс орны үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх бүрдэнэ гэж үзэж болно. Мэдээж өмнө дурдсанчлан аюулгүй байдал, батлан хамгаалах чадавхыг бүрдүүлэх гэх мэт улс орны өргөн хүрээний арга хэмжээг төр засаг хариуцах ч үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх, ялангуяа нийгмийн хүрээний эрсдэлийг шийдвэрлэх арга зам нь бүх нийтийн оролцоотой үйл хэрэг юм. Сингапур, Финланд, Израиль мэт манай улстай ижил төстэй аюулгүй байдлын орчинтой орнууд нийгмийн сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх тал дээр онцгойлон анхаардаг байна. Ингэхдээ эх оронч үзлийг хүн бүрт төлөвшүүлж, эх орныхоо үнэ цэнийг хүн бүрт ойлгуулж, үндэсний түүх, өв уламжлалаа дээдлэн судалж, үндэсний үнэт зүйлсээ хайрлан дээдлэхийг онцгойлон анхаардаг байна. Жишээлбэл, Сингапур улс эх оронч үзлийг бүрдүүлэхдээ “Үндэсний Боловсролын Хөтөлбөр”-өөр дамжуулан эх орноо хамгаалах нь Сингапур иргэдийн бүх нийтийн үүрэг гэдгийг гүн ухамсарлуулдаг байна.

Тус улсын Үндэсний боловсролын хөтөлбөр нь 1997 оноос эхлэлтэй бөгөөд 10 жил тутамд өөрчлөлт орсоор өнөөг хүртэл гурвантаа шинэчлэгдээд байна. Энэхүү үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой хөтөлбөр нь дараах үндсэн зорилготой.

- Сурагчдад Сингапурын түүх, зөвхөн тус улсад хамааралтай онцлог бодит байдал ба сорилтууд, тусгаар улсаа байгуулахдаа туулсан замыг ойлгох мэдлэг, ур чадвар болон үнэт зүйлсийг олгох, үндэстнээрээ аюулыг тэсэн гарах ухамсрыг суулгах, мөн эх орныхоо ирээдүйд итгэх итгэлийг бүрдүүлэх.
- Иргэдээ орон нутгийн, бүс нутгийн ба дэлхий дахины асуудлуудын талаар мэдээлэлтэй, тунгаан бодохуйн сэтгэлгээтэй болон хөгжих хувь хүний хөгжлийг дэмжих, өдөөн сэдэлжүүлэх.
- Сурагчдад Сингапур хүн хэмээх үндэсний онцлогоо таньж мэдэх, түүнийгээ мэдрэхэд нь туслах, эх орныхоо эд эс гэдгийг нь, мөн бодит байдал болон итгэлийг сайтар ойлгуулах, энэ нь тэдэнд хувийн амьдралын зорилгоо гүйцэлдүүлэхийг хичээхээс гадна өөрсдийн хүрээлэлдээ болон эх орондоо дэмжлэг болох үйл ажиллагаанд оролцох сэдлийг өгөх.

Ерөнхийдөө Сингапур улсын Үндэсний боловсролын хөтөлбөр нь олон өөр төрлийн шашин шүтлэг, угсаа гарал, соёл бүхий хүн амаас бүрдсэн тус улсын иргэдийг эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд үндсэн үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг байна.¹ Ингэхдээ энэхүү сургалтын хөтөлбөрийн гол үр дүн нь дээр дурдсан зорилгын дагуу эх оронч үзэл хүмүүжилтэй иргэд бэлдэхэд чиглэсээр ирсэн гэдгийг 1997 оны тус улсын сөрөн тэсвэрлэх чадавхын үзүүлэлт болон өнөөдрийн үзүүлэлтээс харж болно. “ФМ Дэлхий дахины үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын

¹ Tim Huxley, *Defending the Lion City: The Armed Forces of Singapore*, Allen & Unwin, Sydney, 2000, p 25.

индекс 2024” гэх мэт олон төрлийн судалгаа, үнэлгээний статистикаас харахад Сингапур улс дэлхийн улс орнуудаас бүх талаараа эхний 10-т багтаж байгаа нь үүнийг батлан харуулж байна.¹ Иймээс манай улс Сингапурын жишээг авч хэрэгжүүлэх шаардлага буй эсэхийг судлан үзэх нь зүйтэй гэсэн санал, дүгнэлтэд хүрч байна.

Одоо зорилгодоо дэвшүүлсэн асуудлын хүрээнд Монгол Улсын ЕБС-ийн сургалтын нийгмийн ухааны хичээлүүдийн хөтөлбөрт хийсэн судалгааны үр дүнг танилцуулъя.

Аливаа сургалтын хөтөлбөрийн агуулга нь анги ахих тусам өргөсөн гүнзгийрсэн, сурагчийн хөгжлийн үе шат, учир шалтгааны уялдаа холбоогоор дараалж, тасралтгүй давтагдсан, өөр хоорондоо залгамж холбоо бүхий бүтэцтэй байх ёстой. Энэхүү агуулга болон залгамж холбоо хамгийн их хадгалагдаж байгаа хичээл бол “Иргэний ёс зүйн боловсрол” хичээл байна гэж хэлж болохоор байна. Энэ хичээлийн сургалтын хөтөлбөрийн зорилго нь: *“Хүнлэг энэрэнгүй, цэвэр ариун сэтгэлтэй, билиг оюун төгөлдөр, монгол үндэстнийхээ хэл, соёлыг эзэмшсэн, бахархаж хэрэглэдэг, хүндэлж хамгаалдаг, эх орноо эрхэмлэн дээдлэх үүрэг, хариуцлагаа ухамсарласан, хүмүүнлэг нийгмийг цогцлоон байгуулах ирээдүйн монгол иргэнийг өсгөх, хүмүүжүүлэх, бэлтгэхэд оршино”* гэж тодорхойлогдсон бөгөөд зорилтуудад:

- Гэр бүл, анги хамт олон, нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа сайтар ухамсарлах
- Эх орон, ард түмэн, хүн төрөлхтний харилцан хамаарал, бүгдийг тэгш хүндлэхийн учир утгыг ойлгож ухаарах
- Хойч үеийнхээ өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа гүн ухамсарлаж, алсын хараатай, эв ээтэй байж, эх орныхоо болон дэлхий нийтийн хөгжилд хувь нэмрээ оруулах
- Төрийн хуулийг дээдэлж, уламжлалт өв соёл, тогтсон зан суртал, үнэт зүйлсийг эрхэмлэдэг, ёс суртахуунгүй үйлдэл бүрийг тэвчдэг иргэн болж төлөвшихөд оршино² гэх мэт эх оронч үзэл хүмүүжилтэй холбоотой зорилтууд тусгагджээ. Үндсэн гол цогц сургалтын хөтөлбөр хэдий ч сурагчид ёс зүйн боловсрол эзэмших нь зөвхөн уг сургалтын хөтөлбөрөөр хязгаарлагдахгүй, монгол хэл, бичиг, уран зохиол, түүх зэрэг бусад сургалтын хөтөлбөртэй нягт холбоотой.

Энэ сургалтын хөтөлбөрийн арга зүй нь сурагчдад ёс суртахууны хэм хэмжээг дадуулж хэвшүүлдгээрээ бусад сургалтын арга зүйгээс өвөрмөц онцлогтой. Арга зүй нь агуулгын ойлголт ухагдахууныг тоочин заах, дурдах уламжлалт арга зүйгээс ялгаатай бөгөөд ёс зүйн боловсрол эзэмших арга ухааныг сурагчид өөрсдөө хамтран бүтээх, дадуулан хэвшүүлэх таатай нөхцөл боломжийг бүрдүүлэхэд оршдог байна. ЕБС-ийн бага, дунд, ахлах ангийн нийгмийн ухааны хичээлийн хөтөлбөрүүдэд эх оронч үзэл, хүмүүжилтэй холбоотой агуулгын шинжилгээ хийв.

Зураг 1.

ЕБС-ийн бага, дунд, ахлах ангийн үндэсний ёс заншлын чадваруудын шинжилгээ.³

5-р анги	9-р анги	12-р анги
• Ураг удмаа мэдэх ёс • Мэндлэх ёс • Мал аж ахуйтай холбоотой ёс • Хүндлэх ёс /тайлбарлан бичих/ • Монгол наадгай ёс • Монгол дээл хувцас өмсөх, хэрэглэх ёс • Эд хэрэглэлийн ёс • Байгальтай харьцах ёс	• Ураг удмаа мэдэх ёс • Хоол хүнсээ бэлтгэх, хэрэглэх, хадгалах ёс. Мал аж ахуйтай холбоотой ёс • Байгальтай харьцах ёс • Цээрлэх ёс • Уламжлалт баяртай холбоотой ёс • Монгол уламжлалт хэмжүүр • Зөв хүн болж төлөвших монгол ухаан • Монгол дээл хувцас өмсөх, хэрэглэх ёс • Мал аж ахуйтай холбоотой ёс /тайлбарлан бичих/	• Ураг удмаа мэдэх ёс • Монгол уламжлалт хэмжүүр • Уламжлалт баяртай холбоотой ёс • Монгол гэргийн бүтэц, нэрийдэл • Мал аж ахуйтай холбоотой ёс /Хурдан морины дэг ёс, бэлгэдэл/ • Монгол дээл хувцас өмсөх, хэрэглэх ёс • Байгальтай харьцах ёс • Анд бололцох ёс

Хөтөлбөрүүдийн шинжилгээний үр дүнгээс харахад Монгол Улсын ЕБС-ийн нийгмийн ухааны хичээлүүдийн хөтөлбөрт монгол ёс заншил уламжлал, эх оронч үзэл, хүмүүжил, үнэт зүйлс, түүхийн мэдлэг, чадвар, дадал олгох агуулга харьцангуй сайн тусгагдсан мөн их дээд

¹ 2024 FM Global Resilience Index, <https://www.fm.com/resources/resilience-index>

² БСШУСЯ, “Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр”, 2019.

³ Лхагвамаа.Б, “Сурагчдын үндэсний ёс заншлын боловсрол, нөлөөлөх зарим хүчин зүйлийг судалсан үр дүн (ЕБС-ийн 5, 9, 12-р ангийн жишээн дээр)” докторын диссертаци, 2019.

сургуульд тодорхой хэмжээгээр замгамж холбоотой үргэлжилж байгаа нь харагдаж байна. Харин үр дүн нь ямар байна вэ? гэдгийг сурагчдын өөрийн үнэлгээний мэдлэг чадварыг үнэлэх судалгаанаас харахад 5-р ангийн сурагчид үндэсний өв уламжлал, ёс заншлаа эрхэмлэн дээдлэх үзэл төлөвшөөгүй (хангалтгүй 73.1%), 9-р ангийн сурагчдын хувьд мэдлэг, чадварын үнэлгээ хангалтгүй (90.7% нь доод, хангалтгүй), 12-р ангийн сурагчдын хувьд (94.4% нь доод, хангалтгүй)¹ гэж үнэлэгдсэнээс үзэхэд ЕБС-ийн сурагчдын монгол ёс заншил уламжлал, эх оронч үзэл, хүмүүжил, үнэт зүйлс, түүхийн мэдлэг, чадварын түвшин туйлын хангалтгүй байна.

Эх оронч үзэл, хүмүүжил, бахархлын талаарх судалгаанаас үзэхэд сурагчдын үндэсний түүх, ёс заншлын талаарх мэдлэг нь эх оронч үзэл хүмүүжилтэй хамаарах эсэхийг хи квадрат тест ашиглан шалгахад шинжүүрийн “0” таамаглал няцаагдаж (Φ Value=0.000<0.01) байна. Энэ нь сурагчдын тогтвортой урт хугацааны ойд хадгалагдан үлдсэн түүх, ёс заншлын мэдлэг нь тэдний эх оронч үзэл хүмүүжилтэй хамааралтай буюу коэффициент 0,7 байгаа нь эдгээр хувьсагчдын хоорондын хамаарлын хүчтэй зэрэг байгааг илэрхийлж байна. Монгол уламжлал, ёс заншлын мэдлэг нь түүхийн мэдлэг төдийгүй хүрээлэн буй орчиндоо хүндэтгэлтэй хандах хандлага, манлайлал, сайн дурын ажиллагаан дахь оролцоо, эх оронч үзэл хүмүүжилд (Φ Value=0.7. Sig.0.000) хүчтэй хамааралтай байгаа нь статистик шинжилгээний үр дүнгээр илэрсэн. Эдгээр нь судалгаанд дэвшүүлсэн түүхийн мэдлэгээр эзэмшсэн урт хугацааны ой тогтоолт нь эх оронч үзэл хүмүүжилд нөлөө үзүүлнэ гэсэн таамаглалыг баталж байна.² гэжээ.

Хэдийгээр боловсролын байгууллага нь сурагчдад ёс зүйн боловсрол олгох үүргийнхээ хувьд нийгэмд нөлөө бүхий байр суурь эзэлдэг ч сурагчдын хувьд гэр бүл нь хүмүүжил төлөвшил олгох үндсэн орчин, эцэг эх, асран хамгаалагч нь гол сурган хүмүүжүүлэгчид болж байдаг. Иймээс энэхүү хөтөлбөрийн агуулгаар эзэмшиж буй мэдлэг, чадвар, дадлыг эцэг эх, асран хамгаалагчид, багш нартай хамтран ажиллаж төлөвшүүлэх нь зайлшгүй шаардлагатай болно.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад зарим залуу эцэг эхчүүд гадаад улс орны соёлыг судлахын зэрэгцээ монголын уламжлалт үнэт өв соёлоосоо суралцах шаардлагатай байгаа нь ажиглагдлаа. Тухайлбал, “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрт эцэг эхчүүдийн оролцоог тодорхойлсон ч тэд хүүхдийнхээ эзэмшвэл зохих мэдлэг, чадварын талаар мэдэхгүй, дутуу ойлголттой эсвэл өөрсдөө зөв танин мэдээгүйн улмаас сурагчдын ёс зүйн боловсрол эзэмших үйл явцад бэрхшээл учирч болзошгүйг анхаарах шаардлагатай байна. Эцэг, эхчүүд монгол уламжлалт өв соёл, уламжлалаа мэдэхгүй, хайрлан хамгаалах, өвлөх хүсэлгүй бол сургууль, багш нараас тэдний үр хүүхдүүдэд ёс зүйн боловсрол эзэмшүүлэхээр хичээж буй их хөдөлмөр, үйл ажиллагаа үр дүн муутай байх нь гарцаагүй.

ДҮГНЭЛТ: Манай улсын хувьд өнө эртний түүхтэй, эх түүх, хэл соёлоо, ахуй уламжлалаа дээдлэн үздэг эх орончдын өлгий нутаг, залгамж халаа гэдэгтээ бид үргэлж бахархаж байдаг хэдий ч судалгааны ажлын эхэнд дурдсан аюулгүй байдлын олон шинэ асуудлууд үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх төдийгүй улс орны хүчин чадалд нэн хүчтэй нөлөөлж байгаа ба дараах онцгой асуудлууд эх оронч үзлийг анхааран авч үзэхийн чухлыг харуулж байна. Үүнд: нэгдүгээрт, Монголчуудын ялангуяа залуучуудын өнөөгийн амьдралд гадаад орнуудын үнэт зүйлс, соёл уламжлал нөлөөлөх нь машид нэмэгдсэн байна. Энэ нь даяарчлал, цахим сүлжээний хүртээмж, мэдээллийн орон зайн хяналтгүй байдал, боловсролын системийн либералчлал гэх мэт олон зүйлсээс хамааралтай боловч эцсийн дүндээ эх орноо дээдлэн хүндлэх бүхнээ үгүйсгэхэд хүргэх аюулыг бий болгоод байна. Хоёрдугаарт, дэлхий нийтээрээ хүмүүсийн амьдралын хэв маяг өөрчлөгдөж, эх оронч үзэл буурч байна. Жишээлбэл, 2023 онд Австрали улсад явагдсан Нийгмийн нэгдмэл байдлын судалгаанаас харахад тус улсын

¹ Лхагвамаа.Б, “Сурагчдын үндэсний ёс заншлын боловсрол, нөлөөлөх зарим хүчин зүйлийг судалсан үр дүн (ЕБС-ийн 5, 9, 12-р ангийн жишээн дээр)” докторын диссертац, 2019.

² Баатарсүрэн.Б, “Эх оронч үзлийг дээдлэх үзэл баримтлал ба ой тогтоолтыг судалсан үр дүн”, “Боловсрол судлал” сэтгүүл, Vol.179 No.1, УБ., 2022.

иргэдийн эх оронч үзэл эрс буурсан нь харагдаж байна.¹ Мөн АНУ болон бусад олон орнуудад энэ асуудал хүндрэлтэй байдлыг үүсгэсээр байна.²

Энэхүү судалгаанаас дүгнэн үзэхэд Монгол Улсын ЕБС-ийн нийгмийн ухааны хичээлүүдийн хөтөлбөрт монгол ёс заншил уламжлал, эх оронч үзэл, хүмүүжил, үнэт зүйлс, түүхийн мэдлэг, чадвар, дадал олгох агуулга харьцангуй сайн тусгагдсан байгаа боловч мэдлэгийг бататгах, дадал, тэмүүлэлтэй болгоход эцэг, эх, гэр бүлийн гишүүдийн оролцоо маш хангалтгүй, сул байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Иймээс Монгол Улсынхаа үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэхийн тулд эх оронч үзэл, хүмүүжил, үндэсний өвөрмөц түүх, ёс заншлын мэдлэг, чадвар, дадлыг сургуулийн өмнөх боловсролоос эхлэн залгамж холбоотой олгож, эх орноо гэсэн сэтгэлийг, МОНГОЛ ХҮН гэсэн бахархлыг боловсролын байгууллага, эцэг, эх гэр бүлийн хамтын ажиллагаагаар төлөвшүүлэх нь нэн чухал асуудал болж байна.

Мөн улс орнуудын сайн туршлагыг судлан үндэстнээрээ аюулыг тэсэн гарах ухамсрыг суулгах, мөн эх орныхоо ирээдүйд итгэх итгэлийг бүрдүүлэх шаардлагатай байна гэж дүгнэлээ.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ, МАТЕРИАЛ

1. “Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Боловсрол үндэсний хөтөлбөр” (МУЗГ-ын 2018 оны 209 дүгээр тогтоолын хавсралт)
2. “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр” (МУЗГ-ын 2019 оны 200 дугаар тогтоолын хавсралт)
3. 1212.mn
4. 2024 FM Global Resilience Index, <https://www.fm.com/resources/resilience-index>
5. Bar-Tal, Daniel, Patriotism_Its_scope_and_meaning, 1997, <https://www.researchgate.net/publication/>
6. Cabinet Office, The National Resilience Strategy: Call for Evidence, London, 2021.
7. Fran H. Norris, Susan P. Stevens, Betty Pfefferbaum and others “Community Resilience as a Metaphor, Theory, Set of Capacities and Strategy for Disaster Readiness”, April 2008, [American Journal of Community Psychology](#)
8. <https://www.politifact.com/factchecks/2023/jun/28/vivek-ramaswamy/vivek-ramaswamy-is-partially-right-about-patriotis/>
9. <https://www.weforum.org/publications/global-risks-report-2025/in-full/paste-test/>
10. Hurwitz & Peffley 1999; Spinner-Halevand Theiss-Morse 2003; Sullivan, Fried & Dietz, 1992.
11. RSL Australia, Declining Patriotism Putting Australia’s Defense at Risk, Sydney, February 2025. <https://www.rslaualia.org/latest-news/declining-patriotism-putting-australias-defence-at-risk>
12. The White House, National Resilience Strategy, Washington DC, 2025.
13. Tim Huxley, Defending the Lion City: The Armed Forces of Singapore, Allen & Unwin, Sydney, 2000, p 25.
14. Баатарсүрэн.Б, “Эх оронч үзлийг дээдлэх үзэл баримтлал ба ой тогтоолтыг судалсан үр дүн”, “Боловсрол судлал” сэтгүүл, Vol.179 No.1, УБ., 2022.
15. Боловсролын Ерөнхий Хууль, 2023.
16. БСШУСЯ, “Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр”, 2019.
17. БШУ-ны сайдын А/147 дугаар тушаал, 2024 он.
18. Галбадрах.Т нарын орчуулга, “Дэлхийн чиг хандлага-2040”, АНУ-ын ҮТЗ-ийн хэвлэл, 2021 оны 3-р сар.
19. Лхагвамаа.Б, “Сурагчдын үндэсний ёс заншлын боловсрол, нөлөөлөх зарим хүчин зүйлийг судалсан үр дүн (ЕБС-ийн 5, 9, 12-р ангийн жишээн дээр)” докторын диссертаци, 2019.

¹ RSL Australia, Declining Patriotism Putting Australia’s Defense at Risk, Sydney, February 2025.

<https://www.rslaualia.org/latest-news/declining-patriotism-putting-australias-defence-at-risk>

² <https://www.politifact.com/factchecks/2023/jun/28/vivek-ramaswamy/vivek-ramaswamy-is-partially-right-about-patriotis/>

Abstract:

In this presentation, we discussed Immanuel Kant's Perpetual Peace, a foundational work that has significantly influenced modern international relations and the formation of various global organizations. Although the book is brief, its themes are profound and far-reaching. Kant concluded that lasting peace is possible, even if it has not yet been fully realized. Today, many of his ideas remain relevant, and we must reconsider and adapt them to address contemporary global challenges.

Key words: War, Peace, Morality, Duty, UN

Германы агуу философич Иммануэл Кант 1724 оны 4-р сарын 22-нд Зүүн Пруссийн Кенигсберг (одоогийн ОХУ-ын Калининград) хотноо мэндэлжээ. 2024 онд түүний мэндэлсний 300 жилийн ойг дэлхий даяараа тэмдэглэж, философийн түүх, шинжлэх ухааны арга зүй, улс төр, ёс суртахууны онол, урлаг, гоо зүйн үзэл санаа хийгээд нийгмийн оюун санааны хөгжилд оруулсан хувь нэмрийг нь хэлэлцүүлсэн эрдэм шинжилгээний хурал, семинар хаа сайгүй болсон юм. Иммануэл Кант европын оюун сэтгэлгээний уламжлал, философийн баялаг өвийг судлан шинжилсээр тэр дундаа, хүний оюун ухааны төрөлх өгөгдөл, чадамжийг онцолдог рационализм (Рене Декартын *cogito ergo sum*), хүний ухаан хов хоосноос эхэлдэг гэх эмпирицизм (Жон Локкын *tabula rasa*) хоёрыг нэгтгэж боловсруулсан онол номоороо орчин үеийн философийг үндэслэсэн билээ. Түүний өмнөх үеийнхээ философийн сэтгэлгээний уламжлалд гүн шинжилгээ хийж, бүтээсэн системтэй үзэл санааг “трансценденталь идеализм” хэмээн философийн түүхэнд мөнхөлсөн. Тэрхүү рационализм хийгээд эмпирицизмыг нэгтгэсэн онол, хүний түүхийн телеологи үзэл, деонтологи ёс зүй гээд философийн үзэл санаа нь лавтайяа сүүлийн хоёр зуун хэдэн жилийн туршид дэлхийн философийн сэтгэлгээнд жинтэй нөлөөлж иржээ.

И.Кант “Цэвэр оюун ухааныг шүүн шинжлэхүй” хэмээх зохиолын өмнөх үгэндээ өөрийнхөө амьдарч байсан соён гэгээрлийн үеийг “шүүн шинжлэхүй сэтгэлгээний эрин”¹ хэмээсэн байдаг. Чухам энэ шүүн шинжлэхүй сэтгэлгээний эрин үеийн ачаар хүн төрөлхтөний нийгмийн амьдралыг олон талаар өөрчилсөн үзэл санаа, онолын системүүд бүтээгдсэн. Хүний эрхийн тухай, өмчийн эрхийн тухай, эрх чөлөөний үзэл санаанууд бол хүн төрөлхтөний сэтгэлгээний гарамгай ололтууд мөн. Хүний эрхийн үзэл санаа нь эдүгээ бүх улс орнуудын заавал баримтлах нийгмийн хэм хэмжээ болсон зүйл билээ. Эдгээр нь тухайн цагийн хаант төрийн эсрэг, засаглалын эсрэг, сүм хийдийн эсрэг өрнүүлсэн шүүмжлэлт сэтгэлгээний үр дүн болж гарч ирсэн улс төр, философийн үзэл баримтлалууд юм.

XVIII зууны Европын соён гэгээрлийн төгсгөл үеийн шүүмжлэлт эргэцүүлэх сэтгэлгээний хамгийн том төлөөлөгчийн хувиар Кант тухайн цаг үеийн нөхцөл байдал, улс төр-нийгмийн үймээн самуун, дайн тулааныг эргэцүүлсэн нэг бус бүтээл бичсэн билээ. Түүний амьдралынх нь ихэнх хугацаанд Пруссийн эзэнт гүрэн хөрш зэргэлдээ орнууд, ялангуяа Францтай дайтаж ирсэн, түүнчлэн европын том орнууд хоорондоо байнга мөргөлдөж тулалддаг, жижиг сул доройгоо дайрч түрэмгийлдэг байлаа. 1789 онд Францад цус асгаруулсан хувьсгал өрнөж, түүнээс улбаалан нийгмийн хувьсгалт үйл хэрэг, дайн тулааныг эргэцүүлж, нас өндөр болсон хойноо буюу 71 настайдаа бичсэн “Үүрдийн энх тайван: философийн ноорог”² хэмээх бэсрэг бүтээл бол дайнаас сэрэмжилж, дэлхий дахинд энх тайвныг үүрд тогтоох арга замын тухай улс төр, олон улсын харилцааг хөндсөн бүтээл болно. Угтаа орчин үеийн олон улсын харилцааны идеалист онолын үндсэн эх сурвалж болсон юм. Кантын трансценденталь философи бол ёс суртахуун, улс төр, урлаг, гоо зүй, нийгмийн олон асуудлыг хамарсан орчин

¹ Кант, I. Critique of Pure Reason, (Cambridge University Press, 1999), p.13

² Kant, I. “Toward Perpetual Peace: A Philosophical Sketch.” In Toward Perpetual Peace and Other Writings on Politics, Peace, and History. New Haven, CT : Yale University Press, (2006) pp. 67–109.

үеийн оюун санааны түүхийн эргэлтийн цэг болж, философид дахь “Коперникийн хувьсгал” гэгддэг билээ. Дайн тулаан ихэссэн, элдэв зүйл байгалийн хийгээд нийгмийн хямралын эдүгээ үед ч түүний олон санаа үнэ цэнэтэй хэвээр байна. Улс төрийн үйл хэргийг үргэлж ёс суртахуунаар чиглүүлж байхыг номлосон нь яах аргагүй өнөөгийн улс төрийн үйл хэрэгт дутагдаж буй асуудал мөн.

Уг бүтээлд элдэв маргаан, зөрчилдөөнийг хамтран шийдвэрлэж байх эрх чөлөөт улсуудын холбоо байгуулах, олон улсын хооронд асуудлаа харилцан зөвшилцөж, гэрээ, хэлэлцээр байгуулж даган биелүүлэх, улс орнуудын эрх ашиг, сонирхлыг хүлээн зөвшөөрөх боловч хүний нийгмийн эрхэм дээд үүрэг ёс суртахууны үүргээ эхэнд тавьж хэлбэрэлтгүй мөрдөх аваас дэлхий нийтээрээ амар жимэр аж төрөх, энх тайвныг тогтоох боломжтой гэж дүгнэсэн. Кантын ёс суртахууны философийн хамгийн гол ойлголт бол үүргийн тухай байдаг. Тэрхүү ёс суртахууны үүргийг улс орнууд ч баримталж эхэлснээр улс төр ба ёс суртахууны үүрэг, уялдаа холбоог зохилдуулж, дайн тулаангүй, зөрчилдөөн багатай болж энх амгаланг тогтооно гэж үзсэн байна. Эдгээр санаанд үндэслээд XIX зуунаас эхлэн үндэстнүүдийн лиг байгуулах оролдлогууд удаа дараа өрнөж, хожим дэлхийн хоёрдугаар дайны дараагаар Нэгдсэн Үндэстний Байгууллага байгуулагдаж, олон улсын дэг журам, энх тайвны сахиулах үйл хэргийг хариуцах байгууллагатай болсон билээ. Европын Холбоо ч мөн Кантын энх тайвны санаа, үзэл баримтлалд тулгуурлаж байгуулагдсан гэхэд болно. Бүр нарийн яривал түүний санаанууд олон улсын харилцааны үндсэн зарчим болсон төдийгүй зарим онолын үүсэл хөгжилд нөлөөлсөн юм. Үүнд, ардчилсан энх тайвны онол (democratic peace theory), арилжаа наймааны энх тайван (commercial peace), байгууллагын энх тайван (institutional peace) зэрэг өнөөгийн олон улсын харилцааны онолуудыг дурдахад хангалттай.

Тэрээр Макиавелли, Томас Гоббсын нарын нэгэн адил хүний мөн чанарыг “байгалийн байдал”-тай төрөлхийн түрэмгий, хувиа хичээсэн, муу чанартай гэдгийг хүлээн зөвшөөрсөн ч хүний оюун ухааны чадамж энэхүү зэрлэг байдлаасаа ёс суртахуунтай төлөв байдалд шилжих боломжтой гэж үзсэнээрээ ялгардаг. Нөгөө хоёр нь төрийн хатуу гараар нийгмийн гэрээний үндсэн дээр хүмүүсийг нэгтгэн захирах онол номыг бүтээсэн хүмүүс. Кант ёс суртахуунаар хүнийг засамжлахыг, нийгмийг удирдахыг заасан шигээ улс төр, гадаад бодлогыг ч ёс суртахууны дүрэмд нийцүүлж явуулах ёстой гэдэг хатуу байр суурийг баримталж байжээ. Хүний ёс суртахууны хөгжил нь яван явсаар эцэстээ дэлхийн энхтайвныг бүтээх хувь тавилантай гэж өөдрөгөөр төсөөлсөн. Түүнчлэн, Кантын үүрдийн энхтайван боломжтой бөгөөд заавал хэрэгжинэ гэсэн таамаглал нь хүн төрөлхтний хөгжил дэвшилд итгэх соён гэгээрлийн үеийн сэтгэлгээний илэрхийлэл болж харагддаг. Бүтээлдээ хүн өөд болоод л амар тайван байх тавилантай эсэх асуудлыг хөндөж тавиад хүн амьд байхдаа ч хувь хүний хувьд ч тэр нийгмээрээ ч тэр иэнх амгалан орших ёстой гээд үүрдийн энх тайван тогтоох нөхцлийг эрэлхийлж, чиг баримжаа, санаа болох урьдач нөхцөлүүдийг тоочсон байна.

Кант бүтээлийнхээ эхний хэсэгт үүрдийн энхтайвны зургаан урьдчилсан зүйлийг дурдсан бөгөөд хоёрдугаар хэсэгт, тэрээр үүрдийн энхтайвны гурван эцсийн зүйлийг тодорхойлсон. Эдгээр зүйлүүдийн дараа нэмэлт тайлбарууд ба хавсралтууд дагалдуулсан байдаг. Кант урьдчилсан болон эцсийн зүйлүүдийг ялган зааж өгснөөр, үүрдийн энхтайван нь удаан хугацааны, шаталсан үйл явц болохыг тайлбарлажээ. И.Кант “Ёс суртахууны метафизик” бүтээлдээ улсуудын харилцаа нь “байгалийн байдалд”, өөрөөр хэлбэл байнгын дайны нөхцөлд оршдог¹. Нийтлэг хууль, эрх мэдэл байхгүй энэ нөхцөлд аль нэг улс өөрийгөө хохирсон гэж үзвэл хүч хэрэглэх эрхтэй². Кантын хэлснээр, энэхүү байгалийн байдалд эрхийн ойлголт үгүй тул нэг улс нөгөөдөө шударга бус хандсан гэж хэлэх боломжгүй ч, энэ хүч хэрэглэх байдал нь өөрөө туйлын шударга бус юм. Иймээс хөрш улсууд энэхүү нөхцөлийг орхиж, анхны нийгмийн гэрээний үзэл санаанд тулгуурлан, харилцан довтолгооноос хамгаалах, бусдын дотоод хэрэгт оролцохгүй байх зарчимтай ард түмнүүдийн холбоо байгуулах ёстой³. Харин урьдчилсан

¹ Kant, I. Groundwork of the Metaphysics of Morals. p.53

² Kant, I. Groundwork of the Metaphysics of Morals. p.56

³ Kant, I. Groundwork of the Metaphysics of Morals. p.54

зургаан зүйл нь ийм холбоо байгуулагдах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн анхны алхмууд юм. Үүнд нийцэн ажиллах нь “байгалийн байдал”-аас гарах үүргийг биелүүлэх эхний нөхцөл болно.

Урьдчилсан зүйлүүд нь улс төрийн засаглал, гэрээ хэлэлцээ, арми болон зэвсэгт хүчин, олон улсын өрийн асуудлууд, дотоод засаглалд нөлөө үзүүлэх хүчний оролцоо зэргийг зохицуулах замаар дайны шалтгаануудыг багасгах эсвэл арилгах, зөрчил маргааны эрсдлээс сэргийлэхэд чиглэсэн 6 нөхцөл болно. Эдгээр нь:

1. Нууц гэрээ байж болохгүй
2. Ямар ч бие даасан улс, орныг хүчээр нэгтгэхийг хориглох.
3. Байнгын армийг аажмаар бүрмөсөн татан буулгах.
4. Дайныг санхүүжүүлэх зориулалтаар гадаад улсаас зээл авахгүй, өгөхгүй байх.
5. Бусад улсын дотоод болон төрийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх
6. Ирээдүйд энх тайван тогтоох боломжийг үгүй хийх хэрцгий байлдааны арга хэрэглэж болохгүй.¹

Эдгээр урьдчилсан зургаан зүйлс бас дангаараа хангалтгүй. Иймээс Кант дараагийн гурван үндсэн зүйлийг санал болгосон: Нэгдүгээрт, улс орон бүрийн төрийн байгуулал “бүгд найрамдах” засаглалтай байх ёстой. Энэ нь одоогийн улс төрийн томьёоллоор бол төлөөллийн ардчилал юм. Иргэд өөрсдийн сонгосон төлөөлөгчөөр дамжуулан хууль батлахад оролцох эрхтэй. Эрх мэдлийн хуваарилалт, чөлөөт хэвлэл, шүүмжлэлтэй хэлэлцүүлэг зэрэг нь засгийн эрх мэдлийг хязгаарлана. Ийм төртэй улсууд дайн хийх магадлал багатай.

Хоёрдугаарт, “эрх чөлөөт улсуудын холбоо” буюу олон улсын эрх зүйн холбооны засаглал байгуулахын чухлыг онцолсон. Улсууд тус тусдаа “байгалийн байдал”-д оршдог. Тиймээс тэд олон улсын эрхзүйн холбоонд сайн дураар нэгдэж, харилцан эрхээ хамгаалах, зохицуулах ёстой. Кант дэлхий нийтийг хүчээр нэгтгэсэн дарангуй хаант засгийг эсэргүүцсэн билээ, харин бүх улсуудыг хамарсан энхийн холбоо аажмаар үүсч болохыг таамагласан нь өнөөгийн Нэгдсэн Үндэстний Байгууллага зэрэг олон улсын байгууллагуудын үндэс болсон билээ. Иргэн хүн эрхээ хамгаалахын тулд “байгалийн байдлаас” гарч төрд, нийгэмд нэгддэг. Үүнтэй адил улс орнууд ч өөрийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд олон улсын байгууллагад нэгдэх ёстой. Аль ч улс өөрийн бодлогыг нээлттэй зарлаж чадахгүй бол, тэр бодлого шударга бус гэж бичжээ.

Гуравдугаарт, бүх хүн хүндэтгэл эдлэх ёстой. Дайнаас зугтаж буй гадаадын хүмүүсийг аюулд оруулахгүйгээр хүлээж авах ёстой. Энэ нь иргэний эрхгүй хүмүүс (жишээ нь, дүрвэгсэд) ч хүртэл хүний эрхтэй байх ёстой гэсэн санаа юм. Өнөөгийн олон улсын бодит байдлаас харвал Кантын зарим санал бүрэн хэрэгжээгүй, олон улсын байгууллагуудын хүчин чармайлтаар ч дайн тулгаралтыг зогсоож хүчрэхгүй, энх тайван тогтоож чадахгүй байгаа нь зарим санааг хэрэгжүүлэх боломжгүй мэт харагддаг. Тийм хэдий ч Кантын бүтээл нь улс орнуудын удирдагчид өнөөдөр ч анхааран авч үзэж болох санаа онооны баялаг эх сурвалж, олон улсын ёс зүйн, энхтайвны судлалын гол үндэс хэвээр байсаар байна. Кантын үүрдийн энх тайван бүтээл нь хоёр зуун жилийн дараа ч үнэ цэнээ алдаагүй, дайныг шүүмжлэх ёс суртахууны үндэслэл, энх тайвныг тогтоох бодит үйл ажиллагааны төлөвлөгөө хэвээр байна. Түүний үзэл санаа бол зүгээр нэг мөрөөдөл биш, харин урт хугацааны энх тайвныг эрх зүйн ба ёс зүйн үндсэн дээр байгуулах санал санаачилга байсан бөгөөд түүнд үндэслэсэн өнөөгийн дэлхийн дэг журмыг сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд мөрддөг зарчмууд болсон юм.

¹ Kant, I. “Toward Perpetual Peace: A Philosophical Sketch.” In *Toward Perpetual Peace and Other Writings on Politics, Peace, and History*. New Haven, CT : Yale University Press, (2006) p. 70.

ХИИ ЗУУНЫ МОНГОЛЧУУДЫН ДАЯН ДЭЛХИЙД ЭНХ ТАЙВНЫГ ТОГТООХ БОДЛОГО

Ж.ЖАРГАЛСАЙХАН

Доктор (Ph.D)

Философийн хүрээлэн

Монголчууд ХИИ зуунд Төв Азийн өндөрлөгт нэгдсэн төр улсаа байгуулж, хөрш зэргэлдээ улс орнууд руугаа удаа дараагийн аян дайн хийж, хэдхэн арван жилийн дотор хуурай газрын агуу их гүрнийг байгуулсан. Ийнхүү Их талын нүүдэлчид дэлхийг бүхэлд нь нэгтгэх оролдлого хийснээрээ (монголчуудын аян дайн эзлэн түрэмгийлэх гэхээсээ илүү даян дэлхийд энх тайвныг тогтоох зорилготой байсан) Өрнө, Дорно дахиныг ойртуулжээ. Монголын нүүдэлчид соёл иргэншлүүдийн хооронд мэдээлэл дамжуулан нэвтрүүлэгч болж, анх удаа бүс нутгийн бүх том төвүүдийг аж үйлдвэржилтийн өмнөх үеийн дэлхийн систем болгон нэгтгэсэн юм. Монголын эзэнт гүрэн задран унасны дараа ч Европын орнуудад Дорно дахины улс орнуудтай холбогдох зам шаардлагатай болсноор далайн аялал эрчимтэй хөгжсөн. Үр дүнд шинэ тивүүд нээгдэж, колоничлолын дайнууд явагдсан гэх мэт үйл явдлууд өрнөжээ. Ингэж монголчууд “өөрийнхөө” цаг үед дэлхийн түүхэн үйл явцын хурдасгагч буюу хөдөлгөгч хүчний үүргийг гүйцэтгэжээ.

Түлхүүр үгс: Их талын нүүдэлчид, овог аймгийн байгуулал, удмын холбоо, Монголын нүүдлийн феодализм, монголчуудын аян дайн, Их хуралдай, Өрнө, Дорно, байгаль, үзэл санаа, мөнх тэнгэр.

The mongolians of the 13th century – a policy of establishing peace throughout the world
In the thirteenth century, the Mongols founded their unified state on the Central Asian plateau and launched successive military campaigns into neighbouring countries, establishing within only a few decades a vast continental empire. By attempting to unite the world as a whole (the Mongolian military campaigns were aimed less at conquest and aggression than at securing peace throughout the world), the nomads of the Great Steppe brought the East and West closer together. The Mongol nomads became transmitters of information between civilisations, for the first time uniting all major regional centres into a pre-industrial world system. Even after the collapse of the Mongol Empire, European states felt the necessity of establishing routes to the Eastern countries, which led to the rapid development of maritime expeditions. As a result, new continents were discovered and colonial wars unfolded. In this way, the Mongols, in “their own” time, fulfilled the role of catalyst and driving force in the course of world history.

Keywords: *Nomads of the Great Steppe, tribal organisation, lineage ties, Mongolian nomadic feudalism, Mongolian military campaigns, Great Khuraldai, East and West, nature, ideology, Eternal Heaven.*

Нүүдэлчин монголчуудын ХИИ зуунд Европид тивд явуулсан аян дайн, түүнээс улбаатай даян дэлхийд энх тайвныг тогтоох бодлогын талаар өгүүлэхийн өмнө нүүдэлчдийн нийгэм төрийн байгууллын тогтолцоо, нүүдлийн их гүрнүүдийн үүслийн шалтгаан, тэдний цэрэг дайны үйл ажиллагааны онцлогийн талаар авч үзэх ёстой. Зарим судлаачид Чингис хаан монгол угсаатан овог аймгуудыг өөрийн эрх мэдлийн дор нэгтгэж Монголын Нэгдсэн улсыг байгуулсан нь нүүдлийн соёлын оргил үе байсан гэж тэмдэглээд энэ үеийг «Монголын нүүдлийн феодализм»¹ хэмээн нэрлэсэн байдаг. Энэхүү нүүдэлчдийн нэгдсэн төр улсын үед бичиг үсэг бий болж, монголын нүүдлийн нийгмийн амьдралын бүх салбарыг зохицуулсан хууль цаазын эмхэтгэл болох «Их Засаг» батлагдсан. Монголчуудын хилийн чанад дахь байлдан дагуулалт эхэлж, Хятадын хоёр эзэнт гүрэн, Өмнөд Ази, Дорнод Европыг байлдан дагуулсан билээ. Төрийн тогтолцооны хувьд монголчууд бусдаас хуулбарлалгүй өөрсдийн уламжлалт, авсаархан, оновчтой, идэвхтэй, хүчирхэг төрийн

¹ Владимирцов Б.Я. Общественный строй монголов. — Ленинград, 1934. — 223 с.

аппаратыг баяжуулан хөгжүүлж, суурин соёл иргэншилт нийгмийн онцлогт тохируулан хэрэглэсэн нь үр дүнтэй болсон байдаг.

Нүүдэлчин ард түмнүүдийн нийгмийн байгуулал, төрийн тогтолцоог марксизмыг үндэслэгчид тодорхойлохдоо: «нүүдлийн малчин аймгуудын хувьд холбоо нь бараг бүгд нэг дор цугларсан, хамтдаа; энэ нь – хамтран аялагч хүмүүсийн нийгэмлэг, цуваа, орд ба тэдний захирагдах хэлбэрүүд нь энэхүү амьдралын нөхцөл, дүр төрхөөс урган гарч хөгждөг»¹ болохыг тэмдэглэжээ. Гэхдээ үйлдвэрлэлийн харилцаа, амьдралын дүр төрхөөс гадна нүүдэлчдийн нийгэм-төрийн байгууллын үүсэл, хөгжилд нөлөөлөх өөр нэг чухал хүчин зүйл нь байнгын дайны нөхцөл байдал байсныг олон судлаачид дурдсан² байдаг. Чухамхүү цэрэг дайны нөхцөл байдал нь нүүдэлчдийн нийгэм дэх феодалжих үйл явцын хөгжилд голлох үүрэг гүйцэтгэсэн билээ.

Нүүдэлчдийн нийгэм-төрийн байгууллын үүсэл, хөгжилд цэрэг дайны нөхцөл байдлын нөлөөллийн талаар зөвлөлтийн, дараа нь оросын судлаачид олонтоо бичжээ. Тэд үзэхдээ, нүүдлийн нийгэмд овог аймгийн бүтэцтэй байгуулал, хэвшмэл нүүдлийн-холбоо, цэргийн-нүүдлийн байгуулал голчлон оршин тогтнож байсныг дурдсан байдаг. Харин нүүдлийн эзэнт гүрнүүдийн үед богино хугацааны дотор төр улсын байгууллын шинж чанар бүрэлдэн тогтдог³

байсныг тэмдэглэжээ. Оросын судлаач Н.Н. Крадины тодорхойлсноор, нүүдэлчдийн хувьд төр улс дотоодын хэрэгцээ шаардлага нь байгаагүй. Нүүдэлчид нэгдэх, нэгдсэн төр улс байгуулах шаардлага нүүдэлчдийн хувьд амьдралын эх үүсвэрийн төлөөх дайн байлдааны үед үүсдэг байсан. Нүүдлийн эзэнт гүрнүүдийн бүрэлдэл нь «...нэгдэл нягтралын үр дүн, нүүдэлчид, газар тариаланчдын хоорондын мөргөлдөөний үр нөлөөгөөр үүсэн бий болдог»⁴ байжээ. Өөрөөр хэлбэл, нүүдэлчдийн хувьд төр улс нь тэдний нэгдэл нягтралтай дүйцэх зүйл мөн ажээ. Харин нарийн бүтэц, зохион байгуулалттай нүүдэлчдийн нэгдсэн төр улсын үүсэл, бүрэлдэл нь нүүдэлчид, газар тариаланчдын хоорондын дайн байлдааны шууд үр дүн байсан юм.

Товчхондоо нүүдэлчдийн нийгэм төрийн байгуулал байнгын “хөдөлгөөн” дунд оршин байж, гадаад, дотоод янз бүрийн шалтгааны улмаас өөрчлөгдөж, төрөл бүрийн хэлбэрийг агуулсан нийгмийн, угсаатны бүлгүүд нүүдэлчдийн нийгэмд үүсдэг байжээ. Нөгөөтгээгүүр нүүдэлчдийн нийгмийн хөгжлийн явц дахь нарийн бүтэц, зохион байгуулалттай нийгэм-төрийн байгууллын бүрэлдэл, хөгжил удаашралтай байсныг тэмдэглэх хэрэгтэй. Нүүдэлчдийн нийгэм нь хүн төрөлхтний хөгжлийн нийтлэг зарчмаар, «...эхлээд гэр бүл үүссэн, энэ нь аливаа нийгмийн үндэс суурь, дараа нь гэр бүл овог аймаг болсон, харин овог аймаг нь төр улс болж өргөжсөн»⁵ байдлаар явагдсан боловч энэхүү процессын сүүлийн үе шат нэлээд удааширсан юм. Нүүдэлчдийн нийгмийн энэхүү өвөрмөц онцлог байдал түүний нийгмийн байгууллын (төр улсын) үүсэл, хөгжилд шууд тусгалаа олсон байдаг. Зөвхөн суурин ард түмнүүдтэй ойртсон үед л нүүдэлчдийн шаталсан тогтолцоотой нийгэм-төрийн байгуулал үүсэн бий болж байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Нүүдлийн эзэнт гүрнүүдийн гарал үүслийн шалтгааны хувьд судлаачид янз бүрийн дүгнэлт хийсэн байдаг. Нүүдэлчид улс төрийн нөлөөгөө өргөжүүлэх, татварын харилцааг оновчтой болгох нь тэдний төр улсын үндсэн зорилго⁶ байсныг Л.П. Лашук дурдсан байдаг. Монголын нэгдсэн төр улсын үүслийн гол нөхцөл нь овог аймгуудын дотоодын нийгэм улс төрийн тогтворгүй байдал байсныг тэрээр тэмдэглэжээ. Чингис хаан “нэгдмэл овог аймгуудын” системийг түшиглэж, илүү эв нэгдэлтэй «нэгдмэл овог аймгуудыг» өөр бусад гарал үүсэлтэй бүлгүүдэд хүчээр уусган тараах арга хэрэглэн дайсагнасан хүчийг устгадаг байсан бөгөөд түүний шургуу, ухаалаг, дэс дараатай бодлого үр дүнгээ өгсөн. Монголын

¹ Маркс К. и Энгельс Ф. Соч. — Изд-е 2. — Москва, 1968. — Т. 46, ч. 1. — 559 с.

² Маркс К. Хронологические выписки «Архив Маркса и Энгельса» /К. Маркс. — Москва, 1938. — Т. 5. — 424 с.

³ Крадин Н.Н. Империя Чингис-Хана /Н.Н. Крадин, Т.Д. Скрынникова. — Москва, 2006. — 557 с.

⁴ Крадин Н.Н. Империя Чингис-Хана /Н.Н. Крадин, Т.Д. Скрынникова. — Москва, 2006. — 557 с.

⁵ Ленин В.И. ППС. — 5 изд. /В. И. Ленин. — Т. 1. — Москва, 1979. — 662 с

⁶ Лашук Л.П. Историческая структура социальных организмов средневековых кочевников /Л.П. Лашук //Советская Этнография. — 1967. — №4. — С. 25-40.

язгууртнууд «...өөрсдийн болон өмчийнхөө хувь заяаг овог аймаг хоорондын дайснагасан тогтворгүй нөхцөл байдалд даатгахаас илүүтэйгээр төрийн хатуу чанга эмх цэгцийг тогтоож буй дээд удирдагчийг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байсан»¹ нь Чингис хаан монголын нэгдсэн төр улсыг байгуулахад хүчтэй түлхэц болжээ. Мөн оросын судлаач Г.Е. Марков тал нутгийн язгууртнуудын цэрэг, улс төрийн ашиг сонирхол нэгдсэн төр улс үүсэх, цаашлаад хөрш улс орон, ард түмнүүдийг түрэмгийлэн эзлэх дайн хийхэд голлох нөлөө үзүүлсэн болохыг дурджээ. Гэхдээ нүүдлийн эзэнт гүрнүүд нь «...түр хугацааны, цаг зуурын бүрэлдэл» байдгийг тэрээр тэмдэглээд эзэнт гүрний задралын дараа ч нүүдлийн бүлгүүд бие даасан байдлаа хадгалан ямар нэг хүндрэлгүй өөрсдийн замаа олж чаддаг² байсныг дурджээ. Ийнхүү монгол овог аймгуудын нэгдэн нягтрах үйл явц нийгэм-улс төрийн “тохиромжтой” нөхцөл байдал, хүчирхэг удирдагч, түүний чанга хатуу, шургуу бодлогын үр дүнд биеллээ олддог байжээ. Харин нүүдэлчдийн (овог аймгуудын) нэгдэл, бутрал нь тал нутагт хэвийн үзэгдэл байдлаар явагддаг байсан.

Эдийн засгийн хэрэгцээгээ хангах зорилгын үүднээс нүүдэлчид суурин нийгмүүд рүү түрэмгийлэл үйлддэг байсан хэмээн Н.Н. Крадин бичжээ. Тэрээр нүүдэлчид амьдралын эх сурвалжийн төлөө түрэмгийллийн аргыг хэрэглэдэг, цөөнгүй тохиолдолд худалдааны замуудад хяналт тогтоодог байсан ч хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хэрэгцээгээ хангахын тулд тэд суурин иргэдтэй худалдаа арилжаа эрхэлдэг байсныг дурджээ. Харин нүүдэлчдийн улс төрийн системийн хувьд: «олон үе шаттай, шатлан захирагдах хэв шинжийг агуулсан нийгмийн байгуулал, үе шат болгондоо уг гарал, удмын холбоо нэвт шингэсэн овог аймаг болон овог аймгийн байгуулалд тулгуурласан тогтолцоо; хосолсон (баруун, зүүн жигүүр), эсвэл гуравласан (төв болон жигүүрүүд) эзэнт гүрний захиргааны зарчим; аравтын зарчмыг баримталсан цэргийн шатлан захирах шинж чанарыг агуулсан эзэнт гүрний нийгмийн байгуулал; засаг захиргааны дэд бүтцийн онцгой зохион байгуулалттай өртөөний алба; төр улсыг залгамжлах өвөрмөц тогтолцоо (эзэнт гүрэн – хааны удам угсааныхны бүгдийн өв, өмч, хамтран засаглах институт, их хуралдай); газар тариаланчдын ертөнцтэй харилцах онцгой арга зам»³ гэх мэт шатлалтай байсныг Н.Н. Крадин тэмдэглэжээ.

Хүчирхэг газар тариалангийн улсуудын түрэмгийллээс хамгаалах шаардлагын үүднээс нүүдэлчдийн улс, гүрэн байгуулагддаг байсан хэмээн зарим судлаачид үзжээ. Л.Н. Гумилёв монголын нэгдсэн улс нь голлон хятадын түрэмгийллийн эсрэг үүссэн⁴ болохыг тэмдэглэсэн байдаг. Мөн үүнтэй ойролцоо, «нүүдэлчдийн төвлөрлийн зэрэг нь хөрш зэргэлдээх газар тариалангийн соёл иргэншлийн хэмжээтэй тэнцүү байдаг»⁵ гэсэн санаа бас байдгийг дурдаж болно. Түүнчлэн нүүдэлчдийн газарзүйн байрлал тэдний нийгэм-төрийн байгуулалд шууд нөлөөлдөг гэж П.Б. Голден үзжээ. Нүүдэлчид «...Баруун Евроазид төр засаггүй байх нь хэвийн зүйл байсан» бол, «Төв Азид, ...нүүдэлчид баян, хүчирхэг Хятадын эзэнт гүрэнтэй нүүр тулан оршихын тулд өөрсдийн төр улсыг байгуулахаас өөр аргагүй байдалд хүрдэг байсан» гэж тэрээр бичжээ. Өөрөөр хэлбэл, тал нутгийн төр улсын үүсэл нүүдэлчдийн зүгээс Хятадтай хийсэн харилцааны үр дүнгээр тодорхойлогддог⁶ байсан ажээ. Ер нь Хятад олон мянган жилийн түүхтэй хүчирхэг том улс болохын хувьд Зүүн Их тал нутгийн нүүдэлчид нүүдлийн агуу их гүрнүүдийг ээлж дараалан байгуулахад голлох нөлөөтэй эсрэг хүчний үүргийг гүйцэтгэсэн байж болох талтай билээ.

Ийнхүү олонх судлаачид нүүдлийн улс гүрнүүд улс төр, эдийн засаг, батлан хамгаалах шалтгааны улмаас үүсдэг байсныг хөнджээ. Гэхдээ дээрх нөхцөл шалтгаанууд нь тус тусдаа биш, харин хоорондоо уялдаа холбоотой, нэгдмэл байдлаар нүүдэлчдийн нэгдсэн

¹ Лашук Л.П. О характере классообразования в обществах ранних кочевников //Л.П. Лашук //Вопросы истории. — 1967. — №7. — С. 105-121.

² Марков Г.Е. Некоторые проблемы общественной организации кочевников Азии /Г.Е. Марков //Советская Этнография. — 1970. — №6. — С. 74-89.

³ Крадин Н.Н. Империя Чингис-Хана /Н.Н. Крадин, Т.Д. Скрынникова. — Москва, 2006. — 557 с.

⁴ Гумилёв Л.Н. Ритмы Евразии /Л.Н. Гумилев. - Москва, 2007. — 528 с.

⁵ Крадин Н.Н. Империя Чингис-Хана /Н.Н. Крадин, Т.Д. Скрынникова. — Москва, 2006. — 557 сё

⁶ Голден П.Б. Государство и государственность у хазар: власть хазарских каганов /П.Б. Голден //Феномен восточного деспотизма. — Москва, 1993. — С. 211-233.

улс байгуулагдахад нөлөөлсөн нь ойлгомжтой. Улс төр нь эдийн засагтаа суурилахад аюулгүй байдлыг гарцаагүй шаарддаг. Тодруулан дурдахад, монголын нүүдэлчид эдийн засгийн хэрэгцээгээ хангах зорилгоор хүчирхэг гүрэн байгуулж Дундад Ази, Дорнод Европыг байлдан дагуулсан гэвэл бодитой дүгнэлт биш болно. Мөн хүчирхэг Хятадын нөлөө нүүдлийн гүрнүүд байгуулагдахад голлох үүрэгтэй байсан тухай санаа ч итгэл төрүүлэхээр зүйл биш юм. Баримтаас үзвэл Хятад нүүдэлчид рүү довтлох нь ховор харин хамгаалах нь элбэг байсан (энд Хятадын цагаан хэрмийг барьсан шалтгааныг дурдаж болно). Тиймээс нүүдлийн эзэнт гүрэн байгуулагдах, нүүдэлчдийн эзлэн түрэмгийлэх дайн явуулах үндсэн шалтгаан өөр зүйлд байх ёстой. Үүнийг нүүдэлчдийн өөрсдийнх нь амьдралын нөхцөл байдлаас эрж хайх шаардлагатай юм.

Дүгнэн үзвэл (нүүдэлчдийн нийгмийн мөн чанарыг тооцон), нүүдэлчдэд газар нутгийн ашиг сонирхол гэж байхгүй. Тэдэнд зөвхөн бэлчээрийн газар нутаг л хэрэгтэй. Тийм газар тал нутгаас өөр хаана ч бараг байхгүй. Мөн нүүдэлчдэд далайд гарах гарц хэрэггүй. Тэдэнд хот суурин ч бас шаардлагагүй. Тэд хотын суурин амьдралыг үзэн яддаг. Өмч, баялаг тэдний сонирхлыг гойд татахгүй. Нүүдэлчид дэлхийн талыг алтны төлөө туулаагүй нь ойлгомжтой. Эдгээрийг тооцон үзвэл, нүүдлийн эзэнт гүрэн үүсэн бий болох гол шалтгаан нь байгаль, үзэл санаа хоёр юм. Өөрөөр хэлбэл, нүүдлийн мал аж ахуй эрхлэхэд нэн тохиромжтой Зүүн Их Тал нутгийн байгаль, цаг уурын онцлог нөхцөл байдал (Л.Н. Гумилёв), нүүдэлчдийн нэгдэн нийлэх хүсэл, мөн “үзэл санаа” гурав - нүүдлийн эзэнт гүрнүүд байгуулагдах үндсэн шалтгаан нь болжээ. Энд сүүлд дурдсан *үзэл санаа* нь нүүдлийн улс гүрэн үүсэн байгуулагдах, нүүдэлчдийн аян дайн явагдахад голлон нөлөөлсөн шалтгаан юм. Энэхүү *үзэл санаа* нь нүүдэлчдийн амьдралын нөхцөлөөс, өөрөөр хэлбэл нүүдэлчдийн нэгэн хэвийн “дайнч” амьдралын дүр төрхөөс урган гардаг. Тодруулж хэлбэл, дайн энхийн санааг төрүүлдэг. Нүүдлийн овог аймгуудын дотоодод явагддаг байнгын дайн самуун, дээрэм тонуул нь нэгдэн нийлэх санаа буюу “энхийн төлөө дайн хийх” санааг төрүүлжээ. Цаашлаад нүүдэлчдийн нэгдэн нийлэх үйл явц амжилттай өрнөсөн үед дээрх *үзэл санаа* “даян дэлхийд энх тайвныг тогтоох” зорилгыг агуулах болж, нүүдэлчид “мөнх хөх тэнгэрийн ивээлээр” дэлхий дахиныг нэгэн тугийн дор эзлэх *үзэл санаа* болон өргөжжээ. Уг *үзэл санаа* монголын их хаан Гүюгийн Ромын Папад бичсэн захидалд тодорхой тусгалаа олсон байдаг. Тухайлбал, энэхүү захидалд: «Дээд хөхрөгчдийн дээр зөвхөн мөнх хөх тэнгэр, дунд нь бэдрэгчдийн дунд зөвхөн эрх чөлөөт, тэнгэр ивээлт Чингис оршдог хэмээсэн мөнх хөх тэнгэрийн зарлиг буй. Энэ зарлигийг хүний сонсгол, хүлгийн туурай хүрэх газар бүрд дагаж мөрдсүгэй. ...Мөнх тэнгэрийн ивээлээр наран мандахаас наран жаргах хүртэл бүх дэлхий нэгдэн нийлэх үед бидний зорилго биелнэ»¹ гэжээ. Түүнчлэн Ж.Ж. Саундерс монголын нүүдэлчид нүгэлд живж буй хүн төрөлхтнийг гэсгээн цээрлүүлэх, амар амгаланд хүргэх зорилготой мөнх бусын ертөнцийг цэвэрлэх зэвсэг болж, бурхны ивээлээр үнэний төлөө хүрэлцэн ирсэн² болохыг дурдсан байдаг. Ийнхүү амьдралын шаардлагаар *үзэл санаа* хамгийн эхний байранд тавигдаж, монголын нүүдэлчид энхийн зорилгоор даян дэлхийг нэгтгэх аян дайныг өрнүүлж, энэ үйл хэрэг нь тодорхой хэмжээнд бодитойгоор хэрэгжсэн юм.

Нөгөөтээгүүр, монголын нүүдэлчдийн аян дайн амжилттай явагдахад монгол зэвсгийн гайхамшиг шийдвэрлэх үүрэг гүйцэтгэжээ. Монгол зэвсгийн сүр хүчээр нүүдэлчдийн морин цэрэг бараг тулалдаан бүрд ялалт байгуулсан билээ. Нүүдэлчин монголчууд хар бага наснаасаа эмээлдээ бат бөх сууж, нум сумаар мэргэн харваж сурсан төрөлхийн дайчид байсан. Байгалийн догшин ширүүн уур амьсгал тэднийг хатуужуулж, өлсгөлөн, хүйтнийг тэд тэсвэртэй даван туулж, байгалиас өгөгдсөн зүйлд ариг гамтай ханддаг байжээ. Монгол цэрэг жилийн аль ч улиралд, ямар ч хүнд хэцүү нөхцөлд байлдахад бэлэн байсан. Мөн тэдний суут удирдагч Чингис хаан, түүний цэргийн жанжид дайн

¹ Үнэн (Правда). — Улан-Батор, 2002. — № 199 (19642).

² Саундерс Ж.Ж. Монголын байлдан дагуулал (Монгольское завоевание). — Улан-Батор, 1992. — 328 с.

байлдааныг бүхэлд нь удирдах гайхалтай чадварыг эзэмшсэн байсан юм. Энэ бүхэн монголчуудыг ялагдашгүй болгосон¹ билээ.

Ингэж Монголын нүүдэлчид Евроазийн өндөрлөгт Монголын эзэнт гүрнийг байгуулж, өөрсдийн уламжлалт төрт ёсыг дэлгэрүүлж, дайн самуунтай байсан олон улс орныг нэгэн тугийн дор нэгтгэн даян дэлхийд энх тайвныг тогтоох бодлогыг хэрэгжүүлсэн. Энэ бодлогын үр дүнд тодорхой хугацаанд дэлхий дахинд дайн самуун зогсож, худалдаа арилжаа, үйлдвэрлэл цэцэглэн хөгжиж, өрнө, дорно дахин ойртож эхэлсэн билээ. Товчхондоо монголчуудын байлдан дагуулал, түүний үр дагавар нь аж үйлдвэржсэн нийгэм үүсэн бий болох үндсэн нөхцөлийг бүрдүүлэхэд чухал түлхэц болжээ.

НОМ ЗҮЙ

1. Владимирцов Б.Я. Общественный строй монголов. — Ленинград, 1934. — 223 с.
2. Голден П.Б. Государство и государственность у хазар: власть хазарских каганов //Феномен восточного деспотизма. — Москва, 1993. — С. 211-233.
3. Гумилев Л.Н. Ритмы Евразии. Москва. 2007. 528с.
4. Жаргалсайхан Ж. Монголын нүүдэлчдийн нийгэм: мөн чанар, онцлог. УБ. 2024. 298 х.
5. Крадин Н.Н., Скрынникова Т.Д. Империя Чингис-хана. Москва. 2006. 557с.
6. Лашук Л.П. Историческая структура социальных организмов средневековых кочевников //Советская Этнография. — 1967. — №4. — С. 25-40.
7. Лашук Л.П. О характере классообразования в обществах ранних кочевников //Вопросы истории. — 1967. — №7. — С. 105-121.
8. Ленин В.И. ППС. — 5 изд. / — Т. 1. — Москва, 1979. — 662 с.
9. Марков Г.Е. Некоторые проблемы общественной организации кочевников Азии //Советская Этнография. — 1970. — №6. — С. 74-89.
10. Маркс К. Хронологические выписки «Архив Маркса и Энгельса» — Москва, 1938. —Т. 5. — 424 с.
11. Саундерс Ж.Ж. Монголын байлдан дагуулал (Монгольское завоевание). — Улан-Батор, 1992. — 328 с.
12. Үнэн сонин. — Улан-Батор, 2002. — № 199 (19642).

¹ Жаргалсайхан Ж. Монголын нүүдэлчдийн нийгэм: мөн чанар, онцлог. УБ. 2024. 298 х.

ДАЙН БА ЭНХИЙН ТАЛААРХ ОРЧИН ҮЕИЙН ЗАРИМ АСУУДАЛД

Т.ДОРЖДАГВА

Философийн ухааны
доктор /Ph.D/, профессор

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) нь олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхийг дэмжиж, улс хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготойгоор тусгаар тогтносон улсуудыг сайн дурын үндсэн дээр нэгтгэсэн өндөр нэр хүндтэй байгууллага гэдэгтэй та бүхэн бүрэн дүүрэн санал нэгдэнэ хэмээн найдаж байна. Нэгдсэн үндэстний байгууллага анх 1945 оны 10 дугаар сарын 24-нд АНУ-ын Калифорни муж улсын Сан Франциско хотноо 51 улсын оролцоотойгоор байгуулагдсан бөгөөд эдүгээ 2024 оны байдлаар 193 орныг эгнээндээ нэгтгээд байна. Нэгдсэн Үндэстний Байгууллага байгуулагдсан цагаасаа эхлэн өнөөг хүртэл дэлхийн улс орнуудын санал, санаачлагыг хүлээн авч, өргөн цар хүрээнд үр нөлөөтэй үйл ажиллагаа явуулж, олон нийтийн дэмжлэгийг авч ирлээ.

Дэлхийн энх тайвны өдрийг жил бүрийн 9 дүгээр сарын гурав дахь долоо хоногийн мягмар гаригт тэмдэглэн өнгөрүүлж байх тухай шийдвэрийг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1981 онд баталсан ба харин хорин жилийн дараа энэ өдрийг жил бүрийн 9 дүгээр сарын 21-нд тэмдэглэж байхаар шийдвэрлэсэн байна¹. НҮБ-ын Ерөнхий ассамблей энэ өдрийг хүчирхийллээс татгалзаж, даян дэлхийд дайны галыг хориглон зогсоох өдөр болгон тунхагласан нь дэлхийн бүх улс орон, ард түмний дунд энхийн тухай үнэлэмжийг бэхжүүлэх, дайны гамшиг ямар аймшигтай зүйл болохыг сануулж байгаад орших ба энэ бол нийт хүн төрөлхтөний амин чухал хэрэгцээ, бүх нийтээрээ хүсэн хүлээж байдаг ариун соёл юм. Энэхүү шийдвэрийг дэлхийн олон нийт нэн талархалтайгаар хүлээн авч ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлж ирснийг та бид олон нийтийн мэдээллийн хэрэгсэлүүдээс уншиж, олж үзсээр байгаа билээ.

Зарим нэг зүйлийг энэ далимд мэдээлэл болгон сонирхуулахад: Японы хамтын ажиллагааны нийгэмлэг 1954 онд Нэгдсэн үндэстний байгууллагад “Энх тайвны хонх”-ыг бэлэглэсэн байдаг. Уг хонхыг 1951 онд Парис хотод болсон Нэгдсэн Үндэстнүүдийн үндэсний холбоодын XIII Ерөнхий бага хуралд оролцсон 60 орноос бэлэглэсэн зоосоор цутгаж хийсэн ба түүний дээр “Даян дэлхийд энх тайван мандтугай” гэж бичсэн байжээ. Нью-Йорк хотноо байрладаг Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв дэх Япон цэцэрлэгт “Олон улсын энх тайвны өдөр”-ийг жил бүр тэмдэглэн өнгөрүүлэх үеэр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга бүх нийтэд хандан үг хэлж, дараа нь хонхыг цохиж сонордуулан нэг минутын анир чимээгүйг зарладаг байна. Харин энэ ёслолын төгсгөлд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн дарга үг хэлдэг гэх мэт ёс, заншил нэгэнт хэвшин тогтжээ.

Өнөөдөр та бидний хэлэлцэн буй энхийн тухай асуудал маань угтаа түүхэн тодорхой улбаатай асуудал байж ирсэн билээ. Тухайлбал, Германы сонгодог философич, соён гэгээрлийн эрин үеийн нэрт төлөөлөгч Иммануэль Кантын 1795 онд бичиж хэвлүүлсэн “Үүрдийн энх тайван” хэмээх бүтээлийг олон улсын харилцааны онолын үндсэн дэг сургуулиудын нэг болох либераль-идеализмын үзэл санаа бүхий анхдагч суурь бүтээл болсон гэж үздэг байна. Энэхүү бүтээл нь орчин цагийн олон улсын эрх зүйн гол эх сурвалж хэмээн зүй ёсоор тооцогддог ажээ. Түүний дэвшүүлсэн үүрдийн энх тайвны тухай үзэл санаа нь орчин үеийн олон улсын харилцаа, дипломат ажиллагаа хэлбэрээ олж оршин тогтоход томоохон нөлөө үзүүлсний зэрэгцээ дайны асуудлыг энхийн замаар, эв зүйгээр шийдвэрлэх арга замыг эрэлхийлж байсан философич, улс төрчдийн үзэл номлол бүрэлдэн бий болоход чухал ач холбогдолтой байж ирсэн гэж мэргэжлийн хүмүүс, судлаачид үздэг байна. Харин “Үүрдийн энх тайван”-ыг судлан, өнөөдрийн өрнөж буй үйл явдалд дүн шинжилгээ хийхдээ дийлэнх улсуудын гадаад бодлогын

¹ Энэ өдрийг (НҮБ-ын албан ёсны бусад хэлээр: орос. *Международный день мира*, англ. *International Day of Peace*, араб. *اليوم العالمي للسلام*, исп. *Día Internacional de la Paz*, кит. 国际和平日, фр. *Journée internationale de la paix*) жил бүрийн 9 дүгээр сарын 21-нд тэмдэглэж байхаар 2001 оны 9 дүгээр сарын 28-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 55 дугаар чуулганаар хэлэлцэн шийдвэрлэжээ. (Резолюция № A/RES/55/282)

шийдвэрт “үндсэрхэг үзэл” хүчтэй нөлөөлж буй нь тодорхой болж байна гэж судлаачид тэмдэглэсэн байна¹.

Энэ завсар нэг зүйлийг хөндөх ёстой болсондоо та бүхнээс түмэн уучлал хүсье. “Ертөнцийн тухай хүн төрөлхтөний ойлголт” (1891) хэмээх Р.Авенариусын бүтээлд энхийн тухай философи ойлголтыг феноменологийн хүрээнд боловсруулсан гэсэн мэдээлэл үзэгдэж байна. Феноменологийн хүрээнд туршлагын анхдагч хүрээг илэрхийлэх “Ертөнц” /орос хэлэнд “Мир”/ хэмээх философийн нэр томъёо Р.Авенариусын (1891) бүтээлд анх гарч ирсэн гэдэг. Харин Р.Авенариусын «Человеческое понятие о мире» (1891) хэмээх бүтээлийг “энхийн тухай асуудал” болгон орчуулсан зарим нөхөд маань андуу ойлгов уу, эсвэл миний бие төөрөлдөв үү гэдэгт мэргэн нөхөд маань туслана уу гэж байгаа юм аа. Эсвэл манайд орос хэлний “мир” гэдэг үгийг “ертөнц”, “дэлхий”, “энх тайван” гэхлэн орчуулан хэрэглэж байгаа нь асуудлыг төвөгтэй болгов уу?

Хожим нь “Бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, харилцан үл довтолох, бие биеийнхээ дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох, эрх тэгш, харилцан ашигтай, энх тайвнаар зэрэгцэн орших” гэсэн таван зарчим («панча шила»)-ыг одоогоос 70 жилийн өмнө Хятадын анхны Ерөнхий сайд Жоу Энълай, Энэтхэгийн Ерөнхий сайд Ж.Неру нар Бандуны бага хурлын үеэр санаачлан дэвшүүлж, Ази, Африкийн 29 орны удирдагчид хүлээн зөвшөөрч, дэмжсэн байдаг². Эдгээр зарчим нь дэлхийн олон улс орнуудад хүлээн зөвшөөрөгдөж, олон улсын харилцааны хэм хэмжээ, олон улсын харилцааны эрх зүйн үндсэн зарчим болж ирсэн талаар судлаачид, мэргэжлийн хүмүүс бүтээлдээ тэмдэглэсээр иржээ.

Даян дэлхийн энх тайвны сэдэвтэй холбоотой мэдээлэл, судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлүүд ч манайд цөөнгүй гарч байгаад нэн талархалтай байна³. **Харин дайны тухай асуудал нь манай философи судалгааны хүрээнд** төдийлөн идэвхитэй ярьж, бичигдэж байгаагүй сэдвийн нэг бөгөөд зохиогчид, илтгэгчид энэ үзэгдэлд хандахдаа ихэвчлэн ёс суртахууны үнэлгээнээс хэтэрдэггүй байжээ гэсэн шүүмжит санаа ч үзэгдэх нь бий⁴. Хувьд үүнийг үнэний хувьтай байж магадгүй гэж үзэхийн зэрэгцээ манай өмнөх нийгмийн үеийн төрийн байгууллага, салбаруудын ажлын уялдаа холбоо сул хийгээд тухайн үеийн ажлын арга барил, зохион байгуулалт, үзэл суртлын араншинтай нь холбоотой байсан юм болов уу хэмээн бодож байна.

Харин эдгээр сэтгэл зүй, нийгмийн чухал асуудлуудыг илүү гүнзгий ойлгох боломжтой бөгөөд энх тайвныг цогцлоон бүрэлдүүлэх арга замуудыг сайтар судлан эзэмшиж, энэхүү буянтай үйлсэд гар, бие оролцох бололцоо та бидэнд нээлттэй байгаа юм. Асуудлын гол нь философи сургаалиуд орчин үеийн зөрчилдөөнүүдийн учир шалтгааныг нягтлан үзээд тэдгээрийг шийдвэрлэхэд туслаж, энх тайвны замыг хайж олоход тустай байхад орших юм. Иргэд, олон нийт дайн, энхийн тухай философи сургаалийг шамдан суралцсанаар нүүрлэн буй асуудлыг шийдвэрлэхэд иргэн бүр чармайлт гаргах ёстой гэж хэлмээр байна. Үнэхээр асуудал иргэд бидэнд тулж ирээд байна шүү дээ... “Яаж?” гэж асууж магадгүй, тэгвэл мэргэжлийн хүмүүсийн үнэлгээ, дүгнэлтээс заримыг нь энд толилуулья. Тухайлбал: 1. “Улс орны бүх төрлийн хүч хэрэгслийг ашиглан холимог аргаар дайтах болсон:⁵ энд ялангуяа мэдээллийн болон эдийн засгийн дайнд ердийн иргэд, хүн ам бүхэлдээ өртөгдөж, тэдгээрээс хэрхэн ангижирах аргаа бүрэн ухаарахгүй, ерөнхий хямралд нэрвэгдсээр байна. 2. Дайны сонгодог утга байхгүй болсон:⁶ Сонгодог утгаар бол дайны зорилго нь улс орон, хүн ам, газар нутгаа бусдын

¹ П.Мягмардорж. Иммануэл Кантын "Үүрдийн энх тайван" ба олон улсын харилцаан дахь идеалист үзэл санааны сорилт

² <https://info.wikireading.ru/98332>

³ Тухайлбал: П.Мягмардорж Дэлхийн дэг журмын өөрчлөлт ба Макиавеллийн улс төрийн реализм, Б.Алтанхүү. Дайн ба энхийн хил улам бүдгэрч гэх мэт

⁵ <https://info.wikireading.ru/9833>

⁵ Эдүгээ цагт дайн нь өрнөдийн номлолоор DIME (diplomatic, information, military, economic) буюу улс орны дипломат, мэдээлэл, цэрэг, эдийн засгийн гэх мэт хүч, нөөцийг уялдуулан ашиглах болсон.

⁶ Сонгодог утгаар бол дайны зорилго нь улс орон, хүн ам, газар нутгаа бусдын түрэмгийллээс зэвсгийн хүчээр хамгаалах эсвэл өөрийн хүслийг хүчирхийллийн аргаар тулган хүлээлгэх ажиллагаа гэж 1800-аад оны эхээр Пруссийн генерал, дайны онолч Карл Вон Клаусвич "Дайны тухай" гэдэг ажилдаа бичиж үлдээсэн ажээ.

түрэмгийллээс зэвсгийн хүчээр хамгаалах, эсвэл өөрийн хүслийг хүчирхийллийн аргаар тулган хүлээлгэх ажиллагаа байдаг. Тэгвэл эдүгээ үед хуучны үе шиг буу, сэлэм агсахгүй ч гэсэн дайны сонгодог утгаар бус буюу “чимээгүй” дайн аль нэгэн хэлбэрээр явж байна гэх нь бий. 3. Эдийн засгийн хувьд ашиггүй дайнд оролцох сонирхолгүй болсон: гэдэг нь өнөө үеийн дайны нэг түгээмэл онцлог ажээ. Хүйтэн дайнаар олз хайх хомхой сэтгэл бол хэнийг ч үл ойшоож, юуг ч үл хайрлаж, хүн төрөлхтөний бүтээсэн соёлын үнэт их өвийг нураан устгах, байгалийн баялагийн нөөцийг цөмлөн хуурайлах балаг гамшигтай үзэгдэл юм. 4. Уламжлалт дайныхаас өөр орчинд дайсангалцах болсон гэдэг нь:¹ аль нэг уул, голын урд, ард гэсэн байгалийн орон зай байхаа больж, эрдэнэт хүн хаана л байна, тэнд, өөрөөр хэлбэл бидний эргэн тойронд үл мэдэгдэм хэлбэрээр дайн ба энхийн хил улам бүдгэрч байгаа өнөө үеийн бодит байдлын талаар олон улсын харилцааны болон цэргийн мэргэжлийн стратегичид онцлон тэмдэглэж байгаа тухай судлаачид, сэтгүүлчид өөрсдийн өгүүлэлдээ маш тодорхой тэмдэглэн нийтэлсээр байна.

Иймээс манай иргэд, ялангуяа залуу үеийнхэн дайн хийгээд амар амгалангийн тухай түүх-философийн онол, сургаалийг нухацтай судлаж, хүн төрөлхтөний өмнө нүүрлээд байгаа өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ өгч, зөрчил мөргөлдөөний ёс зүйн хийгээд нийгмийн асуудлууд, тэрчлэн энх тайвнаар зэрэгцэн орших тухай асуудлын мөн чанар, учир шалтгааныг гүнзгий ойлгож авах талаар идэвхи чармайлт гаргаж, асуудалд илүү ухаалаг хандаж байхыг сургамжлах саналтай байна. Эл асуудлыг эс тоовоос, эргээд харахад тэр өөрөө ирчихсэн байж мэдэх юм шүү! Энд асуудлыг шийдвэрлэх нэг гол гогцоо нь философи мэдлэгийг нухацтай эзэмшсэнээр орчин үеийн зөрчил, мөргөлдөөний асуудалд илүү ойроос хандаж, энх тайванд хүрэх замыг хайж олоход туслах явдал юм.

Дүгнэлт: 1. Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын үүсэн буй болсон зорилго, үйл ажиллагаа явуулж ирсэн түүх, баримтаас нь харахад хүн төрөлхтөний түүхэн дэх хамгийн буянтай, хүмүүнлэг энэрэнгүй байгууллага гэж тодорхойлоход ч чамлагдана гэж үзэхээр юм. 2. Ийм тэнгэрлэг үйлстэй байгууллага үүсэн буй болоход Германы сонгодог философич, соён гэгээрлийн эрин үеийн нэрт төлөөлөгч Иммануэль Кант, түүний 1795 онд бичиж хэвлүүлсэн “Үүрдийн энх тайван” хэмээх бүтээл тэргүүлэх ач холбогдолтой гэж үзүүштэй юм. 3. Энх тайван үүрд мөнх байх тухай хүсэл мөрөөдөл бол хүн төрөлхтөний хамгийн амин тулгуур хүсэл мөрөөдөл мөн тул хүн төрлхтөн түүнийг бүх нийтээрээ нандигнан хамгаалах ёстой үнэлэмжийн нэг мөн гэж үзүүштэй байна. 4. Үүрдийн энх тайвныг баталгаатай бэхжүүлэхийн тулд олон улсын харилцааны эрх зүйн орчинд дорвитой шинэчлэл хийх, улс орон бүр иргэдийн, ялангуяа өсвөр үеийнхэний дунд үр нөлөөтэй сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааг өндөр түвшинд зохион явуулах талаар дорвитой ахиц гаргах нь чухал байна.

АШИГЛАСАН БҮТЭЭЛ

1. Б.Алтанхүү. Дайн ба энхийн хил улам бүдгэрч. "Эх орны манаа" сонин, 2022.02.10
2. Т.Дорждагва. Ёс суртахууны зарим тулгамдсан асуудал // Монгол дахь ёс суртахууны боловсролын тулгамдсан асуудал УБ.: 2015
3. Т.Дорждагва. Соёл судлал. Сурах бичиг. УБ.: 2010.
4. П.Мягмардорж. Иммануэл Кантын "Үүрдийн энх тайван" ба олон улсын харилцаан дахь идеалист үзэл санааны сорилт
5. Д.Цахилгаан: Энх тайван, найрамдлын төлөө ажиллах нь сэтгэл ухамсарын үйлс
6. <https://info.wikireading.ru/98332>

¹ Өнөөдөр дайн зүгээр л хүмүүс бидний ердийн амьдралын хүрээлэлд орогнож байна гэж хэлмээр болсон байна.

ТҮҮХЭН ҮНЭН ЦЭРГИЙН СОНИН ЭНХИЙГ САХИУЛАХ ҮЙЛСИЙГ ЭХЛҮҮЛЖЭЭ

Г.БААТАРНУМ

*МЗЭ-ийн шагналт, зохиолч,
цэргийн сэтгүүлч, дэд хурандаа*

Нэг. Оршил болгох нь 21 дүгээр зуун айлчлан ирсэн 2000-аад оны эхээр Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид Олон улсын Энхийг сахиулах ажиллагаанд оролцож, өнөөдөр дэлхий дахинаа нэр алдраа дуурсгасан Зэвсэгт хүчин болсныг хэн эс мэдэх билээ. Энэ үйлсэд хүрэх зам мөрийг тэгшилж өгсөн хэвлэл нь тухайн үеийн “Улаан-Од”, “Тусгаар тогтнол”, өнөөдрийн “Соёмбо” сонин байсан гэдгийг хэлэх ёстой. Эдгээр сонинуудад анхлан ямар сэдэв хөндөгдөж, ярьж, бичиж байсныг Батлан хамгаалахын төв архивт хадгалагдаж буй тус сонины шарласан хуудаснаас түүвэрлэн авснаа хуваалцьюу. Түүхэн ямар зам мөрийг туулан байж, Монголын Зэвсэгт хүчин өнөөдрийн өндөрлөгт хүрэв ээ гэдэг нь эндээс бага ч атугай харагдах биз ээ! Хоёр. Өрнөн өгүүлэх нь Өнөөдөр шиг мэдээллийн хэрэгсэл хүчтэй хөгжөөгүй тэртээх он жилүүдэд Монгол Улсад гарч байсан өдөр тутмын цөөхөн хэдэн сонин, түүний дотор “Улаан-Од”, өнөөгийн “Соёмбо” сонин зөвхөн цэрэг арми, Зэвсэгт хүчин гэж хязгаарлагдахгүйгээр мэдээллийг өргөн хэмжээнд түгээж байжээ. Телевизийн ганцхан сувагтай, радиогийн ганцхан долгионтой байсан тэр цагт сонин хэвлэлийн мэдээлэл нь юунаас ч илүү үнэтэй байсан нь ойлгомжтой билээ. Мэдээлсэн мэдээлэл нь өнөөдрийнх шиг хар, шардаа хүрсэн бус, чухамдаа чин үнэнийг өгүүлсэн бодит мэдээлэл байсан нь ямар нэг төөрөгдөлд орох үндэс байхгүй байжээ. Тэр л он жилүүдэд “Улаан-Од”, “Тусгаар тогтнол” сонин улс, нийгмийн чанартай олон арван асуудлыг хөндөн тавьж байсны нэг нь тус сонины сурвалжлагч Ц.Баяраагийн бичсэн “НҮБ-ын Монгол цэрэг” асуудал дэвшүүлсэн өгүүлэл юм. Эдүгээгээс 23 жилийн тэртээ өнөөдрийн Энхийг сахиулах ажиллагааг зөгнөн, “Тусгаар тогтнол” сонины 1992 оны 02 дугаар сарын №04 дугаарт нийтлүүлсэн тэрхүү өгүүлэлд ... “Дэлхийн улс орнууд өөрсдийн тусгаар тогтнолоо баталгаажуулахын тулд ашигладаг олон арга хэрэгсэл байдаг. Тэр бүрийн дотроос манайд урьд өмнө ашиглагдаагүй нэгэн арга буюу НҮБ-ын Энх тайвныг дэмжин сахиулах хүчинд өөрийн цэрэгтэй болохыг хэлж ядаж буй нь энэ. Тэнд бид их цэрэг байлгаж дөнгөх ч үгүй. Үгүй дээ л гэхэд мотобуудлагын нэг рот, дээд тал нь батальон байхад хангалттай. Зардал мөнгийг НҮБ гэж нүсэр байгууллага даачихах байх л даа. Өргөж тэтгүүлэх гэсэн юм биш ээ. Бусдыг нь ч даадаг байх. Дэлхийн бусад орнууд юм уу, Аюулгүйн зөвлөл манайхыг НҮБ-ын энх тайвныг дэмжин сахиулах хүчинд цэргээ оруулья гэхэд нэг их саад тотгор тавиад байхгүй л болов уу!” гэжээ. Тэр бээр цааш нь НҮБ-ын энх тайвныг дэмжин сахиулах хүчний цэрэг байх нь ямар ашигтай байх тухайд хөндөхдөө “Хувь хүний тухайд, Монголчуудад хамгийн их дутагддаг газар үзэж, оюун бодлоо тэлж, нүд тайлна. Доллараар цалинжчихна. Дээрээс нь улсаас харж үзэх нь баараггүй. Финландад НҮБ-д алба хааж буй дайчиддаа Өрнөдийн хамгийн сүүлийн үеийн машиныг хөнгөлөлттэй үнээр олгодог юм байна. Эцэст нь хэлэхэд ёстой жинхэнэ хөлсний цэрэг болно доо!!! Хөлсний гэдэг үгнээс нэг их цэрвэх хэрэггүй. Хөлсний цэрэг боолын нийгэм үүссэн цагаас л бий болсон. Цаашдаа ч байх биз. Бид нэгэнт дэлхий нийтийн цэргийн хөгжлийн жишгийг дагаж, мэргэжлийн армийн суурийг тавьж байна. Мэргэжлийн армид хөлсний цэргийн үр хөврөл заавал байдаг. Мэргэжил болгон мэргэшиж байгаа үед бид хүссэн, хүсээгүй энэ зам дээр гарч ирж л таарна” гэжээ. Энэ нь өнөөдрийн “Тэрээт цэрэг”-ийг ийнхүү төсөөлөн бичиж байсан бололтой. Мөн өгүүлэлд өнөөгийн цэрэг арми, Зэвсэгт хүчний тухай өгүүлэхдээ “Манай цэргийн хөгжил дэлхий нийтийн цэргийн хөгжилтэй хүйгээрээ холбогдоно. Одоо унаад буй армийн нэр хүнд олон улсын болон олон нийтийн дунд суга өсч, цэргийн албанаас “Ум хумгүй” зугатаж байгаа тэдгээр залуус эргээд хошуурцгаах болно. Вьетнамын дайны дараа Америкийн армийн нэр хүнд газарт унаж, гарах газаргүй мэт болжээ. Энэ үед Америк цэргээ НҮБ-ын цэнхэр дуулгатны далбаан дор олноор нь аваачиж зогсоосон нь их хэрэг болсон билээ. Тэд нэр хүндээ яаж аварснаас бидэнд авах ч юм бий, хаях ч юм бий” гэж бичжээ. Харин улс орны хувьд, НҮБ-д цэргээ илгээснээр ямар ашиг авчрах тухайд “Тусгаар тогтнолоо

баталгаажуулна. Монгол Улс гадаад бодлогын талаар бие даах болсныг дэлхий дахинд юу юунаас илүү харуулна. Түүнчлэн бүс нутгуудын хурц асуудлыг шийдвэрлэхэд урьд урьдаас илүү идэвхтэй оролцоно. НҮБ-ын энх тайвныг дэмжин сахиулах хүчинд монгол оржээ гэж бодоход хамгийн түрүүнд санаанд тусч буй ашиг энэ. Бодох тутам энэ ашиг тал тал тийшээ газар авах янзтай. Тэгэхээр ингэсгээд цэглэхийе” гэж бичиж байсан нь сэтгүүлч хүн нийгмээсээ нэг алхам түрүүлж явдаг гэдгийн бодит баталгаа болж байна. Монголын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид НҮБ-ын мандаттай Олон улсын Энхийг сахиулах ажиллагаанд хэрхэн яаж оролцож болохыг цэргийн сэтгүүлч Ц.Баяраа 20 гаруй жилийн өмнө ийнхүү нүдэнд харагдтал бичиж байсан нь өнөөдөр нэгэнт бодит биеллээ олсон нь цэргийн сонин, цэргийн сэтгүүлчдийн үнэлж баршгүй гавьяат үйлсийн нь нэгээхэн жишээ болон түүхэнд үлджээ. Ер нь сэтгүүлч хүнд ямар нэг санаа авахуулчихвал, тэр нь заавал бүтээл болдгийн жишээг сэтгүүлч Ц.Баяраа судлаач Р.Болдын мөн сонины №02 дугаарт бичсэн “Батлан хамгаалах стратеги” өгүүллээс сэдэвлэсэн тухайгаа өгүүлсэн байна. Дипломатч, судлаач Р.Болдын тэрхүү өгүүлэлд “...Монголын цэргийн алба хаагчдыг НҮБ-ын зардлаар энх тайвныг сахиулах хүчний бүрэлдэхүүнд цөөн тоогоор ч болов оролцуулах санааг гадаадын зарим судлаач цухуйлгаж байсан нь судалбал зохих сэдэв мэт” гэсэн ганцхан өгүүлбэр л байна. Энэхүү ганц өгүүлбэр сэтгүүлчийн авьяасаар гал болон дүрэлзэж, хорин жилийн дараа Монголын Зэвсэгт хүчнийг Энхийг сахиулах үйлсэд даллан дуудсан түүхэн бичиглэл болсныг өнөөдөр хүлээн зөвшөөрөхгүй хэн байх билээ. Тэгвэл мөн оны “Тусгаар тогтнол” сонины 03 дугаар сарын №06 дугаарт Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал Ш.Жадамба “...Дэлхийн хөгжлийн хандлага, Монгол Улсыг хүрээлсэн цэрэг-улс төрийн орчны болон улс орны дотоодын гүнзгий өөрчлөлтүүд үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалалтын асуудалд туйлын өргөн хүрээтэй, цоо шинээр хандахад хүргэж байна. Энэ нь хуучны бүгдийг устган, бүхнийг цоо шинээр хийх туйлшрал бус, харин сэтгэлгээний хүлээс, загварчиллаас түргэн ангижирч, шинийг мэдрэх, энэ үндсэн дээр ирээдүйгээ урьдчилан төсөөлж, өргөн зайд холч харах төрийн уян хатан бодлого явуулна гэсэн үгээ” хэмээн “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, Батлан хамгаалах зарим асуудал” өгүүллэд дурьдсан нь Энхийг сахиулах ажиллагааны салхи сэвээр орж ирэх анхны хөрс суурийг тавьж байжээ гэж үзэж болохоор байна. Гурав. Төгсгөн өгүүлэх нь Зэвсэгт хүчний “Соёмбо” сонины 1999 оны №21 дугаарт “Онол, практикийн суурь асуудлуудыг хөндлөө” гэсэн илтгэлүүд нийтлэгджээ. БХЯ-ны СУТГ-ын орлогч дарга, ЦШУ-ны доктор, хурандаа Б.Отгон-Уулын илтгэлд “...Цэргийн гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх талаар шинэ шинэ алхмууд хийгдэж байна. Түүнчлэн НҮБ-ын Энхийг сахиулах хүчний үйл ажиллагаанд оролцох нь Зэвсэгт хүчний гүйцэтгэх нэг үүрэг гэдгийг “Төрийн цэргийн бодлогын үндэс” баримт бичигт тодорхой заасан юм. Энэ чиглэлээр сүүлийн үед нэлээд алхмууд хийгдэж байна...” гэсэн бол ҮАБЗ-ийн нарийн бичгийн дарга Р.Болд “Зөвхөн цэргийн шинжлэх ухааны хүрээнд шийдэхгүй” илтгэлдээ “...Энхийг сахиулах хүчний ажиллагаанд оролцох талаарх судалгааны ажил чухал ач холбогдолтой. Энэ ажиллагаанд манай төрөл мэргэжлийн бүх цэргээс төлөөлөл оролцох ёстой. Хилийн цэрэг Энхийг сахиулах хүчний үйл ажиллагаанд оролцож болно. Бусад орны гүйцэтгэж буй ийм чиг үүргээс харахад дүрвэгсэдтэй ажиллах зэрэг хил хамгаалалтын зарим арга тактик нь хилчдийн ажил үүрэгтэй нэлээд ойролцоо юм. Энэ талаар Ерөнхийлөгчөөс чиг үүрэг өгөгдсөн. Ноднин Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн саналын дагуу Төв Азийн орнуудын Энхийг сахиулах батальонд тодорхой хэмжээгээр орж, хичээл сургуульд оролцох талаар санал тавьж, анх удаа ажиглагчаа оролцуулсан. Төв Азийн орнуудын Батлан хамгаалах салбарын төлөөлөгчид уулзаад Монголыг ажиглагчаар оролцуулъя гэдэг дээр албан ёсны байр сууриа илэрхийлчихсэн байгаа. Ирэх жил Казахстанд болох Төв Азийн орнуудын энхийг сахиулах хүчний үйл ажиллагаанд салаа хэртэй хүч оролцуулахаар ярилцаж байна. Үүнд Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн төлөөлөгчид оролцох ёстой болов уу. Энэ бүгд тодорхой судалгааны ажил болж ЦИС-ийн төлөвлөгөөнд тусгагдан, практик арга хэмжээ нь өдийд өрнөж байх ёстой...” гэсэн асуудлыг дэвшүүлсэн байна. Үүнээс харахад судлаач Р.Болд Монголын Зэвсэгт хүчний цэрэг дайчдыг Энхийг сахиулах үйл хэрэгт оролцуулахын төлөө үнэнхүү сэтгэлээс чармайж байсан нь тодорхой харагдаж байна. Үүний нь баталгаа болгож, энэхүү өгүүллийг бичигчийн Р.Болд дипломатчтай хийсэн “Соёмбо” сонины 2012 оны 05 дугаар сарын №20, 21 дугаарт “Ч.Пүрэвдорж генерал маань “Дахин надаар ийм юм битгий хийлгээрэй” гэж

билээ” гэсэн ярилцлагаас иш татъя. “1980-1990-ээд оны заагт дэлхий дахиныг өөрчилсөн үйл явдлууд шил шилээ даран бий болсон билээ. Цөмийн дайнд ялагч байхгүй гэдгийг сөргөлдөгч талууд харилцан хүлээн зөвшөөрснөөр хүйтэн дайн зогссон. Ингээд сөргөлдөж байсан нийгэм, улс төр нэг тогтолцоонд шилжих үедээ орсон. Энэ шилжилт араасаа улс хоорондын, үндэстэн хоорондын, бүс нутаг, орон нутгийн чанартай олон дайн, зэвсэгт мөргөлдөөн, үймээнийг дагуулж байсан. Энэ үед НҮБ-ын үүрэг дэлхий даяар өсөн нэмэгдэж ирсэн. Ингээд “Дэлхийн улс орнууд, дэлхийд шинэ дэг журам тогтоох ёстой юм байна” гэсэн бодлого, саналыг дэвшүүлэн тавьж байсныг олон хүн санаж байгаа байх. Энэ нөхцөл байдал нь Монгол Улсын гадаад, дотоод нөхцөл байдалд ихээхэн нөлөөлсөн. Энэ нөлөөллийн нэг нь Монгол Улсад арми байх уу, үгүй юу, ер нь Монгол Улс өөрийнхөө аюулгүй байдлыг НҮБ-ын цэргээр хамгаалуулах ёстой юм биш үү зэрэг олон ургальч бодлын хүрээнд хүмүүс үзэл бодлоо уралдуулж эхэлсэн л дээ. Тухайн үед Монгол Улсын гадаад нөхцөл байдал эрс өөрчлөгдсөн. Мөн дотоод нөхцөл байдал ч гэсэн үүнтэй адил эрс өөрчлөгдсөн. Ийнхүү үзэл бодлоо уралдуулах хүрээнд Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид НҮБ-ын ЭСА-нд яагаад оролцож болдоггүй юм бэ? гэсэн бодол санал олноороо гарч ирсэн. Тухайлбал, миний санаж буйгаар 1992 онд тухайн үеийн “Улаан-Од” сонин “Тусгаар тогтнол” нэртэй болсон. Тус сонины сурвалжлагч Ц.Баяраа. Л.Зоригт нар “Монголын цэргийн алба хаагч НҮБ-ын цэнхэр дуулгатны эгнээнд орж болох уу?” гэсэн асуудал дэвшүүлсэн өгүүллийг анх нийтлүүлж байсныг санаж байна. Яг үүнтэй залгуулаад НҮБ-д сууж байсан Монгол Улсын төлөөлөгч Л.Эрдэнэчулуун гуай “НҮБ-ын ЭСА-нд Монгол цэргийн алба хаагч оролцох ёстой” гэсэн мэдэгдлийг мөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хийж байсан. Тухайн үед БХЯ-ны дэргэд ажиллаж байсан Стратегийн судалгааны хүрээлэнд зөвлөх судлаачаар ажиллаж байсан ЗХЖШ-ын дарга агсан, дэслэгч генерал Ч.Пүрэвдорж гуай болоод миний бие, манай хүрээлэнгийн дэд захирал, Монгол Улсын Ерөнхий сайдаар ажиллаж байсан С.Баяр бид хэд сууж байгаад санал бодлоо солилцож байлаа. “Ер нь энэ асуудлыг судалгааны түвшинд авч хөндөж яривал яасан юм бэ?” гэсэн асуудал байсан. Ингээд Ч.Пүрэвдорж генералаас, энэ асуудлыг судлаж, БХЯ-ны удирдлагад судалгааныхаа дүнг танилцуулахыг хүссэн юм. Ч.Пүрэвдорж гуай маань ЭСА-нд Монголын цэргийн алба хаагчдыг оролцуулах асуудлаар судалгаа хийгээд дуусгасан л даа. Энэ судалгаан дээрээ үндэслээд 1994 онд “Стратеги судлал” сэтгүүлд “ЭСА-ны шинэ эрин ба Монголын оролцоо” гэсэн өгүүлэл нийтлүүлсэн юм. Ч.Пүрэвдорж генерал БХЯ-нд судалгааныхаа дүнг танилцуулж ирчихээд С.Баяр дарга бид хоёрт “Ахиж надаар ийм юм битгий хийлгээрэй. Энэ хүмүүс ойлгохгүй юм байна” гээд нэлээд гомдонгуйгаар нулимсаа дуслуулж байсан нь одоо ч нүдэнд харагдсаар байдаг юм. Тухайн үеийн нөхцөл байдал тийм л байсан. 1990-ээд оны сүүлчээр ҮАБЗ-ийн аюулгүй байдлын нарийн бичгийн даргаар ажиллаж байхдаа өмнө нь хийсэн судалгаагаа ажил хэрэг болговол яасан юм бэ гэсэн бодол саналаа тухайн үеийн Ерөнхийлөгч Н.Багабанди гуайд танилцуулсан юм. Ийнхүү 1998 онд шиг санагдаж байна. БХЯ, ЗХЖШ-т ЭСА-г хариуцсан нэгж, тасаг байгуулах чиглэл өгсөн. Үүний дагуу ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Ц.Дашзэвэг ЗХЖШ-ын бүрэлдэхүүнд анхны чиглэл хариуцсан нэгж, тасгийг байгуулсан. Чиглэл хариуцсан анхны офицероор эдүгээгийн бригадын генерал Д.Баярсайханыг ажиллаж байсныг санаж байна. Улмаар энэ чиглэлийн ахлагчаар хошууч генерал Г.Рагчаа томилогдож ажилласан. Түүнчлэн 1999 онд АНУ-ын Флорида мужид болсон ЭСА-ны сургалтад анхны гурван офицерыг явуулах чиглэл өгөгдөж байлаа. Ингээд бага зэрэг туршлага хуримтлуулсны дараа 2000 онд Казахстанд болсон “Центр Азбат” нэртэй Олон улсын хээрийн сургуульд манай анхны салаа цэрэг оролцож байсан юм. Энэ бүхний эцэст дэслэгч генерал Ц.Дашзэвэг гуай “Ер нь эрх зүйн үндсийг бүрдүүлэх, энэ үндсэн дээр цааш явах ёстой юм байна” гэсэн саналыг гаргасан. Ингэж л “Цэрэг, цагдаагийн алба хаагчийг ЭСА-нд оролцуулах тухай” хуулийн төслийг боловсруулах ажлыг ахалж ажиллаад УИХ-д Засгийн газраар дамжуулан өргөн барьсан юм. Ер нь үйл явцыг урагшлуулахад тухайн үеийн Ерөнхий сайдаар ажиллаж байсан Н.Энхбаяр тууштай дэмжиж, зоригтой алхмуудыг хийж байсан. Чухамдаа Монгол Улсын Ерөнхийлөгч, ЗХЕК Н.Багабанди, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр нар уг саналыг хүчтэй дэмжсэний үндсэн дээр Монголын цэргийн алба хаагчдыг ЭСА-нд гадагш явуулах нь зүйтэй гэж үзэж, 2002 онд ЭСА-ны анхны ажиглагчид Африкийн Конго Улсыг зорьж байсан юм даа” гэсэн түүхэн баримтыг энд дурдахаас аргагүй. Ингээд ГХЯ-ны БТЗГ-ын дарга, Түүхийн шинжлэх ухааны доктор

Ц.Батбаярын тавьсан нэгэн илтгэлд Энхийг сахиулах үйл ажиллагааны талаар чамлахааргүй дурдсаныг хураангуйлан өгүүлье. Тухайлбал, НҮБ-тай Энхийг сахиулах үйл ажиллагааны талаар байгуулах санамж бичгийн төслийг ойрын үед Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлэнэ. Ингэснээр энэ оны 09 дүгээр сард НҮБ-ын чуулганы үеэр уг санамж бичгийг байгуулах боломжтой болов уу! гэж бодож байна. Үүний үр дүнд бид НҮБ-ын регистрт орох боломжтой болно. Энэхүү регистрт орсноор НҮБ-ын Энхийг сахиулах үйл ажиллагаанд тухайн үед хүнээ оролцуулах эсэхийг өөрсдөө шийдэх бөгөөд гаргаж чадах хүн хүч, цэргийн ажиглагч, эмнэлгийн ажилчдын тоог өгч, байнгын бүртгэлд байх бололцоотой болно. Санамж бичгийг байгуулсны дараа Энхийг сахиулах хүчний үйл ажиллагаанд оролцох явцад тохиолдож болох гэнэтийн осол эндэгдлийн талаар хоёр талаас хүлээх хариуцлагын тухай баримт бичиг үйлддэг. Цаашдаа Энхийг сахиулах чиглэлээр зохион байгуулагдаж буй сургалт семинарт оролцох ажлыг нэлээд цэгцтэй болгох хэрэгтэй байна. Хүнээ сайтар сонгон явуулахаас гадна нэгэнт сургалт семинарт оролцоод ирсэн хүмүүсээ уг суралцсан зүйлд нь ойролцоо чиглэлээр ажиллуулах шаардлагатай юм...” гэсэн санааг дэвшүүлж байжээ. Энд нэг зүйлийг тодруулахад тусгай нэгж гэдэг нь ЗХЖШ-ын ЭДАХ-ийг хэлж байна. Анхны энэ нэгжийг удирдаж байсан хүн нь “Энхийг сахиулагчдын загалмайлсан эцэг” хэмээн хүндлэгдсэн Г.Рагчаа генерал байсныг дурьд юу!

ЭВ НЭГДЭЛ: НИЙГМИЙН ГОО САЙХНЫ ЗАРИМ АСУУДАЛ

П.МЯГМАРСАЙХАН

ШВА-ийн Философийн хүрээлэн

Товч утга: Энэхүү өгүүлэлд нийгмийн гоо сайхан гэдэг ойлголтыг эв нэгдэл, шударга ёс, эрх тэгш байдал, хамтын үнэ цэнэ дээр тулгуурлан авч үзсэн. Эв нэгдэл нь зөвхөн улс төр, эдийн засгийн асуудал бус, нийгмийн ёс суртахууны үнэт зүйл бөгөөд философийн түүхэнд Аристотель, Платон, Руссо, Милль, Күнз зэрэг сэтгэгчид үүнийг хүний хамтын амьдрал, шударга ёс, сайн чанар, нийтлэг сайн сайхантай холбон тайлбарлаж ирсэн байна. Монголын уламжлалд ч эв нэгдлийг эрхэмлэсэн ардын сургаал олон байдаг. Өнөөгийн Монголын нөхцөлд нийгмийн гоо сайхныг алдагдуулж буй гол хүчин зүйлс нь авлига ба шударга бус байдал, тэгш бус байдал ба ялгаварлал, итгэлцэл ба эв нэгдлийн алдагдал юм. Нийгмийн гоо сайхныг бүтээхийн тулд иргэн бүр хариуцлагатай, ёс суртахуунтай үйлдэл хийх, нийтлэг сайн сайхны төлөө хэрсүү ухаантай оролцох ёстойг онцолсон болно.

Түлхүүр үг: Эв нэгдэл, энх тайван, нийгмийн гоо сайхан, шударга ёс, эрх чөлөө, эрх тэгш байдал, авлига, тэгш бус байдал, ялгаварлал, итгэлцэл, хамтын зорилго, сайн чанар, иргэний оролцоо

Эв нэгдэл гэдэг нь хүмүүс хоорондын харилцаанд үүсдэг зохицол, харилцан ойлголцол, нийтлэг зорилгод суурилсан нийгмийн үнэт чанар юм. Энэ нь бүгд нэг санаа, нэг байр сууринд орж, нэг багт харьяалагдахаас гадна ялгаатай үзэл бодол, соёл, заншил, эрх ашгийг зохистойгоор уялдуулж чаддаг байхыг хэлнэ.

“Эв нэгдэл” (unity, harmony) ба энх тайван (peace) хоорондоо ойр дөт ойлголтууд боловч утга, хэрэглээний хувьд зарим ялгаатай талтай. Эв нэгдэл нь хүмүүс хоорондын харилцаанд бий болох зохицол, хамтын ойлголцол, ялгаатай үзэл бодол, соёл, эрх ашгийг зохистойгоор уялдуулах чадварыг илэрхийлдэг бол, энх тайван нь өргөн хүрээтэйгээр дайн мөргөлдөөнгүй оршихуй, шударга ёс, эрх тэгш байдал, хууль дээдлэх зарчим дээр тогтсон нийгмийн төлөв байдлыг илэрхийлдэг. Иймээс энх тайвны олон улсын өдөрт зориулж илтгэж буй энэхүү сэдэв маань хүн хоорондын эв нэгдэл, харилцан ойлголцол, хамтын зохицолд тулгуурласан нийгмийн сайн сайхан, өөрөөр хэлбэл нийгмийн гоо сайхныг эргэцүүлэхэд чиглэж байна.

Эв нэгдэл нь хүний нийгмийн мөн чанартай салшгүй холбоотой. Энэ нь зөвхөн улс төр, эдийн засгийн чухал хүчин зүйл бус, харин нийгмийн гоо сайхан, ёс суртахууны үнэт зүйл юм. Тэр ч утгаараа эрт үеэс л философичид эв нэгдлийн асуудлыг авч үзэж ирсэн байдаг.

Аристотель эв нэгдлийг төр, улсын зохион байгуулалтын үндэс, иргэдийн хамтын сайн сайхны зорилгод чиглэсэн харилцаа гэж үзээд Аристотель “Улс төр”, “Никомахийн ёс зүй” зэрэг бүтээлүүдэд сайн чанар (virtue) ба эв зохицолтой холбон авч үздэг. Аристотелийн сайн чанарын (virtue) тухай ойлголт нь түүний ёс зүйн онолын цөм бөгөөд тэрээр үүнийг “Никомахын ёс зүй” бүтээлдээ нарийвчлан тайлбарласан байдаг¹. Хүний амьдралын дээд зорилгыг eudaimonia (аз жаргал, сайн сайхан оршихуй, цэцэглэлт) гэж нэрлэсэн. Харин (eudaimonia)-г зөвхөн эд баялаг, таашаал, нэр хүндээр биш, харин сайн чанартай үйлдэл хийснээр олж авдаг гэж үзсэн. Мэдээж хүн бүр л сайн сайхан амьдралд тэмүүлж байдаг. Тэр амьдралыг бүтээх явцад үйлдэх үйл нь ямар байх нь чухал байдаг. Тэгэхээр Аристотель бол тэр үйлдлийг virtue буюу сайн чанар гээд үүнийгээ 2 ангилж үзсэн байна. 1. Ёс суртахууны сайн чанар (moral virtues) - зориг, шударга ёс, хатуужил, өгөөмөр сэтгэл гэх мэт. Эдгээр нь хүний хүсэл, мэдрэмжийг ухаанаар зохицуулах чадвараар бүрддэг. 2. Оюуны сайн чанар (intellectual virtues) – мэргэн ухаан (sophia), практик ухаан (phronēsis), урлаг/ур чадвар (technē) гэх мэт. Эдгээр нь хүний ухаан бодолд суурилдаг бөгөөд мэдлэг, зөв шийдвэр гаргах чадвартай холбоотой. Сайн чанар гэдэг нь хоёр туйлын хоорондох зөв зохицол хэмээн үзээд өөрийн алдарт “алтан дундаж”-ын сургаалаа хэлэлцүүлсэн байдаг. Сайн чанартай хүн болох нь төрөлхөөсөө заяагддаггүй, харин сургалт, дадал зуршилаар бий болдог. Бид “шударга үйлдэл хийснээр шударга, зоригтой үйлдэл хийснээр зоригтон

¹ Никомахын ёс зүй. УБ., 2007 /орч. Б.Даш-Ёндон/ 11-17 дох тал.

болдог” гэж тэр хэлсэн. Ер нь эцэст нь хүн зөвхөн өөрийн төдийгүй нийгмийн сайн сайхны төлөө сайн үйл хийснээр жинхэнэ аз жаргалд хүрнэ гэж үзсэн. Чингэхдээ мөн л хэмжээ зохисийн тухай дундаж үзлээ баримтлаж, сайн чанар бол хүний ухаан, хүсэл хоёрыг зөв зохицуулах чадвар үүний ачаар хүн аз жаргалтай, сайхан амьдралд хүрнэ гэж үзсэн. Нийгмийн хувьд ч мөн адил, хамтын сайн сайхныг зорьсон шударга, ариун журамт иргэдийн оршихуй л гоо сайхны илрэл болно.

Аристотель “Улс төр” бүтээлдээ хүнийг төрийн амьтан (zoön politikon) хэмээн тодорхойлж, хувь хүний оршихуй зөвхөн нийгмийн хүрээнд утга учиртай болохыг онцлон тэмдэглэсэн байна¹. Учир нь төр, хууль, иргэний оролцоо бүгд хамтын сайн сайхны төлөө чиглэж байж шударга ёс оршин тогтнож, нийгмээ бүрдүүлдэг бөгөөд зөвхөн хувь хүний төгөлдөршил бус, олонхын сэтгэлгээ, үнэт зүйл, үйл хөдлөлийн зохицлоор бүрэн төгөлдөр болно. Иймд гоо сайхан нийгмийн суурь нь эв нэгдэл бөгөөд хүмүүсийн харилцаанд бий болох итгэл, харилцан ойлголцол, нийтийн зорилгын төлөө нэгдсэн хүчин чармайлт нь нийгмийн гоо сайхныг дотоод талаас нь гэрэлтүүлж, хамтын оршихуйн утга учрыг бүрдүүлдэг. Эсрэгээрээ, эв нэгдэл алдагдаж, иргэдийн дунд үл ойлголцол, хуваагдал ноёлох аваас нийгмийн гоо сайхан алдагдаж, зөвхөн хууль дүрэм төдийгөөр нийгэм тогтох ч гүн утга, жинхэнэ үзэсгэлэнг алдахад хүрнэ. Тиймээс нийгмийн гоо сайхныг хадгалах, хөгжүүлэх хамгийн чухал нөхцөл бол иргэдийн эв нэгдэл бөгөөд энэ нь төр, хууль, иргэний оролцооны жинхэнэ гоо зүйн хэмжүүр болон хувирдаг. Иймээс Аристотелийн өнцгөөр авч үзвэл нийгмийн гоо сайхан гэдэг нь зөвхөн гадна дүр төрхийн эмх цэгц бус, харин ёс суртахууны чанарууд болох шударга ёс, ухаалаг байдал, зориг, хичээл зүтгэл зэрэг хамтын илэрхийлэл юм.

Платон “Төр” хэмээх алдарт бүтээлдээ нийгмийн шударга байдлын үзэл санааг гүнзгий авч үзсэн байдаг. Түүний хувьд эмх цэгц, дэг журам, хувь хүн бүр өөрийн чадвар, үүрэгт тохирсон байр сууриа эзэлж, зөв зохистой харилцаанд орших үед нийтлэг сайн сайхан бүрдэнэ гэж үзсэн. Энэ утгаар нь тэрээр эмх цэгцтэй нийгмийг хамгийн төгс хэлбэрийн тусгал, өөрөөр хэлбэл гоо сайхны дээд илэрхийлэл хэмээж, үүнийгээ сайн байдлын хэлбэртэй холбон тайлбарласан юм². Платоны онолд Сайн байдал бол бүх хэлбэрүүдийн дээд, бүх оршихуйн утга учир бөгөөд нийгмийн шударга бүтэц нь энэ Сайн байдлын хэлбэрийг өөртөө тусган илэрхийлэхүйцээр бүрэлдэх учиртай. Иймээс шударга ёс, гоо сайхан хоёрыг салангид бус, харин нэгэн бүхэл үнэт зүйл гэж үзсэн нь түүний философийн гол санааны нэг бөгөөд нийгмийн үзэсгэлэн нь зөвхөн гадна талын зохион байгуулалт бус, харин дотоод үнэн, сайн сайханд тулгуурласан төгс зохицол юм гэдгийг илэрхийлсэн байна.

Жан-Жак Руссо “Нийгмийн гэрээ” бүтээлдээ нийт иргэдийн хамтын хүсэл зориг (volonté générale)-оор илэрхийлэгдэх нийтлэг сайн сайхны төлөөх тэмүүлэл чухал болохыг онцолсон байдаг. Түүний үзлээр иргэн бүрийн эрх чөлөө, тэгш эрхийг хангаж чадсан нийгэмд л жинхэнэ эв нэгдэл бүрэлдэж, харин эрх ашиг давамгайлж, хэсэг бүлгийн ноёрхол, тэгш бус байдал үүсэх аваас нийгэм дотоод зохицол, эв нэгдлээ алдана гэсэн санааг илэрхийлдэг³. Иймээс Руссогийн үзэл санааг өнөөгийн нөхцөл байдалтай холбон үзэхэд нийгмийн гоо сайхны үндэс нь иргэн бүрийн идэвхтэй оролцоо, хамтын хүсэл зориг, нийтлэг сайн сайхны төлөө нэгдэн тэмүүлэх хүчин чармайлтад оршдог нь тодорхой байна.

Жон Стюарт Миллийн үзэл санаагаар хувь хүн өөрийн хүсэл, сонирхол, бүтээлч байдлаар чөлөөтэй орших үед хувь хүн төдийгүй нийгэм бүхэлдээ хөгжиж дэвшдэг. Тэрбээр хувь хүний эрх чөлөөг зөвхөн хувь хүний хувьд ач холбогдолтой гэж үзээгүй, харин бусдын эрхийг хөндөхгүйгээр хэрэгжих үед нийгмийн сайн сайхныг нэмэгдүүлдэг гэж тайлбарласан⁴. Ингэснээр эрх чөлөө, ухамсартай шийдвэр, нийтлэг сайн сайхныг салшгүй холбоотой гэж үзэж, нийгмийн зохион байгуулалт хувь хүний чөлөөт оролцоонд тулгуурлах үед илүү утга учиртай, шударга, гоо сайхан нийгмийг бүтээж чадна. Миллийн философи нь ингэснээр хувь хүн, эв нэгдэл, нийтлэг сайн сайхны харилцан хамаарлыг тодорхойлох чухал онолын суурь болж өгдөг.

¹ Аристотель. Улс төр. УБ., 2006. /орч. Б.Даш-Ёндон/ 12 дох тал.

² Plato: “The Republic”: “On the Concept of Justice”. - | [La Audacia de Aquiles](#) |

³ Жан Жак Руссо. Нийгмийн гэрээ ба улс төрийн эрхийн зарчмууд. УБ., 2015. 38-

⁴ Жон Стюарт Милль. Эрх чөлөөний тухай. УБ., 2021. 33-34 дэх тал.

Күнэ эв нэгдлийг “жинхэнэ зохицол” хэмээн нэрлэж, хүний ёс суртахуун, гэр бүлийн болон нийгмийн харилцаанд тулгуурлан ойлгосон.

Бид ч эвтэй байх, тайван амгалан байхыг чухалчилсан уламжлал соёлоор баялаг түүхтэй. “Цувж явсан барнаас цуглаж суусан шаазгай дээр”, “Эвт шаазгай буга барина”, “Нэг үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргино” “Эвлэвэл бүтнэ, ховловол гутна” гэх зэргээр амьдралын туршлага дээр суурилсан эв нэгдлийн ач холбогдлыг чухалчлан авч үзэж энэ нь зөвхөн гэр бүл, ахан дүүсийн хүрээнд бус, бүхэл нийгмийн тогтвортой оршихуйн үндэс болж байсан.

Эв нэгдэл нь үнэт зүйл, зорилго, хамтын хэлэлцээрээр илэрдэг. Хүмүүс нэг үнэт зүйл дээр тохиролцож, түүнийг дагаж хамтран амьдрах, бүтээх нь ч үүнд багтдаг. Тэр утгаараа бид 30 гаруй жилийн өмнө ардчилсан нийгмийн тогтолцоог сонгож, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгож тунхагласан. Үүгээрээ ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэдгээ хуульчилсан.

Тэгэхээр нийгмийн гоо сайхан нь нийгэмд мөрдөгдөж буй үнэт зүйл, эв нэгдэл, хамтын зорилгоор илэрхий болно. Эв нэгдэл нь нийгэмд даган баримтлах үнэт зүйлээ тохиролцож, хамтран амьдрахад оршдог. Энэ үнэт зүйлс нь зөвхөн хүний хувь хүний ухамсар, мэдрэмж дээр суурилахгүй, харин нийгмийн нийтлэг ойлголт, соёлын хүрээнд илэрч, хэрэгждэг.

Эндээс бидний нийгэм үнэхээр гоо сайхнаар оршин байна уу гэдэг асуулт гарч байна. Өнөөгийн нөхцөл байдлыг харахад бид шударга бусаар амьдарч буйгаа алхам тутамдаа мэдэрдэг. Манай нийгэм төрөөс төрсөн тэрбумтнууд гэдэг нэр томъёотой болсон. Төрийн нэрээр байгуулсан бүх сангууд хүрэх ёстой нийгмийн бүлэгтээ хүрч чадаагүй. Түүнчлэн төрийн нэр дээрх, тендер, нүүрсний хулгай, дээр дооргүй хуйвалдаан хулгай, албан тушаалтан эрх мэдэлтнүүд ах дүү хамаатан саднаараа цөлмөснийг нийгмээр мэднэ.

Манайд нийгмийн гоо сайхныг алдагдуулж байгаа гол гурван хүчин зүйлийг бид дараах байдлаар авч үзлээ.

Нэг. Шударга бус байдал, авилгал - Төр, нийгмийн институци шударга бусаар ажиллаж, эрх мэдэлтнүүд өөрсдийн ашиг сонирхлыг дээгүүр тавибал иргэдийн итгэл алдардаг. - Авлига нь баялаг, боломжийн тэгш хуваарилалтыг үгүй хийж, шударга ёсыг алдагдуулснаар нийгмийн гоо сайхан бүдгэрнэ. Авилгал нь нийгмийн гоо сайханд маш сөргөөр нөлөөлдөг бөгөөд үүнийг хэд хэдэн талаас тайлбарлаж болно: Ёс суртахуун ба үнэт зүйлсийг эвддэг байна. Авилгал нь шударга ёс, үнэнч байдал, итгэлцлийг үгүй хийдэг. Хүмүүсийн үзэл бодол, шийдвэр нь хувийн ашиг сонирхолд тулгуурлаж, нийгмийн нийтлэг сайн сайхныг үл тоомсорлодог болох үед нийгмийн гоо сайхан алдагдана. Нийгмийн тэгш бус байдлыг бий болгодог. Авилгатай орчинд эрх мэдэлтэй, хөрөнгөтэй хүмүүс илүү давуу байж, жирийн иргэдэд боломж хомсддог. Энэ нь нийгмийн бүтцэд шударга ёс, харилцан тэнцвэрт байдлыг алдагдуулж, нийгмийн эв нэгдлийг доройтуулдаг. Итгэлцлийг үгүй хийдэг. Хүмүүс засгийн газар, хууль, байгууллагууд, хамт олонд итгэх итгэлээ алддаг. Итгэлцэл нь нийгмийн харилцаа, хамтын ажиллагааны гол үндэс бөгөөд илтгэл алдархад нийгмийн эв нэгдэл доройтож, хүмүүс хувиа л хичээж эхэлдэг. Бүтээлч байдал, хөгжилд саад учруулдаг. Авилгал нь чадварлаг, шударга хүмүүсийн боломжийг хязгаарлаж, шийдвэр гаргах процесс, инноваци, хөгжлийг удаашруулдаг. Ингэснээр нийгмийн гоо сайхан буюу хөгжил, амар тайван амьдралын чанар буурна. Хүмүүнлэг чанар, ёс жудагт сөргөөр нөлөөлдөг. Авилгал нь хүмүүсийг ашиг сонирхол руу түлхэж, бусдад хүндэтгэл үзүүлэх, шударга ёсыг сахих зан чанарыг сулруулдаг. Ингэснээр нийгмийн хүмүүнлэг, ёс суртахуунд тулгуурласан гоо сайхан алдагдана. Авилгал нь нийгмийн бүтцэд худал, шударга бус, тэгш бус байдлыг бий болгож, иргэдийн итгэлцэл, ёс суртахуун, хамтын ажиллагааг сулруулж, улмаар нийгмийн гоо сайхныг бууруулдаг.

Хоёр. Тэгш бус байдал ба ялгаварал: Нийгмийн бүлгүүд хоорондын орлогын ялгаа, боловсрол, эрүүл мэндийн хүртээмж зөрүү ерөөсөө хэрээс хэтэрсэн. Энд зөвхөн хот хөдөөгийн ялгаа ч биш, улсынхаа нийслэл дотор, нэг дүүрэгт гэхэд л боловсролын хүртээмжийн ялгаа асар их болсон. Нийслэлчүүд удахгүй өвлийг утгана. Дарийн утаа үнэртсэн дайны талбараас өөрцгүй утаат хөндийдөө дахиад л олон олон шийдэл ярьсаар үйлдэл байхгүй орно. Бид өвлийн үзэсгэлэнг нийслэл хотоосоо харалгүй маш их удсан. Эмнэлэгийн коридороор дүүрэн, орчны

бохирдлоос үүдэлтэй өвдсөн хүүхдүүдийн өрөвдмөөр дүр зураг, халтирч бэртчихгүйг хичээн бээцэгнэн алхах иргэд, замын түгжрэл, хараал урсгасан иргэдийн уур хилэн...энэ бол нийгмийн гоо сайхны алдагдал мөнөөс мөн. Гэвч эрх мэдэлтнүүд нь хүүхдүүддээ улсынхаа сургуульд сургадаггүй. Өөрсдөө улсынхаа эмнэлэгээр үйлчүүлдэггүй. Өвлийн утаанаас гэр бүл, үр хүүхдээ холдуулж, халуун орны тансаг хаусандаа аваачдаг зэрэг яриа нь нийгмийн тэгш бус байдал, ялгаврлыг харуулж байдаг.

Гурав. Итгэлцэл ба эв нэгдлийн алдагдал: Иргэд хоорондын итгэл, хамтын зорилгын мэдрэмж сарниж, үл ойлголцол, үл итгэлцэл давамгайлбал нийгмийн дотоод зохицол алдагддаг. Эв нэгдэлгүй орчинд хүмүүсийн хамтын хүчин чармайлт сулрах бөгөөд энэ нь нийгмийн гоо сайхныг үгүй хийдэг. Эв нэгдэлгүй байдал, талцалын гол талбар нь өнөөдөр сошиал орчин болж байна. Энд бас иргэдийн дунд асар их төөрөгдлийг авч ирж, нэг асуудлыг өөр нэг сенсаацитай мэдээгээр дарах явдал нийгэмд нийтлэг болсон. Үүний үр дүнд хоёр талцаад иргэд нь маргалдаж, юунд итгэхээ мэдэхгүй тодорхойгүй байдалд орж байна. Үүнд улс төрийн албан тушаалтнууд ихээр оролцдог болсон нь илэрхий болсон. Иргэд маань хэрсүү байх, шүүн тунгаах чадвартай байх нь чухал болж байна. Нийгэм бүхэлдээ, иргэдийн сэтгэл хөдлөлөөр бус, шүүн тунгааж, ажиглах чадвартай байх нь нийгмийн итгэлцэл, эв нэгдэлд хэрэгтэй хүчин зүйл болж байна. Мэдээж энэ чадварыг төлөвшүүлэх хэрэгтэй. Үүнд боловсролын системд хэрэгжүүлэх арга нь Медиа болон мэдээлэл боловсруулах боловсрол чухал болжээ. Хүүхдүүдийг багаас нь мэдээллийн эх сурвалж ялгах, шүүмжлэлтэйгээр унших, мэдээ ба суртал ухуулгын ялгааг таних дадалд сургах. Шүүмжлэлт сэтгэлгээний хичээл, философийн хичээл оруулах энэ мэдээллийн зорилго юу вэ? эх сурвалж, баримтад тулгуурласан эсэх? гэх мэт асуулт тавьж сурах дадлыг сургалтын хөтөлбөрт оруулах; хариуцлагатай сэтгүүл зүйг ямагт дээдлэх, мэдээлэл тараахдаа “fact-checking” заавал хийдэг соёл төлөвшүүлэх; иргэдийн хувьд, мэдээлэлд хариу үйлдэл үзүүлэхээс өмнө бодох хугацаа өөртөө гаргах, мэдээллийг хэд хэдэн эх сурвалжаас шалгах, ялангуяа улс төрийн томоохон үйл явдлын үед. Сошиал орчинд соёлтой оролцохыг чухалчлах, шууд сэтгэгдэл бичихийн оронд эхлээд уншиж, хүлээцтэй хандах хэрэгтэй. Түүнчлэн нийгмийн орчинд тайван, тэвчээртэй зан чанарыг үнэлэх, уур омогтой, хэт хөөрч “хурдан хариу үйлдэл” хийдэг хүнийг биш, бодлогоороо, ухаанаар шийддэг хүнийг үлгэр дууриал болгох зэрэг нь чухал юм.

Ийнхүү Авлига, тэгш бус байдал, эв нэгдэл, итгэлцлийн хямрал гурав нийлээд нийгмийн гоо сайхныг алдагдуулдаг гол хүчин зүйлс болдог байна.

Дүгнэлт: Нийгмийн гоо сайхан нь зөвхөн гадаад орчны эмх цэгц бус, харин шударга ёс, эв нэгдэл, эрх тэгш байдал, хамтын үнэ цэнийн хэрэгжилтэд оршдог. Түүнийг алдагдуулж буй гол хүчин зүйлс бол авлига ба шударга бус байдал, тэгш бус байдал ба ялгаварлал, итгэлцэл ба эв нэгдлийн алдагдал юм. Иймээс нийгмийн гоо сайхныг хадгалах, хөгжүүлэхийн тулд иргэн бүр ёс суртахуунтай үйлдэл хийх, төр шударга тогтолцоог бий болгох, хамтын үнэ цэнэ, нийтлэг сайн сайхны төлөө эв нэгдэлтэйгээр оролцох шаардлагатай. Ингэж чадсан цагт бидний нийгэм дотоод төгөлдөр зохицолтой, жинхэнэ гоо сайхантайгаар оршин тогтноно.

ЭХ СУРВАЛЖ

1. Аристотель. Никомахын ёс зүй. /орч. Б.Даш-Ёндон/. УБ., 2007.
2. Аристотель. Улс төр. /орч. Б.Даш-Ёндон/. УБ., 2006.
3. Платон. Төр /орч. Д.Одонтуяа/ УБ., 2005
4. Жан Жак Руссо. Нийгмийн гэрээ ба улс төрийн эрхийн зарчмууд. /орч. Р.Янжмаа/ УБ., 2015
5. Жон Стюарт Милль. Эрх чөлөөний тухай. //орч.Н.Лхагважав/ УБ., 2021
6. [Plato: “The Republic”: “On the Concept of Justice”.- | La Audacia de Aquiles](#)

ЭНХ ТАЙВНААР ОРШИХУЙ БА БОЛОВСРОЛЫН ҮНЭТ ЗҮЙЛ

Ж.БЯМБАСҮРЭН

Философийн хүрээлэнгийн ЭШДЭА

Философийн ухааны магистр

Хураангуй: Энх тайван гэдэг нь зөвхөн дайн дажингүй, мөргөлдөөнгүй, хүчирхийлэлгүй байх тухай санааг илэрхийлэх төдийгүй шударга ёс, харилцан итгэлцэл, хүний эрхийг хүндэтгэх, эв найрамдал зэрэг утгыг багтаасан өргөн хүрээний ойлголт юм. Энх тайвнаар оршино гэдэг нь зөрчил тэмцэлгүй, чимээгүй, хүлцэнгүй орших бус харин хамтын үнэ цэнэ, харилцан ойлголцол дээр суурилсан идэвхтэй амьдралын хэв маяг юм.

Боловсрол нь энх тайвны үндэс мөн. Учир нь боловсрол хүн бүрт харилцан хүндэтгэл, ялгааг ойлгох, хүлээн зөвшөөрөх чадвар олгодог, хүний эрхийн мэдлэгийг түгээж шударга ёсыг тогтооход нөлөөлдөг, зөрчлөөр бус хамтын шийдвэрээр нэгдсэн шийдэлд хүрэх нь чухал гэдгийг ухааруулахад чиглэгдсэн олон оршино.

Нөгөөтэйгүүр иргэдийн боловсролын түвшин нь нийгмийн хөгжлийн чухал хэмжүүр төдийгүй харилцан бие биеэсээ шалтгаацдаг хамаарал бүхий ойлголтууд юм.

Түлхүүр үг: боловсролын зорилго, үнэт зүйл, хөгжил

Хүн төрөлхтний түүхэнд олон зууныг дамжин бүтээгдэж ирсэн оюуны соёлын өвийн нэг хэсэг нь боловсрол юм. Боловсрол нь нийгэм, соёлын үзэгдэл үү?, нийгмийн хөгжлийн түлхүүр үү? гэсэн асуултад хариулт олох явцдаа боловсролын мөн чанар, үүрэг, ач холбогдлыг тодруулах зорилгын үүднээс энэхүү илтгэлээ бичлээ. Дээрх асуулт бол боловсролын философи, социологи, антропологи болон хөгжлийн онолуудын төв асуулт бөгөөд олон олон эрдэмтэд янз бүрийн өнцгөөс тайлбарласан байдаг. Тухайлбал, боловсрол бол нийгэм-соёлын үзэгдэл мөн гэж үздэг эрдэмтэд үзэхдээ боловсролыг тухайн нийгэм, соёлын үнэт зүйл, уламжлал, хэл, түүхийн тусгал гэж тодорхойлдог. Жишээ нь боловсролын онолч П.Фрейре “боловсрол нь нийгмийн шударга бус байдлыг ухамсарлуулах, чөлөөлөх хэрэгсэл. Соёлын дарлал, дархлалын талаарх үзлүүд боловсролын соёлын шинж чанарыг онцолно” гэсэн бол Э.Дюркгейм “боловсрол нь нийгмийн үнэт зүйл, хэм хэмжээг шинэ үеийнхэнд дамжуулах тогтолцоо бөгөөд нийгмийн интеграци буюу нэгдмэл байдлыг хангадаг” гэжээ.

Боловсрол нь нийгмийн хөгжлийн түлхүүр хэмээх санааг дэмждэг сэтгэгчид боловсролыг эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжигч хүч, хувь хүнийг бүтээж, нийгмийг өөрчлөгч хүчин зүйл гэсэн санааг илэрхийлдэг. Жишээ нь хөгжлийн онолч Амартия Сен “боловсрол бол хөгжлийн чадавхийг нэмэгдүүлэгч хүчин зүйл бөгөөд хүмүүсийг өөрсдийн амьдралыг удирдах, сонголт хийх чадвартай болгодог” гэсэн бол Марта Нусбаум “боловсрол нь хүний эрх, ёс суртахууны ухамсрыг хөгжүүлдэг ба ардчилал, иргэний нийгмийн төлөвшилд шийдвэрлэх үүрэгтэй” гэсэн байна.

Юутай ч ардчилсан, нээлттэй нийгмийн зохион байгуулалттай барууны соёлын нөлөө их манай орны хувьд боловсролыг зөвхөн хөгжлийн түлхүүр эсвэл нийгэм-соёлын үзэгдэл гэж ялгаж үзэх нь хэт явцуу ойлголт болох юм. Орчин үед боловсрол нь нэг талаар соёлыг дамжуулж, нөгөө талаар нийгмийг шинээр бүтээгч хүч гэж үзэх хандлага хүчтэй болжээ.

Өнөөдөр эрдэмтэн судлаачид боловсролыг зөвхөн мэдлэг олгох үйл явц бус, харин тухайн нийгмийн хөгжил, соёл иргэншлийн чиг хандлагыг тодорхойлдог суурь хүчин зүйл хэмээн ойлгож байна. Боловсрол нь хувь хүний боломжийг тэлэх, эдийн засгийн өсөлтийг хангах, ардчилсан үнэт зүйлсийг төлөвшүүлэх, ядуурлыг бууруулах, энх тайвнаар зэрэгцэн орших арга зам, цаашлаад тогтвортой хөгжлийг дэмжих үндсэн хөшүүрэг гэж харж байна. Тиймээс боловсрол нь нийгмийн хөгжлийн түвшинг тодорхойлох чухал хэмжүүр мөн.

Сүүлийн үед дэлхий нийтээрээ хөгжлийн түвшинг зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмждэг хандлагаас зайлсхийх болсон. Үндэсний статистикийн хорооноос гаргасан “Хүний хөгжил 2020” товхимолд хүний хөгжлийн индексийг тодорхойлох үзүүлэлтэд дараах 3 хүчин зүйлийг нэрлэжээ. Үүнд¹: 1 дүгээрт, хүний амьдрах хугацааг тодорхойлох үзүүлэлт болох хүн

¹ Үндэсний статистикийн газар. Хүний хөгжил 2020. УБ., 2021, 9 дэх тал

амын дундаж наслалтын индекс; 2 дугаарт, бичиг үсэг тайлагдалтын байдал буюу боловсролын индекс; 3 дугаарт, нэг хүнд ногдох ДНБ буюу ҮНО-ын индекс орж байна. Эндээс боловсрол нь нийгмийн хөгжил, эдийн засгийн хөгжил, ёс суртахууны төлөвшилд нөлөө үзүүлэхүйц чухал хүчин зүйл болохыг харж болно.

Иймээс ямар нийгмийг хүсч байна вэ? гэдгээс ямар иргэнийг төлөвшүүлэх вэ? гэдэг асуудал урган гарах ба тийм иргэнийг төлөвшүүлнэ гэвэл боловсролын салбарын зөв, оновчтой бодлого, хүртээмжтэй үйл ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэнэ. Боловсрол нь нийгмийн хөгжлийн түвшинг тодорхойлох чухал хэмжүүр гэж үзвэл боловсролын зорилго, алсын хараа нь хэмжигдэхүйц, тодорхой томъёологдох ёстой. “...Боловсролын зорилгыг тодорхойлохдоо хувь хүний хэрэгцээ, сонирхол тухайн орны боловсролын уламжлал, боловсролын хөгжлийн чиг хандлага хийгээд тэргүүлэгч байдал, дэлхийн улс орнуудын туршлага, сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлалын үзэл баримтлал зэргээс гадна үнэт зүйлсэд тулгуурласан тодорхой хэв шинжийн бие хүнийг баримжаалсан нийгмийн захиалга, мөн хүмүүсийн байр суурийн төлөвшилд нөлөөлж буй олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, техник технологийн дэвшил, шийдлүүд зэрэг олон хүчин зүйлийн нөлөөг давхар тооцоолох шаардлага бий болно.”¹

Боловсролын ерөнхий хуулинд “Монгол Улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших, тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд оршино”² хэмээсэн бол сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд “Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэхэд оршино. Ерөнхий боловсролын зорилго нь суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино”³ гэжээ. Дээд боловсролын тухай хуульд “Дээд боловсролын зорилго нь нийгэм, эдийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх, бүтээлчээр ашиглах, олон соёлын орчинд ажиллаж, амьдрах чадвартай, ёс суртахуунтай иргэнийг бэлтгэхэд оршино” хэмээн тодорхойлжээ. Эдгээр хуулиудад тодорхойлсон зорилгуудаас үзэхэд монгол улсын боловсролын хамгийн гол зорилго нь ёс суртахуунтай иргэнийг бэлтгэхэд чиглэгдэж байгаа ба үүнд шат шатны боловсролын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрүүд, хүний нөөцийн бодлого, төлөвлөлт хамгийн чухал нөлөөтэй ба манай орны хувьд энэ асуудалд онцгой анхаарч жил тутамд сайжруулалт хийгдсээр байна.

Нийгмийн хэрэгцээ шаардлагаас хамаарч боловсролын хэлбэр, агуулга тодорхой хэмжээнд өөрчлөгддөг. Улс орны хөгжлөө хэрхэн тодорхойлж хөгжлийн зорилтуудаа яаж дэвшүүлснээс үүдээд ямар иргэнийг төлөвшүүлэн бэлтгэх вэ? гэдэг асуудал боловсролын зорилготой салшгүй холбогдоно. Өөрөөр хэлбэл боловсролын зорилгод улс орны эрх ашиг, тэргүүлэх чиглэл чухлаас гадна хувь хүний сонголт, сонирхол, зорилго тэмүүлэл тусгагдсан байх нь ардчилсан нийгмийн үнэт чанар билээ.

Боловсролын мөн чанар гэдэг нь түүнд заавал байх, үндэс суурийг нь бүрдүүлж байдаг мөнхийн чанар, зорилго, утга агуулга юм. Хүнийг хүн болгох үйл явц (хувь хүний оюун ухаан, сэтгэлгээ, ёс суртахуун, хандлагыг төлөвшүүлэх), мэдлэг чадвар, үнэт зүйл дамжуулах механизм (тухайн соёл, түүхийн үргэлжлэл), нийгэмших үйл явц (хувь хүнийг нийгмийн гишүүн болгох), өөрийгөө таних утга учрыг эрэх (боловсрол бол танин мэдэхүйн болон ёс суртахууны аялал) зэргээр боловсролын мөн чанар, агуулга тодорхойлогдоно. Тиймээс XXI зууны монголчуудад үндэстний адилслалыг товойлгон гаргах өв соёл, уламжлал, ёс суртахууны боловсрол гээд нийтлэг үнэт зүйлсээ хөгжүүлэх, хадгалж өвлүүлэх явдал чухал билээ. Үүнд боловсролын бодлого, сургалтын хөтөлбөр болон хүний нөөцийн чадавх чухал үүрэгтэй.

¹ Дам ишлэв. Т.Нэмэхжаргал, Б.Батзаяа. Боловсролын зорилго ба нийгмийн үнэт зүйлсийн хамаарал. Философи, эрх зүйн боловсрол. №12, УБ., 2019, 80 дахь тал

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759958962301>

³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759959012931>

Хөгжил хэмээх ойлголт энэхүү илтгэлд нилээдгүй дурдагдсаныг тухайлан авч үзэх нь зүйтэй болов уу? Хөгжлийн тухай асуудлаар манай эрдэмтдийн¹ бичсэн судалгааны бүтээлүүд нилээдгүй бий. Философийн нэвтэрхий тольд “Хөгжил нь байгаль хийгээд нийгэмд нэг чанар нэгэн төрх байдлаас нөгөөд хуучнаас шинэд шилжих лүгээ холбогдсон хөдөлгөөн, өөрчлөлтийн дээд хэв маяг”² гэж тодорхойлсон бол философийн шинжлэх ухааны доктор Б.Даш-Ёндон “Хөгжил гэдэг бол ерөнхийлж хэлбэл, юмс, үзэгдэл өөрөөсөө салаалан цэцэглэж, салаалсан нь бие даан төгөлдөржиж, улмаар эргээд нэгдмэл болгодог холбоонд орж найрсах үйл явц, найрссан төрх байдлыг заасан нэр томъёо юм”³ гэж өөрийн бүтээлдээ томъёолжээ. Тэгэхээр хөгжил хэмээхүй нь боловсролын мөн чанар, зорилготой салшгүй холбоотой ойлголт ажээ.

Монголчуудын “Эвтэй байхдаа хүчтэй” хэмээх хэлц үг нь хамтын оршихуйн мөн чанарыг илэрхийлж буй бие, сэтгэл, оюун санааны нэгдмэл байдлыг илэрхийлсэн чухал нэгэн ойлголт юм. Боловсролын мөн чанар нь мэдлэг, чадвар эзэмшүүлэхээс гадна хамтдаа амьдрах, нийгэмд зөв харилцах, бусдыг хүндэтгэх үнэт зүйлсээр төлөвшүүлэхэд оршино. Бие биенээ хүндэтгэн ойлголцож, эв эеийг сахих нь боловсролын үндсэн зарчим болно. Эвтэй байх нь зөвхөн ахуйн түвшинд бус боловсролын салбарын зорилго, алсын хараанд ч чухал байр суурь эзлэх юм. Тэгэхээр боловсролын мөн чанар болох хамтын ажиллагаанд суурилсан хөгжил, боловсролын зорилго болох нийгмийн эв нэгдлийг бэхжүүлэх иргэнийг төлөвшүүлэх үйлстэй монголчуудын энх тайвныг сахин хамгаалах, бэхжүүлэх гэсэн сургаалууд шууд нийцэж байна.

Дүгнэлт

- ✓ Энх тайвнаар оршихуй нь боловсролоос эхлэлтэй бөгөөд боловсрол нь зөвхөн мэдлэг бүтээх, дамжуулах үйл ажиллагаа бус энх тайвны үнэт зүйлтэй иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэнэ.
- ✓ Монголын боловсролын бодлого, сургалтын хөтөлбөрт энх тайвны боловсролыг системтэй шингээх нь XXI зууны хөгжлийн гол суурь болно.

НОМ ЗҮЙ

1. Sen A. Development as freedom. New York., 2000
2. Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус). УБ., 2017
3. Н.Бэгз. Боловсролын хөгжлийн онол арга зүйн асуудлууд. УБ., 2008
4. Боловсролын хүрээлэн. Боловсролын философи. УБ., 2012
5. МУБИС. Боловсролын философи-арга зүйн асуудал. УБ., 2019
6. Философийн хүрээлэн. Философийн нэвтэрхий толь. УБ., 2022
7. Б.Даш-Ёндон. Хөгжихүйн философи. УБ., 2019

¹ Академич Г.Чулуунбаатар, Академич Ч.Ган-Өлзий, Философийн шинжлэх ухааны доктор (Sc.D) Д.Дашпүрэв, Философийн шинжлэх ухааны доктор (Sc.D) Б.Даш-Ёндон, Философийн шинжлэх ухааны доктор (Sc.D) Ц.Гомбосүрэн, Философийн ухааны доктор (Ph.D) Ж.Энхбаяр нарыг дурдаж болно.

² Философийн хүрээлэн. Философийн нэвтэрхий толь. УБ., 2022, 1343 дахь тал

³ Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус). УБ., 2017, 13 дахь тал

“СЭТГЭЛИЙН АМАР АМГАЛАНГААС МӨНХИЙН ЭНХ ТАЙВАН РУУ”

О.БОЛОР-ЭРДЭНЭ

ЭШДЭА, магистр

ШУА-ийн Философийн хүрээлэн

Эрхэм нөхөд өө!

Өнөөдөр бидний хэлэлцэх сэдэв бол хүн төрлөхтний хамгийн аугаа хүсэл мөрөөдөл - энх тайван юм. Энх тайван гэдэг үг бидэнд дотно сонсогддог ч түүний жинхэнэ мөн чанар хаанаас эхэлдэг вэ?

Нэгэнт ийм асуулт нухацтай сөхөгдөж байгаа учраас юунд түрүүнд энэ асуулт: “энх тайван тогтоох ажиллагаа” нэрийн дор өөрийн геополитикийн нөлөөг тэлдэг “Улс төрийн ашиг сонирхол”, энх тайвныг хамгаалах нэрийдлээр стратегийн байр сууриа бэхжүүлдэг “Үзэл суртлын зэвсэг”, энх тайвны уриалдаг ч өөрсдийн үнэт зүйлсийг бусдад тулган хүлээлгэдэг “Бүлэглэлийн арга хэрэгсэл” болгох ёсгүй гэдгийг санах хэрэгтэй.

Тиймээс уг асуултыг марталгүй хадгалах, шинээр тавих, амьд хариултыг бүтээх нь эхний алхам юм.

Бид эрт үеэс энх тайвныг мөрөөдсөөр ирсэн. Хүн төрлөхтний оюуны наран гийсэн үеэс үүнд бодол ухаанаа чилээж, бүх цаг үеийн сэтгэгчид үүнээс тайтгарлыг эрж ирсэн юм. Эртний Энэтхэгийн мэргэдээс эхлээд Грекийн философичид, Буддагаас эхлээд Кант, Шопенгауэр хүртэл-бүгд л энх амгалангийн сургаалыг өөрийнхөөрөө айлдсныг санацгаая! Энэ нь энх тайван бол зөвхөн түүхийн нэг үеийн хүсэл мөрөөдөл бус, харин хүн төрлөхтний мөнхийн эрэл гэдгийг гэрчилж байна.

Та-бид нар ч өнөөдөр, энэ тухай хэлэлцэхээр цуглажээ. Яагаад? Энэ бүхэн хангалттай биш гэж үү?

-Тийм ээ, хангалттай биш. Учир нь энх тайван бол зөвхөн ухаантнуудын мөрөөдөл төдий биш, харин бидний өдөр тутмын амьдралын амьсгал, ирээдүйн оршихуйн үндэс байх учиртай. Хэрэв бид өнөөдөр түүнд хүрэх алхмаа хийж чадахгүй бол маргаашийн гэрэлт ирээдүй зөвхөн төсөөлөл болон үлдэх болно.

Харин эсрэгээрээ, “Энх тайванд дайсагнагч” байсан ба байсаар ирсэн. Өчигдрөөс өнөөдрийг хүртэл, өнөөдрөөс магадгүй маргаашийг чиглэн түүний сүүдэр холдохгүй... Хүн төрөлхтний түүхийн хуудсуудыг сөхвөл, дайсан нь үргэлж өөр өөр дүрээр гарч иржээ: заримдаа цэрэг зэвсгийн дайн болж, заримдаа колоничлол, заримдаа үзэл суртлын хуваагдал, заримдаа терроризм, эдийн засгийн мөлжлөгийн хэлбэрээр. Хэлбэр нь өөрчлөгдөвч мөн чанар нь нэг - тэр бол энх амгалангийн эсрэг чиглэсэн хүч.

Эртний дайнудаас эхлээд дэлхийн хоёрдугаар дайн, хүйтэн дайны хуваагдал, өнөө цагийн терроризм хүртэл -энх тайванд дайсагнагч хүчин түүхийн туршид хэлбэрээ сольсон ч мөн чанартаа хэвээр байсаар ирснийг түүх гэрчилж байна.

Энэ нь хүн төрөлхтнөн түүхээсээ сургамж авч чадаагүйг, дахин дахин алдаагаа давтаж байгааг бидний дөжирсөн чихэнд сануулж байна. Артур Шопенгауэрийн хэлсэнчлэн, “өнгөрсөн үеийн алдаа, зовлонгоос сургамж авч чаддаг байсан бол өнөөдөр бид түүхийн өөр зам мөрөөр алхах байсан. Гэвч хүний хүсэл шунал үүнийг үл зөвшөөрдөг” ажээ.

Гэвч, бид “үнэний сүр хүчин дор” ингэж асуух ёстой: энэ бүхний учрыг олох боломжгүй гэж үү? Дайн самуун, түүхийн замбараагүй үймээний цаана ямар “логик” оршиж байна вэ? Хэрэв өчүүхэн ч гэсэн энх тайвны гэгээ, хүний сэтгэлийн амар амгалангийн оч байгаагүйсэн бол хүн төрөлхтөн өдгөө хүртэл оршиж чадах байсан уу? Магадгүй зовлон дунд төрсөн энэ өчүүхэн гэгээ л биднийг хүн болгож, ирээдүйн энх тайвныг мөрөөдөх эрх өгдөг биз ээ.

Гадаад ертөнцөд долигсон шуурсан ч, толгой хорогдохоор заяасан газар бидэнд бий. Түр азнаж, ертөнцийн үймээн самуунаас ангид, “эрх чөлөөний бяцхан арал” болох дотоод ертөнц рүүгээ өндийе. Энд бид бодол мэдрэмжээ ажиглан, зовлон гомдлынхоо учрыг ойлгож, сэтгэлийнхээ гүнд орших энх тайвныг бэдрэнэ. Учир нь дотоод сэтгэл нь энх тайвны эх булаг, бүх асуултын голыг олох чиг шугам. Энэ бяцхан арал дээр бид гадны үймээнээс ангид тайван байх замыг олж, ирээдүйн амар амгалан, энх тайвныг мөрөөдөх эрхээ бататгана.

Энх тайвны дайсан бидний гадна талд байна гэж боддог. Бид дайн, шударга бус тогтолцоо, туйлширсан үзэл сурталд бурууг өгөх дуртай. Үнэндээ бол тэдгээрийн үндэс нь хүний сэтгэлийн гүнд нуугдан байдгийг бүх цаг үеийн сэтгэгчид нэгэн дуугаар хүлээн зөвшөөрдөг билээ.

Энх тайвныг бүтээхийн тулд бид “prima facie” сэтгэлээ шинжилж, сэтгэл доторх “дайсан” - тайгаа нүүр тулан номхотгоход суралцах ёстой.

Тиймээс энэхүү илтгэлд сэтгэлийн амар амгалангийн асуудлыг хөндөх гэсэн юм. Оршил хэсгээ үүгээр өндөрлөж, судалгааны гол чиглэл рүү орцгооё. Үүний тулд дараах хэдэн асуултыг тавья.

- Энх тайван гэж хэлэхдээ бид зөвхөн дайнгүй байхыг төсөөлөөд байна уу, аль эсвэл нийгмийн шударга ёс, хүн төрөлхтний эв нэгдлийг хамтад нь ойлгож чадаж байна уу?
- Хэрэв хүн бүр сэтгэлийн амар амгаланг олоогүй бол дэлхийн энх тайван тогтоно гэж итгэж болох уу?
- Энх тайван нь бодит зорилго юу, аль эсвэл хэзээ ч хүрч болохгүй хийсвэр мөрөөдөл үү?
- Бид үнэхээр “энх тайван” –ы гоц үзэгдлийг өөрийнхөөр нь мэдэрч чадаж байна уу, аль эсвэл зөвхөн улс төрийн уриа лоозон байдлаар сонсож байна уу?

Эдгээр асуултуудын гол зангилаа нь “сэтгэл”-ийг танин мэдэхүйд оршиж байна. Энх тайван, амар амгалан, шударга ёс, эв нэгдлийн тухай ойлголт бүгд гаднын үзэгдлээс эхлэлтэй мэт санагддаг ч үнэндээ бидний дотоод ухамсар, сэтгэлийн амар амгалан дээр тулгуурладаг билээ. Сэтгэлээ танин мэдснээр дотоод амгаланг олох үүд нээгдэх төдийгүй, бусдын сэтгэл хөдлөл хийгээд үйл хөдлөлийг ойлгож, энхийн харилцааг бий болгох үндэс тавигдана. Эдгээр асуултууд нь гадаад үймээнээс ангид сэтгэлийн гүн рүү орохыг биднээс шаардаж буй. Сэтгэлийг танин мэдэхүй нь хувь хүн төдийгүй хүн төрөлхтний энх тайван, шударга ёсны үндэс болох учиртай гүн утгатай алхам юм гэж бид хэлнэ!

Бидний судалгааны гол арга зүй нь сэтгэлийн үйл явц, танин мэдэхүйн асуудлыг випашьяна бясалгалын арга техник болон феноменологийн арга зүйгээр судлахад тулгуурлана. Энэ нь сэтгэлийн амар амгалан хэрхэн мөнхийн эх тайванд хүрэх гүүр болох тухай илүү тодорхой өгүүлэхийг зорьсон арга юм.

Энх тайван бол хүн төрөлхтөн зуун зууны турш мөрөөдсөн хамгийн эрхэм зүйлсийн нэг. Гэвч зөвхөн сайхан үг, уриа тунхаг байх ч нэг хэрэг, түүнийг амьдралын хөрсөнд тарихгүйгээр энх тайван бодит агуулгагүй, хий хоосон хэвээр үлдэх болно шүү дээ. Энх тайваны тухай бодит ойлголт, бодитой туршлагыг шинжлэн үзэх хэрэгтэй.

“Айлаас эрхээр авдраа уутал” гэдэг биз дээ. Өөрсдийн талаас өгүүлэхүйд, дорно дахинд энхийн тухай арвин баялаг туршлага, үзэл санаа бий (Тухайлбал: амьтанд хорлолгүй байх ахимса зарчим, дотоод амар амгалан хийгээд эв найрамдлыг бий болгох бясалгалын арга техникүүд, хамаг амьдыг энрэн нигүүлсэх альтурист үзэл санаа, энх тайвнаар зэрэгцэн орших тухайтад соёл, шашин хоорондын харилцан ойлголцол-ярилцаа, зөрчил мөргөлдөөн, хямралуудыг даван туулхад чиглэгдсэн нийгмийн төсөл, санаачлага зэргийг дурьдаж болох юм). Үүнд, тэр дундаа бурхны сургаал гол үүрэг гүйцэтгэж ирсэн билээ.

Энэ хувьд сэтгэлд амар амгаланг бий болгох тухайд бурхны сургаал номлол нь энэ цаг дор онцгой чухал ач холбогдолтой болж байна. Орчин үеийн амьдралын хурдац, эдийн засгийн өрсөлдөөн, технологийн тасралтгүй дэвшил дунд хүмүүний сэтгэлийн тогтворгүй байдал, стресс, түгшүүр, ганцаардал улам нэмэгдэх болсон нөхцөлд сэтгэлийн төвлөрхүй (mindfulness), ухаарахуй (self-awareness), нигүүлсэхүй (compassion) талуудыг хөгжүүлэх нь хүмүүсийн аж амьдралд тайвшрал, сэтгэлд ариусал авчирч чадах юм. Ялангуяа, Буддын бясалгалын арга техникүүд (випашьяна, анапанасати зэрэг) нь: стрессийн түвшинг бууруулах, сэтгэлийн хямрал, түгшүүрийг даван туулах, анхаарал төвлөрөл, оюун санааны саруул байдлыг нэмэгдүүлэх, амьдралын баяр баясал, амар амгалангийн мэдрэмжийг гүнзгийрүүлэхэд өргөн хэрэглэгдэх болжээ.

Эдгээр аргыг зөвхөн урьд бурхны шашны уламжлалтай орнуудаар (тухайлбал, Монгол улсад вишайяна бясалгалын төв байгуулагдаж амжилттай үйл ажиллагаа явуулж иржээ¹) тогтохгүй Өрнө дахинд ч судалж, шинжлэх ухааны түвшинд баталгаажуулсаар байгаа юм. Тухайлбал²:

- АНУ, Европын их сургуулиудад “mindfulness meditation”-ийг сэтгэл судлал, анагаах ухааны сургалтанд оруулж, сэтгэцийн эрүүл мэндийн эмчилгээний арга болгон хэрэглэх болжээ.
- Эмч, сэтгэл засалчид бясалгалыг депресс, түгшүүр, нойргүйдэл, хар тамхи болон архины хамаарлыг эмчлэх нэмэлт арга хэлбэрээр ашиглаж байна.
- Технологийн компаниуд хүртэл ажилтнуудаа стрессээс хамгаалах, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор бясалгалын хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Ийнхүү Бурхны сургаал, түүний сэтгэлийн амар амгалан бий болгох арга зүй нь орчин үеийн хүн төрөлхтөнд зөвхөн шашны уламжлал бус, харин эрүүл мэнд, нийгмийн харилцаа, боловсрол, аж ахуйн менежментэд хүртэл чухал ач холбогдолтойгоор нэвтэрч байна.

Тэгвэл, хүний сэтгэл санааны мөн чанарын тухайд Буддизм юу гэж сургадаг вэ?

Буддын сургаалд хүнийг “таван цогц” (Pañca-skandha / Five Aggregates) –аас бүрдэнэ гэж үздэг³:

1. Бие махбод - (Дүрс) Материаллаг бие, мэдрэхүйн эд эрхтэн, орчныг хүлээн авах биеийн чадвар. Бие махбод нь сэтгэлийн шунан татагдах нэг тал болох бөгөөд хувьсан өөрчлөгдөж байдгаас мөнхийн зүйл биш юм.

2. Сэтгэл хөдлөл, мэдрэмж (Сэрэхүй) - Амт, үнэр, өнгө, дотоод болон гадаад мэдрэмжээс үүссэн тохь тух, таатай, тааламжгүй мэдрэмж. Бодгальд татагдах, таашаал эсвэл дургүйцэл үүсэх үндэс нь эдгээр мэдрэмжид оршдог.

3. Сэтгэлийн танин мэдэхүйн үйл ажиллагаа (Хуран мэдэхүй) Ертөнцийн объект, үйл явдлыг танин мэдэж, ялгаж салгах үйл явц. Жишээ: хүний нүүр царай, эд зүйлсийг таних, нэрлэх.

4. Сэтгэлийн дотоод урсгал (Хуран үйлдэхүй) Сэтгэлийн хандлага, хүсэл шунал, хөдөлгөөн, зан төлөв зэрэг ухамсарлагдсан болон ухамсаргүй үйлдлүүд багтаана. Энэ нь хүний үйлдэл, зан чанар, сэтгэлийн тогтвортой байдлыг тодорхойлоход чухал үүрэгтэй.

5. Ухамсар (Vijñāna / Consciousness) Бие махбод болон танин мэдэхүйд үндэслэн ухамсар, мэдрэмжийг бий болгох язгуурын сэтгэл. Бусад дөрвөн цогцтой харилцан нөлөөлж, амьд оршихуйг бүрдүүлдэг.

Эндээс, орчин үеийн сэтгэл судлалын шинжлэх ухаан нь хүний ухамсар, сэтгэхүйн үйл ажиллагааг ихэвчлэн мэдрэхүйн таван эрхтэнтэй (харж, сонсож, амтлан, үнэрлэн, хүрэлцэн мэдрэх) холбож судалдаг. Энэ нь сэтгэхүйн (сэтгэл хөдлөлийн) үйл явцыг ажиглах, хэмжих, дүрслэх (дескриптив) төвтэй арга юм. Гэвч ийм судалгааны арга нь сэтгэлийн урсгалын өөрчлөн хувиргах, удирдах талаараа хязгаарлагдмал байдаг. Өөрөөр хэлбэл, орчин үеийн шинжлэх ухаан сэтгэлийг зөвхөн тайлбарлах боломжтой, харин практик түвшинд жолоодох аргыг бүрдүүлээгүй гэж хэлж болно.

Ер орчлонгийн хоёр үндсэн бодит байдал нь матери (дүрс) ба ухамсар (сэтгэл) хоёр юм. Барууны философи, шинжлэх ухаан ихэвчлэн матери буюу биологийн оршин тогтнол, тархины үйл ажиллагаа-нд тулгуурлан сэтгэлийн үзэгдлийг судалдаг. Орчин үеийн психологийн судалгаа ч голчлон мэдрэлийн, биохимийн, физиологийн үндсэн дээр сэтгэлийг тайлбарлах хандлагатай байдаг. Ингэснээр сэтгэлийн “өөрийг нь” буюу ухамсрын нарийн бүтэц, мөн чанар-ыг шууд судлахад ихээхэн хязгаарлал бий болдог.

Харин Дорнод философи ба шашны уламжлал, ялангуяа буддизм, ухамсар буюу сэтгэлийн онцлогийг нарийн төвшинд судалсан бөгөөд зөвхөн сэтгэл зүй, бие физиологийн үзэгдлээр хязгаарлагдахгүйгээр, туршлага, бясалгал, ухамсрын феномэнийг шууд ажиглах аргаар хийдэг.

Хүний бодит байдлыг ч энэхүү матери, ухамсар хоёр бүрдүүдэг. Сэтгэл нь бие махбодтой салшгүй холбогдсон ч, түүнийг биеэс тусдаа, өөрөө амьд ухамсартай урсгал гэж

¹ <https://byasalgal.mn/>

² https://www.psychiatry.wisc.edu/patient-care/mindfulness-program/?utm_source=chatgpt.com
https://mindfulness.sph.brown.edu/?utm_source=chatgpt.com

³S.R.Bhatt. Anu Mehrotra. Buddhist Epistemology. London.: Greenwood Press. 2000.

(хувийн болон нийтийн хүрээнд) танин барьж чадахгүй байгаа нь өөрөө гол асуудал юм. Хүн гадны материаллаг объектод рүү шунан татагдах нь түүний сэтгэл шунал хүсэл, таашаалд автагдсантай холбоотой гэдэг.

Хүний бие сэтгэлийн холбоо нь төсөөлөхөд бэрх гүн гүнзгий зүйл ажээ. Бидний ухамсарт сэтгэл өөрийн гүн давхаргад юу болж байгаа бараг мэддэггүй. Маш олон сэрэл мэдрэмжүүд ээлжлэн солигдож тэр бүхэнд сэтгэл өөрийн хариу үйлдлийг үзүүлснээр (сайхан мэдрэмжид татагдах, тааламжгүй мэдрэмжээс зугтах гэх мэтээр): тогтсон хэв загварыг бий болгодог байна. Энэхүү урт хугацааны дадлуудаас үүссэн хорсох-автагдах “авир үйлдлийн загвар” тогтсноос бодол, үйлдэл, сэтгэл хөдлөл маань бидний байнгын “эзэн захирагч” мэт болж орхиодог байна. Ингэснээр сэтгэлийн тааламжтай мэдрэмжийг давтан эрэлхийлэх, тааламжгүй мэдрэмжээс зайлсхийх үйлдлүүдийг автоматаар гүйцэтгэдэг. Үр дүнд нь сэтгэл гаднын нөхцөлд хэт автсан, тогтворгүй байдалд ордог. Хэрэг дээрэ, бидний зовлон, түгшүүр нь гадаад орчны нөлөөллөөс илүүтэйгээр өөрсдийн маань дотоод хариу үйлдлийн урсгалд оршдог ажээ¹. Товчхондоо, өөртөө хор учруулахгүйгээр бусдад хор учруулах боломжгүй. Сэтгэлийг нь уур хилэн, хорсол шунал эзэмдсэн хүн хамгийн түрүүнд өөрөө хохирогч болдог. Муу сэтгэлийн (зуршлын) боолчлолыг ухамсарлан сэрсэн л хүн сэтгэлийн амар амгаланг бүтээж чадна.

Харин буддын бясалгалын уламжлал сэтгэлийн энэ талд онцгой арга замыг санал болгодог. Буддын бясалгал нь сэтгэлийг туршлагаар нь ажиглах, төвлөрүүлэх, хувиргах, удирдах аргуудыг системтэй хөгжүүлж чаджээ. Жишээ нь: анапанасати (амьсгалаар төвлөрөх) бясалгал нь сэтгэлийн анхаарлыг төвлөрүүлж, төвшинг нь тогтворжуулахад чиглэдэг бол, випашьяна (өндөр ухаарал) бясалгал нь ухамсартай шууд холбогдож, сэтгэлийн динамик, хувирдаг чанарыг нарийвчлан ажиглах боломж олгодог байна².

Сэтгэлийн амар амгаланг бий болгох буддын бясалгалын үйл явцыг товч авч үзье. Бясалгал нь биднийг мэдрэхүйн сэтгэгдэлд хэт автсан сэтгэлийг буцааж ухамсрын өөрт нь төвлөрч сургадаг байна. Ингэхийн тулд таван мэдрэхүйгээс үүсэх ухамсар (төрөн түгэхүй)-аас гадна зургаадах ухамсар буюу сэтгэл хөдлөлүүдийг (citta) барьж авьж авахыг хичээх ёстой. Мэдрэхүйгээс хөндийрсөн ухамсар нэг хэсэгтээ л “юу ч үгүй” болсон мэт хөндий хоосон мэдрэмжид автах ч яваандаа сэтгэл тогтоод ирэхлээр толь мэт тунгалаг төлөв бий болж, тэр нь бясалгалын гол зоригдохуун болох ажээ. Гэхдээ энэхүү гол сэтгэлд (эрхэн сэтгэл)-д хүрэхэд мэдрэхүйд дасал болсон байдал болон сөрөг сэтгэл хөдлөлүүд саад болдог байна. Хэрэв эрхэн сэтгэлд хүрч чадахгүй бол хүн өөрийн сөрөг сэтгэл хөдлөлүүдэд автаж, сэтгэлдээ амар амгалан бий болгож чадахгүй. Үүний тулд сэтгэлийг сацруулалгүй нэгэн зүгт хураах шаматха (амирлан ахуй) бясалгалаар эрхэн сэтгэлийн хүчийг нэмэгдүүлж, түүнээс нөхөр сэтгэлийн үйл явцыг ажиглан шинжлэхэд випашьянаг (үлэмж үзэхүй) хэрэглэдэг байна. Эдгээр нь бидний оршихуйг (сэтгэлийн экзистенциаль үндсийг) үнэхээр өөрчилж чадна гэж баталдаг³.

Буддын бясалгал нь зөвхөн сэтгэлийг ажиглах төвтэй бус, мөн сэтгэлийг залах өөрчлөх, боловсронгуй болгох практик аргачлалыг нэгтгэдэг. Энэ ялгаа нь сэтгэлийг гүнзгий судлах, ухамсрын бүтэц, динамикийг ойлгоход чухал ач холбогдолтой.

Ийм байр суурь хүний оршихуй, ухамсар, сэтгэл зүйг ойлгоход гол үндэс болох ёстой.

Бурханы сургаалд, бидний ердийн ухамсрын хүрээнд жинхэнэ, үнэнтэй гэж боддог зүйлс нь сэрж сэхээрсэн оюун ухааны үүднээс бол худал хуураг шинжтэй гэж хэлдэг. Ийм хуурмаг байдлыг бүтээж буй сэтгэхүй болон ойлгохуйн «мунхаг» байдлаас гарахын тулд сэтгэлийн элдэв ээдрээнээс ангид одоогийн бодит байдлыг хүлээн зөвшөөрч сурах нь эхний алхам болдог байна. Харин феноменологи философид, бидний сэтгэлд дасал болсон механизмыг ухамсрын “жам ёсны удирдамж” гэж томъёолдог⁴. Энэ нь орон, цагт оршиж байгаа ертөнц биднээс огтоос хамааралгүй учраас түүний үнэ цэнэ, хэрэглээг ч түүнчлэх үзэх хэрэгтэй гэх үзлийн шүүмжлэл юм. Туршлагын агуулгын олон янз байдлыг гагхцүү физик юмс үзэгдлийн шинж чанараар

¹ Медитация Випассана. Пояснения S.N. Goenka: <https://www.youtube.com/watch?v=tDnmNQaVxOg&t=181s>

² Памоджо П. Випассана. Иллюстрированное руководство по буддийской медитации для начинающих. – М.: Ориенталия, 2014. 128 с.

³ Далай-лама о медитации: <https://www.youtube.com/watch?v=Kw8IhZuWxLk&t=294s>

⁴ Гуссерль Э. Идея феноменологии: пять лекций. Пер. с нем. Н.А. Артеменко. СПб.: Гуманитарная Академия, 2008

нөхцөлдүүлэн тайлбарлах нь өрөөсөл. Бидэнд хүртэгдэх юмс нь хэлбэр дүрс, өнгөнөөс гадна бидэнд хамаатай хэрэглээ (use), гүйцэтгэл үйл (function), сонирхол, бүр цаашилбал соёлын контекст дотор дайралдаж байдгийг харгалзан “аль ямар буйгаар” тайлбарлах буюу, феноменологи хэллэгээр, бол “юмс тэргүүтний өөрт нь хандах” ёстой ажээ.

Нөгөөтэйгүүр, ер гаслангаас нөгчихүйн мөрийг үзүүлэх бурхны сургаал орчлонгийн хамаг зовлон үүдэх сөрөг сэтгэл хөдлөлүүдийг танин барьж номхруулахыг уриалдаг. Үүний тулд хүн бие сэтгэлээ ажиглаж, тэнд юу өрнөж байгааг, өөрөөр хэлбэл бидний сэтгэл юмсад хүлэгдэхийн зовлон, шалтгаан, түүнээс ангижрахуй, зам мөрийг ойлгох хэрэгтэй ажээ.

Ухамсарт юмс хэрхэн өгөгдөх өгөгдлийг судалж, түүнд хандахдаа аливаа суртал, таамаглал, шүүлтээс ангид байж, бодит байдлыг “тэр хэвээр нь” ажиглах чадварт суралцах нь хүний дотоод амар амгаланг төлөвшүүлэх суурь болох юм.

Элдэв итгэл үнэмшлийн зөрчил, суртал маргаанд автахгүйгээр, бодит туршлага дээр тулгуурлан бусдыг ойлгож, хүлээн зөвшөөрөх чадварыг хөгжүүлснээр харилцан хүндлэл, эв нэгдэл, хүчирхийлэлгүй байдлыг бэхжүүлнэ.

Юун түрүүнд, энх тайвны үзэл санаа бол гаднаас тулгасан сургаал биш, харин хүний ухамсрын гүнээс төрөн гарах, тогтвортой төлөвшсөн үнэт зүйл байх ёстой.

Энх тайвны эрхэмлэл нь улс түмнүүдийн хэрэгжүүлэх энхийн бодлогын эх үндэс байсаар ирсэн. Хэдийгээр мөнхийн энх тайваны үзэл санаа олон улсын харилцааны болон эрхзүйн түвшинд он удаан жилийн явцад нийгмүүдийн аж байдал, давхарга, үзэл сурталын дор ахин дэвшсээр ирсэн ч, өнөөдрийн ердийн нөхцөлд бүрхэг балархай төсөөлөл мэт санагдавч ертөнцийг үзэхүйн цөм байсаар байх учиртай билээ.

“Мөнхийн энх тайван” нь улс түмнүүд хоорондын харилцаанд ёс зүйтэй харилцан хандлага төлөвшүүлэх, дайн дажиныг таслан зогсоох зарчмыг нэвтрүүлэхэд чиглэгдсэн нийгэм-улстөрийн хүрээний шинжтэй төсөл юм. Энэ нь хувийн түвшнээс давсан, нийгэм, олон улсын харилцаанд шингэж, бодит амьдрал дээр НҮБ зэрэг байгууллагуудын үйл ажиллагаагаар хэрэгжиж ирсэн. Тэр хувьдаа аливаа харилцаанд шударга ёс, хууль ёсны зарчим үйлчлэх боломжийг бүрдүүлж чадах ч, энх тайван нь хууль дүрэмд тулгуурласан зохицуулалтаас илүүтэйгээр дотоод сэтгэлд гүн гүнзгий сууж, хүний ёс суртахуун болон боловсрох нөхцөлгүйгээр тогтохгүй.

Тиймээс тухайн улс нийгмээрээ хүний эрх, шударга ёс, ёс зүйг эрхэмлэж, иргэд нь бие биедээ хүндэтгэлтэй хандах амьдралын хэв маягийг цогцлоож чадсан цагт л сая энх тайвны гэгээ татах боломжтой.

Эндээс нэгэн “гүүр” тодорно:

Хувь хүн дотоодын амар амгаланд хүрэхгүйгээр,

Ухамсар ил тод ойлголцолд хүрэхгүйгээр,

Нийгэм шударга ёсны тогтолцоо бүрдүүлэхгүйгээр — мөнхийн энх тайван тогтох боломжгүй.

Эрхэм нөхөд өө!

Мөнхийн энх тайван бол хийсвэр мөрөөдөл бус. Энэ бол бидний амьсгал бүрт, ухамсрын агшин бүрт, хамтын шударга тогтолцооны бүтээл бүрт оршиж буй бодит боломж юм.

НОМ ЗҮЙ

- S.R.Bhatt. Anu Mehrotra. Buddhist Epistemology. London.: Greemwood Press. 2000.
- Памоджо П. Випассана. Иллюстрированное руководство по буддийской медитации для начинающих. – М.: Ориенталия, 2014. 128 с.
- Урбанаева И.С. Буддийская медитация и феноменологический метод: основания и смысл сравнения // Вопросы философии. 2018. № 2.
- Прадип П. Гокхале. Буддизм и феноменология: сопоставление в контексте медитации осознанности. HORIZON 7 (2) 2018 : I. Research : P. P. Gokhale : 452–471.
- Трактаты о вечном мире / Сост. И. С. Андреева и А. В. Гулыга. СПб.: Алетейя, 2003. — 398 с.
- Гуссерль 2008 – Гуссерль Э. Идея феноменологии: пять лекций. Пер. с нем. Н.А. Артеменко. СПб.: Гуманитарная Академия, 2008

**“Z” ҮЕИЙН ОЮУТАН, ЗАЛУУСЫН ЁС СУРТАХУУНЫ
ТӨЛӨВШЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ
(Ёс суртахуун, зан заншил, гэр бүлийн үнэт зүйлс)**

Д.ЭНХТАЙВАН

*Дотоод хэргийн их сургуулийн
ахлах багш, магистр, дэд хурандаа*

Түлхүүр үг: Оюутны ёс суртахуун, оюутан залуусын ёс суртахууны төлөвшил, “Z” үеийн залуусын ёс суртахуун

Судалгааны үндэслэл: Өнөө цагийн оюутан суралцагчдын ёс суртахууны төлөвшлийг судлах болсон дараах үндэслэл байна. Үүнд:

Нэгд, үе хоорондын ялгаа нь олон нийттэй ажилладаг нийгмийн ухааны олон салбарын судлагдахууны объект болж байна. Тухайлбал, латин хэлний “Z” үсгээр тэмдэглэсэн энэхүү нэр томъёог судалсан энгийн хайгуулаас орчин цагийн оюутны ёс суртахуунд илэрч байгаа онцлогийг лавшруулан судлах эрэлт хэрэгцээ үүссэн юм. Судлаач В.Каррингтон, Ж.Роуселл нарын бүтээлд¹ “Z” үеийн залуусыг “зомбинууд” гэж тэмдэглэсэн нь санамсаргүй хэрэг биш ажээ. Зомби буюу хагас хүн, хүн дүрст араатан эсвэл ямар нэг халдвараар өвчилсөн согогтой хүн зэрэг олон утгыг өөртөө агуулж байна.

Хоёрт, “Z” үеийн залуусын онцлогийг тодорхойлсон судалгааны ажлуудад орчин үеийн оюутан залуусын бусад үеийнхнээс ялгарах байдлыг ёс суртахуунаа гэж буй гэсэн утгаар тэмдэглэсэн нь цөөнгүй.



Судалгааны арга зүй: Хувь хүний ёс суртахууны төлөвшлийг тодорхойлсон хэд хэдэн нөлөө бүхий онолын хандлага бий. Эхнийх нь судлаач Гарванова (2014) нарын судлаачид хувь хүний ёс суртахууны төлөвшлийн суурь болдог **үнэт зүйлийг** сэдэл, хандлага, амьдралын зорилго, учир шалтгааны хамаарал, итгэл үнэмшил, хүлээлт, хүсэл эрмэлзэл, зан үйлийн хэв маяг, сонирхол, хүслийн төвлөрөл гэж үздэг. Удаах хандлагад нийгэм, нийгмийн бүлгүүдэд хувь хүний үнэт зүйлс ялгаатай харагддаг тул тусгайлан судлах шаардлагатай (Поттс, 2015; Шварц, 2002; Карандашев, 2004) гэж үздэг.

Хувь хүний үнэт зүйлсийн талаарх онолуудын нэг бол Израилын сэтгэл судлаач С.Х.М.Рокачийн аргыг судлаач С.Х.Шварц өргөжүүлсэн. Түүнийхээр нийгмийн болон хувь хүний **ёс суртахуун үнэт зүйлсээс хамааралтай**. Хүний үнэт зүйл (value) уг хүний итгэл бишрэлээс (belief) хамааралтай. Хувь хүний үнэт зүйл нь мэдрэмжээр (feelings) нөхцөлддөг. Судлаач Шварцынхаар үнэт зүйл бол үйлдлийг өдөөдөг хүссэн зорилго болдог. Энэхүү судалгааны арга зүйг судлаач Шварцын ёс суртахууны төлөвшлийг үнэт зүйлстэй холбон тодорхойлдог судалгааны загварыг ашиглав.



Судалгааны үр дүн: Бид энэхүү судалгаагаар “Z” үеийн оюутны ёс суртахууны төлөвшлийг тодорхойлоход оршино. Судалгаанд Дотоод хэргийн их сургууль, Монгол Улсын боловсролын их сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 348 оюутан залуус хамрагдаж, үүнээс хүйсээр нь авч үзвэл 63.8 хувь нь эмэгтэй, 36.2 хувь нь эрэгтэй оюутан суралцагчид хамрагдсаныг доорх үзүүлэлтээс харж болно.



Судалгаанд оролцогчдын 75.6 хувь нь 18-20 нас, 21 хувь нь 20-22 нас, 1.7 хувь нь 22-24 нас, 1.4 хувь нь 26-28 насны оюутан суралцагчид хамрагдсаныг дээрх үзүүлэлтээс харж болно.

¹Genera&on Z: Zombies, Popular Culture and Educa&ng Youth. edited by Victoria Carrington, Jennifer Rowsell, Esther Priyadharshini, Rebecca Westrup



Аль сургуульд сурдаг вэ? 349 responses  МУБИС ДХИС ШУТИС	Хэддүгээр курст сурдаг вэ? 350 responses  I II III IV
Нийт судалгаанд оролцогчдын 223 буюу 63.9 хувь ДХИС, 124 буюу 35 хувь нь МУБИС, 5 буюу 1.4 хувь нь ШУТИС-ийн оюутнууд эзэлж байгааг доорх үзүүлэлтээс харж болно.	Судалгаанд оролцогчдын 39.7 хувь нь I, 37.7 хувь нь II, 6.6 хувь нь III, 16 хувь нь IV дүгээр курсийн оюутнууд эзэлж байгааг доорх үзүүлэлтээс харж болно.



Нэг. Z үеийн оюутны өөрийгөө бусдад зориулах байдал



1. Эргэн тойрон дахь хүмүүст туслах нь маш чухал. 352 responses  Бүрэн нийлж байна. Зарим талаар санал нийлж байна. Санал нийлэхгүй байна. Огт санал нийлэхгүй байна.	2. Найз нөхдөдөө үнэнч байх нь чухал. 351 responses  Бүрэн нийлж байна. Зарим талаар санал нийлж байна. Санал нийлэхгүй байна. Огт санал нийлэхгүй байна.
Судалгаанд оролцогчдын 40.1 хувь нь бүрэн санал нийлж байна, 58.8 хувь нь зарим талаар санал нийлж байна, 1.1 хувь санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.	Судалгаанд оролцогчдын 69.5 хувь нь бүрэн санал нийлж байна, 29.6 хувь нь зарим талаар санал нийлж байна, 0.9 хувь нь санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.

3.Танихгүй хүн асуулт асуувал хариулна. 352 responses  Бүрэн нийлж байна. Зарим талаар санал нийлж байна. Санал нийлэхгүй байна. Огт санал нийлэхгүй байна.	4.Өөрийг нь гомдоосон хүмүүсийг уучилж чаддаг. 352 responses  Бүрэн нийлж байна. Зарим талаар санал нийлж байна. Санал нийлэхгүй байна. Огт санал нийлэхгүй байна.
Судалгаанд оролцогчдын 29.8 хувь нь бүрэн санал нийлж байна, 64.8 хувь нь зарим талаар санал нийлж байна, 4.5 хувь нь огт санал нийлэхгүй байна, 0.9 хувь нь огт санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.	Судалгаанд оролцогчдын 29.7 хувь бүрэн санал нийлж байна, 66.3 хувь нь зарим талаар санал нийлж байна, 3.1 хувь санал нийлэхгүй байна, 0.8 хувь огт санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.



Хоёр. Нэгдмэл байдлыг ухамсарлаж буй байдал

1. Дэлхийн хүн бүрд тэгш хандах нь чухал. 351 responses  - Бүрэн нийлж байна. - Зарим талаар санал нийлж байна. - Санал нийлэхгүй байна. - Огт санал нийлэхгүй байна.	2. Хоорондоо ялгаатай ч гэсэн өөрөөсөө өөр хүмүүсийг сонсох нь түүний хувьд чухал. 351 responses  - Бүрэн нийлж байна. - Зарим талаар санал нийлж байна. - Санал нийлэхгүй байна. - Огт санал нийлэхгүй байна.
Судалгаанд оролцогчдын 69.4 хувь бүрэн санал нийлж байна, 27.2 хувь нь зарим талаар санал нийлж байна, 2.8 хувь нь санал нийлэхгүй байна, 0.8 хувь нь огт санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.	Судалгаанд оролцогчдын 53.3 хувь бүрэн санал нийлж байна, 44.2 хувь нь зарим талаар санал нийлж байна, 2.3 хувь нь санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.



3. Хүмүүс байгалиа хамгаалах ёстой. 351 responses  - Бүрэн нийлж байна. - Зарим талаар санал нийлж байна. - Санал нийлэхгүй байна. - Огт санал нийлэхгүй байна.	4. Дэлхийн бүх хүмүүс эв найртай амьдрах ёстой. 349 responses  - Бүрэн нийлж байна. - Зарим талаар санал нийлж байна. - Санал нийлэхгүй байна. - Огт санал нийлэхгүй байна.
Судалгаанд оролцогчдын 95.2 хувь нь бүрэн санал нийлж байна, 4.3 хувь нь зарим талаар санал нийлж байна, 0.6 хувь нь санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.	Судалгаанд оролцогчдын 71.9 хувь бүрэн санал нийлж байна, 26.4 хувь нь зарим талаар санал нийлж байна, 1.7 хувь санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.

5. Танихгүй хүмүүстэй шударга харьцахыг хүсдэг. 350 responses  - Бүрэн нийлж байна. - Зарим талаар санал нийлж байна. - Санал нийлэхгүй байна. - Огт санал нийлэхгүй байна.	6. Хүмүүс байгальд дасан зохицож амьдрах ёстой. 350 responses  - Бүрэн нийлж байна. - Зарим талаар санал нийлж байна. - Санал нийлэхгүй байна. - Огт санал нийлэхгүй байна.
Судалгаанд оролцогчдын 57.1 хувь нь бүрэн санал нийлж байна, 39.7 хувь зарим талаар санал нийлж байна, 2.9 хувь нь санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.	Судалгаанд оролцогчдын 64.9 хувь нь бүрэн санал нийлж байна, 34 хувь нь зарим талаар санал нийлж байна, 1.1 хувь санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.



Гурав. Өөрийгөө удирдах байдал

1. Миний хувьд шинэ санаа олж, бүтээлч байх нь чухал. 352 responses  - Бүрэн нийлж байна. - Зарим талаар санал нийлж байна. - Санал нийлэхгүй байна. - Огт санал нийлэхгүй байна.	2. Миний хувьд юу хийх талаар өөрөө шийдвэр гаргах нь чухал юм. 349 responses  - Бүрэн нийлж байна. - Зарим талаар санал нийлж байна. - Санал нийлэхгүй байна. - Огт санал нийлэхгүй байна.
Судалгаанд оролцогчдын 66.5 хувь нь бүрэн санал нийлж байна, 33 хувь нь зарим талаар санал нийлж байна, 0.6 хувь санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.	Судалгаанд оролцогчдын 70.2 бүрэн санал нийлж байна, 28,9 хувь нь зарим талаар санал нийлж байна, 0.3 хувь нь огт санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.



Дөрөв. Өөрийгөө урамшуулах байдал

1. Би амьдралд олон янзын зүйлийг хийх нь чухал гэж боддог. 349 responses  - Бүрэн нийлж байна. - Зарим талаар санал нийлж байна. - Санал нийлэхгүй байна. - Огт санал нийлэхгүй байна.	2. Би эрсдэлд орох дуртай. 352 responses  - Бүрэн нийлж байна. - Зарим талаар санал нийлж байна. - Санал нийлэхгүй байна. - Огт санал нийлэхгүй байна.
Судалгаанд оролцогчдын 68.6 хувь нь бүрэн санал нийлж байна, 30.3 хувь нь зарим талаар санал нийлж байна, 0.6 хувь нь санал нийлэхгүй байна, 0.6 хувь нь огт санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.	Судалгаанд оролцогчдын 15.6 хувь нь бүрэн санал нийлж байна, 54.7 хувь нь зарим талаар санал нийлж байна, 25.2 хувь нь санал нийлэхгүй байна, 4.5 нь огт санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.



Тав. Амьдралын идэвхтэй байдал

1. Би хөгжилтэй байх бүх боломжийг эрэлхийлдэг. 352 responses  - Бүрэн нийлж байна. - Зарим талаар санал нийлж байна. - Санал нийлэхгүй байна. - Огт санал нийлэхгүй байна.	2. Амьдралаас таашаал ханамж эдлэх нь чухал. 352 responses  - Бүрэн нийлж байна. - Зарим талаар санал нийлж байна. - Санал нийлэхгүй байна. - Огт санал нийлэхгүй байна.
Судалгаанд оролцогчдын 55 хувь нь бүрэн санал нийлж байна, 42.5 хувь нь зарим талаар санал нийлж байна, 2.3 хувь нь санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.	Судалгаанд оролцогчдын 80.7 хувь нь бүрэн санал нийлж байна, 19 хувь нь зарим талаар санал нийлж байна, 0.3 хувь нь санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.



Зургаа. Амжилтын талаарх ойлголт

1. Би өөрийн чадвараа бусдад харуулах нь маш чухал. 352 respondents  - Бүрэн нийлж байна. - Зарим талаар санал нийлж байна. - Санал нийлэхгүй байна. - Огт санал нийлэхгүй байна.	2. Миний хувьд амжилтанд хүрэх нь маш чухал юм. 352 respondents  - Бүрэн нийлж байна. - Зарим талаар санал нийлж байна. - Санал нийлэхгүй байна. - Огт санал нийлэхгүй байна.
Судалгаанд оролцогчдын 50.3 хувь нь бүрэн санал нийлж байна, 47.2 хувь нь зарим талаар санал нийлж байна, 2 хувь нь санал нийлэхгүй байна, 0.6 хувь огт санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.	Судалгаанд оролцогчдын 61.6 хувь нь бүрэн санал нийлж байна, 36.1 хувь нь зарим талаар санал нийлж байна, 1.7 хувь нь санал нийлэхгүй байна, 0.6 хувь нь огт санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.


Долоо. Эрх мэдлийн талаарх ойлголт

1. Миний хувьд баян байх нь чухал. Би их мөнгөтэй, үнэтэй зүйлтэй болохыг хүсдэг. 351 respondents  - Бүрэн нийлж байна. - Зарим талаар санал нийлж байна. - Санал нийлэхгүй байна. - Огт санал нийлэхгүй байна.	2. Би хариуцлагатай байж, бусдад юу хийхийг нь зөвлөж чаддаг. 351 respondents  - Бүрэн нийлж байна. - Зарим талаар санал нийлж байна. - Санал нийлэхгүй байна. - Огт санал нийлэхгүй байна.
Судалгаанд оролцогчдын 23.1 хувь нь Бүрэн санал нийлж байна, 62.4 хувь нь зарим талаар санал нийлж байна, 11.4 хувь нь санал нийлэхгүй байна, 3.1 хувь нь огт санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.	Судалгаанд оролцогчдын 37.6 хувь нь бүрэн санал нийлж байна, 58.7 хувь нь зарим талаар санал нийлж байна, 3.1 хувь нь санал нийлэхгүй байна, 0.6 хувь нь огт санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.

Найм. Аюулгүй байх хэрэгцээ


1. Миний хувьд аюулгүй орчинд амьдрах нь чухал юм. 349 respondents  - Бүрэн нийлж байна. - Зарим талаар санал нийлж байна. - Санал нийлэхгүй байна. - Огт санал нийлэхгүй байна.	2. Миний хувьд эх орон минь дотооддоо аюулгүй байх нь маш чухал юм. 351 respondents  - Бүрэн нийлж байна. - Зарим талаар санал нийлж байна. - Санал нийлэхгүй байна. - Огт санал нийлэхгүй байна.
Судалгаанд оролцогчдын 92 хувь нь бүрэн санал нийлж байна, 7.7 хувь нь зарим талаар санал нийлж байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.	Судалгаанд оролцогчдын 88.3 хувь бүрэн санал нийлж байна, 11.7 хувь зарим талаар санал нийлж байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.

3. Миний хувьд бүх зүйл эмх цэгцтэй, цэвэрхэн байх нь чухал.
351 responses



Судалгаанд оролцогчдын 74.6 хувь нь бүрэн санал нийлж байна, 24.5 хувь нь зарим талаар санал нийлж байна, 0.9 хувь нь санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.

4. Миний хувьд эрүүл байх нь түүний хувьд маш чухал.
348 responses



Судалгаанд оролцогчдын 86.2 хувь нь бүрэн санал нийлж байна, 12.4 хувь нь зарим талаар санал нийлж байна, 1.4 хувь нь санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.


Ес. Дуулгавартай байдал

1. Хүн харахгүй байсан ч гэсэн дүрмийг үргэлж дагаж мөрдөх ёстой.
350 responses




Судалгаанд оролцогчдын 66 хувь нь бүрэн санал нийлж байна, 30.9 хувь нь зарим талаар санал нийлж байна, 2.6 хувь нь санал нийлэхгүй байна, 0.6 хувь нь огт санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.

2. Би биеэ зөв авч явах нь маш чухал байдаг.
350 responses



Судалгаанд оролцогчдын 88.3 хувь нь бүрэн санал нийлж байна, 11.1 хувь нь зарим талаар санал нийлж байна, 0.6 хувь санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.

3. Миний хувьд дуулгавартай байх нь чухал. Би ахмад настай хүмүүс болон эцэг эхийнхээ үгийг сонсдог.
350 responses



Судалгаанд оролцогчдын 55.7 хувь нь бүрэн санал нийлж байна, 42.3 хувь нь зарим талаар санал нийлж байна, 1.2 хувь нь санал нийлэхгүй байгааг дээрх үзүүлэлтээс харж болно.

Дүгнэлт: Бид энэхүү судалгаагаар "Z" үеийн оюутан залуусын ёс суртахууны төлөвшилийг тодорхойлохыг зорьсон.

Судалгаанд Дотоод хэргийн их сургууль, Монгол Улсын Боловсролын Их сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн нийт 348 оюутан, залуус хамрагдаж үүнээс хүйсээр нь авч үзвэл 63.8 хувь нь эмэгтэй, 36.2 хувь нь эрэгтэй оюутан суралцагчид хамрагдсан.

Судлаач С.Х.Шварцын судалгааны загварыг ашиглан тодорхойлсон өнөө цагийн оюутан, залуусын ёс суртахууны төлөвшилд дараах онцлог шинжүүд илэрч байна. Үүнд:

- *Бусдад өөрийгөө зориулах байдал.* Судалгаанд оролцогчдын 58.5 хувь нь бусдад өөрийгөө зориулах эсэхэд эргэлздэг хэр нь тэдний 69.5 хувь нь найз нөхдөдөө туслах ёстой гэж үздэг. Мөн тэдний 66 хувь нь бусдыг уучилж чаддаг гэж үзсэн.
- *Нэгдмэл байдал.* Өнөө цагийн оюутны 69.4 хувь нь дэлхийн хүн бүр тэгш байх ёстой гэдэгт эргэлздэг хэр нь 95.2 хувь нь бид нэг эх дэлхийтэй учраас байгалиа хамгаалах ёстой гэж үздэг.
- *Өөрийгөө удирдах байдал.* Орчин цагийн оюутны 70.2 хувь нь өөрийн санаа бодол өөртөө зөв гэж үздэг бол 85.4 хувь нь сонгох, хийх эрх чөлөөг илүүд үздэг байна. Мөн оюутнуудын 83.1 хувь нь бие даасан байдлыг илүү үздэг.
- *Өөрийгөө урамшуулах байдал.* Оюутнуудын 68.6 хувь нь олон янзын юм хийх сонирхолтой хэр нь тэдний 54.7 хувь нь эрсдэл гаргах чадвартай гэж өөрсдийгөө үнэлжээ.
- *Амьдралын идэвхт чанар.* Тэдний 80.6 хувь нь маш эерэг бөгөөд амьдралаас таашаал авах нь чухал гэж үзсэн.
- *Амжилтын талаарх ойлголт.* Орчин цагийн оюутны 61.6 хувь нь амжилт чухал гэж үздэг ч 50.3 хувь нь өөрийгөө амжилт гаргах чадвартай гэж үзсэн байна.
- *Эрх мэдлийн тухай ойлголт.* 62.4 хувь нь баян байх нь чухал гэж үздэг ч 56 хувь нь өөрийгөө бусдын өмнөөс шийдвэр гаргаж чадна гэж дүгнэжээ.
- *Аюулгүй байх хэрэгцээ.* Оюутнуудын 92 хувь нь аюулгүй байдал маш чухал гэж үзэж байгаа ч хувийн зохион байгуулалт эмх цэгцийн хувьд тэдний 74.6 хувь нь хувьдаа эмх цэгцтэй байж чаддаг гэжээ.
- *Дуулгавартай байдал.* Тэдний 66 хувь нь дуулгавартай байдал чухал гэж үзсэн ч 57 хувь нь ахмад настай болон эцэг эхийнхээ үгийг дуулгавартай ханддаг гэж үзжээ.

НОМ ЗҮЙ

1. Genera&on Z: Zombies, Popular Culture and Educa&ng Youth. edited by Victoria Carrington, Jennifer Rowsell, Esther Priyadharshini, Rebecca Westrup
2. Genera&on Z Leads: A Guide for Developing the Leadership Capacity of GeneraYon Z Students. [Corey Seemiller](#), [Meghan Grace](#). 2017
3. Hello Gen Z: Engaging the Genera&on of Post---Millennials. By Claire Madden. 2017

АРГА БИЛГИЙН НЭГДЭЛ БА ТАНИН МЭДЭХҮЙ

Н.ТОГТОХ

*Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн,
техникийн ухааны доктор (Ph.D)*

Төрийн билэгдэл

Монгол хүний (бие, ухаан, сэтгэл гурав) **билэгдэл нь Нар, Сар, Гал гурав.**

“Арга билгийн нэгдэл”-ээр: Нар бол ухааны гэрэл цацруулагч- Билиг, Сар бол ухааны гэрлийн цацрагийг ойлгон тусгалд оруулагч-Арга, ухааны гэрлийн цацрагууд тусгалын цэгт төвлөрөн Нэгдэж Гал асааж- Үр, Дөл бадраана-Ашиг.

Томьёолол нь: **Арга + билиг = Нэгдэл → Үр → ашиг**

Анхаарал төвлөрөхөд оюун ухааны хүч(чадавхи) нэмэгдэж, сэтгэхүйн чадвар сайжирч. Ухаарах тусам ухаан нэмэгдэнэ.

Нар Сар Гал гурав нь нийтийн тооллоос 300-аад жилийн өмнө “Хүннү гүрэн”-ий төрийн сүлд байсан бөгөөд Анхдугаар богд Занабазар XVI зууны үед суурь нэмж Соёмбо үсгийн тэргүүн болгосон нь улмаар Төрийн билэгдэл -- алтан Соёмбо болжээ.

Монгол Улсын үндсэн хуулинд: 12.3 Төрийн сүлдний төв хэсэгт, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, цог хийморийг илтгэсэн алтан Соёмбо эрдэнийн хүлэг морьтой хослуулан дүрсэлсэн.

Чингис хааны билэг сургаалаас:

**Өөдлөхөд сэрэх санах эрхэм, Өсөхөд
сурах дадах эрхэм,.**

Сэцэн билигтэн үүнийг Сэрж ухан(НТ:ухааран) билиг болгомуй,

Саруул ухаантан үүнийг , Санаж ухан(НТ:ухааран) эрдэм (НТ:арга) болгомуй.

Арга билиг хоёрыг мэдвээс, Аливаа хүчтэнийг эрхэндээ оруул юу, Арга билиг хоёрыг эс ухваас(НТ:ухаарваас) Алгандаа бичсэнийг тогтоохуйаа бэрх.

Шинжлэх ухаан салбарлан хөгжөөгүй байсан XIII зууны үед Монголчууд Их эзэн

Чингис хаан Арга, билгийн ухааныг эрхэмлэн дээдэлж амьдрал тэмцэлд, амжилт ялалтад хүрч байсныг дэлхийн түүхэн баримтуудад тулгуурлан дэлхийн хүмүүс юу гэж үзэж байснаа тэмдэглэн үлдээсний заримаас дурдвал:

Италийн жуулчин, судлаач **Марко Поло** Монголчууд гүн ухаантай, Оюун ухааны өндөр чадвартай тэдний мэдлэгийн цар хүрээ гайхалтай байсан.

Америкийн цэргийн түүхч **Тимоти Мэй** “Монголчууд зөвхөн цэргийн ур чадвараар төдийгүй, Оюун санааны хүчээрээ дэлхийд алдаршсан”

Английн түүхч **Роберт Маршалл** Монголчуудын өөрсдийн Оюун ухаан, Бүтээлч байдал, зохион байгуулалт, ухаалаг төрийн бодлогоор Дэлхийн түүхэнд томоохон нөлөө үзүүлсэн.

Оросын алдарт жанжин **А.Суворов** “Чингис цэргийн олноор байлддаггүй, аргын сайнаар байлддаг.

В.Ф.Гегель “Хүн төрөлхтөний түүх Дорноос, тэр дундаа Монголчуудаас эхлэлтэй, Учир нь тэдэнд **төр** байсан юм билээ” гэсэн байдаг.

АРГА БИЛГИЙН НЭГДЭЛ БА ТАНИН МЭДЭХҮЙН ОНОЛ

Арга билгийн ухааны нэгдэл (Монгол сэтгэлгээний арга)

Мал сүрэг-**Арга(санаа)** + Бэлчээрийн ургамал - **Билиг(материаллаг)** = Улирлын ялгавартай идээшилдэг - **Нэгдэл (үйлийн нэгдэл)** → Тарга хүч авхуулах - **Үр** — идээшилдэг ургамлыг, улирлаар ялгаварлан дагуулж хариулан малласнаар - **Ашиг**(тэмцэл) **нь** хэмжигдэнэ.

XVIII зууны сүүлч XIX зууны эхээр Ф.Гегель: **Арга билгийн нэгдэл**-ийг

“Тезис+Антитезис=Синтез” хэмээх гурвал буюу **Санаан эхлэлтэй Диалектик**-ийг философид оруулж ирсэн боловч К.Маркс: “юмс, үзэгдэл, үйл явц бүхнийг зөвхөн гурвалаар авч үзэх албагүй, хэд ч байж болно” гэж үзээд хүлээн зөвшөөрөөгүй.

Диалектик (Материаллаг эхлэлтэй диалектик)

Мал сүрэг **Эсрэг** + Бэлчээрийн ургамал **Тэсрэг** = улирлын ялгавартай идэшлэдэг нь **Нэгдэл** → Тарга хүч авхуулах-**Үр**, идээшилдэг ургамлыг дагуулан, үгүйгээс нь хамгаалан хариулж маллах нь **Тэмцэл**.

(XVIII зууны сүүлч XIX зууны эхээр **К.Маркс, Ф.Энгельс** нар **Материаллаг** эхлэлтэй Диалектикийг Философид оруулж ирээд “**Диалектик материализм**” болгосон)

НТ: Зүй нь: Арга билгийн ухаанаар буюу Монгол сэтгэлгээгээр Санаан болон материаллаг эхлэл бүхий Диалектикийг нэгдэл-д нь авч үзэх ёстой байтал, салангид авч үзэн туйлшруулж, улмаар хэрэгжүүлсэн нь ашиггүй болов уу.

Логик (түүхэн буюу гурван цагийн холбоонд сэтгэх арга)

Мал сүрэг, Бэлчээрийн ургамлыг улирлын ялгавартай идээшилдэг. **Ерөнхий** (эсрэг)

Адуун сүрэг нь Мал сүргийн нэг төрөл мөн. **Тусгай** (тэсрэг)

Адуун сүрэг, бэлчээрийн ургамлыг улирлын ялгавартай идэшлэнэ. **Оюун дүгнэлт**(нэгдэл).

(н.т.ө 300 жил Аристотелийн формал логик)

Эдгээр сэтгэлгээний аргууд нэгэн жишээгээр тайлбарлагдаж байгаа нь хэлбэрийн хувьд ялгаатай ч агуулгын хувьд ижил болохыг нотолж байгаа мэт.

НТӨ 300-аад жилийн тэртээх хүн төрөлхтний танин мэдэхүйн түүхэн хөгжлийн түвшинд онолын сэтгэлгээг тогтолцоонд оруулах нөхцөл бүрдсэн нь Азийн Хүннү гүрэнд **Арга билгийн нэгдэл**, Энэтхэгт **Нагаржунайн хоосон чанар**, Европод Аристотелийн **формал логик** хэлбэрээр сэтгэлгээний үйл явцын хоорондоо хамааралгүйгээр өөр өөрийн өвөрмөц хэлбэртэй тогтолцоонд оруулсан ч агуулгын хувьд бололтой.

Шинжлэх ухаан ойрын болон алсын зорилготой байдаг бөгөөд Ойрын зорилго нь судалж байгаа зүйлийн онолын тал болох тогтолцоо зүй тогтол буюу хуулийг эрж хайж нээх явдал байдаг бол алсын зорилго нь нээсэн хуулийг нийгмийн практикт хэрэгжүүлж үр ашгийг нэмэгдүүлэх явдал юм.

Арга билгийн нэгдлийг дараах хоёр жишээнд: Төрийн тамганы бичиг-тэй, Мал, бэлчээрийн ургамлыг улираын ялгавартай идээшилдэг байгалийн зохицолдоо-той холбон хэрэглэх оролдлого хийв.

Төрийн тамганы бичиг

Чингис хааны гутгаар хөвгүүн Өгөөдэй хааны ахмад хөвгүүн Гүюг 1246 онд их хааны сууринд суухад Ромын папаас Монголын их хаанд илгээсэн бичгийн, Хариу бичиг дээр Гүюг хааны тамганы дардас түүхэнд баримт болон үлджээ. Чингис хаанаас хойш Гүюгийг хаан ширээнд суух хүртэлх 18 жилийн хугацаанд Монголчууд хүчирхэг хэвээр байсан тул Төрийн тамга үрэгдэх нөхцөл үгүй учир “Гүюг хааны тамга бол түүний өвөг эцэг Чингис хааны тамга” мөн гэж зарим түүхчид үздэг.¹



Төрийн тамганы бичгийн нэг дэх далд утга

Тамганы 19 үг, үеийг Арга билгийн ухааны нэгдлээр хүснэгт(матриц)-ийн тооллын тогтолцоонд оруулахад зургаан багана, гурван мөр болж хуваагдана.

Босоо зургаан багана нь:

1. **Мөнх тэнгэрийн,**
2. **Хүчин дор Их Монгол,**
3. **Улсын далай,**
4. **Хааны зарлиг ил болгон,**

¹ Эртний сүлдээс эдүүгээгийн соёмбо Улаанбаатар хот, 1996 он, Н.Тогтох

5. Иргэн дор хүрвээс,
6. Биширтүгэй, аюутугай,

Хөндлөн гурван мөр нь:

эхэн мөрөнд 1. Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол Улсын хааны иргэнд биширтүгэй.
дунд мөрөнд 2. Их зарлиг ил.

адаг мөрөнд 3. Тэнгэрийн монгол далайн болгон хүрвээс аюутугай.

гэж тус тус уншигдана. Их монгол улсын төр, Чингис хааны гадаад бодлогын томъёолол юм болов уу.

Ийнхүү хүснэгт (матриц)-ийн тоолол(алгебра, анализ)-ын үйлдлийн зарчмаар багана, мөрийн дарааллаар хослол хувилбарууд үүсгэхэд утга, санаа бүхий 28 өгүүлбэр уншигдах болно.

Төрийн тамганы бичгийн хоёр дахь далд утга

Тамганы бичгийн 19 үг үеийг, 19 үсэг (5 буюу 7 эгшиг, 12 гийгүүлэгч гэгдэх төлөөлөх авианы оноосон үсэг)-гээр бичжээ.

1-р зураг

Дуудлагын үе

ᠠ ᠡ ᠢ ᠣ ᠤ ᠦ

ᠨ ᠨ ᠨ ᠨ ᠨ ᠨ


N	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠦ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ
1	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠦ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ
2	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠦ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ
3	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠦ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ
4	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠦ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ
5	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠦ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ	ᠨ

3-р зураг

Монгол бичгийн дуудлагын задгай үе(на, нэ, но гэх мэт), дуудлагын битүү үе(ан, эн, он)-ийг таван махбод Арга билгийн ухааны нэгдэл бүхий хүснэгтийн тогтолцоонд оруулав.

Авианы хувьслын тогтолцоо(зүй тогтол) ба төлөөлөх авианы оноосон үсэг

үндэстэн ястны үг аялага	Төлөөлөх авиа	Салбарлах авиа
Цагаан: Цагаан (халх), чагаан (цахар), сагаан (буриад), шагаан (мончоого)	Ч	Ц, с, ш
Багтах: багтах (халх), бахта (нутгийн), багатах (харчин) Дараагийн-Дараачийн	Г	Х, Га, Ч
Хатавч: хатавч -хачавч-хацавч т- ч-ц,	Т	Ч, Ц
барзгар- барсгар з-с, дуртгал- дурсгал т-с, хашбу-хасбу ш-с, Сихэр-Чихэр	С Ш	З-Ш-Т С
Мөнхэ-Мөнкэ хар а-кара х-к,	Х	К
дүгүриг-төгүриг ө-ү, д-т	Т ө	Д ү
нот-нут о-у, Унших-Умших н-м	о н	у м
зүрх-жирүх з-ж, ү-и	З ү	Ж и
дүрэм-журам (дүрим -жирум) д-ж, э-и хамар-хабар м-б	Д Ж М Б а э л	Ж Д Б М ? и ?



Ийнхүү авиа зүйн тогтолцоогоор нийт 315 задгай үе, 448 битүү үеэр Төрийн хэл тэмдэглэдэг Монгол бичгийн төлөөлөх авианы оноосон 19 үсгээр Чингис хааны тамганы 19 үг үеийг бичиж мөнхөлсөн(орчин үеийнхээр бол стандартчилсан)-тэй адил төрийн хууль, зарлиг бичигдэж байсан болов уу. Харин тэдгээрийг нутаг нутагт үндэстэн ястнууд төрийн хэлний төлөөлөх авианы оноосон үсгээр бичсэн тул өөр өөрийн аялга бүхий салбар авиагаар нь дуудан уншихад зөрчил гарах ёсгүй ажээ.

Монгол бичиг-ийн авиа зүйн тогтолцоогоор илэрсэн Ян-иг(Ноот)-ийн 7 эгшиг. Йан, Йон, Йун, Йин, Йэн, Йүн,Йөн гэсэн таван битүү үе гарч ирсэн бөгөөд хожим крилл авианы үсэгт Я-гийн төрлийн Я,Ё,Е,Ю үсэг бий болж улмаар Ян, Ён, Ин Ен, Юн гэсэн 5 буюу 7 битүү үе дээрх хүснэгтийн тогтолцоогоор Ян-гэсэн эхний үеийг Я.Цэвэл Монгол бичгийн тайлбар тольд “ая эгшиг” гэж бичсэн бол нэрт хөгжмийн зохиолч Н.Жанцанноров Гүр дууны ая тэмдэглэдэг Монгол хөгжмийн ноот Ян-иг байна гэжээ.

Их Монгол улсын үеэс төрийн бичгийг, олон үндэстэн ястнаас бүрдсэн ард түмнээ нэгэгтгэх хэрэгсэл болгосон.

Энэ нь авианы үет Монгол бичгийн онцлог шинж болов уу.

Ийнхүү Монгол бичиг нь эвэр толгой, араа шүд, нуруу гэдэс, сүүл дуслыг дүрсэлдгийн хувьд **Дүрс бичиг**, үргэлжилсэн на, нэ-тэйн хувьд **Авианы үет бичиг**, а, э-тэйн хувьд салангад **Авианы бичиг** тул хүн төрөлхтний бичгийн соёлын бүх шинжийг агуулдаг ажээ.

Үгийнхээ язгуурыг хадгалдаг бөгөөд хурдан бичилгийн хувилбартай Монгол бичгийг эртний Согд, Уйгараас хуулж аваагүй, өөрсдөө зохиосон гэх үндэслэлүүд бас бий.

Их Монгол Улсын төр, олон үндэстэн ястаны ард түмнээ, төрийн хэл бичиг-ээр нэгэгтгэх бодлого юм болов уу.

Мал, бэлчээрийн байгалийн зохицолдоог тогтолцоонд оруулсан нь

Ж.Самбуу гуай, Мал бэлчээрийн ургамлыг улирлаар ялгаварлан идээшилдэг байгалийн зохицолдоог арга билгийн ухаанаар нэгтгэн **“Ялгаварласан хүснэгт”**-ийн тогтолцоонд оруулж мал, ургамлын харилцан хамаарлын зүй тогтолыг илэрүүлж. 1946 онд “Бор ном”-доо бичсэн байна.

Зураг 2 Ялгаварласан хүснэгт

“Хангай, Хээр, Говийн бүсийн түгээмэл тархацтай, мал сүрэг голчлон идээшилдэг бэлчээрийн 60(38 нь эмийн чанартай)-аад төрөл зүйлийн ургамлыг **Билиг** болгон хүснэгтийн багананд, таван хошуу малаа дөрвөн төрлөөр сүрэглэн **Арга** болгон жилийн дөрвөн улирлыг түрүүч, сүүлчээр нь 45 хоногтой найман мөчлөгт хувааж хүснэгтийн мөрөнд оруулж, тэдгээрийн **Нэгдэл** болох огтолцолын нүдэнд тухайн мөчлөгт мал идээшилдэг ургамлыг (+)ээр тэмдэглэж, үгүйг хоосон үлдээжээ.¹

“Ялгаварласан хүснэгт” нь нийт 1728 нүдтэй бөгөөд ямар мал, ямар ургамал, аль улирлын мөчлөгт идээшилдгийг (+)-ээр тэмдэглэсэн 782 нүд байгаа нь мал бэлчээрийн ургамлын харилцан хамаарлын зүй тогтлыг буюу Мал(арга) бэлчээрийн ургамал(билэг)-ын тухайн улирлын мөчлөг дэх шүтэн барилдлагыг буюу харилцан хамаарлын зүй тогтлыг илрүүлжээ. Харин үлдсэн 946 нүд нь тухайн улирлын мөчлөгт мал идээшилдэггүй ч дараа, дараачийн мөчлөгт идээшилдэг ээлж тохиодог ажээ. Хэрэв тухайн улирлын мөчлөгт тэмдэглээгүй ургамлыг мал идээшилбэл тарга хүч нэмэгдэхгүй хатангиршихаар үл барам, зарим нь хордуулж үхэлд хүргэдэг тохиолдол ч байдаг. Жишээлбэл: Таантах, Борзонтох гэх мэт ургамлын өвчнүүд үүсгэдэг байна.

Малчин хүн хариулга маллагаа илүү шаардагддаг хонин сүргийг аль ч улиралд идээшилдэг хиаг, хазаар, ерхөг, хонин агь, нарийн цагаан өвс зэрэг “махан тарга” авдаг олон наст ургамал болон тухайн улиралд идээшилдэг бусад ургамлын хамт дагуулан, идэшлэдэггүйгээс нь зайлуулан хариулж маллах ёстой ажээ. Ийнхүү ялангуяа хонин сүргийн хариулга маллагааг идээшилдэг ургамалтай тухайн улирлын мөчлөгт нарийн тохируулснаар мах, өөхөн таргаа жигд тэнцвэртэй авч **Үр Ашиг нь** мал сүргийн тарга хүчний өсөлт, бууралтаар хэмжигдэнэ. Арга билгийн ухааны нэгдэл нь Үйлийн үрийн жамаар өөрчлөгдөж хөгждөгийг илэрхийлсэн танин мэдэхүйн томьёолол нь:

Арга+ Билиг = Нэгдэл(Үйлийн)→Үр – ашиг ().

¹ Мал аж ахуйдаа яаж ажиллах тухай ардад өгөх сануулга сургаал
Улаанбаатар хот, 1946 он, Ж.Самбуу

Энэ томьёололд **Арга, Билиг** хоёр эсрэг тэсрэг чанартай харилцан хамааралтай үйлийн **Нэгдэл** тул, Үйл хийвэл **Үр** гардаг нь зайлшгүйг сум(→)-тай холбоосоор тэмдэглэсэн бол харин **Ашиг**-тай байх эсэх нь нөхцөл байдлаас хамаарах тул санамсаргүйг (-) зураасан холбоосоор тэмдэглэв.

Ж.Самбуу гуай, Мал аж ахуй дээрээ яаж ажиллах тухай ардад өгөх сануулга сургаал, 1945 оны "Бор ном": Өвөг дээдсээс уламжлан олон мянган жилийн тэртээгээс Мал, бэлчээрийн байгалийн зохицолдоог **малаар дамжуулан улирлын ялгавартай идээшилдэг ургамлуудыг ажиглан тогтоож** тэр дагуу малын хариулга маллагааг зун намрын улиралд тарга хүч авхуулдаг, өвөл хаврын улиралд тарга хүчний алдагдлыг хадлан тэжээлээр нөхөж тогтворжуулдаг уламжлалт арга туршлага дээр үндэслэн бичсэн нь олон дахин хэвлэгдсэн бөгөөд өнөөдөр ч малчдын **гарын авлага-өврийн ном болсоор байна.**

Мөн түүнчлэн "Бор ном"-д нэг гайхамшигтай зүйл нь мал, бэлчээрийн ургамлыг улирлын ялгавартай идээшилдэг байгалийн зохицолдоог Арга билгийн ухаанаар **"Ялгаварласан хүснэгт"-ийн тогтолцоонд оруулж** мал, бэлчээрийн ургамлыг улирлын мөчлөгөөр ялгаварлан идээшилдэг мал бэлчээрийн харилцан хамаарлын зүй тогтлыг илэрүүлсэн явдал юм. Энэ зүй тогтлыг ашиглан **идээшилдэг ургамалаар нь дамжуулан** малын мах, сүү цагаан идээний найрлагыг тогтоож, хүнсэндээ хэрэглэсэн хүний биед үзүүлэх эмт болон шимт чанарыг тоон үзүүлэлтээр нарийвчлан тодорхойлох бодит боломж манай улсад одоо л бүрдээд байна.

ШУТИС-ийн Хүнс-биотехнологийн сургуулийн эрдэмтэн багш нар **"Бэлчээрийн малын махны сувилахуй чанар"**. 2005-2006 он **"Бэлчээрийн малын махны үнэт чанар"**. 2007-2008 онуудад шинжлэх ухаан технологийн төслийг, **тарга хүч гүйцсэн** намрын **малын** махны найрлагад 16 эрдэс бодис болон амин дэмүүд агуулагддгийг суурь судалгааны түвшинд шинжлэн тогтоож, Монголын бэлчээрийн малын махыг **ЭКОЛОГИЙН ЦЭВЭР, ЭРҮҮЛ МЭНДИЙН, ОРГАНИК ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН** болохыг тогтоосон байна.¹

Орчин үед **бэлчээрийн ургамлаар дамжуулан** малын махны хүний биед үзүүлэх эмт болон шимт чанарыг шинжлэн тоон үзүүлэлтээр тодорхойлж **"Ялгаварласан хүснэгт"-ийн** тогтолцоонд дахь мал, бэлчээрийн ургамал идээшилдгийг (+)-ээр тэмдэглэсний оронд орлуулан тавьснаар **Ж.Самбуу гуайн "Ялгаварлах хүснэгт", Оросын нэрт эрдэмтэн Д.Менделеевийн химийн элементийн "Үелэх хүснэгт"-ийн тогтолцоотой ижил болно.**

Энэ нь Монголын бэлчээрийн малын мах зөвхөн хүнсний зүйл төдийгүй эм, эмчилгээний чанартай болох нь дэлхийд хүлээн зөвшөөрөгдөхөд дөхөм болох бөгөөд, олон улсын зах зээл дээр шинэ эрэлт хэрэгцээ үүсгэж мах өндөр үнэд хүрэх нөхцөл бүрдэнэ. **Тухайлбал:** Ямааны махнаас, Монгол ямааны мах, тэр дундаа яргуй идсэн ямааны мах, Хонины махнаас таана идсэн хонины мах эмчилгээний чанараар илүү байж таарна.

Энэ бүхнийг үндэслэн Монгол улс үндсэн хуулинд, үндэсний баялгаар тунхаглагдсан иргэний туурвисан оюуны үнэт зүйлс болон бэлчээрийн мал сүргийнхээ бүтээгдэхүүнд тулгуурлан хөгжих өргөн боломж нээгдэх ирээдүй улам ойртож байна. Үүний тулд Төрийн чиглэсэн зорилготой бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй юм.


Арга билгийн ухааны танин мэдэхүйн томьёолол болон эргэх холбооны өдөөлтөөр хариу үйлдэл хийх ороомог замнал

Хөдөлмөр, хүний өвөг сармагчны урд хоёр мөчийг гар болгосонтой адил, тархийг нь сэтгэдэг оюун ухаантай болгосон. Гар тархи хоёр үйлийн нэгдэлтэй ажээ.

Хүн өнөөдрөөр амьдардаг учраас ихэвчлэн сэрэх, хүртэх, сэтгэх хүрээнд анхаарал төвлөрүүлж тусгалд орсон оюун ухааны танин мэдэхүйн зам буюу "Ухамсарт оюун ухаан(IQ)-ы томьёолол **Арга + билиг = Нэгдэл** буюу **Үйл → Үр → ашиг-Хөгжил**_{1.2.3...n}

Ухамсраас ангид Эргэх холбооны өдөөлтөөр хариу үйлдэл хийх замаар нөхцөл байдлыг сайжруулах хэрэгцээг Сэтгэл хөдлөлийн оюун санаа(EQ)-ны буюу мэдрэмжийн хүрээнд тухайн хөгжлийн өмнөх хүрсэн түвшинд эргэн очиход, хөгжлийн түрүүчийн хүрсэн түвшин өсөн нэмэгддгийг доор дүрслэн үзүүлэхийг оролдов.

¹ "Бэлчээрийн малын махны сувилахуй чанар", "Бэлчээрийн малын махны үнэт чанар", 2005-2006 он, ШУТИС-ийн төслийн тайлан



Эргэх холбооны өдөөлтөөр хийх хариу үйлдлээр хөгжих ороомог замнал

Арга билгийн ухааны нэгдэлд аналитик геометр, барагдашгүй бага хэмжигдэхүүний анализыг хэрэглэх нь К.Маркс: Аливаа шинжлэх ухаан математикийг хэрэглэсэн цагт сая төгс

боловсронгүй болж чадна. Үүгээр Ф.Гегелийн гурвалаар төгс төгөлдөрт хүрэхийг үгүйсгэсэн.

Хэрэв Р.Декартын координатын систем дэх материал цэг(ертөнцийг төлөөлсөн)-т хүчний вектор $\mathbf{F}$, $\mathbf{F}$ үйлчилж байвал тэдгээрийн

! 2

үйлчилгээний нийлбэр вектор $\mathbf{F}$. $\mathbf{F} = \mathbf{F} + \mathbf{F}$

! 2

тэнцэнэ : $\mathbf{Арга} - \mathbf{F} + \mathbf{Билиг} - \mathbf{F} = \mathbf{Нэгдэл} - \mathbf{F}$

! 2

Арга, билгийн нэгдлийн томъёолол бол материал цэг О-д үйлчлэх хүч, түүнээс үүсэх чиглэлт Векторуудын нийлбэр $\mathbf{F}$ -ийн үйлчлэлийг буюу шүтэн барилдлагыг орон зайд барагдашгүй бага хэмжигдэхүүнээр илэрхийлбэл:

$$\mathbf{F} = \frac{\partial f}{\partial x} dx. \quad \mathbf{F} = \frac{\partial f}{\partial y} dy, \quad \mathbf{F} = \frac{\partial f}{\partial x} dx + \frac{\partial f}{\partial y} dy.$$

Ийнхүү эрт, эдүгээгийн Монгол төрийн сүлдэнд Арга билгийн ухааныг билгэдэн дээдэлсээр ирснийг Математикийн барагдашгүй бага хэмжигдэхүүний анализ хэрэглэхэд улам боловсронгүй болно.

ЭВ ЗҮЙГЭЭР ЗЭРЭГЦЭН ОРШИХТОЙ ХОЛБОГДОЖ БОЛОХ ШАШНЫ ЭКСКЛЮЗИВИЗМ, ИНКЛЮЗИВИЗМ, ПЛЮРАЛИЗМ, РЕЛЯТИВИЗМ ҮЗЭЛ САНААНУУДЫН ТУХАЙ

О.МӨНГӨНСОР

*СЭЗИС, МУИС гэрээт багш
Философийн магистр*

Хураангуй: Эдүгээ цагт дэлхий ертөнцөд өрнөж буй дайн дажин, зэвсэгт мөргөлдөөн, иргэний дайн, цэргийн үйл ажиллагаа нь дан ганц улс төр, эдийн засаг, геополитикийн асуудлаас үүдэлтэй байхаас гадна шашны сэдэлтэй буюу шашны ялгаат байдлыг хүлээн зөвшөөрч чадаагүйн улмаас үл ойлголцон зөрчилдөх, шашнаар ялгаварлан гадуурхах, шашин шүтлэгээс нь үүдэн хоморголон устгах зэрэг байдлаар илэрч байна. Шашнаас үүтгэлтэй дайн дажин дэлхийн түүхэнд олонтаа тохиолдсон агаад харьцангуй соёлжиж, гэгээрч, иргэншсэн гэх орчин цагт ч энэ байдал нэг мөр арилаагүй бололтой. Хүний ертөнцийг үзэх үзэлд томоохон байр суурь эзлэх шашны итгэл үнэмшил нь тухайн хүн өөрийнхөөсөө өөр шашин шүтлэгтэй хүнд хэрхэн хандахыг тодорхойлох боломжтой. Нэг шашин үнэн гэж үзэн бусад шашныг буруу, худал хуурмаг гэдэг нь шашны эксклюзивист чиглэл болно. Нэг шашин үнэн байж болох ч бусад шашинд үнэн, үнэний хэсэг бий гэж үзэх нь шашны инклюзивист хандлага юм. Нэжгээд шашин буюу бүх шашны итгэл үнэмшил үнэнийг агуулдаг, үнэн зөв ба бүгд Бурханыг өөр өөрийн аргаар танин мэддэг, илэрхийлдэг гэж үздэг нь шашны плюралист үзэл аж. Бүх шашныг “үнэн” гэж үзэж болох бөгөөд тэрхүү шашнууд итгэн дагагч бүрдээ үр өгөөжтэй байдаг тул аль нэг шашныг үнэн гэх, шашны үнэнийг тогтоох боломжгүй гэж үзэх нь шашны релятивист үзэл билээ. Энэхүү өгүүлэлд өөрийн итгэдэг шашныг цор ганц үнэн хэмээн үзэж бусдыг буруу хэмээх нь хүчирхийлэл, гадуурхалт, мөргөлдөөн зэрэгт хүргэж болно гэж авч үзэх агаад хүн тодорхой нэг итгэл үнэмшлийг үнэн гэж үздэг байж болох боловч бусад шашинд, бусад шашны сүсэгтнүүдэд шашны инклюзивист, шашны плюралист байдлаар хандваас хүн зон энх тунх оршин амьдарч болно хэмээн санал болгож буй.

Түлхүүр үгс: олон янз байдал, зохицол, нэг үнэн, нэжгээд үнэн.

Шашин хоорондын эв зохиролт байдал (**religious harmony**) нь бусад шашны уламжлалыг ойлгосноор, шашин бүрд төрөлхийн өгөгдмөл буй сайн үнэлэмжийг хүлээн зөвшөөрснөөр бий болох боломжтой. Шашин шүтлэгийн ялгаатай байдлаас үл хамааран хоорондоо эвтэй найртай, бие биетэйгээ зохицон, бусадтай зохиролдон амьдрахад нэг нэгнээ хүлцэн тэвчих шаардлагатай болно. Шашны хүлцэл тэвчил (**religious tolerance**) хэмээх ойлголт шашны ялгаанаас үл хамааран хүмүүн төрөлхтөн сайн сайхан нийгмийг бүтээж, эв зохицолдлоготойгоор амьдарч болно гэсэн найдвадыг төрүүлдэг. Хэрвээ дэлхий дахины шашнуудыг практик байдлаар нь үнэлж цэгнэх шаардлагатай болох аваас тодорхой шашны итгэгчид бусад шашныг хэр тэвчдэг, хүлцдэг, нөгөөтээгүүр бусад шашныг хэр үл тэвчдэг, үл хүлцдэг тухай тодорхойлох нь үнэлэмжийн томоохон хэмжүүр болох байх. Бусад шашнууд, нэг шашны бусад урсгал, чиглэл, бүлгүүдтэй хоршин амьдран суухын хэрээр сургаал номлол, соёл, практик үйлийн ялгаат байдлаас үүдэн зөрчил сөргөлдөөн нэмэгдэх магадлалтай. Хүлцэл, үл хүлцэл гэх үгсийг ямар утгаар хэрэглэх нь ихээхэн чухаг бололтой. Хүлцэл (**tolerance**) гэдэг үгийг “бүх шашин эн тэнцүүхэн үнэн гэж хүлээн зөвшөөрөх” утгаар хэрэглэж байгаа эсвэл “бусад шашны итгэл үнэмшил, практик ёс горимыг ойлгож мэдэх, хүндлэх” гэдэг утгаар ашиглах хоёр хоорондоо ялгаатай аж. Үл хүлцэл (**intolerance**) гэдгээр бүх шашнууд нэг нэгэнтэйгээ ижилхэн үнэн гэж хүлээн зөвшөөрөхгүй гэсэн утга санаагаар хэрэглэж байгаа тохиолдолд энэ нь мөн бусад шашны итгэл үнэмшил, практик ёс горимыг ойлгож мэдээгүй, хүндэлдэггүй гэдэг утгаар үл хүлцэл гэх үгийг хэрэглэж байгаагаас өөр байх аж (Chad Meister, 41). Ихэнх хүн арьс өнгөөр ялгаварлах, мухар сохроор шашныг шүтэх, геноцид үйлдэх, хүүхдийн хүчирхийлэл зэргийг хүлцэн тэвчдэггүй бөгөөд энэ бол муу муухайг үл хүлцэн тэвчих хүний ёс суртахууны үүрэг хариуцлагын шинжтэй ажээ. Гэтэл зарим тохиолдолд шашин нь арьс өнгөөр ялгаварлахыг,

муйхарлан хэнээтэн шүтэхийг, зарим үндэстэн, угсаатныг зэрлэг бүдүүлэг гэж үзэн аймаглан устгах, бусад шашныг буруу номын гэж зарлах, бусдын эсрэг үйлдэх хүчирхийлэл хэрцгийллийг ариун үүрэг гэж үзэх зэргээр шашны үл тэвчил хүлцлийг зөвтгөх нь бий. Шашны текстүүдэд хэрцгийлэл, хүчирхийллийг зөвтгөх агуулгатай шүлгүүд байдаг. Нэгэн судлаач ямарваа нэгэн юмыг хүлцэх, тэвчих гэдэг бол тийм ч хүсмээр, таатай зүйл биш бөгөөд тодорхой зорилгод хүрэхийн төлөөнөө хийж буй үйлдэл гэлтэй хэмээгээд шашны итгэл үнэмшлүүдийг оюун санааны түвшинд хүлцэн тэвчих нь нийгмийн энх тунхыг, нийгмийн зохирлыг бий болгодог уу эсвэл эсрэгээр нь байдаг уу хэмээн асуужээ (Mehdi Aminrazavi, 279-280). Хүлцэл тэвчил хэмээх үгнээс илүүтэйгээр өөрийнхөөсөө өөр бодол санаа, харах өнцөг, итгэл үнэмшлийн тухайд хүндэтгэлтэйгээр, нээлттэйгээр харилцах явдал болох оюун санааны түвшний хүлцэл тэвчлийн (**intellectual tolerance**) тухай дурдахгүй байхын аргагүй. Энэ нь юмсын тухай алтернатив хувилбарыг харан, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэн, өөрийнхөө үзэл бодлыг ч шалган хэрвээ алдаа мадаг байх аваас засаж сайжруулах боломжийг олгох агаад ингэснээр хүний хувийн өсөлт хөгжлийг дэмжиж, шинэ санаачлагыг бий болгож, нийгэмд зохицон амьдрахыг сургана. Орчин цагт иргэншиж нийгэмшсэн байх, оноогдсон үүрэг хариуцлагаа биелүүлэх гэх мэт үгс хүлцэл тэвчил хэмээх үгтэй ойролцоо утгыг илэрхийлэн хүний сайн сайхан үйлийн нэг болжээ. Хүн чанартай байх, хүний мөстэй байх, хүнлэг энэрэнгүй байх зэрэг нь хүлцэж тэвчихүйн тухай хүүрнэлүүдтэй холбогдоно.

Шашны философийн сэдвүүд болох шашны эксклюзивизм, шашны инклюзивизм, шашны плюрализм, шашны релятивизмийн байр суурийг тодорхойлсноор энэхүү чиглэлүүд хүн төрөлхтөн хоорондоо эв эсийг эрхэмлэх ухаанд ямар хувь нэмэр оруулж болохыг харж болно. Урьд бид шашин хоорондын (**inter-religion**) ялгааг онцлох хандлагатай байсан бол эдүгээ цагт нэг шашин доторх урсгал хоорондын (**intra-religion**) ялгааг ч чухалчлах шаардлагатай болжээ (David Basinger, Peter Byrne, 244). Шашны эксклюзивизм (**religious exclusivism**) нь дэлхийн нэг шашин үнэн зөв ба бусад бүх шашин ямар нэг байдлаар алдаа дутагдалтай учир зөвхөн тухайн зөв шашнаар дамжуулж авралд хүрнэ хэмээн үзнэ. Шашны инклюзивизм нь (**religious inclusivism**) дэлхийн нэг шашин үнэн боловч бусад шашнууд тухайн үнэн зөв шашны үнэнийг тодорхой хэмжээгээр илэрхийлдэг тул тэрхүү өөр шашнуудын сургаал номлолоор дамжуулан авралд хүрэх боломжтой хэмээдэг. Хүмүүс нэг шашныг цор ганц үнэн зөв хэмээвч тухайн шашны яг аль урсгал, чиглэл нь үнэн гэдэг талаар хоорондоо маргалддаг. Бүх шашин цаг хугацааны явцад олон урсгал, чиглэлд хуваагдан задарчээ. Шашны плюрализм (**religious pluralism**) бол бүх шашнууд эцсийн дүндээ үнэн зөв ба шашин бүр үнэнд хүрэх, аврагдах өөр өөр замналыг санал болгож, Бурханы тухай тодорхой нэг харах өнцгийг хүмүүст өгдөг гэж үздэг. Шашны плюрализм нь шашны туршлага (**religious experience**) хэмээх ойлголттой холбогдох бөгөөд шашин тус бүрийн итгэгчид өөрсдийн гэсэн өвөрмөц онцлог бүхий шашинлаг, сүнслэг мэдрэмж, зүүд, үзэгдэл, гайхамшиг, тохиолдол, дуудлага, дуу хоолой, илчлэлт, аз, илэрхийлэлт зэргээс үүдэн шашинд итгэсэн, шашны итгэл үнэмшил нь бэхжсэн байх тохиолдлууд бий. Иймд аливаа нэг шашинтай холбогдох шашны туршлагыг тооцон үзвээс плюралист байдлаар харах нь илүүд зүйд нийцэж байх магадлалтай (John H. Hick, 710-712). Шашны релятивизм (**religious relativism**) бол шашин бүрийн сургаал номлолыг “үнэн” хэмээн үзэж болох бөгөөд тухайн шашин нь сүсэгтэн хүмүүсийнхээ амьдралд үр өгөөжтэй байдаг, аль нэг шашныг бусдаас илүү үнэн, зөв гэж үзэх цэвэр объектив шалгуур, хэмжүүр үгүй, шашны үнэн нь харьцангуй шинжтэй гэж үздэг байна. Шашны талаарх энэхүү дөрвөн ялгаатай үзлийг харьцуулан үзвэл ямар нэг шашны итгэл үнэмшилтэй хүн шашны эксклюзивист эсвэл шашны инклюзивист чиглэлийн аль нэгэнд нь харьяалагдах бол шашныг объектив байдлаар судалдаг хүн судлаачийн байр суурины үүднээс шашны плюрализм болон шашны релятивизм чиглэлийг баримталдаг байх магадлалтай болов уу. Шашин шүтлэгтэй хувь хүн мэдээж шашны плюралист, релятивист үзлийг дэмждэг байж болох юм.

Шашны олон янз байдалтай (**religious diversity**) холбоотой авч үзэх үзэл санаануудаас шашны эксклюзивизм, шашны инклюзивизм нь эсрэгцэх мэт үзэл санаанууд болно. Ямарваа нэгэн шашны итгэгчдээс олонх нь өөрийн шашиндаа шашны эксклюзивист, шашны инклюзивист байдлаар хандах явдал түгээмэл бөгөөд энэхүү хоёр үзэл ямар нэг шашин үнэн, Бурхан бий, аврал, чөлөөлөлт бий гэж үздэгээрээ, бусад шашны сургаал номлолоос өөрсдийнх

нь шашны үндсэн итгэл бишрэл бол илүү үнэн, үнэн мөнд илүү ойрхон гэж үздэгээрээ адил төстэй. Шашнууд хоорондоо таарч тохирохгүй, зохицохгүй (**incompatible**) сургаал номлолтой байдаг гэдэг бодит үнэнийг чухалчилдаг нь энэхүү хоёр үзлийн бас нэгэн ижил төст байдлыг харуулж байна. Шашны эксклюзивизм, шашны инклюзивизмийн хоорондоо төсөөгүй шинж нь тухайн үнэн зөв гэж үзэж буй шашнаасаа өөр бусад шашинд хэрхэн хандаж буйгаараа ялгарч байна. Эксклюзивист үзэлтний хувьд үнэн нэг л шашинд бий хэмээн үзэж аврал, чөлөөлөлт (**salvation/liberation**) тухайн шашны арга замаар ирэх ёстой ажээ. Тухайн шашныг цорын ганц үнэн хэмээн үздэг хүн яагаад ингэж үзэж буй үндэслэлээ сайтар дэвшүүлж чадахгүй байх, яагаад ёс суртахууны хувьд буруу зүйл хийсэн гэдгээ зөвтгөх тайлбарлал хангалттай хэлж чадахгүй байх тохиолдлууд бий бөгөөд бусад шашныг ямар нэг байдлаар алдаатай, буруу гэж үзэн шашны талаарх энэхүү эксклюзивист хандлагатай байсаар байж болох аж (Elizabeth Burns, 157). Инклюзивист үзэлтний хувьд нэг шашныг бусдаас илүү хэмээн үзэх боловч бусад шашнууд ч нэн чухал үнэний зарчмуудыг агуулдаг тул шашин номын үнэн мөнгийг эрхэмлэн хайгч хэн ч гэсэн шашны итгэл үнэмшлээсээ үл хамааран эцсийн үр дүндээ аврал, чөлөөлөлтөд хүрэх боломжтой гэдэг (Chad Meister, 41). Шашинд хандах хандлагаараа шашны плюрализм, шашны релятивизм нь хоорондоо ихэд төстэй мэт харагдаж болох ч зарим талаар ялгаатай байна. Шашны плюралист байр сууринаас харвал шашнуудын сургаал номлолд аврал, чөлөөлөлтөд хүрэх олон янзын арга зам байгаа харагдана. Харааны бэрхшээлтэй хүмүүс зааныг танин мэдэхдээ сүүл, соёо, хөл, их биеийг нь тэмтэрч үзээд өөр өөрөөр тодорхойлдог эрт цагийн энэтхэгийн сургаалт үлгэр шиг (**The Blind Men and the Elephant**) шашин бүр тус тусын арга замаар дээдийн ахуйд, ертөнцөөс чинагшид, Бурханд хүрэх арга замыг тайлбарлана. Шашны релятивист байр суурь нь шашны плюралист хандлагаас гарч ирсэн олон янз байдал, ялгаат байдалтай холбогдон бий болох бөгөөд ямар нэгэн шашны үнэн зөв гэдэг бол тухайн шашныг даган бишрэгч хамт олон, бүлгийн ертөнцийг үзэх үзэлтэй холбоотой, хамааралт шинжтэй, харьцангуй шинжтэй гэдэг.

Орчин цагт олон янзын шашны номлол сургаалыг ойлгож ухаарах, утгыг тайлж тайлбарлах нь нэн чухал агаад шашнуудын сургаал номлол хоорондоо төстэй байхаас гадна нэг нэгэнтэйгээ зөрчилдөж эсрэгцдэг гэдэг бодит баримтыг орхигдуулж болохгүй. Аврал судлал (**soteriology**) нь дэлхийн шашнууд хүн хэрхэн аврагдах тухай ямар сургаал номлолтой вэ гэдгийг судална. Аврагдахын тулд шашны итгэгч хүн энэ амьдралдаа юу хийх, ямар сургаал дагах, ямар зан үйл үйлдэж байх, биеэ хэрхэн авч явах, бусдад хэрхэн хандах, шашныхаа төлөө юу хийх, бусад шашинтнуудад хэрхэн хандах, дайн байлдааны цаг үед хэрхэн үйлдэх гэх мэт асуудлууд урган гарна. Жон Хик “Дэлхийн аугаа шашнууд гэдэг бол авралын арга замууд” (**ways of salvation**) хэмээжээ (John J. Hick, 2010, 294). Өөр өөр шашныг итгэн дагагч хүмүүс нь ертөнцийн эхлэл, Бурханы мөн чанар, үхлийн дараах хүмүүний хувь заяа гэх мэтчилэн гол асуудлууд дээр ялгаатай байр суурь баримтлан ойлголцох үедээ ойлголцож, заримдаа хоорондоо зөрчилддөг. Шашны олон янз байдлаас бий болсон ээдрээтэй асуудлууд нь ялгаатай шашны итгэл үнэмшилд харьяалагдах хүмүүсийн зөрчлөөс урган гарч ирж буй (Victoria S. Harrison, 258). Шашин хоорондын ойлголцлоос гадна тухайн нэг шашны олон төрлийн урсгал, хөдөлгөөн, секц (**denomination, movement, sect**) хоорондоо ойлголцох, нэг нэгнээ хүлцэн тэвчих асуудал мөн чухал байна. Хоорондоо таарч тохирохгүй шашны сургаал ихэнхдээ сүсэгтэн олны дунд адармаатай нөхцөл байдал үүсгэж, зөрчил мөргөлдөөнд хүргэж, энх тайвныг эвдэж сүйтгэх бүрэн бололцоотой юм. Шашны хүчирхийллийн тухайд судлаач “Хүний хүчирхийллийн шинжтэй үйлдлийг анхаарч үзвээс шашнаас эх үүтгэлээ авсан зэрлэг балмад авир үйлдэл хийх олон арга зам, хүчирхийллийн агуулгатай олон төрлийн үзэгдэл бий” гэжээ (Daniel J. McKaughan, 289). Шашны нэрийн дор болдог зөрчил сөргөлдөөн олон янз байдлаар илрэх нь 1) соёл иргэншлийн хүрээнд шашны дайн хийж үүнийгээ ариун хэмээн нэрийдэх, дайн хийх зөвтгөлөө өөрсдийн сургаал номлолоор тайлбарлах 2) нийгэм, улс орны хүрээнд гадуурхаж буй шашныхаа хүмүүст иргэний хувьд амьдрахад нь зохион байгуулалттайгаар ядуу зүдүү байдалд байлгах, ажил хөдөлмөр эрхлэх болон боловсрол эзэмших боломж олгохгүй байх, бусдаас тусгаарлан хөгжил дэвшлийн олон амжилтаас хол байлгах, геноцид үйлдэх 3) хувь хүний хүрээнд өөрийнхөөсөө өөр шашинд итгэгчдийн эсрэг үйлдлүүд болох үг хэлээр

доромжлох, ад шоо үзэх, эд хөрөнгийн эвдрэл сүйтгэл учруулах, эрүүл мэнд, ам насанд нь халдах зэргээр илэрч болно хэмээн мэтгэлээ.

Дүгнэлт: Шашин нь хүний амьдралын өдөр тутмын үйлдэлд чухал нөлөөтэй хэвээр байгаа бөгөөд ертөнцийг үзэх үзэл төлөвших, бусдыг үзэх хандлагыг хэлбэршүүлэхэд гол хүчин зүйл байсаар байна. Нэг шашныг үнэн гээд үүний сургаал номлол туйлын зөв мэтээр үзэх хандлага хүмүүсийн дунд байдаг нь яваандаа шашны хүлцэл тэвчлийг үгүй хийж, шашны нэрийн дор үйлдэх түрэмгийлэл, хүчирхийллийг өдөөх бололцоотой. Харин нэг шашныг үнэн гэж хүлээн зөвшөөрч байгаа боловч бусад шашны сургаалууд үнэнийг агуулдаг, тэдгээр шашнаар дамжин авралд хүрч болно гэж үздэг хэсэг нь бусадтай эв хамтаар зохицон амьдрах боломжийг илүү бүрдүүлэх боломжтой байна. Мэдлэг, танин мэдэхүй, ёс зүйн илүү өндөр түвшинд хүрсэн, илүү өргөн хүрээний үзэл бол шашны плюрализм болон шашны релятивизм байгаа нь илт ажиглагдаж байна. Бүх шашнууд адилхан үнэн мөнийг агуулдаг, бүгдээр итгэгч нарынхаа амьдрал, зан дадалд үр дүнтэй байдаг гэж үзэж буй плюралист хандлага нь олон туйлт, ялгаат, ондоо шашны ертөнцүүд нэгэн дэлхийд ойлголцон орших боломжийг бүрдүүлж өгнө. Аль ч шашныг бусдаас илүүд үзэх, ганц үнэн шашин хэмээн үзэх шалгуур байхгүй, шашны үнэн нь тухайн шашны бүлгүүдэд хамааралтай гэж үздэгээрээ релятивист хандлага олон төрлийн шашинтай, ертөнцийг үзэх ялгаатай үзэлтэй хүмүүс хамтаар эв нэгдэлтэй оршин суух боломжийг түлхүү бүрдүүлж өгөх давуу чанартай байгаа нь харагдаж байна. Ийн шашны сүсэгтнүүдэд шашинд хандах эксклюзивист, инклюзивист, плюралист, релятивист үзлийн талаар тайлбарлан таниулах нь олон шашны практикт итгэдэг нэг үндэстэн улс орон дотроо эв зүйгээр зэрэгцэн орших боломж олгож, янз бүр шашинтай олон үндэстнээс бүрдэх улсын дотор эв нэгдэлтэй хамтран орших бололцоог бүрдүүлж, мөн олон янзын соёл, шашин, хэл, ертөнцийг үзэх үзэлтэй хүн төрөлхтөн эв зүйгээр зэрэгцэн орших боломжийг бий болгож болох юм. Бусад шашныг ойлгосноор, бусад шашинд ч үнэн зөв зүйл, сайн эрхэмлэл, дээд үнэлэмж байдаг зэргийг хүлээн зөвшөөрснөөр шашны нэр барин үйлдэх гэмт хэрэг, хүчирхийлэл, хэлмэгдүүлэлт, геноцид, дайн зэргээс сэргийлж эв зүйгээр зэрэгцэн оршиж чадах буй за.

НОМ ЗҮЙ

1. Aminrazavi, M. (2015). Religious tolerance. In Oppy, G. (Ed.), *The Routledge Handbook of Contemporary Philosophy of Religion*. (pp. 279-288). New York, USA: Routledge.
2. Basinger, D. Peter, B. (2020). Is it reasonable to Believe That Only One Religion is True?. In Peterson, M. L., VanArragon, R.J. (Eds.), *Contemporary Debates in Philosophy of Religion*. New Jersey, USA: Blackwell.
3. Burns, E. (2018). What is This Thing Called Philosophy of Religion?. New York, USA: Routledge.
4. Cottingham, J. (2014). *Philosophy of Religion*. New York, USA: Cambridge University Press.
5. Evans, C. S. Manis, R. Z. (2009). *Philosophy of Religion*. Illinois, USA: IVP Academic.
6. Harrison, V. S. (2015). Religious pluralism. In Oppy, G. (Ed.), *The Routledge Handbook of Contemporary Philosophy of Religion*. (pp. 257-269). New York, USA: Routledge.
7. Hick, J. (2010). Religious Pluralism. In C. Taliaferro, P. Draper, P.L. Quinn (Eds.), *A Companion to Philosophy of Religion*. (pp. 710-717). MA, USA: Wiley-Blackwell.
8. Hick, J. (2009). Religious Pluralism and Salvation. In C. Cahn S.M. (Ed.), *Exploring Philosophy of Religion*. (pp. 292-304). New York, USA: Oxford University Press.
9. Meister, C (2009). *Introducing Philosophy of Religion*. New York, USA: Routledge.
10. McKaughan, D. J. (2015). Religious violence. In Oppy, G. (Ed.), *The Routledge Handbook of Contemporary Philosophy of Religion*. (pp. 288-301). New York, USA: Routledge.

ХҮНИЙ ОРШИХУЙН ГОЛ МӨН ЧАНАР НЬ ЭНХ ТАЙВАН БОЛОХ ТУХАЙ АСУУДАЛ

Б.ЦЭРЭНХАНД

Доктор (Ph.D)

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, ШУТИС-ийн харьяа,
Ш.Отгонбилэгийн нэрэмжит “Эрдэнэт
цогцолбор” дээд сургууль

Хураангуй: Энх тайвны өдөр нь дэлхий дахинд дайсагнал, хүчирхийлэл, дайн бус харин эв нэгдэл, хүн хоорондын харилцан ойлголцол, хамтын ажиллагааг дэмжих зорилготой өдөр юм. НҮБ энэ өдрийг тогтоохдоо улс орнуудыг зөвхөн төрийн түвшинд төдийгүй иргэдийн түвшинд ч энх тайвныг эрхэмлэж, дайнгүй ертөнцийн үнэ цэнийг ухамсарлуулъя гэж зорьсон бөгөөд 1981 оны 11-р сарын 30 НҮБ-ын Ерөнхий Ассамблей (36/67 дугаар тогтоол) гаргаж, “НҮБ-ын Ерөнхий Ассамблей жил бүрийн есдүгээр сарын гурав дахь Мягмар гарагийг Олон улсын энх тайвны өдөр болгон зарлаж байна” гэж тунхагласан. Энэ нь хамгийн эхний албан ёсны тогтоол юм. Харин дараа нь 2001 оны 9-р сарын 7 НҮБ-ын Ерөнхий Ассамблей дахин тогтоол(55/282) баталж, өмнөх шийдвэрийг шинэчлэн, энх тайвны өдрийг жил бүрийн 9-р сарын 21-нд тэмдэглэхээр тогтсон бөгөөд энэ өдрийг дэлхийн хэмжээнд хүчирхийлэл, зэвсэгт мөргөлдөөнөөс бүрэн татгалзах, гал зогсоох өдөр гэж тунхаглагдсан. Энэхүү өдрийн тэмдэглэхийн практик ач холбогдол нь улс орнуудын хооронд эв найрамдлыг уриалах; иргэдийн дунд энх тайвны соёлыг түгээх, сурталчлах; хүүхэд, залуусыг дайсагнал бус харилцан ойлголцолд сургах; дайнд нэрвэгдсэн бүс нутагт түр зуурын ч болов гал зогсоох, хүмүүнлэгийн тусламж хүргэх боломжийг бүрдүүлэх ач холбогдол бүхий үнэ цэнтэй өдөр юм. Манай улс НҮБ-ын Монгол дахь Суурин зохицуулагчийн газар, шашны болон олон улсын хүмүүнлэгийн байгууллагын төлөөллүүдтэй хамтран 2001 оноос хойш энэ өдрийг тэмдэглэдэг уламжлал тогтсон.

Түлхүүр үг: Гуманизм. Зөрчилдөөнийг хувиргах. Эе эв.

Оршил: Хүн төрөлхтний түүхийн ямар ч үеийг авч үзсэн хүчирхийлэлгүй байсан үеийг олоход үнэхээр бэрх. Хүчирхийлэл, зөрчилдөөн, мөргөлдөөнийг хүн төрөлхтөн даван туулж, түүнийг нийгмийн хүрээнээс алга болгох арга замыг олон судлаачид эрэн хайж байна. Философийн түүх сөхвөл энх тайвны тухай философийн үзэл санаа эртний Грекийн сэтгэгчдээс эхлэлтэй байдаг. Учир юу гэвээс энх тайван бол хүн төрөлхтний оршихуйн суурь зорилго бөгөөд философийн бүхий л хүрээний чухал асуудлын нэг байсаар ирсэн байх ч болох сэдэв юм. Энх тайван нь зөвхөн дайн, хүчирхийлэлгүй байх төлөв байдлыг илэрхийлэхээс гадна хүмүүнлэг ёс суртахуун, хамтын оршихуйн үндсэн зарчим болдог.

Философи, ёс зүйн онол болон орчин үеийн энх тайвны онолуудыг харьцуулан судалснаар энх тайван бол зөвхөн дайн үгүй байх төр улсын асуудал бус, харин хувь хүний дотоод эв нэгдэл, нийгмийн шударга ёс, үүрэг, соёлын интеграцийн цогц ойлголт болохыг энэхүү судалгаа илрүүлэв. Энэ асуудлыг зөвхөн улс төр, дипломат харилцааны асуудлаар хязгаарлах бус, философи, ёс зүй, психологийн түвшинд авч үзэх шаардлагатай нэн чухал сэдэв юм гэдгийг энд онцлон дурдаж байна. Тиймээс энэхүү өгүүллийн гол зорилго бол энх тайван байхын гол үндэс шалтгаан нь юу болох вэ? гэдгийг илрүүлэн судлах нь энэхүү өгүүллийн гол зорилго болно.

Үндсэн хэсэг: 1992 онд баталсан Монгол улсын шинэ Үндсэн хуульд: Монголын ард түмэн бид:

“-улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,
-хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
-төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,
-хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,

-эх орондоо **хүмүүнлэг, иргэний ардчилсан** нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгосон". Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна ¹ хэмээн хүмүүнлэг нийгмийг бүтээх замаар энх тайванд хүрэх арга замыг монголчууд үндсэн хуулиараа тодорхойлсон байдаг. Гэвч нийгэм бүрд энх тайван хялбар аргаар бий болдоггүйг түүх бидэнд гэрчилдэг.

Дэлхий нийтийн хэмжээнд энх тайвныг алдагдуулах хэд хэдэн гол шалтгаан байна. Эдгээрийг товч дурдвал: ядуурал, геополитикийн мөргөлдөөн, терроризм ба радикализм, мэдээллийн технологийн дезинформаци, соёл, шашин хоорондын мөргөлдөөн, уур амьсгалын өөрчлөлт ба нөөцийн хязгаарлалт зэрэг гэх мэт сорилтуудыг энд дурдаад дуусашгүй юм.

Дэлхий дахины шинжтэй болон тухайн ард түмэнд тулгарч буй орчин үеийн сорилтуудыг даван туулах зүй зохистой арга зам бол энх тайвны аргаар асуудлыг шийдвэрлэх явдал юм. Тэгвэл энх тайван гэж юу вэ? гэдэг асуудал эндээс зүй ёсоор урган гарна. Философи болон ёс зүйн онолд энх тайвныг хэрхэн тодорхойлсон байдгийг энд товч авч үзье.

Энх тайван бол хүн төрөлхтний оршихуйн суурь зорилго билээ. Гэхдээ хүний суурь инстинкт, мөн чанар нь үргэлж энх тайван байдлыг хангаж чаддаггүй. Учир нь энх тайвныг үгүйсгэх, энх тайван байдлыг дарж байдаг инстинкт хүний өөрийн мөн чанарт агуулагдаж байдаг. Энэ тухай хятадын философич Сюньз(Хр.т.ө 310-235) хэрхэн өгүүлсэн байдгийг энд товч дурдвал, хүн бол төрөлх чанараараа хорон муу шинжтэй байдаг. Учир нь, хүн бол дарамт үзүүлэх инстинкттэй байдаг. Иймд хүмүүс дайсагналцаж байдаг.² Хэрэв хүн төрөлхөөсөө сайн байсан бол түүнд хүмүүжил, ёс төр, хууль, үүрэг, эцсийн эцэст төрийн засаглал хэрэггүй байх байлаа гэж өгүүлсэн байна.

Английн философич Томас Гоббс(1588-1679): “Хүн хүндээ чоно” гэдэг нийгэм, ёс зүйн утга бүхий алдарт томъёолол гаргасан философич билээ. Энэ нь: Хүмүүс анх үүсэхээсээ “бүгдийн эсрэг бүгдээрээ” харилцан дайны байдалд оршиж ирсэн хэмээх санааг илэрхийлдэг. Хүн бол байгалиас заяаснаараа эгоист(зөвхөн өөрийгөө бодогч) байдаг гэсэн Н.Макиавелли, Ф.Бэкон нарын үзлийг уламжилсан ийм үзэл нь бүх хүн харилцан нэгнээ устгачихгүйн тулд өөр өөрийнхөө эгоист эрмэлзлийг хязгаарлах ёстой гэдэг дүгнэлтэд Т.Гоббсыг хүргэжээ. Тэгж хязгаарлах хэрэгсэл нь төр байх аж. Төр бол хүмүүсийн түрэмгий эрмэлзлийг даван туулах, хүмүүс харилцан нэгнээ устгахаас сэргийлэх, өөрөөр хэлбэл, нийгмийн гэрээг хүчээр сахиулах хэрэгсэл мөн. Хүний үнэ цэнэ бол төрөөс хүнд оноодог үнэ цэн мөн.³ Тиймээс Т.Гоббсын үзлээр ёс суртахуунлаг байна гэдэг бол бусад хүнийг засаглах эрмэлзлээс ундарч, бусдын хүндэтгэлийг хүлээдэг байдал мөн. Нөгөөтэйгүүр захирагдана гэдэг бол хүндэтгэдэг байдал мөн. Ийнхүү Т.Гоббсын үзлээр ёс суртахууны эцсийн эцэст төрөөр, эрх зүйгээр зохицуулагддаг.

Тэгэхээр эндээс нэг дүгнэлт гарч байгаа юм. Дэлхий дахин, тухайн улс дотооддоо энх тайван, эв нэгдэлтэй байхын үндэс бол сайн хүмүүжил, сайн төрийн институт, хуулиа биелүүлэх, үүргээ ухамсарлах, эцсийн эцэст сайн төрийн засаглалтай байх явдал юм гэж дүгнэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, бид нийтээрээ хамтран амьдарч, бие бие хүндэлж, нэг үгээр хэлбэл бусдыгаа хайрлаж сурах явдал нь энх тайвныг бүтээх зайлшгүй арга юм. Японы философич Цэцуро Уацуки(1889-1960): хүний мөн чанарын нэг гол хэсэг бол бусадтай “холбоотой” байх явдал ба бусдын оршихуйг хүлээн зөвшөөрөх юм хэмээн бичсэн байдаг. Тиймээс “чи, бусад, дайсан” гэх дайсагналцсан ойлголтуудад үнэлэмж өгөх биш харин “бид, бүгдээрээ” хамтран амьдарна гэсэн ухамсрыг бий болгох нь зөрчилт сэтгэлгээг үгүй хийх арга юм. Эндээс зөрчлийг хувиргаж энх тайван болгох нэн тэргүүний шаардлагатай хүн төрөлхтөн тулгарч байгаа юм.

Ийнхүү зөрчлийг хувиргах ёстой гэсэн “Conflict Transformation”(“Зөрчилдөөнийг хувиргах”) онолыг боловсруулсан хүн бол Америкийн судлаач Жон Пол Ледерач юм. Түүний үзэж байгаагаар зөрчил бол дандаа сүйтгэгч хүчин зүйл биш, харин зөв аргаар хандаж чадвал нийгмийн харилцааг өөрчлөх, хөгжүүлэх боломж юм. Тэрээр “зөрчил намжаах”(conflict management) болон “зөрчил шийдвэрлэх”(conflict resolution) гэх мэт уламжлалт ойлголтоос

¹ Монгол улсын үндсэн хууль. (1992). Улаанбаатар.

² Xunzi. (2014). *Xunzi: The Complete Text* (E. L. Hutton, Опч.). Princeton University Press. p. 248

³ Гомбосүрэн. Ц.(2008). Ёс зүй. Улаанбаатар. х. 64

цааш гарч, “зөрчилдөөнийг хувиргах”(conflict transformation) хандлагыг дэвшүүлсэн. Энэ нь зөрчилд хүргэсэн үндэс суурь шалтгааныг ойлгож, нийгмийн харилцааг шинэ шатанд гаргахыг зорих явдал юм. Ийнхүү Ж.Ледерач “энх тайван бол зөвхөн зөрчлийг намжаах бус, харин нийгмийн бүтцийг шинэчлэх, нийгмийн харилцааг шинэ шатанд гарган өөрчлөхөд чиглэсэн үйл явц”¹ хэмээн бичжээ. Тийнхүү тэрээр цааш нь бичихдээ: Зөрчил нь зөвхөн улс төрийн эсвэл эдийн засгийн асуудал биш, харин хүмүүсийн хоорондын харилцаа, хүний хүсэл, үнэт зүйл, соёл, түүхийн ялгаанаас үүсдэг. Тиймээс зөрчил бол хүний мөн чанарын нэг хэсэг. Зөрчлийг зөвхөн намжаах биш, харин шударга ёс, итгэлцэл, эвлэрлийг сэргээх замаар хувиргах нь ёс суртахууны хариуцлага² гэж Ледерач үзсэн байна.

Өргөн утгаар авч үзвэл нийгэмд буй тэгш бус байдал, ялгаварлал нь гэмт хэрэг, зөрчлийн гол шалтгаан болдог. Өөрөөр хэлбэл, ялгаатай хүсэл, ялгаатай соёл, ялгаатай үнэт зүйлс нь энх тайвныг үгүй хийж байдаг.

Германы философич Артур Шопенгауэр(1788-1860)-ийн философидолтоор “хүн бол танин мэдсэн зүйлээ хүсдэг гэж рационалистуудын үздэг худлаа. Угтаа хүн хүсэж буй юмаа танин мэддэг байх ёстой. Гэвч хүн ахуйгаа танин мэдэж чаддаггүй.³ Иймд ахуйгаа, сайн сайхны төлөө гэсэн хүний хүсэл эрмэлзэл биелдэггүй. Үүнээс болоод хүн жаргаж чаддаггүй” хэмээн бичсэн буй. А.Шопенгауэрийн философидолтоор арга зүйгээ хийж дүгнэлт хийвэл, хүн төрөлхтөн энх тайван байхыг хүсдэг ч энх тайван хэмээх ойлголтыг анализад оруулдаггүй, энх тайван байх асуудлыг ухамсарладаггүй юм хэмээсэн дүгнэлт эндээс хийж болохоор байна.

Зөрчлийг даван туулах ёс суртахууны арвин их мэдлэг монголчуудын уламжлалт сэтгэлгээнд бий. Үүнийг энд товч авч үзвэл.

Монголчууд энх тайван, эе эвтэй байх тухай эртнээс нааш уламжлалдаж ирсэн гүн гүнзгий мэдлэгтэй ард түмэн билээ. Монголын уламжлалт нийгмүүдийн бүх гол үед ёс суртахууны зарим нийтлэг зарчим хойш хойшдоо уламжлагдан ирсэн байдаг. Үүний хамгийн чухал жишээ бол энх тайван байхын үндэс болох эв эвийг хичээх үзэл юм. Тухайлбал, Алунгуа хатны тухай алдарт домогт тэрээр таван хүүдээ хандан: “та нар эе эвээ нэгтгэвэл багласан таван сум мэт бэх болж, хэнд ч хялбар дийлдэхгүй болно”⁴ гэж сургамжилсан тухай Монгол нууц товчоонд өгүүлсэн байдаг.

Мөн Чингис богдын сургаалд “эрдмийн дээд эв” хэмээсэн болой. Ийнхүү монголчуудын сэтгэлгээнд эе эв бол бүтээгч хүч юм. Өөрөөр хэлбэл, монголчуудын хүчтэй байх гол бэлгэдэл бол “эе эвтэй” байх юм.

То ван Тогтохтөр(1797-1868) өгүүлэхдээ: “их, бага бүгдээр эвтэй болбоос цөм өлзийтэй болж, хамаг сайн иргэн болохуйн тэргүүн тэр”⁵, 1853 онд зохиосон “Хэбэй вангийн аж төрөхийг заасан сургаал болой” хэмээх бүтээлдээ: Хүний эрхэмлэх юм нь энэ ертөнцөд ёс журмыг хүндэтгэн, аж зуухуйг хичээх болой⁶ гэсэн байдаг.

Эцэг эх, өвөг дээдсээ хүндлэх ёс монголчуудад нэн хүчтэй байв. Монголчуудын үзлээр өөр хоорондоо эвтэй байхын үндэс нь эцэг эхээ хайрлах, хүндлэхээс эхтэй гэж үздэг байсан нь түүхэн бичвэрүүдээс тодорхой харагддаг. МНТ-д бичсэнээр талын язгууртнуудад эх эцгээ хүндлэх ёс хүчтэй байсан нь ургийн гишүүд эв нэгдэлтэй, үйл хэрэг нь бүтэмжтэй байхын маш чухал нэг нөхцөл болж байжээ. Чингис хаан улсын чухал асуудлыг хэлэлцдэг алтан ургийнхаа зөвлөлдөөнд эхийгээ оролцуулдаг байв. Дэв Тэнгэрийн хатгаасаар Хасарыг барин байцааж асан Чингис хаан эхийгээ алсаас зориуд ирж Хасарыг өмөөрөхөд нь: “Эхийг хилэгнээсэнд би айхын эхээр айж, ичихийн ихээр ичив. Бид одоо больё”⁷ гэсэн байдаг.

¹ Lederach, J. P. (2003). The Little Book of Conflict Transformation. Good Books. p.29

² Lederach, J. P. (1997). *Building peace: Sustainable reconciliation in divided societies*. United States Institute of Peace Press.

³ Гомбосүрэн. Ц.(2008). Ёс зүй. Улаанбаатар. х. 76

⁴ Монголын нууц товчоо. (1990). Улаанбаатар.х.22

⁵ Монгол улсын шинжлэх ухааны академийн философи, социологи, эрхийн хүрээлэн. (2001). Монголын философийн түүх. (XVII-XIX зуун). IV дэвтэр. Улаанбаатар. х. 406

⁶ Монгол улсын шинжлэх ухааны академийн философи, социологи, эрхийн хүрээлэн. (2001). Монголын философийн түүх. (XVII-XIX зуун). IV дэвтэр. Улаанбаатар. х. 414

⁷ Монголын нууц товчоо. (1990). Улаанбаатар.х.244

Эцэг эхээ хайрлах, ахас ихсийг хүндлэх нь эв эеэ хичээх энх тайван байхын үндэс суурь болохыг эртний монголчууд эрт үеэсээ ухамсарлан, нийтийн ухамсар сэтгэлгээ болгон, амьдрал ахуйдаа хэрэглэдэг байсан нь дээрхээс харагдаж байна. Ерөнхийдөө бол энх тайван байхын гол шалгуур нь хайр ба хүндлэл юм. Хайр, хүндлэл оршихуйн чухал нөхцөл юм гэдгийг Өрнө, Дорнын олон философи, ёс зүйн онолд нухацтай авч үзсэн байдаг. Жишээ нь, Хятадын философич Күнзийн “жэнь” хэмээх ойлголт нь бусдыг хайрлаж, хүндлэх асуудлыг нухацтай авч үзсэн байдаг. Мөн Э.Фромм “Хайрын амт” хэмээх зохиолдоо энх тайван орших, амьдралыг утга учиртай өнгөрүүлэхийн гол нөхцөл нь хайр юм хэмээн өгүүлсэн байдаг. Оросын эрдэмтэн Л.Н.Толстой(1828-1910) хүчирхийллийг үгүй хийх, энх тайвныг бүтээх цор ганц арга зам бол хайр, хүндлэл юм хэмээн үзсэн.

Л.Н.Толстойн үзлээр “хүний амьдралын үндэс нь үл хүчирхийлэл. Үл хүчирхийллийн үндэс нь хайр, итгэл, эрх чөлөө, сайн үйл юм. Хүний амьдралын эмгэнэлт явдал бол амьдралд итгэхгүй байх, өөрийгөө болон бусдыг үл хайрлах, чөлөөт бус байдал, хариуцлагагүй байх явдал бөгөөд энх тайван бол зөвхөн улс төрийн төдийгүй ёс зүйн ухагдахуун юм. Л.Толстойн үзлээр “хүний амьдралын мөн чанар түүнийг удирдаж байвал зохих дээд хууль бол хайрын хууль бөгөөд хайр бол хүний оршихуйн суурь хэрэгцээ, үнэт зүйл, хүнийг бусадтай нэгтгэж өгдөг идэвхтэй хүч, эв нэгдэлд хүрэх нэг арга хэрэгсэл юм. Жинхэнэ хайр бол амьдрал өөрөө юм. Жинхэнэ хайранд айдас үл оршино. Хайр бол сайн сайханд тэмүүлэх тэмүүлэл.”¹

Л.Толстойн үзлээр, хайрын хууль бол: 1.Битгий уурла, хилэгнэ. Битгий ал. 2. Эхнэрээ битгий орхи. 3.Хэнд ч, хэзээ ч, юунд ч битгий тангарагла. 4. Муу үйлийг хүчээр бүү эсэргүүц, муу үйлийг гэвч. 5.Бусад ард түмнийг өөрийн дайсан гэж битгий үз. Дайснаа ч хайрла.”²

Мөн түүнчлэн үл хүчирхийллийн эсрэг ойлголт болох хүчирхийллийн талаар ч бас тэрээр тайлбарласан буй. Уур хилэнгээр битгий эсэргүүц гэдэг нь хүчээр битгий хий гэсэн үг. Хүн хүнээ шүүхээр заяагдаагүй. Сэтгэл санаа өөрөө хууль тогтоодог. Энэ нь хүн өөрөө өөртөө эзэн, өөрийгөө захирдаг гэсэн үг.

Үл эсэргүүцэхийн ёс суртахуун бол хүн бүр өөрийн ухаан бодлоо аврах тухай бодох ёстой гэсэн шаардлага юм. Бусдын сэтгэл санааг захирч болохгүй, захирах ч хэрэггүй. Захирах гэсэн анхны хүслээс энх тайван алдагдаж байдаг.

Бусад хүмүүсийг бус, өөрөө өөрийгөө засах хэрэгтэй. Үл эсэргүүцэх нь хүний ёс суртахууны өөрийгөө төгөлдөржүүлэх идэвхт байдал юм. Аливаа хүчирхийлэл нь эрх чөлөөгүй, хариуцлагагүй байдлын илрэл мөн. Хариуцлагатай байдлаараа үл хүчирхийлэл нь хүчирхийллээс ялгаатай.

Л.Толстойн үзлээр хүчээр хүч хэрэглэхийг хязгаарлана гэдэг нь буруу, ялангуяа энэ санаа нь үл эсэргүүцэх тухай хуулиар цуцлагдсан. Хүч хэрэглэх нь амархан, тэр байнга тохиолддог. Түүнийг зөвтгөж болохгүй. Хүн бүр хуулийн болон бурхны өмнө тэгш эрхтэй, ёс суртахууны хувьд тэгш эрхтэй гэвэл хүн хүндээ хүч хэрэглэх үндэслэл байхгүй. Өөрийгөө бүхнээс илүү гэдгээ батлах, хүмүүсийн магтаалыг хүртэх, бусдаас ялгарах эрмэлзэлд орших хүний мөн чанар нь мөн хүч хэрэглэхэд оршино хэмээн өгүүлжээ.

XIX зууны Монголын нийгэм, улс төрийн сэтгэлгээний томоохон төлөөлөгч бол ноён хутагт Дулдуйтын Данзанравжаа(1803-1859) юм. Ноён хутагт бичихдээ, мэдрэхүйн ертөнц дэх хүмүүсийн аливаа үйл ажиллагаа нь эцсийн дүндээ уг хүний ухамсар сэтгэлгээс хамаарна³ гэсэн байна. Өөрөөр хэлбэл, нийгэмд тулгарсан асуудлыг энх тайвнаар шийдэх үү, зөрчил мөргөлдөөнөөр шийдэх үү гэдэг нь хүний ухамсар, сэтгэлгээс хамаарах аж. Тиймээс энх тайвныг бий болгохыг хүсвэл хувь хүний ухамсар, сэтгэл, ёс суртахууны боловсролд нь анхаарах хэрэгтэй гэдэг дүгнэлт эндээс урган гарч байгаа болно.

Тийм ч учраас, нийгэм- улс төрийн аливаа асуудлыг авч үзэхдээ Данзанравжаа уг хүмүүсийн, нийгмийн гишүүдийн зан суртахууны байдал, төгөлдөржлийн хэр хэмжээг үндэс

¹ Дарьхүү.Р, Цэрэндолгор.Т. (2010). Үл хүчирхийлэл нь хүний амьдралын үндэс болох тухай Л.Н.Толстойн үзэл баримтлал.- МУИС. Философи, шашин судлал. XI. №.336/60/. Улаанбаатар. х.34

² Дарьхүү.Р, Цэрэндолгор.Т. (2010). Үл хүчирхийлэл нь хүний амьдралын үндэс болох тухай Л.Н.Толстойн үзэл баримтлал.- МУИС. Философи, шашин судлал. XI. №.336/60/. Улаанбаатар. х.34

³ Монгол улсын шинжлэх ухааны академийн философи, социологи, эрхийн хүрээлэн. (2001). Монголын философийн түүх. (XVII-XIX зуун). IV дэвтэр. Улаанбаатар. х. 344

болгож, хүмүүсийн сэтгэл, зан суртахууны үүднээс ургуулан тайлбарлахыг оролдхийлсэн болно. Түүний үзлээр нийгэмд болж буй муу, муухай бүхнийг даван туулах арга зам нь нийгмийн бүх гишүүн, ялангуяа нийгмийг ноёлогч дээд хэсгийхэнд ёс суртахууны шилдэг сайн чанаруудыг эзэмшүүлэх явдал юм гэж үзсэн.

Тэрээр нийгэмд оршин буй дутагдлыг засан сайжруулах арга бол: Нийгмийн гай зовлонг анагаахын тулд хүмүүсийн ёс суртахууныг төгөлдөржүүлэх хэрэгтэй гэж үзсэн.¹ Нийгмийн зөрчил тэмцэл, авах идэхийн шунал өдрөөс өдөрт гүнзгийрэн хэмэгдэж муу муухай, бузар гутамшигтай бүхэн түгэн дэлгэрч байгаа нь эцсийн дүндээ манай хүмүүсийн сэтгэл санаа доройтож, ёс суртахууны талаар уналтад орсноос л болж байгаа юм. Учир иймд байдлыг өөд татан сайжруулахын тулд юуны өмнө хүмүүст ёс суртахууны эерэг шинж чанарыг төлөвшүүлэх хэрэгтэй гэж үзжээ.

Данзанравжаа “Сэтгэлийг амраагч оршвой” гэдэг зохиолдоо: уужим тогтуун зангаар хүний боол болдоггүй, догшин дээрэнгүй зангаар хүнээс дээгүүр гардаггүй хэмээн өгүүлснээрээ энх тайванч байхын чухлыг чухалчилсан байна.

“Онох үзлийн тухай хариу” хэмээх гүн ухааны бүтээлдээ Данзанравжаа: “Дээд доод гэж хоёргүй, хоёулаа дээд”, Сайн муу гэж хоёргүй, хоёулаа сайн, Хоёр хэмээх томъёог орчлон нэрийдсэн юм” гэж дүгнэсэн байна. Эндээс дүгнэлт хийвэл энх тайван байх гол үзэл бол бусдыг дайсан, зөрчилт тал гэж утга оноохгүй, минийх, чинийх гэж ялгаж зөрчил үүсгэхгүй байх явдал юм. Данзанравжаагийн үзлээр зөрчил, тэмцэл маргааны үндэс бол би-д баримтлах ташаа үзэл, минийхийлэн баримтлах элдэв адхаг бодол гэж үзсэн байна.

Мартин Буберын “Би–Чи” (Ich–Du) харилцааны философид жинхэнэ хүний оршихуй нь зөвхөн **“чи-г хүлээн зөвшөөрөх”-өөр бий болдог**. Энх тайвны өдөр бол улс орнууд, ард түмэн, хувь хүмүүс бие биеэ дайсан бус **“чи” гэж хүлээн зөвшөөрөхийг** уриалсан бэлгэдэл.

Хүнийг зовлонд унагадаг эцсийн шалтгаан бол үл мэдэх мөн гэдэг үзэл бол олон философи сургаалд давхацдаг санаа юм. Тиймээс энх тайван, эв нэгдэлтэй байх нэг чухал үндэс бол энх тайван, эв нэгдлийн тухай мэдлэгтэй байх, хүнийг хайрлах, энэрэх мэдлэгтэй байх явдал юм. Нөгөө талаас “Чи ямар ч үйл ажиллагаа явуулсан тэрний цаана хүн байгаа гэдгийг сана” гэсэн И.Кантын ёс зүйн зарчмыг баримталбал энх тайван байх нөхцөл бүрдэнэ.

Бид бол анализад орох ёстой зүйлс гэж Мартин Хайдеггер хэлсэн байдгийг энд эш татаж, энэхүү өгүүллээ төгсгөө.

Дүгнэлт: Дээрх санаануудыг дүгнэж үзвэл, энх тайван гэдэг бол дараах философи болон ёс зүйн онолд дараах утгаар илэрхийлэгдэж байна. Үүнд: Германы философич Ф.Ницшегийн үзлээр, хүн бол өөрийгөө даван туулж, шинэ үнэ цэнийг бүтээдэг амьтан. Ф.Ницшегийн философийг арга зүйгээ болговол энх тайвны өдөр нь хүн төрөлхтөн өөрийн дотоод зөрчил, дайсагнал, айдас, түрэмгийллийг даван гарч, шинэ үнэ цэнийг бүтээх бэлгэдэл юм.

К.Г.Юнгийн аналитик психологийн үүднээс авч үзвэл, хүн төрөлхтний сэтгэл дотор агуулагдаж байдаг заль мэхт(Trickster), сүүдрийн архетип нь дайсагнал, зөрчил, будлианы эх үүсвэр болдог. Харин энэ архетипийг ухамсарлаж, хяналтдаа авч, улмаар хамтын ухамсарт **шинэ тэнцвэр** бий болгосноор энх тайван орших юм.

Практик түвшинд, ёс зүйн боловсролыг боловсролын системд бэхжүүлж боловсролын бодлогодоо өөрчлөлт оруулах, хууль, эрх зүйд бусдыг хүндлэх, хайрлах ухамсар суулгах заалт оруулж институтыг бэхжүүлэх арга хэрэглэвээс зохимжтой гэсэн дүгнэлт хийж байгаа болно.

¹ Тунгалаг. Д. (2002). Ёс зүй. Улаанбаатар.х. 71

НОМ ЗҮЙ

1. Гомбосүрэн. Ц.(2008). Ёс зүй. Улаанбаатар.
2. Дарьхүү.Р, Цэрэндолгор.Т. (2010). Үл хүчирхийлэл нь хүний амьдралын үндэс болох тухай Л.Н.Толстойн үзэл баримтлал.- МУИС. Философи, шашин судлал. XI. №.336/60/. Улаанбаатар.
3. Монгол улсын үндсэн хууль. (1992). Улаанбаатар.
4. Монголын нууц товчоо. (1990). Улаанбаатар.
5. Монгол улсын шинжлэх ухааны академийн философи, социологи, эрхийн хүрээлэн. (2001). Монголын философийн түүх. (XVII-XIX зуун). IV дэвтэр. Улаанбаатар
6. Тунгалаг. Д. (2002). Ёс зүй. Улаанбаатар
7. Lederach, J. P. (2003). *The Little Book of Conflict Transformation*. Good Books.
8. Lederach, J. P. (1997). *Building peace: Sustainable reconciliation in divided societies*. United States Institute of Peace Press
9. Xunzi. (2014). *Xunzi: The Complete Text* (E. L. Hutton, Орч.). Princeton University Press.

МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ НҮҮДЭЛЧИН СОЁЛ БА НҮБ-ЫН ЭНХИЙГ САХИУЛАХ ФИЛОСОФИЙН УЯЛДАА

Ц.ГАНБАТ

*БХЭШХ, Цэргийн түүх судлалын төв
Эрдэм шинжилгээний ахлах ажилтан*

Хураангуй: Энэхүү өгүүлэл нь Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг сахиулах ажиллагаанд оролцсон туршилагыг философийн болон соёлын үүднээс шинжлэх ухааны задлан дүн шинжилгээ хийх зорилготой. Судалгааны үндсэн асуудал нь: Монголын уламжлалт ёс заншил, нүүдэлчин соёлын онцлог нь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны философийн зарчимтай хэрхэн нийцэж байгааг тодруулахад чиглэнэ.

Судалгааны онолын суурь нь энхийг сахиулах үйл ажиллагааны философийн гурван тулгуур болох **эвлэрэл** ба **итгэлцэл**, **хүний амьдралын үнэ цэнэ**, тогтвортой хөгжил юм. Эдгээр үзэл санааг Монголын түмний уламжлалт соёлын үнэт зүйлс болох эв нэгдэл, ахмадаа хүндэтгэх, хамтын ажиллагааг эрхэмлэх, уян хатан дасан зохицох чадвартай харьцуулан шинжилсэн.

Өмнөд Судан Улсад Монголын Улсын Зэвсэгт хүчний энхийг сахиулагчид аюулгүй байдлыг хангахаас гадна нутгийн удирдлагатай харилцах, хүмүүнлэгийн төсөл хэрэгжүүлэх, соёлын ялгааг хүндэтгэх замаар энх тайвныг бүтээхэд хувь нэмэр оруулсан нь энэхүү судалгааны гол кейс болсон. Энэ туршилага нь Монголын соёлын үнэт зүйлсийг олон улсын энхийг сахиулах философийн зарчимтай уялдуулан бодитоор хэрэгжүүлсэн тодорхой жишээ юм.

Дүгнэлтэд, Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах UNMISS ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн баг энхийг сахиулах үйл ажиллагаа үүргээс гадна, иргэн-цэргийн харилцаа, хүмүүнлэгийн тусламж, философийн суурь зарчмыг нэгтгэсэн өвөрмөц загвар болж, олон улсын энх тайвны бүтээлд онол-практикийн чухал хувь нэмэр оруулж байгааг тогтоов.

Түлхүүр үгс: Монгол Улс, энхийг сахиулах ажиллагаа, философийн тулгуур, үнэт зүйлс, нүүдэлчин соёл, эв нэгдэл, итгэлцэл, хүний амьдралын үнэ цэнэ, тогтвортой хөгжил, Өмнөд Судан, хүмүүнлэгийн төсөл, соёлын мэдрэмж, харилцааны ур чадвар, энх тайван.

Үндсэн хэсэг:

XXI зууны олон улсын харилцааны тулгамдсан асуудлын нэг нь энх тайвныг тогтоох, мөргөлдөөнийг шийдвэрлэх, зөрчилдөөнт бүс нутгуудад тогтвортой байдлыг бий болгох явдал билээ. Үүний тулд Нэгдсэн Үндэстний Байгууллага болон бүс нутгийн аюулгүй байдлын байгууллагууд цэргийн болон иргэний шинжтэй өргөн цар хүрээтэй энхийг сахиулах ажиллагааг хэрэгжүүлж ирсэн. Энхийг сахиулах ажиллагаа бол дан ганц цэргийн үйл ажиллагаа бус, харин соёл, үнэт зүйл, философийн үзэл санаанд суурилсан цогц үйл явц юм.

Монгол Улс 2002 оноос эхлэн НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож, өнөөдрийн байдлаар дэлхийн 10 гаруй улс оронд энхийг сахиулагчдаа илгээсэн байна¹. Монголын Улсын Зэвсэгт хүчин энхийг сахиулах ажиллагаагаар дамжуулан олон улсын тавцанд нэр хүндээ өсгөхийн зэрэгцээ энх тайвныг бүтээх үйл хэрэгт бодит хувь нэмрээ оруулж байна. Энэхүү оролцоо нь Монгол Улсын батлан хамгаалах бодлогын чухал тулгуур болж, гадаад бодлогын “гуравдагч хөршийн” чиг хандлагатай нягт уялдаж байгаа юм.

Гэвч энхийг сахиулах ажиллагаа нь зөвхөн зэвсэг, техник, сахилга дэг журамд тулгуурлахгүй. Харин тухайн орны цэрэг, иргэдийн **соёлын онцлог**, **үндэсний үнэт зүйлс**, түүнчлэн **философийн хандлага** чухал байр суурь эзэлдэг. Монголчуудын хувьд нүүдэлчин

¹ https://peacekeeping.un.org/en/2023-united-nations-peacekeeping-ministerial?utm_source=chatgpt.com

уламжлал, ахмадаа хүндэтгэх ёс, хамтын эв нэгдлийг эрхэмлэх сэтгэлгээ зэрэг нь энхийг сахиулах ажиллагаанд онцгой ач холбогдолтой хүчин зүйл болж иржээ.

Өмнөд Судан Улс дахь Монголын энхийг сахиулагчдын туршлага нь үүний тод жишээ юм. Өндөр түвшний угсаатны зөрчил, шашны ялгаа давамгайлсан энэ бүс нутагт Монголын цэргүүд зөвхөн аюулгүй байдлыг хангах үүрэг гүйцэтгээд зогсохгүй, орон нутгийн иргэдтэй ойлголцох, соёлыг нь хүндэтгэх, хүмүүнлэг тусламж үзүүлэх замаар энх тайвныг бүтээхэд оролцож байна. Энэ үйл явц нь энх тайвны философийн суурь зарчмууд болох **эвлэрэл, харилцан итгэлцэл, хүний амьдралыг дээдлэх хандлагатай** уялдаж байв.

Иймээс энэ өгүүллийн зорилго нь Монгол цэргийн энхийг сахиулах үйл хэрэгт шингэсэн соёл, үнэт зүйл, философийн тулгуурыг шинжлэх ухааны үүднээс задлан судалж, Өмнөд Суданд үүрэг гүйцэтгэсэн туршлагатай холбон тайлбарлахад оршино. Судалгааны асуудал нь: **Монгол цэргийн үнэт зүйлс болон нүүдэлчин уламжлал, энхийг сахиулах ажиллагааны философийн үзэл санаатай хэрхэн нийцэж байна вэ?** гэсэн асуулт юм. Энэ нь цаашид Монголын энхийг сахиулах үйл ажиллагааны онол-практикийн ач холбогдлыг тодруулахад чухал ач холбогдолтой.

Онолын үндэс ба философийн тулгуур

Нэг. Энхийг сахиулах үйл ажиллагааны философи.

Энхийг сахиулах ажиллагаа бол зөвхөн цэргийн тактик, стратегийн асуудал бус харин хүний эрх, хүмүүнлэгийн зарчимд тулгуурласан, улс төр–дипломат үйл явцтай нягт уялдсан цогц ойлголт юм. НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагааны философи нь үндсэндээ гурван тулгуур үзэл санаанд суурилдаг гэж судлаачид тэмдэглэдэг. Үүнд:

1. **Эвлэрэл ба итгэлцэл:** Хоёр талын хоорондын хүчирхийллийг намжаах, харилцан ойлголцлыг сэргээх.
2. **Хүний амьдралын үнэ цэнэ:** Зөрчилдөөнт бүсэд амьдарч буй энгийн иргэдийн амь насыг дээдлэх.
3. **Тогтвортой хөгжил:** Энхийг сахиулах ажиллагаа нь зөвхөн түр зуурын гал зогсоох бус, харин урт хугацааны тогтвортой байдлыг бий болгох зорилготой.

Эдгээр үзэл санаа нь философийн түвшинд “Энх тайвны соёл” (culture of peace) хэмээх ойлголттой нягт холбоотой. ЮНЕСКО-гийн тодорхойлсноор энх тайвны соёл гэдэг нь “Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, эв нэгдэл, тэгш боломж, шударга ёс, нийгмийн оролцоог дээдлэх зан үйлийн цогцолбор” юм¹.

Хоёр. Монголчуудын ёс, заншил, соёлын үнэт зүйлс ба энх тайвны философи

Монголын уламжлалт нүүдэлчин соёл нь байгальтай зохицон амьдрах, хамтын ажиллагааг эрхэмлэх, ахмад үеэ хүндэтгэх, эв нэгдлийг дээдлэх зэрэг үнэт зүйлд тулгуурладаг. Түүхэн уламжлалд “эвтэй бол хүчтэй” гэх ардын мэргэн үгс нь зөрчил маргааныг эв зүйгээр зохицуулах, харилцан ойлголцолд хүрэхийг илэрхийлдэг.

Энэ үнэт зүйлс нь энхийг сахиулах үйл ажиллагааны философийн зарчимтай ижил төстэй. Жишээлбэл:

- **Эв нэгдлийг эрхэмлэх уламжлал** - Энхийг сахиулах ажиллагааны эвлэрэл, итгэлцлийг сэргээх зорилготой нийцдэг.
- **Хүндэтгэл ба ахмадаа сонсох ёс** - Талуудын дуу хоолойг сонсох, соёлын ялгааг хүлээн зөвшөөрөх дадал болж хувирна.
- **Нүүдэлчний амьдралын уян хатан чанар** - Байгал цаг уурын хүнд нөхцөлд дасан зохицох чадвар, Өмнөд Судан зэрэг халуун бүс нутагт үүрэг гүйцэтгэхэд хурдан дасан зохицдог.

Гурав. Өмнөд Судан дахь Монголын энхийг сахиулагчдын үйл ажиллагааны туршлага ба онцлог

Өмнөд Судан Улсад Монголын энхийг сахиулагчид ажиллах явцдаа зөвхөн аюулгүй байдлыг хангаад зогсохгүй, нутгийн иргэдтэй харилцахдаа соёлын онцлогийг ойлгох, хүндэтгэх

¹ *UNESCO. (1999). Learning the Way of Peace: A Teacher's Guide to Education for Peace, Human Rights, and Democracy. Paris: UNESCO.*

шаардлагатай болсон. Өмнөд Судан бол 60 гаруй угсаатны бүлэг, олон овог аймгаас бүрдсэн, шашны болон угсаатны зөрчил ихтэй нийгэм юм. Иргэдийн өдөр тутмын амьдралд мал аж ахуй, овгийн харьяалал, уламжлалт ёс заншил онцгой байр суурь эзэлдэг.

Монголын цэргүүд нутгийн иргэдтэй харилцахдаа:

- **Малын үнэ цэнийг** ойлгож, харьцуулах жишээ болгон мал аж ахуйн талаарх яриа өрнүүлэхэд дөхөм байсан. Энэ нь хоёр орны уламжлалын ижил төстэй тал болж өгсөн.
- **Овгийн зохион байгуулалтын онцлогийг хүндэтгэх** замаар нутгийн ахмадуудтай уулзалт хийж, мэдээллийг зөв дамжуулах, зохицуулалтыг амжилттай хийхэд тусалсан.
- **Шашны мэдрэмжийг** харгалзан үзэж, аль нэг талыг дэмжихгүй төвийг сахисан байдлаа сахих нь итгэлцлийг бий болгосон.

Эндээс харахад Монголын уламжлалт үнэт зүйлс нь зөвхөн дотоодын нийгмийн харилцаанд төдийгүй, олон улсын энхийг сахиулах ажиллагаанд ч хэрэгжиж болдгийг батлан харуулж байна.

4.Онолын түвшинд харьцуулж дүн шинжилгээ хийх арга

Энхийг сахиулах үйл ажиллагааг судалсан судлаачид энхийг сахиулагчдын соёлын мэдрэмж, нутгийн иргэдтэй харилцах арга барил нь амжилтын гол хүчин зүйл гэдгийг тэмдэглэсэн байдаг. Монголын цэргүүдийн хувьд энэ нь уламжлалт соёл, үнэт зүйлтэй нь шууд холбогдон гарч ирдэг. Тухайлбал, Өмнөд Суданд нутгийн иргэд малтайгаа холбоотойгоор амьдардаг бол Монголчууд ч мөн адил мал аж ахуйд түшиглэсэн соёлтой тул харилцааны “соёлын гүүр” үүсгэх боломж бүрдсэн¹.

ӨМНӨД СУДАН ДАХЬ ТУРШЛАГА БА СУДАЛГАА

Өмнөд Судан Улсын нийгэм, соёлын онцлог.

Тус улс нь 2011 онд бие даасан улс болсон ч олон арван жилийн иргэний дайн, овог угсааны маргаанаас үүдэн улс төр, нийгмийн тогтвортой байдал сул, угсаатны зөрчил ихтэй улс юм. 60 гаруй үндэстэн, олон овог аймагтай, шашны ялгаа ихтэй учир энхийг сахиулах ажиллагаа явуулахад нарийн зохицуулалт шаарддаг². Иргэдийн өдөр тутмын амьдралд мал аж ахуй, овог угсааны уламжлал, ахмадын үүрэг онцгой байр суурь эзэлдэг³.

Монгол цэргүүд Өмнөд Суданд үүрэг гүйцэтгэхдээ зөвхөн аюулгүй байдлыг хангаад зогсохгүй, нутгийн иргэдтэй ойлголцох, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд оролцох шаардлагатай болсон⁴. Энэ нь **соёлын мэдрэмж, харилцааны ур чадвар, үнэт зүйлсийн философийн ойлголттой** нягт холбоотой байв.

Өмнөд Суданд Улсад Монгол цэргүүдийн үүрэг гүйцэтгэсэн туршлагаас дараах жишээг авч үзэж болно. Үүнд:

Нэгд. Орон нутгийн удирдлагатай харилцаа талаар.

Монгол цэргүүд овгийн ахмадууд, нутгийн удирдлагатай уулзалт хийж, мэдээлэл солилцох, зохицуулалт хийх замаар олон талын итгэлцлийг бий болгосон. Монголын уламжлалт **ахмад настанд хүндэтгэл үзүүлэх** соёл нь энэ харилцаанд эерэг нөлөө үзүүлсэн. Энэ нь философийн түвшинд **эвлэрэл ба харилцан ойлголцлын зарчимтай** нийцэж байсан⁵.

Хоёрд. Иргэн-цэргийн харилцаа ба хүмүүнлэгийн үйл ажиллагаа. Монгол цэргүүд сургууль, эмнэлэг барих, хүүхдэд боловсролын дэмжлэг үзүүлэх зэрэг хүмүүнлэгийн төслүүдэд оролцсон⁶. Энэхүү үйл ажиллагаа нь зөвхөн орон нутгийн иргэдэд туслах төдийгүй, монгол

¹ Autesserre, S. (2014). *Peaceland: Conflict Resolution and the Everyday Politics of International Intervention*. Cambridge University Press

² United Nations Mission in South Sudan (UNMISS). *South Sudan Facts and Figures*. UN Peacekeeping, 2022;

³ Autesserre, S. (2014). *Peaceland: Conflict Resolution and the Everyday Politics of International Intervention*. Cambridge University Press;

⁴ United Nations Peacekeeping. *Mongolia and UN Peacekeeping*. UN Peacekeeping, 2023;

⁵ UNMISS. *Humanitarian Assistance Programs in South Sudan*, 2022;

⁶ Mendee, J. (2015). *The Role of Peacekeeping in Mongolia's Military Strategy: A New Paradigm for Security*. National Bureau of Research.;

цэргийн нэр хүндийг өсгөж, орон нутгийн иргэдийн итгэлцлийг нэмэгдүүлсэн¹. Энэ нь хүний амьдралыг дээдлэх, хүмүүнлэг энэрэнгүй хандлагын бодит хэрэгжилт байлаа.

Гуравт. Соёлын ялгааг ойлгох, дасан зохицох чадвар. Өмнөд Судан Улсад овог, угсаатны ялгаатай учраас маргаан үүсэх нь түгээмэл. Монгол цэргүүд тухайн орчны уламжлалт зан үйл, шашны мэдрэмжийг хүндэтгэж, аль нэг талыг дэмжихгүйгээр төвийг сахих арга барилыг баримталсан². Энэ нь олон улсын энхийг сахиулах философийн тогтвортой байдлыг хангах зорилготойгоор нийцэж байсан.

Дөрөвт. Харилцан итгэлцлийн гүүр үүсгэх. Монголчуудын нүүдэлчний соёлд хамтын ажиллагаа, эв нэгдлийг эрхэмлэх зарчим гүн гүнзгий шингэсэн³. Энэ нь Өмнөд Суданд ажиллахад олон үндэстний бие бүрэлдэхүүнтэй хамтран ажиллах, нутгийн иргэдтэй итгэлцэл бий болгох суурь болж өгсөн⁴. Жишээлбэл, мал аж ахуйд түшиглэсэн соёл нь Монгол, Өмнөд Суданы иргэдийг хооронд нь ойлголцуулах “соёлын гүүр” болж чадсан⁵.

Бодит жишээ: Сургалт ба хүмүүнлэгийн төсөл.

БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын мандаттай “UNMISS” энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний мотобуудлагын батальон нь ажиллагааны мандатад хүлэсэн үүргээ мадаггүй гүйцэтгэхийн сацуу НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр баримталж буй бодлого, үйл ажиллагаанд тодорхой өөрчлөлтүүд гарах магадлал бүхий нөхцөл байдалд үндэслэн тус улсын иргэд, төр захиргааны байгууллагууд руу чиглэсэн иргэн-цэргийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээнүүдийг идэвхтэй явуулдаг.

Ажиллагааны газар оронд иргэн-цэргийн харилцааны арга хэмжээг зохион байгуулахын ач холбогдол нь орон нутгийн удирдлага, ард иргэдийн итгэлийг хүлээх замаар өөрийн цэргийн аюулгүй байдлыг хангах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэх, улс орон, Зэвсэгт хүчнээ эергээр сурталчлах, НҮБ-ын зорилго, зорилтыг ойлгуулж, таниулах, хоорондын харилцаа холбоог бэхжүүлэх зэрэгт оршдог.

Түүнчлэн ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэж буй цэргийн багаас хэрэгжүүлж буй иргэн-цэргийн харилцааны арга хэмжээг НҮБ-ын зүгээс НҮБ, орон нутгийн иргэд, төр, захиргааны байгууллага хооронд амьд холбоог үүсгэж, бэхжүүлж байна гэж үнэлдгийг энд дурдах нь зүйтэй.

Дээрх зорилтуудыг хангах ажлын хүрээнд монголын батальон үүрэг гүйцэтгэх хугацаандаа өөрийн хариуцлагын бүс дэх Париаанг, Жамжанг, Ийда, Абьемном суурин, батальоны үндсэн бүрэлдэхүүн Бентью хотод зорилтот бүлгүүд рүү чиглэсэн улс, эх орон, зэвсэгт хүчнээ сурталчлах, эмнэлгийн үзлэг, анхан шатны тусламжийн ажлуудыг тасралтгүй зохион байгуулж эхэлсэн.

Монгол Улсын Зэвсэгт хүчний мотобуудлагын батальон Өмнөд Судан Улсад хийсэн бүтээн байгуулалт, томоохон арга хэмжээ (2011–Одоог хүртэл)⁶

Нэгдүгээр хүснэгт

Он	Бүтээн байгуулалт / арга хэмжээ	Иргэдийн хамралтын тоо	Байршил
2013	Бага сургууль сэргээн засварлалт	200 сурагч, багш нар	Рубкона

¹ Mendee, J. (2015). *The Role of Peacekeeping in Mongolia's Military Strategy: A New Paradigm for Security*. National Bureau of Research;

² UNESCO. (1999). *Learning the Way of Peace: A Teacher's Guide to Education for Peace, Human Rights, and Democracy*. Paris: UNESCO;

³ UNMISS. *Humanitarian Assistance Programs in South Sudan*, 2022;

⁴ UNMISS. *Community Engagement Activities of Mongolian Peacekeepers in South Sudan*, 2022;

⁵ UNMISS. *Peacekeeping Training for Local Communities in South Sudan*, 2022;

⁶

2015	Дунд сургууль иж бүрэн засварлалт (анги, багшийн өрөө, ариун цэврийн байгууламж, спорт талбай)	300 сурагч, 20 багш	Парянг
2015	Бентью амбулаторийн 4 өрөө сэргээн засварлалт	1000 оршин суугч	Бентью
2016	Сургалт, өдөрлөг (сэдэвт охидын боловсрол, эрхийн мэдлэг)	200 охид, сурагчид	Парянг
2014-2015	РоС бүсэд эргүүл, хамгаалалтын ажиллагаа	3,000 иргэн	Бентью–Рубкона
2020	Абиэмньом нэгдсэн эмнэлгийн шинэчлэл (цахилгаан, сантехник, COVID-19 тусгаарлах өрөө)	2,000 оршин суугч	Абиэмньом
2024-2025	Түр бааз, 24/7 эргүүл, халдлагын дараах хамгаалалт	800 оршин суугч	Абиэмньом

Монгол цэргүүд орон нутгийн хүүхдүүдэд аюулгүй тав тухтай орчинд сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх олон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн. Сургалтууд нь аюулгүй байдал, хүний эрхийн мэдлэг, маргааныг эв зүйгээр зохицуулах арга барилд чиглэсэн¹. Энэхүү туршлага нь Монголын **соёлын уян хатан чанар**, эв найрамдлыг эрхэмлэх хандлагыг бодит нөхцөлд туршсан нь онцлог юм².

Мөн Өмнөд Суданы эмэгтэйчүүдийг хамгаалах, хүүхдийн боловсролыг дэмжихэд чиглэсэн хүмүүнлэгийн төсөл нь цэргийн үүрэг, хүний эрх, философийн утга санааг нэгтгэсэн бодит кейс болсон.

Монголын цэргийн баг (MONBATT)-ын Орон нутгийн иргэдэд зориулсан сургалтууд
Хоёрдугаар хүснэгт

д/д	Сургалтын төрөл	Тайлбар	Хамарсан иргэд / үр дүн
1	Гагнуурын сургалт	Барилга, засвар үйлчилгээний ур чадварыг эзэмшүүлэх	Залуучууд, эрэгтэйчүүд (~50–100 оршин суугч)
2	Оёдлын сургалт	Хувцас оёх, засварлах ур чадвар эзэмшүүлэх	Эмэгтэйчүүд (~50 оршин суугч)
3	Сургалт, өдөрлөг (охидын боловсрол, эрхийн мэдлэг)	Боловсролын ач холбогдол, эмэгтэйчүүдийн эрхийг сурталчлах	200 сурагч, охид
4	Эрүүл мэндийн сургалт	Ариун цэврийн мэдлэг, COVID-19 халдвараас сэргийлэх арга	500 оршин суугч
5	Механик / техник сургалт	Тоног төхөөрөмжийн ажиллагаа, засварлах ур чадвар	30–50 залуучууд
6	Аюулгүй байдлын сургалт	Галын аюулгүй байдал, орон нутгийн хамгаалалтын арга хэмжээ	100–200 иргэн
7	Хөнгөн үйлдвэрлэлийн сургалт	Гэр ахуйн хэрэгцээний зүйл хийх (гар урлал, оёдол, гагнуур)	50–100 оршин суугч

Монголын цэргийн баг (MONBATT) нь Өмнөд Суданд үүрэг гүйцэтгэх хугацаандаа орон нутгийн иргэдэд мэргэжлийн ур чадвар, амьдралын мэдлэг, аюулгүй байдалд чиглэсэн олон төрлийн сургалт зохион байгуулсан.

¹ Galtung, J. (1996). *Peace by Peaceful Means*, Sage Publications;

² Mendee, J. (2015). *The Role of Peacekeeping in Mongolia's Military Strategy*, National Bureau of Research;

Сургамж ба философийн утга. Өмнөд Суданд Улсаас олж авсан туршлагаас дараах сургамж гарч байна:

- Монгол Улсын соёл, ёс заншил, уламжлалт үнэт зүйлс нь олон үндэстний орчинд амжилттай хэрэгжиж, энхийг сахиулах ажиллагааны философийн зарчмуудтай нийцэж чаддаг¹⁶;
- Соёлын мэдрэмж, харилцааны ур чадвар нь зөвхөн аюулгүй байдал хангахад чухал бус, олон талын итгэлцлийг бий болгох, зөрчлийг зөөлрүүлэхэд ч гол хүчин зүйл болдог¹⁷;
- Хүмүүнлэг үйл ажиллагаа, орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах нь энхийг сахиулах ажиллагааг зөвхөн цэргийн үүрэгт хязгаарлахгүй, **энх тайвны бүтээл** болгодог¹⁸.

Дүгнэлт ба санал

Монгол Улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцсон туршлага нь батлан хамгаалах бодлого, философийн үнэт зүйлс, соёлын ойлголтыг бодит үйл ажиллагаанд нэгтгэж чадсан жишээ боллоо. Өмнөд Судан Улсад хэрэгжүүлсэн Монгол цэргүүдийн гүйцэтгэсэн ажил, арга хэмжээг судалгаа харуулж буйгаар, орон нутгийн иргэдтэй харилцах, хүмүүнлэгийн төсөл хэрэгжүүлэх, соёлын ялгааг ойлгож төвийг сахих зэрэг нь энх тайвны бүтээлийн гол бүрэлдэхүүн болж чаддаг

Монголын цэргийн үнэт зүйлс эх оронч үзэл, сахилга бат, хамтын ажиллагаа, хүмүүнлэг энэрэнгүй хандлага нь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны зарчим, UNESCO-гийн тодорхойлсон энх тайвны соёлын философитой нийцэж байна.

Өмнөд Судан Улсад эдгээр үнэт зүйлсийг хэрэгжүүлэхдээ Монгол цэргүүд орон нутгийн ахмад, овог удирдлагатай уулзаж, итгэлцлийг бий болгож, маргаан зөрчилдөөнийг эв зүйгээр зохицуулахад амжилттай ажилласан.

Харьцуулсан дүн шинжилгээний үр дүнгээс харахад, бусад орнууд зөвхөн аюулгүй байдлыг хангах, техникийн зэвсгийн арга барилд төвлөрдөг бол Монголын туршлага нь үнэт зүйлс, соёл, хүмүүнлэгийн үйл ажиллагааг нэгтгэж энх тайвны бүтээл болгон хэрэгжүүлдэг нь онцлог юм.

Ийм арга барил нь олон үндэстний орчинд итгэлцэл бий болгох, орон нутгийн иргэдийг идэвхтэй оролцуулах, зөрчлийг багасгах гэх мэт нэмэлт үр дүнг авчирдаг.

